

# СУДАЛГААНЫ ТОВХИМОЛ

Дугаар №4



Улаанбаатар хот  
2023 он

**ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:**

Н.Хүдэрчулуун Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга  
Н.Оюунчимэг Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын дарга

**ЭМХЭТГЭСЭН:**

Н.Нарантуяа Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт

**ЭХ БЭЛТГЭЛ:**

Т.Билэгсайхан Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт

## ӨМНӨХ ҮГ



Уншигч таны амар амгаланг айлтгая.

Санхүүгийн зохицуулах хороо 2023 онд холбогдох байгууллагуудтай хамтран санхүүгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч ажилласны зэрэгцээ зохицуулалтын орчинг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд цогц арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллалаа. Тухайлбал, Уул уурхайн биржийн эрхзүйн орчныг бүрдүүлж, үйл ажиллагааг эхлүүлсэн бол хөрөнгийн зах зээл дээр анхны биржээр арилжигддаг хөрөнгө оруулалтын сан гарч бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо, төрөл ч нэмэгдэв. Мөн банкны реформ, төрийн өмчит компаниудыг хувьчлах ажлыг эхлүүлснээр хөрөнгийн

зах зээл идэвхжиж, зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2 дахин буюу 5.5 их наяд төгрөгөөр өсөж 10.3 их наяд төгрөгт, нийт арилжааны хэмжээ 654.6 тэрбум төгрөгт хүрсэн ололт, амжилт арвин жил байлаа.

Олон улсын ссанхүүгийн зохицуулагч байгууллагууд нь санхүүгийн салбарын бодлого, зохицуулалт, хяналтын хүрээнд аливаа шийдвэрийг гаргахдаа судалгаа, шинжилгээг үндэслэж урт хугацааны хөгжлийн гарцаа тодорхойлдог. Үүний адил Санхүүгийн зохицуулах хороо ч олон улсын шилдэг туршлага, стандартыг хяналт, зохицуулалтандаа нэвтрүүлэх, судалгаа шинжилгээний үндсэн дээр шийдвэр гаргах, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, системийн эрсдэлийг урьдчилан тооцсон урт хугацааны хөгжлийн стратеги бий болгоход анхаарч ажилладаг бөгөөд энэ дагуу хийсэн судалгааны ажлуудаа та бүхэнд цувралаар хүргэсээр дөрөв дэх жилээ золгож байна.

Энэ удаагийн товхимолд инновацын хаб, хамтын санхүүжилт болон инсуртекийн судалгаа мөн үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулдаг хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчин, хадгаламж, зээлийн хоршооны хуулийн шинэчилсэн найруулгад тусгах хадгаламж хамгаалал болон тогтворжилтын сангийн тухай, үнэт металл болон үнэт эдлэлийн арилжаа эрхлэгчдийн эрхзүйн орчин зэрэг судалгааны ажлууд багтлаа. Эдгээр судалгаа нь цаг үеийн онцлог болон тулгамдаж буй асуудлыг хөндсөн бөгөөд уншигч таны ажил үйлсэд хувь нэмэр оруулж бодлогын шийдвэр гаргахад үндэслэл, харгалзах хүчин зүйл болно гэдэгт итгэлтэй байна.

Эцэст нь судалгааны талаарх санал, дүгнэлтээ Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлбэл бид талархаж, үнэтэй саналыг тань дараа, дараагийн судалгааны ажилдаа тусгах болно.

Хүндэтгэсэн,

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

СУДАЛГААНЫ ТОВХИМОЛ №4–г Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газраас эрхлэн гаргав.

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурь бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

01	ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖ БА ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖААГ БИЙ БОЛГОХ НЬ	7
02	ББСБ-ЫН ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГА	40
03	ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СИСТЕМИЙН ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ НЬ	74
04	ФИНТЕК ИННОВАЦЫН ХАБ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА	100
05	ТОГТВОРЖИЛТЫН САН БОЛОН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА	149
06	ХАМТЫН САНХҮҮЖИЛТ БОЛОН P2P ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ	214
07	ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭЛ, САНГИЙН ЭРХЗҮЙН ОРЧИН	256
08	ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ, ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ЭРХЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА	278
09	ИНСУРТЕКИЙН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД	314

# 1

## ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖ БА ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН АРИЛЖААГ БИЙ БОЛГОХ НЬ

Гүйцэтгэсэн: Н.Нарантуяа<sup>1</sup>  
Х.Нинжбадгар<sup>2</sup>  
А.Бямбажаргал<sup>3</sup>

<sup>1</sup> СЗХ, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт email: [narantuya@frc.mn](mailto:narantuya@frc.mn)

<sup>2</sup> СЗХ, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн email: [ninjbadgar@frc.mn](mailto:ninjbadgar@frc.mn)

<sup>3</sup> “Үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийн Клиринг эрсдэлийн удирдлагын албаны ахлах мэргэжилтэн

## ХУРААНГУЙ

Хөрөнгийн зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эхлүүлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, эрхзүйн орчин болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг явуулах гэрээний стандарт, эрхзүйн орчныг бүрдүүлэхэд энэхүү судалгааны зорилго оршино.

*Түлхүүр үгс: Түүхий эд, фьючерс, таваарын бирж, агуулах, тээвэрлэлт*

*JEL ангилал: L510, L520, K220*

I.	УДИРТГАЛ	9
II.	ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ, ОРОЛЦОГЧИД	10
	2.1. Энэтхэгийн таваарын бирж	14
	2.2 Этиопын таваарын бирж	20
III.	САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛИЙН ГЭРЭЭ	27
	3.1 Түүхий эдийн үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний загвар гаргах зарчмууд (contract design principles)	27
	3.2 Олон улсын своп, деривативын холбоо (isda)–ны мастер гэрээ	29
	3.3 Далианы түүхий эдийн биржийн нүүрсний арилжаа	32
IV.	САНАЛ, ДҮГНЭЛТ	33
	Хавсралт	34
	Ашигласан материал	39
	<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b>	
	Зураг 1. Түүхий эдийн арилжааны бүтэц	10
	Зураг 2. Фьючерсийн зах зээлийн үндсэн зураглал	12
	Зураг 3. Энэтхэгийн түүхий эдийн биржээр арилждаг бүтээгдэхүүн	15
	Зураг 4. Энэтхэгийн түүхий эдийн биржийн төлбөр тооцооны схем	16
	Зураг 5. Түүхий эдийг хүргэх процесс	18
	Зураг 6. Этиопын түүхий эдийн зах зээлийн бүтэц	21
	<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b>	
	Хүснэгт 1. Гэрээний хугацаа дуусах тухай мэдээлэл	17
	Хүснэгт 2. Далианы түүхий эдийн биржийн коксжих нүүрсний фьючерсийн гэрээ (jm2304–өөс өмнөх коксжих нүүрсний гэрээнд хамаарна)	32
	<b>ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ</b>	
	Хавсралт 1. Далианы түүхий эдийн биржийн коксжих нүүрсний нийлүүлэлтийн чанарын стандарт (f/dce jm001–2018) jm2304–өөс өмнөх гэрээнд хамаарна	34
	Хавсралт 2. Далианы түүхий эдийн биржийн коксжих нүүрсний нийлүүлэлтийн чанарын стандарт (f/dce jm003–2022) jm2304 болон түүний дараагийн гэрээнд хамаарна.	36

## I. УДИРТГАЛ

Түүхий эдийн арилжаа нь бартерын системээс спот зах зээл рүү үүсмэл хөрөнгийн зах зээл хүртэл олон зууны турш хөгжиж ирсэн. Түүхий эдийн фьючерсийн арилжаа Японд эхэлсэн бөгөөд Осака хотод будааны бирж 1730 онд хамгийн анхны зохицуулалттай фьючерс зах зээлийг байгуулжээ. Улмаар 1848, 1877 онд АНУ-д Чикагогийн худалдааны төв (CBOT), Лондоны металлын бирж (LME) тус тус үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Дараагийн хэдэн арван жилд Аргентин, Хятад, Египет, Орос, Унгар, Турк, Энэтхэг зэрэг дэлхийн улс орнуудад илүү олон арилжаа бий болсон. 1990-ээд оноос хойш зах зээлийн зохицуулалт, мэдээллийн технологийн гайхалтай хөгжлийн үр дүнд түүхий эдийн биржүүд дэлхий даяар хөгжиж эхэлсэн.

Манайд Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталж, 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс тус хуулийг мөрдөж эхлэх шийдвэр гарснаар уг бирж эхлэх эрхзүйн орчин бүрдлээ. Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжих эрхзүйн орчин үүссэнтэй холбоотой олон улсын стандартад нийцсэн санхүүгийн үүсмэл хэрэгслийг арилжих, тухайн бүтээгдэхүүнийг стандарт хангасан агуулахад хадгалж, тээвэрлэх байдлаар худалдан авагчид чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг хүргэх шат дамжлагуудыг бий болгох хэрэгцээ шаардлага

бий болсон. Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжсанаар худалдан авагчийн итгэлийг нэмэгдүүлэх, гадаадын олон улсаас арилжаанд оролцох, мэдээллийн ил тод байдал сайжрах давуу талуудтай.

Нөгөө талаасаа бирж оролцогч талуудыг хооронд нь зуучилж, тэдгээрийн худалдах, худалдан авах үйл ажиллагаанд итгэл олгож байгаа тул эрсдэлийг удирдах сайн механизм байх шаардлагатай. Иймээс үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний стандартыг хангах, төлбөр тооцооны эрсдэлийг удирдах, агуулах, тээвэрлэлтийн удирдлагыг зөв хэрэгжүүлэх шаардлагатай.

Түүхий эдийн биржийн онцлог нь үүсмэл санхүүгийн хэрэгслийг худалдан, худалдан авч буй талууд нь цөөн тооны, их хэмжээгээр арилжаа хийдэг тул арилжаа нь хил дамнан хийгддэг онцлогтой тул олон улсын хэмжээнд, олон талууд ойлгогдохуйц байх шаардлага тавигддаг.

Энэхүү судалгаагаар түүхий эдийн биржийн арилжаа явагддаг үйл явц, оролцогч талуудыг зураглан, тэдгээрийн үүрэг, оролцоо судалж, жишээ болгон Энэтхэг болон Этиопын түүхий эдийн биржийн туршлагыг оруулсан.

Мөн үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээ боловсруулах талаар стандарт, загваруудын талаар тусгасан болно.



## II. ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ, ОРОЛЦОГЧИД


Худалдан авагч, худалдагч хоёрын хооронд бараа нийлүүлдэг тул таваарын зах зээл нь хөрөнгийн зах зээлээс ялгаатай. Гэрээний хугацаа дууссаны дараа бараа бүтээгдэхүүнийг худалдан авагч болон худалдагчийн хооронд биет байдлаар солилцдог нь агуулах, тээвэр, логистикийн дэд бүтэц, түүний удирдлагыг хэрэгжүүлдэг онцлогтой.

Түүхий эдийн арилжааны оролцогч талууд нь олон улсын хамарсан байдаг тул үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээ нь олон улсын стандартад нийцсэн, бүтээгдэхүүн тус бүрээр ялгаатай байдаг.

Түүхий эд нь гаргасан чанарын шаардлагын дагуу худалдан авагчид хүргэгдэх тул лабораториор түүхий эдийг шинжлүүлж, чанарыг тогтоолгох ба тодорхойлсон чанарыг алдагдуулахгүйн тулд агуулахад хадгалах, тээвэрлэх стандартыг бүтээгдэхүүн тус бүрээр бирж боловсруулан баталж, түүнийг нь зохицуулагч байгууллага батламжлах үүрэгтэй. Бирж түүхий эд тус бүрээр чанарын стандартыг боловсруулдаг байна.

Түүхий эдийн биржийн ажиллах процессыг дараах схемээр зураглалаа.

Зураг 1. Түүхий эдийн арилжааны бүтэц



Түүхий эд худалдан борлуулагч нь биржийн агуулахын үйлчилгээ үзүүлэгчид бараагаа хадгалуулах ба төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгүүлэн өмчлөх эрхээ бүртгүүлж, агуулахын баримт авна. Бирж арилжаа зохион байгуулахдаа худалдагч талын түүхий эдийн үлдэгдлийг, худалдан авагч талын маржин байршуулсан эсэхийг тулгаснаар захиалгыг хүлээн авна.

Худалдагч, худалдан авагч тал аль аль нь биржийн гишүүн брокероор дамжуулан биржид худалдан, худалдан авах захиалга өгнө.

Хэлцэл биелсний дараа клирингийн төв тооцоог гүйцэтгэх ба арилжаанд оролцогчдын аль нэг тал төлбөрөө төлөхгүй байх буюу холбоотой талуудын эрсдэл болон дефолтын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

Клирингийн төвөөс тооцооны мэдээлэл төлбөрийн банк болон агуулахын үйлчилгээ үзүүлэгчид илгээгдэх ба төлбөрийн банк төлбөрийг шилжүүлэх, агуулахын үйлчилгээ үзүүлэгч барааг ачуулах үүрэг хүлээнэ. Үүний дараа төвлөрсөн хадгаламжийн байгууллага өмчлөх эрхийг худалдан авагч талд шилжүүлнэ.

Түүхий эдийн бирж нь агуулахын үйлчилгээ үзүүлэгчдийн сонгон шалгаруулж гишүүнээр ажиллуулах ба шалгарсан агуулахууд нь түүхий эдээ биржээр дамжуулж арилжих худалдан борлуулагчдын бараа найдвартай, чанартай хадгалах үүрэг хүлээнэ.

Түүхий эдийг худалдан борлуулагч нь агуулахад бараагаа нийлүүлснээр төвлөрсөн хадгаламжийн байгууллага бүртгэж, өмчлөх эрхийг илэрхийлэх агуулахын баримт өгнө. Хэлцэл биелсний дараа худалдан авагч талаас төлбөр хийгдсэнээр түүхий эдийн өмчлөх эрх худалдан авагч талд шилжинэ.

Худалдагч тал түүхий эдийг тээвэрлэх явцад үүсэх эрсдэлээс хамгаалж даатгалд хамрагдаж болно.

Хэлцэл биелсэн барааг худалдагч талд хүргэхэд тээвэрлэлтийн компаниуд гишүүнчлэлд үндэслэн биржтэй хамтран ажилладаг. Барааг олон улсын арилжааны танхимаас гаргасан incoterm-ын шаардлагыг хангасан стандартчилагдсан контейнероор тээвэрлэдэг байна.

Бараа таваарын дериватив гэрээний арилжаа нь барааг хүргэх шаардлагын улмаас үнэ ханшийг зохиомлоор өсгөх эрсдэлд өртөмтгий байдаг. Иймд зах зээлийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал байдаг.

**Клирингийн төвийн үүрэг:** Бусад санхүүгийн зах зээлүүдтэй адил фьючерсийн зах зээлд харилцагчийг зах зээлд хандах боломж олгох, арилжаатай холбоотой төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг хэд хэдэн төрлийн зуучлагч нар байдаг. Ялангуяа фьючерсийн зах зээлд харилцагч, арилжааны байгууллага, клирингхаус нарын дунд зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг клирингийн байгууллага нь чухал ач холбогдолтой.

Клирингийн байгууллага буюу АНУ-д Future Commission Merchant (FCM), Европт клирингийн ерөнхий гишүүн гэж нэрлэгддэг байгууллага нь фьючерсийн зах зээлийн арилжаа, клирингийн циклд хэд хэдэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

- Харилцагчдад фьючерсийн арилжаа эрхлэх байгууллага, клирингхауст нэвтрэх эрх олгодог.
- Зах зээл болон харилцагчдыг хамгаалах зорилгоор өргөн хүрээний хяналт, шалгалтыг явуулдаг.
- Харилцагчдаас маржин цуглуулж, тэдний зах зээлийн гэрээний үүргийн




баталгааг гаргаж өгдөг.

- Клирингхаусын барьдаг дефолтын сангийн томоохон хэсгийг бүрдүүлдэг. Энэхүү сан нь дефолтын үеийн алдагдлыг хаах, зах зээлийн тогтвортой байдлыг хангах үүрэгтэй.

Эдийн засгийн болоод зах зээлийн стресст үед фьючерсийн зах зээлийн бат бөх, уян

хатан чанар нь танигдсан. 2008 оны санхүүгийн хямралын үеэр фьючерсийн зах зээлийн үйл ажиллагаа тогтвортой явсаар байсан. Фьючерсийн зах зээлийн стресст нөхцөл байдалд тэсвэртэй байгаа шалтгаан нь зах зээлд ажиллаж байгаа клирингийн байгууллагууд гэж үздэг.

## Зураг 2. Фьючерсийн зах зээлийн үндсэн зураглал



### Клирингийн гишүүн болон эрсдэлийн удирдлага:

Клирингийн тогтолцоонд учирч болох хамгийн том эрсдэл бол дефолт. Фьючерсийн гэрээний хөшүүрэг өндөр байдаг тул зах зээлийн гэнэтийн хөдөлгөөн их хэмжээний алдагдлыг үүсгэж болно. Клирингийн гишүүн нь клирингийн тогтолцоо болон зах зээлийн тогтвортой байдалд гол үүргийг гүйцэтгэдэг.

Клирингийн байгууллагын доголдол ховор тохиолддог ба үүнээс шалтгаалж харилцагчид алдагдал үүсэх тохиолдолд бүр ч ховор. Учир нь клирингийн байгууллагын харилцагчдад хийж буй төлбөрийн чадварын хяналт өндөр байдаг.

Клирингийн гишүүн харилцагчдынхаа гэрээний үүргийн хэрэгжилтийг батлан даадаг. Харилцагчийн эзэмшиж буй гэрээний позицод алдагдал үүсэх тохиолдол гардаг учир заавал батлан даах шаардлага үүснэ.

Хэрэв харилцагчийн маржин тухайн позицын шаардлагад хүрэлцэхгүй болсон тохиолдолд гэрээг хаах үед үүсэх аливаа алдагдлыг клирингийн гишүүн барагдуулна.

Бүтцийн үүднээс дүгнэн үзвэл клирингийн тогтолцоо нь хэсэглэсэн эрсдэлийн (compartmentalizing risk) нөлөөтэй. Нэг хэсгийн доголдол гэхээсээ илүү клирингийн систем нь клирингхаусын гишүүдийн эрсдэлийг нэгтгэн (mutualize) клирингхаус тэр чигтээ доголдохоос сэргийлдэг. Иймд клирингийн гишүүдийн санхүүгийн чадвар нь клирингхаусын найдвартай байдлыг хангадаг.

Олон улсын фьючерсийн зах зээлд клирингийн үйлчилгээ үзүүлдэг ICE Clear Europe байгууллагын эрсдэлийн удирдлагыг жишээ болгон авч үзлээ.

ICE Clear Europe-ийн эрсдэлийн удирдлагын бодлого нь хүчирхэг клирингийн зохицуулалт болон Клирингхаус, клирингийн гишүүдэд учирч болзошгүй эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахад төвлөрдөг. Дээрх зорилгын дагуу ICE Clear Europe цогц, шаталсан хамгаалалтын системийг хөгжүүлсэн. Үүнд:

Хамгаалалтын шугамууд:

- 1. Гишүүнчлэлийн шалгуур үзүүлэлт:** Клирингийн гишүүн бүр хангалттай хэмжээний санхүүгийн нөөц, үйл ажиллагааны бололцоо, эрсдэлийн удирдлагын туршлагатай байх.
- 2. Хувьсах маржины шаардлага:** Бүх нээлттэй позицууд өдөр бүр зах зээлийн үнийн дагуу явна. Позицын ашиг алдагдал (P&L) өдөр бүр гэрээнд заасан валютын дагуу төлөгдөнө (settled).
- 3. Өдөр тутмын хяналт, Маржин кол:** Клирингийн гишүүдийн позиц өдөр тутам хянагдана. Хувьсах маржины алдагдал эсвэл Анхдагч маржины шаардлагатай дүн өссөн тохиолдолд өдрийн дотор нэмэлт маржин шаардах.
- 4. Маржин шаардлага:** Клирингийн гишүүд нээлттэй позицод хамаарах анхдагч маржин байршуулах шаардлагатай. Анхдагч маржин нь зах зээлийн хэвийн нөхцөл байдалд Клирингийн гишүүн дефолт болсон тохиолдолд үүссэн алдагдлыг нөхөх зориулалттай байна.
- 5. ICE-ийн Анхдагч нөөц:** Өөрийн нөөцийг (skin-in-the-game) санд байршуулна.
- 6. Дефолтын даатгал:** ICE нь Клирингийн

гишүүдийн болон ICE-ийн дундын дефолтын сангаас давсан алдагдал үүссэн тохиолдолд ашиглах дефолтын даатгалтай байна.

- 7. Клирингийн гишүүний Баталгааны сан:** Зах зээлийн экстрим нөхцөл байдалд Клирингийн гишүүний анхдагч маржин алдагдлыг хаахад хангалтгүй болсон тохиолдолд алдагдлыг хаах тусдаа (separate) CDS болон F&O Баталгааны сантай байна.
- 8. Хуваарилалтын эрх мэдэл (Power of Assessment):** Клирингийн гишүүний дефолтын алдагдал Баталгааны сангийн хэмжээнээс давсан тохиолдолд хуваарилалтын эрх мэдлийн хүрээнд ICE бусад клирингийн гишүүдээс нэмэлт сан босгох эрх мэдэлтэй байна.
- 9. CCP Нөхөн сэргэлтийн механизм:** Олон дараалсан эсвэл том хэмжээний дефолтоос үүдэн Клирингхаусын нөөц шавхагдах үед хэрэгжүүлэх арга хэмжээ, бодлогыг тодорхойлох.

**Маржин тооцоолол:** Клирингхаус нь фьючерсийн гэрээний төрөл, онцлогоос шалтгаалан маржины аргачлал, моделийг боловсруулдаг. Түгээмэл ашиглагддаг маржин моделиуд нь түүхэн мэдээлэлд үндэслэдэг. Жишээ нь:

- Түүхэн симуляцийн арга
- Параметрик VaR
- Монте карло симуляци
- Стресс түүхийн симуляци гэх мэт.

Төвлөрсөн хадгаламжийн төв: ЕСХ нь бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдлыг баталгаажуулдаг төвлөрсөн хадгаламжийн



газар эсвэл агуулахын баримтын бүртгэлийг хөтөлдөг. ЕСХ-ийн агуулахад цахим бараа хүлээн авсан тухай мэдэгдэл нь ЕСХ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс Цахим агуулахын баримт олгох урьдчилсан нөхцөл юм. ЕСХ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь цахим агуулахын баримт гаргах, төлбөрийн баримтын хуулбарыг хэвлэх, эрхийн шилжүүлэг, баримтыг хүчингүй болгохыг хариуцдаг. ЕСХ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн сангаас гаргасан цахим агуулахын баримт нь хадгалуулсан барааны хууль ёсны эрхийг илэрхийлдэг. Цахим агуулахын баримтыг ЕСХ төвлөрсөн хадгаламжийн функцээр дамжуулан ЕСХ дээр шилжүүлж, тохиролцож болно. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь хадгаламж эзэмшигч бүрд тус тусад нь данс хөтөлдөг.

**Логистикийн удирдлага:** Логистик нь түүхий эдийн арилжаан дахь нийлүүлэлтийн гинжин хэлхээний чухал хэсэг ба нийлүүлэлтийн гинжин хэлхээ нь тээвэрлэлт, хүргэлт, хүлээн авах, хадгалалт, удирдлагыг багтаадаг. Нийлүүлэлтийн гинжин хэлхээний үүрэг нь яг цагт нь зөв газар, чанарын шаардлагын дагуу хүргэх.

**Тээвэрлэлт:** Түүхий эдийг төмөр замаар, усан онгоцоор болон ачааны машинаар тээвэрлэдэг ба стандартад нийцсэн контейнероор тээвэрлэх үүрэгтэй.

**Мөрдөн байцаах үйл ажиллагаа (enforcement):** АНУ-ын Бараа таваарын фьючерсийн хороо нь мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага бөгөөд анх зөвхөн АНУ-д мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулдаг байсан бол түүхий эдийн бараа, бүтээгдэхүүний арилжаатай холбоотой MENA-ийн бүс нутагт мөрдөн байцаах үйл ажиллагаа хийх болсон. Мөрдөн байцаах үйл ажиллагаа нь залилан, зах зээлийг урвуугаар ашиглах, хууль зөрчсөн үйлдэл, хэвийн бус арилжааг шалгадаг байна.

АНУ-ын Бараа таваарын фьючерсийн хороо нь мөрдөн байцаалт хийх мэдээлэл авах нээлттэй эх сурвалжтай ба АНУ-ын иргэншилгүй арилжаанд оролцогчдыг шалгах олон талуудтай (Dubai Financial Services Authority and the Financial Services Regulatory Authority of Abu Dhabi гэх мэт) харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан мэдээлэл авч ажилладаг.

## 2.1. ЭНЭТХЭГИЙН ТАВААРЫН БИРЖ

Энэтхэгт таваарын арилжаа 19 дүгээр зууны сүүлчээр үүссэн. Гэвч тусгаар тогтносны дараа янз бүрийн шалтгааны улмаас худалдааг зогсоосон. Зохион байгуулалттай, зохицуулалттай үндэсний хэмжээний таваарын биржүүд дараа нь 2003 онд Энэтхэгийн олон түүхий эдийн бирж (MCX) болон National

Commodity & Derivatives Exchange Limited (NCDEX)-ийг нэгтгэснээр бий болсон. Санхүүгийн зах зээлийг нэгтгэсний дараа Үндэсний хөрөнгийн бирж (ҮХБ) болон Бомбейн хөрөнгийн бирж (BSE) мөн өөрсдийн платформ дээр таваарын деривативыг санал болгож эхэлсэн.

Үндэсний хэмжээний онлайн таваарын арилжаа Энэтхэгт 2003 онд эхэлсэн. Арилжаалах боломжтой таваар нь гулдмай, эрчим хүч, үндсэн металл, хөдөө аж ахуй гэж ангилдаг. Энэтхэгийн томоохон түүхий эдийн биржүүд нь Энэтхэгийн олон түүхий эдийн бирж, Үндэсний түүхий эдийн бирж (NCDEX), Энэтхэгийн түүхий эдийн бирж (ICEX) юм. Үндэсний хөрөнгийн бирж (NSE)

болон Бомбей хөрөнгийн бирж (BSE) нь түүхий эдийн арилжааг санал болгодог. 2015.09.28-ны өдөр хуучин зохицуулагч Форвард зах зээлийн хороо (FMC) түүнд нэгдсэний дараа Энэтхэгийн Үнэт цаас, биржийн зөвлөл (SEBI) нь түүхий эдийн дериватив зах зээлийн зохицуулагч болсон.

**Зураг 3.** Энэтхэгийн түүхий эдийн биржээр арилждаг бүтээгдэхүүн



Эх сурвалж: ICIC

зээлийн хөрвөх чадвар, түүхий эдийн үйлдвэрлэл, улс төрийн мэдрэмж, нэгэн төрлийн шинж чанар, барааны дуусах хугацаа, хадгалалт, төрийн зохицуулалт, хяналт зэрэг үндсэн хүчин зүйлсийг авч үзсэний үндсэн дээр түүхий эдийн бирж бараа бүтээгдэхүүнээ зарладаг.

Түүхий эдийн биржид бүртгэлтэй бараа бүтээгдэхүүн нь зохицуулагч, тухайлбал SEBI-аас зөвшөөрөл авах ёстой. SEBI-аас батлагдсан гэрээний хуваарьт аливаа өөрчлөлт/цуцлах, арилжаанд хамрагдаагүй байгаа гэрээний хувьд SEBI-ийн зөвшөөрөл шаардлагатай. SEBI нь фьючерс арилжаа хийхийг зөвшөөрсөн 91 түүхий эдийг мэдэгдсэн.

Зах зээлд оролцогчдын (үйлдвэрлэгч, боловсруулагч, хэрэглэгч, худалдаачид гэх мэт) эрэлт, нийлүүлэлтийн динамик, үнийн тогтворгүй байдал, бараа материалын түвшин, хувьцааны ашиглалт, үнийн уян хатан байдал, түүхий эдийн зах



Зураг 4. Энэтхэгийн түүхий эдийн биржийн төлбөр тооцооны схем



Эх сурвалж: ICIC

#### Төлбөр тооцоо хийх үйл явц:

1. Түүхий эдийн биржүүд арилжааны дэлгэрэнгүй мэдээллийг клирингийн корпорацуудад бодит цаг хугацаанд дамжуулдаг
2. Худалдааны мэдээллийг хүлээн авсны дараа клирингийн корпорац/клирингийн төв нь арилжааны гишүүдэд хэлцлийн талаар мэдэгдэнэ.
3. Клирингийн гишүүд санхүүжилтийн хэлцэл, төлбөрийн талаар зөвлөгөө авдаг.
4. Клирингийн банкнуудад төлбөрөө төлөх хугацаандаа эх үүсвэрээ бэлэн болгохыг даалгадаг.
5. Гүйцэтгэсэн арилжааны хөрөнгийн төлбөрийг клирингийн гишүүдийн данснаас дебет хийж, клирингийн корпорацын дансанд төлөх ёстой мөнгөн дүнгээр клирингийн банкнуудаар хийдэг.
6. Төлбөрийг клирингийн корпорацын зааврын дагуу клирингийн банкнуудаар хийж, шаардлагатай бол клирингийн гишүүдийн дансанд шилжүүлдэг.

**Төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцож буй байгууллагууд:**

Энэтхэгийн түүхий эдийн деривативын экосистемд клирингийн гишүүд, клирингийн корпорацууд, клирингийн банкнууд, кастодианы үйлчилгээ, агуулахын үйлчилгээ үзүүлэгч, цахим бүртгэлийн үйлчилгээ үзүүлэгч гэх мэт арилжаа, төлбөр тооцоо хийх олон төрлийн зуучлагчдыг хамардаг.

Хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус барааны хувьд худалдагчаас хүргэлтийг биелүүлээгүй тохиолдолд төлбөр тооцооны

үнийн дүнгийн 4% ба 3%–ийг нэмж солих зардлын торгууль ногдуулна. Худалдан авагч болон худалдагч хоёр биет барааг солилцохоор тохиролцсон тохиолдолд л биет хүргэлт явагдана.


Биржүүд нь гэрээний хугацаа дуусахаас тав хоногийн өмнө тендерийг хүргэх механизмтай байдаг. Тендерт хүргэх хугацаа эхлэхээс өмнө нээлттэй арилжаа явуулахгүй байхыг зөвшөөрдөг.

**Хүснэгт 1. Гэрээний хугацаа дуусах тухай мэдээлэл**

Таваар	Дуусах хугацаа
1 кг алт	Хугацаа дуусах сарын 5
Алт мини бяцхан /Gold mini/	Хугацаа дуусах сарын 5
Алтан Гвиней зоос /Gold Guinea/	Хугацаа дуусах сарын сүүлийн арилжааны өдөр
Алтан дэлбээ /Gold Petal/	Хугацаа дуусах сарын сүүлийн арилжааны өдөр
Мөнгө	Хугацаа дуусах сарын 5
Мөнгө мини /Silver Mini/	Хугацаа дуусах сарын сүүлийн арилжааны өдөр
Мөнгөн микро	Хугацаа дуусах сарын сүүлийн арилжааны өдөр
Газрын тос	Хугацаа дуусах сарын 19
Байгалийн хий	Хугацаа дуусах сарын 26
Хөнгөн цагаан	Хугацаа дуусах сарын сүүлийн арилжааны өдөр
Зэс	Хугацаа дуусах сарын сүүлийн арилжааны өдөр
Хар тугалга	Хугацаа дуусах сарын сүүлийн арилжааны өдөр
Никель	Хугацаа дуусах сарын сүүлийн арилжааны өдөр
Цайр	Хугацаа дуусах сарын сүүлийн арилжааны өдөр



Зураг 5. Түүхий эдийг хүргэх процесс



Эх сурвалж: ICIC

Худалдан авагч болон худалдагчийн амлалтыг баталгаажуулж, хүргэх явцад алдаа гарахаас зайлсхийхийн тулд тендерийн хугацаанд нэмэлт маржин шаардлагатай.

Урамшуулал/хөнгөлөлт: Энэтхэгийн бирж дээр арилжаалагддаг бараа бүтээгдэхүүн нь нийлүүлэх боломжтой гэрээ байдаг тул биет бараа солилцоход эдгээр барааны чанар маш чухал байдаг. Гэрээг боловсруулахдаа биржүүд хүлээн зөвшөөрөгдсөн чанарын стандартыг зааж өгдөг. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтүүдийг өвөрмөц байдлаар хадгалдаг.

Гэсэн хэдий ч байгалийн гаралтай түүхий эдийг хадгалах нь маш хэцүү байдаг. Гулдмай болон металлын чанарын үзүүлэлтүүд үргэлж ижил хэвээр байна. Гэсэн хэдий ч Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар олон хүчин зүйлээс шалтгаалж өөр өөр байдаг. Ийм тохиолдолд бирж нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанарын урамшуулал, хөнгөлөлтийг үзүүлдэг. Бүтээгдэхүүний чанар нь гэрээнд заасан үзүүлэлтээс давсан бол өндөр үнээр авах бөгөөд хэрэв чанар нь гэрээний үзүүлэлтээс доогуур боловч хүлээн зөвшөөрөгдсөн хязгаарт багтсан бол хөнгөлөлттэй үнээр тооцно.

Доорх нь урамшуулал болон хөнгөлөлтийн тооцооны жишээ:

Урамшуулал: Кастор үрийн фьючерсийг NCDEX дээр арилжаалах боломжтой. Түүний чанар нь

газрын тосны агууламжаас ихээхэн хамаардаг бөгөөд энэ нь 47% юм. 49%-ийн тосны агууламжтай касторын үрийг нийлүүлбэл 2%-ийн нэмэлт үнэ авах боломжтой.

Шимтгэлийн тооцоог дараах байдлаар үзүүлэв.

47% тос агуулсан касторын үрийн үнэ: Rs. Цин нь 7300

49% тос агуулсан касторын үрийн үнэ = Rs. 7,300 + (7,300 X 2%) = Rs. 7446

Хөнгөлөлт: МСХ хөвөн нь 8.5% чийгтэй хөвөнг шаардлага хангасанд тооцдог бөгөөд бирж 9.5% хүртэл чийгтэй хөвөнг хөнгөлөлттэй үнээр авдаг. Хөнгөлөлтийн тооцоог доор харуулав.

Хөвөнгийн үнэ = Rs. 37,000 – (37,000\*1%) = Rs. Нэг боодол нь 36,630.

**Хүргэлтийг биелүүлээгүй тохиолдолд торгууль ноогдуулах:**

Худалдагчийн хүргэлтийн хугацаа: Хэрэв худалдагч нь хүргэх зорилгоо илэрхийлсний дараа төлбөрөө төлж чадахгүй бол худалдагч нь хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүний хувьд төлбөр тооцооны үнийн дүнгийн 4%, хөдөө аж ахуйн бус бараа бүтээгдэхүүний хувьд нөхөн төлбөрийн үнийн дүнгийн 3%, орлуулах зардлын 3%-ийг биржид төлөх ёстой.

Худалдан авагчийн хүргэлтийн хугацаа: Хэрэв худалдан авагч нь хүргэх хүсэлтэй байгаага илэрхийлсний дараа төлбөрөө төлөхгүй бол клирингийн корпорац өөрийн үзэмжээр төлбөрөө хүлээгээгүй тал буюу худалдагчийн учирсан хохирлыг хянан үзэх ёстой.

Төлөгдөөгүй талуудаас авах торгуулийг дараах байдлаар ноогдуулна.

1. 1.75–аас доошгүй хувийг клирингийн корпорацын Төлбөрийн баталгааны санд байршуулна.
2. Захиргааны зардалд 0.25 хүртэлх хувийг клирингийн корпорац хадгална.
3. Нөлөөлөлд өртсөн тал нь хөдөө аж ахуйн бус бараа бүтээгдэхүүний хувьд 1%, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд 2%, солих зардал нэмсэн тохиолдолд авдаг.



## 2.2 ЭТИОПЫН ТАВААРЫН БИРЖ

Этиопын таваарын биржийн гол суурь нь Этиопын газар тариалангийн экологи, үйлдвэрлэл, бүтээмжийг хөгжүүлэх чадвар дээр суурилдаг. Тариаланчид өөрсдийн үйлдвэрлэлээс шууд ашиг хүртдэггүй идэвхгүй байсан тогтолцоог Этиопын таваарын бирж олон улсын туршлагыг хөгжүүлж Африкийн орнуудын бараа таваарын худалдах орчин үеийн худалдааны төв болгож чадсан.

Этиопын таваарын бирж (ECX) нь Этиоп улсын хувьд шинэ санаачилга бөгөөд Африкийн хамгийн анхны таваарын бирж ба зах зээлд оролцогчид, биржийн гишүүд болон түүний гол дэмжигч Этиоп улсын Засгийн газар хамтран байгуулсан. ECX нь бараа бүтээгдэхүүнийг боловсруулах, ангилах, хадгалах, бараа бүтээгдэхүүний арилжааны санал, тендерт нийцүүлэх, эрсдэлгүй төлбөр тооцоо, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, захиалагч хүлээн авах хүртэлх процессыг хянахаас гадна, таваарын аюулгүй байдал, тээвэрлэлт, хадгалалтад бүрэн хяналт тавьдаг. Мөн гүйлгээний төлбөр тооцоог эрсдэлгүй хийх, бараа хүргэлтийн системээр хангах чиг үүргийг хүлээдэг.

ECX нь зах зээлийн бүх оролцогчдод мэдээллийг шуурхай байдлаар түгээх, худалдаа, агуулах, төлбөр тооцоо, хүргэлт, бизнесийн үйл ажиллагааны тодорхой дүрэм журам, маргааныг дотооддоо шийдвэрлэх механизмаар дамжуулан итгэлцэл, ил тод байдлыг бий болгодог. ECX нь зах зээлийн нэгдмэл байдлыг бүтээгдэхүүн ба гүйлгээний бүрэн бүтэн байдал, зах зээлд оролцогчдын шударга байдал гэсэн гурван чухал түвшинд хангадаг.

ECX-ийн байгууллага нь No550/2007 журам дээр үндэслэдэг. Энэхүү журам нь ECX-д бүхий л үйл ажиллагаанд удирдлага болгодог. Этиопын таваарын биржийн удирдах газар (ECEA) нь ECX-ийн зохицуулах байгууллага болох 551/2007 журмаар байгуулагдсан.

Этиопын Түүхий эдийн биржийн газар нь биржийн оролцогчдыг (Гишүүд ба тэдгээрийн төлөөлөгчдийг) хүлээн зөвшөөрөх, хяналт тавих, Клирингийн байгууллагуудыг (дотоодын банкнууд болон төлбөр тооцооны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхэлдэг бусад санхүүгийн байгууллагууд) хүлээн зөвшөөрөх, хяналт тавих эрх, үүрэгтэй. Биржийн дүрэм, биржээр арилжаалагдах гэрээний зохицуулалт, түүнчлэн хөрөнгө оруулалтын зөвлөхүүд, зөвлөх компаниуд, хууль эрх зүйн туршлага, нягтлан бодох бүртгэл, аудитын мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны зохицуулалт нь ECX чиг үүрэгтэй холбоотой байдаг. Мөн /Этиопын таваарын биржийн удирдлага/ ECEA нь хууль бус үйлдлүүдийг шалгаж, өөрийн харьяалалд хамаарах хэргийг шийдвэрлэх эсвэл эрүүгийн хэргийг зохих шүүхэд шилжүүлэх эрхтэй.

ECX нь 2008 онд Засгийн газраас гаргасан төсөв, олон улсын байгууллагуудын мөнгөн дэмжлэгээр байгуулагдаж 5 жилийн дараа орлогоороо бизнесээ явуулж эхэлсэн. Байгууллагын зорилго нь орчин үеийн технологид суурилсан барааны агуулах барих, удирдах, орж ирж буй барааг хүлээн авах, ангилах, жинлэх, байршуулах, агуулахын баримт олгох, бараа хүргэх, үр ашигтай, төвлөрсөн, автоматжуулсан агуулахын баримтын системийг бий болгож, хэрэгжүүлэх байв.


Бусад орны туршлагаас үзэхэд агуулахын үйлчилгээг хувийн компани, аж ахуйн нэгжүүдээр дамжуулан хариуцахаар төлөвлөж байсан ч Этиоп улсад сайн зохион байгуулалттай чадавх байхгүй байсан. ECX орчин үеийн, үр ашигтай агуулахын системийг бий болгох таатай орчныг бүрдүүлэхийн тулд Этиопын хөдөө аж ахуйн Барааны агуулахын үйлчилгээний аж ахуйн нэгж /EACWSE/ нь төрийн байгууллагын бизнесийн фирм хэлбэрээр байгуулагдсан.

Түүнээс хойш ECX болон EACWSE биржийн арилжааны бараа хүлээн авах – арилжих –

клирингийн төлбөр тооцооны үйл ажиллагааг хамтран гүйцэтгэж эхэлсэн. Үүний дараа Паве, Данша салбаруудыг байгуулж, агуулахын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.

2017 онд кофены худалдааны шинэ системд гарсан өөрчлөлтүүдийн нэг нь EACWSE-г татан буулгаж, ECX-д нэгтгэснээр үр ашигтай, үр дүнтэй арилжаа хийх боломжтой болсон. Этиопын таваарын бирж нь төв оффис болон 22 салбараараа 10 жилийн турш орчин үеийн арилжааны үйлчилгээг үзүүлж байна.

**Зураг 6.** Этиопын түүхий эдийн зах зээлийн бүтэц





Бирж дээр арилжаалагддаг түүхий эдийн жагсаалт:

» Кофе
» Гүнжидийн үр
» Улаан шош
» Цагаан шош /цагаан бөөрний шош/
» Ногоон шош /вандуй/
» Ангаахай шош /chickpeas/
» Шар буурцаг
» Улаан буудай
» Эрдэнэ шиш
» Пинто шош / алаг шош/
» Тагтааны вандуй /white pigeon pea/

**Биржийн үйлчлүүлэгчийн эрх, үүрэг:** Үйлчлүүлэгчийг Зуучлагч гишүүн (IM) эсвэл Хязгаарлагдмал хариуцлагатай зуучлагч гишүүнээр дамжуулан төлөөлж болно. Биржийн үйлчлүүлэгч нь биржээс санал болгож буй бүх барааг худалдан авах, борлуулах боломжтой. Үйлчлүүлэгч нь арилжааны гэрээг хүчингүйд тооцох, цуцлах талаар зуучлагч гишүүний гаргасан аливаа нэхэмжлэл, санал зөрөлдөөн, маргаантай тохиолдолд биржийн Арбитрын шүүхэд хандах эрхтэй.

**Үйлчлүүлэгчийн журам:** Оролцогч болон Харилцагчийн хоорондын харилцаа маш нууц байдаг ч Бирж нь үйлчлүүлэгчээ хамгаалж, систем хүн бүрд саадгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг. Үйлчлүүлэгчээ мэдэх (Know Your Client) тодорхой журмын дагуу ажилладаг. Үйлчлүүлэгч гишүүнээр дамжуулан арилжаа хийхээр бүртгүүлэх үед тухайн биржийн салбар эсвэл төв байранд өөрийгөө танилцуулж Гишүүн-Хэрэглэгчийн гэрээнд (Member –Client

Agreement) гарын үсэг зурах ёстой. Гишүүн Гишүүн-Хэрэглэгчийн гэрээг (Member – Client Agreement) Биржид ирүүлэх ёстой. Мөн үйлчлүүлэгч Биржид дараах мэдээллийг өгөх ёстой. Үүнд:

- Хоршоо, жижиг фермерийн үйлчлүүлэгчдээс бусад нь хүчин төгөлдөр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл;
- Татварын дугаар;
- НӨАТ-ын бүртгэл (хэрэв байгаа бол);
- Ерөнхий менежерийн үнэмлэх, хэрэв Гишүүн-Хэрэглэгчийн гэрээнд (Member –Client Agreement) төлөөлөгч гарын үсэг зурсан байх ёстой бол төлөөлөгчийн бичиг.

Дээрх шаардлагуудаас гадна

- PLC эсвэл хувьцаат компанийн үйлчлүүлэгчдийн хувьд санамж бичиг, үндсэн дүрэм;
- Хоршооны үйлчлүүлэгчдийн бүртгэлийн гэрчилгээ;
- Жижиг тариаланчдын хувьд тухайн тариачны өөрийн ферм дээр тухайн багцыг харуулсан холбогдох эрх бүхий байгууллагаас бичсэн захидал;
- Гишүүнээр дамжуулан ажиллаж буй үйлчлүүлэгчийн хувьд гишүүний зуучлалын төлбөрийг хоёр тал харилцан тохиролцдог боловч гүйлгээний үнийн дүнгийн 2 хувиас хэтрэхгүй.

**Сертификат шалгалт:** Бүх боломжит гишүүд/ NMDTs болон тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгчид ЕСХ-ийн сургалтад хамрагдаж, 70/100-аас доошгүй оноо авсан гэрчилгээ олгох шалгалтад тэнцсэн байх ёстой.

ЕСЕА-ийн эрх мэдэл, үүрэг нь биржийн гишүүдийг (Гишүүд/NMDTs ба тэдгээрийн төлөөлөгчид) хүлээн зөвшөөрөх, хянах, клирингийн байгууллагуудыг хүлээн зөвшөөрөх, хяналт тавих (төлбөр тооцоо, төлбөр тооцоонд оролцдог орон нутгийн банкууд эсвэл бусад санхүүгийн байгууллагууд), стандартын хэрэгжилтэд хяналт тавих зэрэгт хамаарна. Биржийн дүрэм, биржийн гэрээ, түүнчлэн ЕСХ-ийн бизнестэй холбоотой байдаг тул хөрөнгө оруулалтын зөвлөхүүд, зөвлөх компаниуд, хуульч, нягтлан бодох бүртгэл, аудитын мэргэжилтнүүдийн зан үйлийг зохицуулдаг. Нэмж дурдахад, ЕСЕА нь өөрийн харьяаллын хүрээнд гэмт хэргийг шалгаж, хэргийг шийдвэрлэх эсвэл эрүүгийн хэргийг зохих шүүхэд шилжүүлэх эрхтэй.

Биржийн оролцогчдын холбоо: ЕСХ-ийн корпорацийн боловсрол, зохицуулагчийг хөгжүүлэхийн зэрэгцээ Үндэсний биржийн гишүүдийн холбоо (NEAA) нь ЕСХ экосистемд чухал үүрэг гүйцэтгэдэг. Дэлхийн шилдэг туршлагын дагуу гишүүд болон тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгчид NEAA-д оролцох ёстой бөгөөд энэ нь солилцооны бүх оролцогчдын шударга байдал, мэргэжлийн ур чадвар, стандартыг хангах, хадгалах зорилгоор эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрсөн байгууллага юм.

NEAA нь солилцоонд оролцогчдын мэдээллийн санг хөтөлж, хөгжлийг хариуцна:

1. Бүтээгдэхүүний маркетинг, ЕСХ дүрмийн сургалтын стандарт, ур чадварын шалгалт;
2. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн стандарт, худалдааны үйл ажиллагааг зохицуулдаг ЕСХ-ийн холбогдох дүрэм, удирдамжид нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах

зорилгоор гишүүдэд зориулсан бие даасан аудитын хөтөлбөрүүд;

3. Бирж, биржийн гишүүдийн эсрэг үйлчлүүлэгч болон бусад этгээдээс гаргасан гомдлын олон нийтийн мэдээллийн сан;
4. Хэвлэл мэдээлэл, улс төрчид, оролцогч талууд, оюутнууд болон бусад хүмүүст түүхий эдийн биржийн талаарх олон нийтийн боловсрол, мэдээлэл;
5. Биржийн оролцогчдын өмнөөс өмгөөлөл хийх

Этиопын таваарын бирж нь энгийн болон хязгаарлагдмал гишүүд гэсэн хоёр төрлийн гишүүнтэй. Хоёр төрлийн гишүүнчлэл одоогоор хаалттай байна.

ЕСХ гишүүд нь арилжааны гол оролцогчид юм. Гишүүнчлэл нь бирж дээр арилжаа хийх байнгын бөгөөд шилжүүлж болох эрх юм. Гишүүнчлэлд тавигдах шаардлагыг хангасан аливаа хүн, компани, төрийн өмчит үйлдвэр, хоршоо гишүүн байж болно. Гишүүд ЕСХ-ийн Удирдах зөвлөлийн 5 гишүүнийг сонгох эрхтэй тул ЕСХ-ийн засаглалыг хэрэгжүүлэх эрхтэй. Гишүүнчлэл эзэмшигчид эсвэл гишүүд Биржийн дүрмийг дагаж мөрдөх шаардлагатай бөгөөд ингэснээр ЕСХ зах зээлийн бүрэн бүтэн байдлыг хадгалах ёстой. Гишүүд ЕСХ-ээр дамжуулан хийсэн гүйлгээгээ хариуцна.

Биржийн үйл ажиллагаа

- Агуулах ба чанар
- Төвлөрсөн хадгаламж
- Арилжаа
- Төлбөр тооцоо
- Комплаинс /засаглал/



**Агуулах ба чанар:** ЕСХ нь барааг хүлээн авахаас эхлээд төрөл бүрээр нь борлуулах хүртэл стандарт, стандартын шаардлагад үндэслэн агуулахын нэгдсэн системийг үйлчлүүлэгчдэд санал болгодог. Манай улсын гол бүс нутгуудын ЭХХ-ны харьяа агуулахуудад бараагаа хадгалдаг. ЕСХ агуулахад хамгийн сүүлийн үеийн ангилах, жинлэх төхөөрөмж ашиглан барааг сонгож, жинлэж, ангилдаг. ЕСХ агуулахууд нь барааны цахим баримтыг гаргаж, гарын үсэг зурсан цаасан хуулбарыг үйлчлүүлэгч эсвэл түүний төлөөлөгчдөд өгнө. Цахим бараа хүлээн авах вексель нь шилжүүлэх боломжгүй бөгөөд хадгалуулсан барааны хууль ёсны өмчлөлийг төлөөлөхгүй. Хадгалуулагч нь хадгалуулсан барааны өмчлөлийг тогтоохын тулд ЕСХ Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөс гаргасан Цахим агуулахын баримтыг авах ёстой. Хадгалсан барааг дэлхийн бараа материалын менежментийн стандартын дагуу "эхлээд орсон, эхлээд гарах /First-In-First-Out/" зарчмаар, байгаль орчныг сайтар хянах зарчимд нийцүүлэн хадгалдаг. ЕСХ бараа материалын удирдлагын систем нь урьдчилан тогтоосон хадгалах хугацааны туршид барааны чанар, тоо хэмжээг баталгаажуулдаг. Мөн ЕСХ агуулахууд хадгаламжийн алдагдал, эвдрэлээс хамгаалахын тулд дээд зэргийн даатгалд хамрагдсан байдаг.

ЕСХ агуулахууд дараах үйлчилгээг үзүүлдэг.

- Агуулах бүрд ирж буй үр тариа, тосны үр, кофеноос ЕСХ стандартын дагуу ЕСХ-ээс нийлүүлсэн тоног төхөөрөмжөөр дээж авах, ангилах, жинлэх, баталгаажуулах;
- ЕСХ автоматжуулсан системд тохирсон электрон барааг жинлэх, хүлээн авах, гаргах
- Орж, гарч буй бараа, хувьцааны өдрийн мэдээг бүртгэх;
- Агуулахад бараа бүтээгдэхүүнтэй зөв харьцах (зохион байгуулалт, овоолго, хогийн савны дугаар, бараа материалын менежмент);
- ЕСХ болон бүсийн агуулахуудын хооронд хамгийн сүүлийн үеийн мэдээлэл солилцох тайлангийн систем ба формат;
- Хүлээн авсан бүтээгдэхүүний чанарыг хадгалах;
- Үр тариа, тосны үр, үр тарианы таваарт зориулсан стандартын шаардлага хангасан шуудай зардаг.

**Төвлөрсөн хадгаламж:** ЕСХ нь бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдлыг баталгаажуулдаг төвлөрсөн хадгаламжийн газар эсвэл агуулахын баримтын бүртгэлийг хөтөлдөг. ЕСХ-ийн агуулахад цахим бараа хүлээн авсан тухай мэдэгдэл нь ЕСХ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс Цахим агуулахын баримт олгох урьдчилсан нөхцөл юм. ЕСХ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь цахим агуулахын баримт гаргах, төлбөрийн баримтын хуулбарыг хэвлэх, эрхийн шилжүүлэг, баримтыг хүчингүй болгохыг хариуцдаг. ЕСХ Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн сангаас гаргасан цахим агуулахын баримт нь хадгалуулсан барааны хууль ёсны эрхийг илэрхийлдэг. Цахим агуулахын баримтыг ЕСХ төвлөрсөн хадгаламжийн функцээр дамжуулан ЕСХ дээр шилжүүлж, тохиролцож болно. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь хадгаламж эзэмшигч бүрд тус тусад нь данс хөтөлдөг. ЕСХ одоогоор ойрын ирээдүйд барьцаа хөрөнгийн санхүүжилт буюу бараа материалын санхүүжилт гэж нэрлэгддэг цахим агуулахын баримтыг ашиглахаар ажиллаж байна.

Биржийн төвлөрсөн хадгаламжийн төв нь дараах үйлчилгээг үзүүлдэг:

- Агуулахын цахим баримт үүсгэх;
- Цахим агуулахын баримтын шаардлагатай мэдээллийг засварлах;
- Шимтгэл төлөгчдийн бүртгэл хөтлөх;
- Бирж дээр арилжаалагдаж буй гэрээг эзэмшигчдийн хооронд Цахим агуулахын баримт шилжүүлэх замаар шийдвэрлэх;
- Цахим агуулахын баримтыг шилжүүлсний дараа хүргэлтийн мэдэгдэл гаргах;
- Агуулахын цахим баримтыг цуцлах;
- Бүртгэлийг өдөр бүр нэгтгэх.

**Худалдааны систем:** Стандартчилагдсан бүтээгдэхүүний ангилалд (гэрээ гэж нэрлэгддэг) стандартчилсан багцын хэмжээтэй гүйлгээний борлуулалт, худалдан авалтын захиалгыг Захиалгын хүсэлтэд бүртгэдэг. ЕСХ автоматжуулсан арын албаны систем нь борлуулалтыг баталгаажуулсан агуулахын баримт байгаа эсэх, эскроу дансанд худалдан авагчийн мөнгө байгаа эсэх, шаардлагатай тохиолдолд Оролцогч болон Үйлчлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээний хүчинтэй байдлыг баталгаажуулдаг. Энэхүү автомат эвлэрэл нь хэдхэн минут шаардагдах бөгөөд зах зээлийн бүх оролцогчид зах зээлд итгэх итгэлийг баталгаажуулах түлхүүр юм.

ЕСХ автоматжуулсан арын албаны систем нь борлуулалтыг баталгаажуулсан агуулахын баримт байгаа эсэх, хадгаламжийн дансанд худалдан авагчийн мөнгө байгаа эсэх, шаардлагатай тохиолдолд Гишүүн-Үйлчлүүлэгчийн гэрээний хүчинтэй байдлыг баталгаажуулдаг.

**Төлбөр тооцоо:** ЕСХ-ийн zero default төлбөр тооцооны хэлтэс нь хурдан бөгөөд үр ашигтай бүх оролцогчдын арилжааны төлбөр тооцооны төв (ССР) эрсдэлийг хариуцдаг.

Энэ нь гишүүн бүрийн цэвэр үүргийг тогтоож, гишүүдэд өдөр тутмын цэвэр үүргийн талаар мэдээлэх, гишүүдийн хооронд мөнгө, эд хөрөнгийг бараагаар шилжүүлдэг. Биржийн Төвлөрсөн Хадгаламжийн Төв гүйлгээ хийснээс хойш дараагийн өдөр бүр хөрөнгийн эрх шилжүүлэхдээ барааны өмчлөлийг эхлээд шилжүүлдэг.

Төлбөрийн дансны үлдэгдлийн лавлагаа

» Арилжааны өдрийн 10:00 цаг  
(үдээс хойших арилжаанд зориулагдсан)

» Арилжааны өмнөх өдрийн 16:00 (Т-1)

» Гишүүний төлбөр (ЕСХ руу)

» Дараагийн ажлын өдөр 08:00–09:00 (Т+1)

» Гишүүний төлбөр (ЕСХ-с)

» Дараагийн ажлын өдөр 11:00–12:00 (Т+1)

**Банкнуд ба салбарууд:** Одоогоор ЕСХ нь арван зургаан төлбөр тооцооны банктай хамтран ажиллаж байна. Эдгээр банкнуд төв оффистоо ЕСХ төлбөр тооцооны багийг тусгайлан ажиллуулдаг.

**Комплайнс /засаглал/:** Комплайнсын хэлтэс нь Биржийн дүрэм болон Биржийн үйл ажиллагаанд нөлөөлөх бусад холбогдох хууль тогтоомжийг боловсруулж мөрдүүлэх үүрэгтэй. Энэхүү өргөн хүрээтэй зорилгод хүрэхийн тулд Биржийн дүрэмд тодорхой эрх мэдэл бүхий дөрвөн тусдаа нэгжийг байгуулдаг.

Үүнд: (1) Дүрэм, журам; (2) Комплайнсын хяналт, шалгалт; (3) Сахилга бат ба хэрэгжилт; (4) Арбитрын шүүх.

Комплайнсын хэлтэс нь орон нутгийн болон олон улсын зохицуулалтын бүх байгууллагатай албан ёсны харилцаа холбоог бий болгож, Биржийн үйл ажиллагааг хэвийн, зөв зохистой



явуулах талаар Биржийн салбар нэгжүүдэд хууль зүйн ерөнхий зөвлөгөө өгдөг.

Дүрэм, журмын нэгж: Биржийн дүрмийн төслийг боловсруулах үүрэгтэй шинэ дүрэм, журам гаргах шаардлагатай зохицуулалтын асуудлын судалгаа, дүн шинжилгээ; гишүүд, үйлчлүүлэгчид болон бусад сонирхогч талуудаас хүлээн авсан санал хүсэлтийг үндэслэн одоо мөрдөж буй дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон биржийн дүрмийн тайлбар гаргадаг.

Комплайнсын хяналт–шинжилгээ, мөрдөн шалгах алба: Биржийн холбогдох хууль тогтоомж, Биржийн дүрэм, бодлого, Этиопын таваарын биржийн газрын удирдамжийг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй. Биржийн үйл ажиллагааг жигдрүүлэх; биржийн дүрэм, эрх бүхий байгууллагын удирдамж болон бусад холбогдох хууль тогтоомжийн зөрчлийн шалгалтыг явуулж, зохицуулах. Бирж болон тус газрын холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгах, гишүүдтэй газар дээр нь танилцах, гишүүдийн дэвтэр, дансыг шалгах, гишүүдийн жилийн үйл ажиллагаанд

хяналт, шалгалт хийх үүрэгтэй. Мөн гишүүдийн жилийн болон бусад тогтмол дагаж мөрдөх тайлангуудад хяналт тавьдаг.

Сахилга бат, хэрэгжүүлэлтийн алба: Сахилгын дүрмийг хэрэгжүүлэх механизмаар дамжуулан Биржийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцдаг. Биржийн зах зээлийн хяналтын (market surveillance) механизмын бүрэн бүтэн байдлыг хамгаалахын тулд эрх бүхий байгууллага болон холбогдох хууль сахиулах байгууллагуудтай нягт хамтран ажилладаг.

Арбитрын шүүх: Бирж дээр арилжаа хийх явцад Гишүүд эсвэл Гишүүд болон Бирж хоорондын маргааныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Бирж нь маргаан шийдвэрлэх хоёр төрлийн өөр механизмтай: (1) Мэргэжилтэн тодорхойлох: Бирж болон түүний гишүүдийн хоорондох чанарын маргааныг шийдвэрлэх зэрэглэлийн маргааныг шийдвэрлэх механизм, (2) Гишүүдийн хоорондын болон гишүүд болон тэдний үйлчлүүлэгчдийн хоорондын худалдааны маргаан.

### III. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛИЙН ГЭРЭЭ

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн гэрээг боловсруулах хоёр хувилбар байна. Эхнийх нь Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)–аас 2011 онд деривативын зах зээлийг зохицуулах зарчмуудыг гаргасан. Үүнд:

1. Түүхий эдийн деривативын гэрээний загвар гаргах зарчмууд – Contract design principles
2. Түүхий эдийн деривативын зах зээлийн хяналтын зарчмууд –
3. Түүхий эдийн деривативын зах зээлд үүссэн зөрчлийг шийдвэрлэх зарчмууд – Principles to address disorderly commodity derivatives markets

4. Хууль сахиулах, мэдээлэл хуваалцах зарчмууд – Principles for Enforcement and information sharing

5. Түүхий эдийн деривативын зах зээлд үнийг тогтоох үйл явцыг эрчимжүүлэх зарчмууд – Principles for enhancing price discovery on commodity derivatives markets

Дээрх зарчмуудаас Түүхий эдийн деривативын гэрээний загвар гаргах зарчмуудад тусгасан зөвлөмжүүдийг даган гэрээг боловсруулах.

Хоёр дахь нь Олон улсын своп, деривативын холбоо (ISDA)–нд гишүүнээр элсэж, гэрээний загварыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.

#### 3.1 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР ГАРГАХ ЗАРЧМУУД (CONTRACT DESIGN PRINCIPLES)

Бараа таваарын деривативын гэрээ оролцогч талуудад ойлгогдохуйц байхын тулд олон улсын стандартыг хангасан гэрээний загвартай байх. Түүнчлэн гэрээнд эрсдэл болон зах зээлийн хэлбэлзлээс үүсэх аюулуудыг

удирдах зохицуулалтыг тусгадаг. Иймд гэрээний загварыг зохицуулагч байгууллагаас хянаж, баталдаг байх зохицуулалтыг журамд оруулах.



## ТҮҮХИЙ ЭДИЙН ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН ГЭРЭЭНИЙ ЗАГВАРЫН ЗАРЧМУУД

### Зарчим 1. Ил тод байх

Зохицуулагч байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг загварчлах шалгуурыг гаргах. Зохицуулагч байгууллагууд нь байнгын комплайнс, зохицуулалтын стандартыг ил тод тайлагнадаг байх.

### Зарчим 2: Эдийн засгийн хангамж

Зохицуулагч нь боломжит хэрэглэгчдийн эрсдэлийн удирдлагын хэрэгцээг хангах, гэрээний төрлийг ил тод байлгах, батлах, хянах.

### Зарчим 3: Бараа таваарын зах зээлтэй хамааралтай байдал

Гэрээний хугацаа болон нөхцөл нь гэрээ дуусах үеийн бүтээгдэхүүний үнэ цэнтэй уялдсан байх.

Барааг хүргэх нөхцөлтэй гэрээнд тусгах зүйлс:

- Хүргэлтийн үнэлгээ
- Хүргэлтийн нэгжийн хэмжээ
- Хүргэлтийн хэрэгслүүд
- Хүргэлтийн явц
- Хүргэх цэг
- Хүргэх тээврийн хэрэгсэл
- Шалгалт болон эрх олгох явц
- Тээвэрлэлт болон хадгалалтын төлбөр
- Гэрээг хүргэх сар
- Хуулийн хэрэгжилт

### Зарчим 4: Үнэ ижил байх

Зарчим 5: Гэрээний хугацаа болон нөхцөл ил тод байх

Зарчим 6: Үнийн үнэлгээ дэх үнэ тайлагнах агентын үүрэг

Зарчим 7: Өгөгдөл болон мэдээллийн үүргийг нэмэгдүүлэх

Зарчим 8: Олон нийтэд мэдээлэх, ил тод байх

Зарчим 9: Биржийн бус зах зээлийн ил тод байдал

Зарчим 10: Зах зээлийн хяналтыг хийх зарчим

Зарчим 11: Мэдээллийг цуглуулах, шинжлэх, хянах

Зарчим 12: Мэдээлэл олж авах эрх

Зарчим 13: Хэлцлийн мэдээлэл цуглуулах

Зарчим 14: Позиц

Зарчим 15: Зах зээлд интервенц хийх

Зарчим 16: Зах зээл дэх гэнэтийн үйл явдлууд

Зарчим 17: Хувьсан өөрчлөгдөж буй практик нийцэл

Зарчим 18: Комплайнсын программ

Зарчим 19: Зах зээлийн дайралтад хариу үйлдэл тэсвэр

Зарчим 20: Зах зээлийн болон зах зээлийн бус оролцогчдод хууль эрхзүйн орчныг мөрдүүлэх

Зарчим 21: Мэдээлэл хуваалцах

Зарчим 22: Шууд нэвтрэлт

Зарчим 23: High frequency trading ба алгоритмик арилжааны үүрэг

Зарчим 24: Хөрөнгө оруулагчийн боловсролыг дээшлүүлэх

## 3.2 ОЛОН УЛСЫН СВОП, ДЕРИВАТИВЫН ХОЛБОО (ISDA)–НЫ МАСТЕР ГЭРЭЭ

ISDA–ийн анхны мастер гэрээ арилжааг стандартчилах зорилгоор 1985 онд гарсан. Гэрээ нь 1992 болон 2002 онд дахин шинэчлэгдсэн бөгөөд 2 гэрээг одоогоор хүчин төгөлдөр ашиглаж байна. ISDA–ийн мастер гэрээг дэлхийн томоохон банкууд хоорондоо болон үндэстэн дамнасан корпорацууд ашигладаг. ISDA–ийн мастер гэрээ нь дэлхийн орон бүрд хэрэглэгдэж буй хууль эрх зүйн зөрүүтэй байдал, стандарт хоорондын зөрүүг холбодог тул олон улсын түвшинд гэрээ байгуулахад түлхүү ашигладаг.

### Мастер гэрээний давуу тал

ISDA мастер гэрээ нь талууд гарын үсэг зурсны дараа арилжааг баталгаажуулдаг баталгаат бичиг баримт юм. ISDA мастер гэрээ нь ил тод, ойлгомжтой байхаас гадна гэрээнд оролцогч хоёр талын хооронд хийгдэх бүх арилжаанд тавигдах стандарт нөхцөлүүдийг заасан тул арилжаа хийгдэх бүрд гэрээний нөхцөлүүдийн талаар дахин хэлэлцэх шаардлагагүй, арилжааг автоматаар хийж, талуудын цаг хугацаа, хуулийн төлбөрийг хэмнэдэг.

### Мастер гэрээний бүтэц

Хэдийгээр энэ нь ихэвчлэн банк, санхүүгийн байгууллагуудад зориулсан хэрэгсэл гэж үздэг ч мастер гэрээг олон улсын түвшинд өргөнөөр ашигладаг. Валютын болон хүүгийн своп зах зээл сүүлийн жилүүдэд гайхалтай өсөлтийг үзүүлж байна. Мастер гэрээгээр өдөр тутмын арилжаанд хэдэн их наяд долларыг бүрдүүлж байна.

Зээлийн дэмжлэгийн хавсралт (CSA credit support annex) нь зарим тохиолдолд мастер гэрээг дагалддаг. CSA нь холбогдох хоёр талдаа барьцаа хөрөнгө байршуулах шаардлагатай нөхцөлийг зааж өгснөөр зээлийн эрсдэлээ бууруулах боломжийг олгодог.

Ерөнхий гэрээ, хуваарь нь нөгөө тал цуцлах үйл явдал үүссэний улмаас талуудын аль нэг нь хамрагдсан гүйлгээг албадан хаах үндэслэлийг тодорхойлсон. Стандарт цуцлах үйл явдалд төлбөр төлөхгүй байх эсвэл дампуурал орно. Хуваарьт нэмж болох бусад дуусгавар болох үйл явдлуудад зээлийн зэрэглэлийг заасан түвшнээс доош бууруулах орно.

ISDA–ийн мастер гэрээ нь Их Британи эсвэл Нью–Йорк муж улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх эсэхийг тодорхойлдог. Түүнчлэн дуусгавар болсон тохиолдолд хамрагдсан бүх гүйлгээг үнэлэх, хаах, нягтлан бодох бүртгэлийн нөхцөлүүдийг тодорхойлсон.

Олон улсын своп ба деривативын нийгэмлэгээс гаргасан ISDA–ийн мастер гэрээ нь олон улсын хэмжээнд ОТС деривативын гүйлгээнд хамгийн өргөн хэрэглэгддэг үндсэн үйлчилгээний гэрээ юм. Энэ нь ОТС деривативуудыг бүрэн, уян хатан байдлаар баримтжуулахад зориулагдсан баримт бичгийн нэг хэсэг юм. Энэхүү хүрээ нь үндсэн гэрээ, хуваарь, баталгаажуулалт, тодорхойлолтын товхимол, зээлийн дэмжлэгийн баримт бичгээс бүрдэнэ.

### ISDA гишүүнчлэлийн давуу тал

- ✓ Туршлага судлах



ISDA-гийн гишүүг дэлхийн 1000 гаруй байгууллагаас салбарын шилдэг туршлагыг хөгжүүлэх, дэлхийн деривативын зах зээлийг эрсдэлгүй, үр ашигтай удирдахад стандартчилал бий болгох.

#### ✓ Хамтын ажиллагаа

ISDA нь дэлхийн хэмжээнд зохицуулагч байгууллага болон бодлого боловсруулагчидтай тасралтгүй хамтран ажилладаг. Хамтын ажиллагаагаар дамжуулан гишүүд эрсдэлийн удирдлагын хэрэгсэл болох деривативын орчны талаар зохицуулагч байгууллага, бодлого боловсруулагчидтай хамтран ажиллах боломжтой.

#### ✓ Мэдээлэлд ойр байх

Салбарын өөрчлөлтийн талаарх мэдээллийг цаг алдалгүй авах, мэдээллийг ашиглан өөрийн үйл ажиллагаатай уялдуулан шийдвэр гаргах гишүүнчлэлийн гол давуу тал юм.

ISDA Мастер гэрээ нь 30 гаруй жилийн турш дэлхийн деривативын зах зээлийн аюулгүй байдал, үр ашгийг нэмэгдүүлж ирсэн. ISDA-ийн мастер гэрээ болон баримт бичгийг боловсруулах явцад үүсэх эрсдэл, зээлийн болон хуулийн эрсдэлийг бууруулдаг.

ISDA гишүүн болсноор мастер гэрээ болон бусад бодлогын гол баримт, нийтлэлүүдийг онлайн аргаар авах боломжтой. Дэлхийн хаанаас ч хандах хамгийн хурдан, хялбар бөгөөд зардал багатай арга юм.

#### ✓ ISDA-аас хууль зүйн дүгнэлт авах

Зөвхөн ISDA-ийн гишүүд нь ISDA-ийн Мастер гэрээний нөхцөлийн хэрэгжилтийн талаарх Холбооны хууль зүйн дүгнэлтийг авах эрхтэй. 1992 оны ISDA Мастер гэрээ болон 2002 оны ISDA Мастер Гэрээний дуусгавар болгох,

хоёр талт хаалтын тооцоо болон олон салбарыг нэгтгэх заалтуудын хэрэгжилтийг хангах тухай дүгнэлтүүд. Эдгээр нь байгууллагуудад зээлийн эрсдэлийг үр дүнтэйгээр бууруулах, зохицуулалтын маржингийн цэвэр үндсэн дээр солилцож, олон улсын эрх зүйн хүрээнд хөрөнгийн шаардлагыг бууруулах боломжтой эсэхийг тодорхойлох боломжийг байгууллагуудад олгодог.

ISDA нь 50 гаруй өөр эрх мэдлийн ISDA зээлийн дэмжлэгийн баримт бичгийн талаар гишүүдэд хууль зүйн дүгнэлт өгдөг. Эдгээр барьцааны саналууд нь гишүүдэд ISDA Зээлийн дэмжлэгийн баримт бичгийн дагуу хийгдсэн барьцаа хөрөнгийн зохицуулалтын хүчин төгөлдөр байдал, хэрэгжилтийг хангахад тусалдаг. ISDA-ийн мастер гэрээний дагуу гүйлгээнд зээлийн дэмжлэг үзүүлэхдээ эдгээр баримт бичиг нь маржингийн зохицуулалтыг дагаж мөрдөх, хөрөнгийн зорилгоор барьцаа хөрөнгийн ашиг тусыг хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай шалгалтыг хөнгөвчилдөг.

Гишүүд Европын зах зээлийн дэд бүтцийн зохицуулалтын (EMIR) клиринг хийгээгүй своп хэлцлийн маржингийн дүрмийн дагуу бие даасан хууль эрх зүйн хяналтын шаардлагыг хангахын тулд ISDA-ийн нягтлан бодох бүртгэл болон барьцаа хөрөнгийн хэрэгжилтийн дүгнэлтэд хандах, найдах чадвар. Банкнууд болон бусад санхүүгийн байгууллагууд олон жилийн турш хөрөнгийн зорилгоор ISDA-ийн саналд тулгуурлаж ирсэн боловч одоо EMIR маржингийн дүрэм нь илүү өргөн хүрээний санхүүгийн эсрэг талуудад үйлчилдэг.

ISDA нь ISDA/FIA Cleared OTC Derivatives Addendum-тай холбоотой 45 гаруй клирингийн гишүүн болон үйлчлүүлэгчийн итгэлцлийн талаарх санал бодлыг ISDA-ийн Мастер гэрээтэй

хослуулан нийтэлсэн. Нэмэлт санал дүгнэлтийг захиалсан. Саналууд нь клирингийн гишүүн болон үйлчлүүлэгчийн байр сууринаас ISDA/FIA Client OTC Derivatives Antendum-ийн нягтлан бодох бүртгэл, тооцоо, үндсэн заалтуудын хэрэгжилтийг тус тус авч үздэг.

Нэмж дурдахад, ISDA болон FIA нь: (i) FIA-ISDA Cleared derivatives-ийн хавсралтын дагуу янз бүрийн хууль эрх зүйн хүрээнд өөрийн үйлчлүүлэгчидтэй тулгарах үед АНУ-д бүртгэлтэй фьючерсийн комиссын (FCM) хаах, нийлбэр тогтоох эрхийн хэрэгжилтийг хангах талаар санал дүгнэлтээ гаргаж, нийтэлдэг. суурь фьючерс болон опционы гэрээтэй; болон (ii) FIA-ISDA-ийн Cleared Derivatives-ийг ашиглах үед үйлчлүүлэгчид өөрсдийн FCM-тэй харьцуулах чадвар.

Нэмэлт, мөн клирингийн FCM загварыг дэмждэг гурван ХКН-ын эсрэг (CME, ICE and LCH). Ийм 20 гаруй санал нийтлэгдсэн бөгөөд нэмэлт санал дүгнэлтийг захиалсан байна.

ISDA нь CRR-ийн 305-р зүйлд заасны дагуу эрсдэлийн жинг хэрэглэхэд ISDA-ийн гишүүдэд туслах зорилгоор клирингийн холбоотой санал дүгнэлтүүдийг нийтэлсэн. Эрсдэлийн жинг бууруулахын тулд клирингийн гишүүний үйлчлүүлэгч хараат бус, бичгээр, үндэслэл бүхий хуулийн дүгнэлттэй байх ёстой. янз бүрийн холбогдох аж ахуйн нэгжийн харьяаллын хууль тогтоомжийн дагуу клирингийн гишүүн эсвэл клирингийн гишүүний аль нэг үйлчлүүлэгч төлбөрийн чадваргүй болсноос "ямар ч хохирол" хүлээх. Тиймээс 305-р зүйлийн 2-ын (с) саналууд нь гишүүдэд 305-р зүйлд заасан эрсдэлийн жинг хэрэглэхэд тусалдаг боловч тухайн байгууллага зөвшөөрөгдсөн эрсдэлийн жинг хэрэглэхээс өмнө хангасан байх ёстой хэд хэдэн нөхцөлийн зөвхөн нэг нь юм.

ISDA нь илүү олон эрх мэдэл, эсрэг талын төрөл болон цахим гэрээ гэх мэт бусад салбаруудыг багтаах үүднээс санал бодлоо өргөжүүлсээр байна. Саналуудыг тогтмол шинэчлэлтийн хамт зөвхөн ISDA-ийн гишүүдэд нээлттэй болгодог.

#### ✓ Industry profile

Нарийн төвөгтэй, эрсдэлд мэдрэмтгий, цаг үеийн асуудалд бүрэн оролцдог гэдгээрээ салбартаа нэр хүндээ хадгалах.

#### ✓ Хурал болон бусад салбарын арга хэмжээ

Дериватив болон эрсдэлийн удирдлагын салбарын онцлох арга хэмжээ болох ISDA-ийн жилийн ерөнхий хурал (AGM) нь зөвхөн гишүүдэд нээлттэй.

Гишүүн пүүсүүд нь ISDA бага хурал, арга хэмжээ, вебинаруудад илүүд үздэг илтгэгч юм.

Чуулганы бүртгэлийн гишүүдийн үнийг бууруулж, онцгой үзэсгэлэн, ивээн тэтгэгч, сүлжээний боломжууд.

Жилийн туршид зөвхөн гишүүдэд зориулсан орон нутгийн хурал, бага хурал, вебинарууд зохион байгуулагдаж, оролцогчдод салбарын өнөөгийн сэдвүүдийн талаар мэдээлэл өгдөг.

#### ✓ Нөөц ба мэдээллийн хүртээмж

Бүтээгдэхүүний чиглэл, зохицуулалт, хууль эрх зүй, үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн ажилтнуудад хандах. Эдгээр харилцагчид нь зах зээлийн өнөөгийн сэдвүүдийг хэлэлцэх, ISDA-ийн нөөцийг бүрэн ашиглахад туслах боломжтой.

Бодлогын баримт бичиг, хариу захидал, зах зээлийн судалгааны мэдээлэл, ISDA болон



түүний зөвлөхүүдийн гаргадаг бизнесийн гол асуудлуудын талаарх харилцаа холбоог тогтмол шинэчилдэг.

### Associate Membership Dues /гишүүнчлэлийн татвар/

Төлбөрийг үнэлэхийн тулд Ассоциацийн гишүүдийг Associate Global болон Associate Regular гэсэн хоёр дэд ангилалд хуваадаг. Энэ ялгаа нь зөвхөн хураамжийн үнэлгээнд зориулагдсан бөгөөд дэд гишүүний давуу эрхэд нөлөөлөхгүй.

### Associate Global

Дэлхийн ихэнх эсвэл бүх санхүүгийн төвүүдэд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад зориулагдсан.

### Хамтран ажиллагч

Бусад бүх салбарын үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд

ISDA гишүүнчлэл нь корпорацийнх тул гишүүн байгууллагуудын бүх ажилтнууд гишүүнчлэлийн давуу талыг ашиглах боломжтой. Гишүүнчлэл нь гишүүн компанийн эрх бүхий бүх охин компаниудад хамаарна.

## 3.3 ДАЛИАНЫ ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН НҮҮРСНИЙ АРИЛЖАА

Бирж нь зах зээлийн нөхцөл байдлын дагуу гэрээ бүрийн үнийн хязгаарын хүрээ болон арилжааны маржин стандартыг тохируулах боломжтой. Өдөр тутмын арилжаа нь эхний хэсэг 9:00–10:15, хоёр дахь хэсэг 10:30–11:30,

гурав дахь хэсэг 13:30–15:00 гэсэн гурван арилжаанд хуваагддаг. Шөнийн арилжааг эхлүүлсэн бөгөөд шөнийн арилжааны цаг 21:00–23:00 байна.

### Хүснэгт 2. Далианы түүхий эдийн биржийн коксжих нүүрсний фьючерсийн гэрээ (JM2304–өөс өмнөх коксжих нүүрсний гэрээнд хамаарна)

Арилжааны төрөл	Коксжих нүүрс
Арилжааны нэгж	60 тонн/лот
Үнийн саналын нэгж	юань (RMB)/тонн
Хамгийн бага үнийн өөрчлөлт	0.5 юань/тонн
Өдрийн үнийн хязгаарлалт	өмнөх арилжааны өдрийн тооцооны үнийн 4%
Гэрээний сар	1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12–р сар
Арилжааны цаг	Даваагаас Баасан гарагт 9:00–11:30, 13:30–15:00 болон бусад цагийг биржээс зарладаг.
Сүүлийн арилжааны өдөр	Гэрээ байгуулсан сарын 10 дахь арилжааны өдөр
Хүргэх огноо	Сүүлийн арилжааны өдрөөс хойших гурав дахь арилжааны өдөр
Хүргэх стандарт	Далианы түүхий эдийн бирж коксжих нүүрсний нийлүүлэлтийн чанарын стандарт (F/DCE JM001–2018)
Хүргэх газар	Далианы түүхий эдийн биржээс тогтоосон коксжих нүүрс хүргэх агуулах
Маржингийн доод хэмжээ	Гэрээний үнийн дүнгийн 5%
Хүргэх арга	Биет хүргэлт
Худалдааны код	JM
Бүртгэлтэй бирж	Далианы түүхий эдийн бирж

## IV. САНАЛ, ДҮГНЭЛТ

Түүхий эдийн биржийн арилжааны зах зээл нь үүсмэл санхүүгийн хэрэгсэлд суурилж үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн системийн хувьд нөлөөлөхүйц эрсдэл үүсгэх магадлал өндөр байдаг тул дэд бүтцийн хувьд эрсдэлийг бодитоор удирдаж чадах тооцооны байгууллага чухал үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн үнэт цаасны биржтэй харьцуулахад түүхий эдийн бирж нь агуулах, тээвэрлэлт гэсэн нэмэлт функцийг шаардах, түүний удирдлагыг сайтар хэрэгжүүлэх механизм бий болгоход зөв тогтолцоог бүрдүүлэх.

Түүхий эдийн биржид бүртгэлтэй бараа бүтээгдэхүүний санхүүгийн үүсмэл хэрэгслийг арилжихад нь холбогдох санхүүгийн зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл авдаг тул Санхүүгийн зохицуулах хороо үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх зохицуулалт бий болгох.

Түүхий эдийн бирж түүхий эд тус бүрээр үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээ болон чанарын стандартыг боловсруулж, батлан

зохицуулагч байгууллагаар батламжлуулах шаардлагатай.

АНУ-ын Түүхий эдийн фьючерсийн арилжааны хороо (CFTC)-нд мөрдөн байцаах үйл ажиллагааны чиг үүрэг хамаардаг ба олон улсын түвшинд холбогдох байгууллагуудтай хамтран мөрдөн байцаах ажиллагаа явуулдаг байна. Этиопын таваарын биржийн удирдлага (ECEA) нь хууль бус үйлдлүүдийг шалгаж, өөрийн харьяалалд хамаарах хэргийг шийдвэрлэх эсвэл эрүүгийн хэргийг зохих шүүхэд шилжүүлэх эрхтэй. Харин Санхүүгийн зохицуулах хороонд мөрдөн байцаах чиг үүрэг байдаггүй тул уг үйл ажиллагаа хязгаарлагддаг. Түүхий эдийн бирж дээрх үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд зөвхөн Монгол Улсаас бус, хэд хэдэн улсаас оролцогч талууд оролцдог тул ижил төстэй байгууллагуудтайгаа хамтран мөрдөн байцаалт хийх шаардлагын улмаас Санхүүгийн зохицуулах хорооны эрхзүйн байдлын тухай хуульд мөрдөн байцаах чиг үүргийг нэмж тусгах нь зүйтэй.



## ХАВСРАЛТ

Хавсралт 1. Далианы түүхий эдийн биржийн коксжих нүүрсний нийлүүлэлтийн чанарын стандарт (F/DCE JM001–2018) JM2304–өөс өмнөх гэрээнд хамаарна

### 1. Сэдвийн агуулга, хамрах хүрээ

1.1 Энэхүү стандарт нь Далианы түүхий эдийн биржээс нийлүүлж буй коксжих нүүрсний чанарт тавигдах шаардлага, турших арга, хяналтын дүрэм, тээвэрлэлтийн шаардлагыг тогтооно.

1.2 Энэхүү стандартад заасан коксжих нүүрс гэдэгт нүүрс угаах үйлдвэрт угаасан, чанарын үзүүлэлт нь кокс үйлдвэрлэх шаардлага хангасан, гарал үүслийн газар нь хязгаарлагдахгүй коксжих нүүрсийг хэлнэ.

1.3 Энэхүү стандарт нь Далианы түүхий эдийн биржийн коксжих нүүрсний фьючерсийн нийлүүлэлтийн стандарт бүтээгдэхүүн болон нийлүүлэгчид хамаарна.

### 2. Норматив лавлагаа

Дараах баримт бичгийн заалтууд нь энэхүү стандартыг эш татсанаар энэхүү стандартын заалтууд болно. Огноотой лавлагааны хувьд дараагийн бүх нэмэлт өөрчлөлтүүд (алдаатай заалтаас бусад) эсвэл засварууд нь энэ стандартад хамаарахгүй. Огноогүй лавлагааны хувьд хамгийн сүүлийн хувилбар нь энэ стандартад хамаарна.

GB/T 5751 Хятадын нүүрсний ангилал

GB/T 212 Нүүрсний үйлдвэрлэлийн шинжилгээний аргууд

GB/T 214 Нүүрсний нийт хүхрийн хэмжээг тодорхойлох арга

GB/T 479 Битумен нүүрсний /чулуужсан түлш/ коллоид давхаргын индексийг тодорхойлох арга

GB/T 5447 Битумен нүүрсний /чулуужсан түлш/ жигнэсний индексийг тодорхойлох арга

GB/T 6948 Нүүрсний витринитийн тусгалыг микроскопоор тодорхойлох арга

GB/T 15591 Арилжааны нүүрсний альбедо тархалтын зураглалыг ялгах арга

GB/T 397 Коксжих нүүрсний техникийн үзүүлэлтүүд

GB/T 3715 Нүүрсний чанар, нүүрсний шинжилгээтэй холбоотой нэр томьёо

GB 475 Арилжааны нүүрсний дээжийг гараар цуглуулах арга

Q/СҮ–МКZY–006–2012 Коксжих нүүрсний коксжих туршилтын арга 40кг–ын туршилтын коксын зуухны арга

#### 4. Чанарын шаардлага

##### 4.1 Стандарт бүтээгдэхүүний чанарын шаардлага

Индекс	Чанарын стандарт	
Үнс (Ad)	10.0%	
Хүхэр (St,d)	0.7%	
Дэгдэмхий бодис (Vdaf)	≥16.0% ба ≤28.0%	
Барьцалдах чанарын индекс (G)	Хадгалах хэмжээ ≥ 75%	Хүргэлт>65%
Гель давхаргын хамгийн их зузаан (Y)	≤25.0 мм	
Урвалын дараа коксын зууханд үүссэн коксын бат бөх чанарыг турших (CSR)	≥60% ба ≤65%	

##### 4.2 Бүтээгдэхүүний чанар, ялгаа ба хөнгөлөлт

Стандарт	Зөвшөөрөгдөх хэмжээ	Шимтгэл, хөнгөлөлт (юань/тонн)	
Үнс (Ad)	≤10.5%	>10.0% ба ≤10.5%	0.1%–ийн өсөлт бүрд хөнгөлөлт 4
		≥9.0% ба <10.0%	0.1% буурах бүрд үнэ 2–оор нэмэгдэнэ
		<9.0%	Үнэлгээ 9.0%
Хүхэр (St,d)	≤1.6%	>1.30% ба ≤1.60%	0.01%–ийн өсөлт бүрд үнийг 5–аар хөнгөлөх бөгөөд өмнөх үнийн хөнгөлөлттэй нэгтгэн тооцно.
		>1.00% ба ≤1.30%	0.01%–ийн өсөлт бүрд үнийг 2.5–аар хөнгөлөх бөгөөд өмнөх үнийн хөнгөлөлттэй нэгтгэн тооцно.
		>0.70% ба ≤1.00%	0.01%–ийн өсөлт бүрд үнэ 1.5–аар буурна
		≥0.50% ба <0.70%	0.01% буурах бүрд үнэ 0.5–аар өснө
		<0.50%	Үнэлгээ 0.50%
Урвалын дараа коксын зууханд үүссэн коксын бат бөх чанарыг турших (CSR)	≥55%	≥55% ба <60%	хямдрал 100
		>65%	0
Гель давхаргын хамгийн их зузаан (Y)	хязгааргүй	>25.0мм	0

##### 4.3 Витринит санамсаргүй тусгалын стандарт хазайлт (S) ≤ 0.13.



- 4.4 Витринитийн хамгийн их тусгал нь  $1.0-1.6$  ( $R_{\max}$  харьцаа)  $\geq 70\%$  байна.
- 4.5 Чийглэг  $Mt \leq 8.0\%$ , чийгийн хэмжээ  $8.0\%$ -аас их бол илүүдэл хэсгийг хасахын тулд аравтын нэг хүртэл дугуйрна (жишээлбэл, хэмжсэн чийгийн хэмжээ  $9.32\%$ , хасалт нь  $1.3\%$ ).
- 5 Туршилтын арга, хяналтын дүрэм
- 5.1 Дээж цуглуулах, бэлтгэх ажлыг GB 475-ын заалтын дагуу гүйцэтгэнэ;
- 5.2 Чийг, үнс, дэгдэмхий бодисыг тодорхойлохдоо GB/T 212-ын заалтын дагуу гүйцэтгэнэ;
- 5.3 Хүхрийн агууламжийг тодорхойлохдоо GB/T 214-ийн заалтын дагуу гүйцэтгэнэ;
- 5.4 Барьцалдах чанарын индексийг тодорхойлохдоо GB/T 5447 заалтын дагуу гүйцэтгэнэ;
- 5.5 Коллоид давхаргын хамгийн их зузааныг тодорхойлохдоо GB/T 479-ийн заалтын дагуу гүйцэтгэнэ;
- 5.6 Витринитийн санамсаргүй тусгалын хэмжилтийг GB/T 6948 заалтын дагуу гүйцэтгэнэ;
- 5.7 Витринитийн санамсаргүй тусгалын стандарт хазайлтыг GB/T 15591-ийн заалтын дагуу шүүнэ;
- 5.8 Туршилт Коксын зуухны туршилт Урвалын дараа коксын бат бэхийг тодорхойлохдоо Q/CY-MKZY-006-2012-ын заалтын дагуу гүйцэтгэнэ.
6. Хүргэлтийн шаардлага
- Коксжих нүүрсийг цэвэр төмөр зам, автомашины вагон, хөлөг онгоцны бүхээг болон бусад тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

## Хавсралт 2. Далианы түүхий эдийн биржийн коксжих нүүрсний нийлүүлэлтийн чанарын стандарт (F/DCE JM003-2022) JM2304 болон түүний дараагийн гэрээнд хамаарна.

### 1. Сэдвийн агуулга, хамрах хүрээ

1.1 Энэхүү стандарт нь Далианы түүхий эдийн биржээс нийлүүлж буй коксжих нүүрсний чанарт тавигдах шаардлага, турших арга, хяналтын дүрэм, тээвэрлэлтийн шаардлагыг тогтооно.

1.2 Энэхүү стандартад заасан коксжих нүүрс гэдэгт нүүрс угаах үйлдвэрт угаасан, чанарын үзүүлэлт нь кокс үйлдвэрлэх шаардлага хангасан, гарал үүслийн газар нь хязгаарлагдахгүй коксжих нүүрсийг хэлнэ.

1.3 Энэхүү стандарт нь Далианы түүхий эдийн биржийн коксжих нүүрсний фьючерсийн нийлүүлэлтийн стандарт бүтээгдэхүүн болон нийлүүлэгчид хамаарна.

### 2. Норматив лавлагаа

Дараах баримт бичгийн заалтууд нь энэхүү стандартыг эш татсанаар энэхүү стандартын заалтууд болно. Огноотой лавлагааны хувьд дараагийн бүх нэмэлт өөрчлөлтүүд (алдаатай контентоос бусад) эсвэл засварууд нь энэ стандартад хамаарахгүй. Огноогүй лавлагааны хувьд хамгийн сүүлийн хувилбар нь энэ стандартад хамаарна.

GB/T 5751 Хятадын нүүрсний ангилал

- GB/T 212 Нүүрсний үйлдвэрлэлийн шинжилгээний аргууд
- GB/T 214 Нүүрсний нийт хүхрийн хэмжээг тодорхойлох арга
- GB/T 479 Битумен нүүрсний коллоид давхаргын индексийг тодорхойлох арга
- GB/T 5447 Битумен нүүрсний жигнэсний индексийг тодорхойлох арга
- GB/T 6948 Нүүрсний витринитийн тусгалыг микроскопоор тодорхойлох арга
- GB/T 15591 Арилжааны нүүрсний хольцын төрлийг ялгаварлан гадуурхах арга
- GB/T 3715 Нүүрсний чанар, нүүрсний шинжилгээтэй холбоотой нэр томьёо
- GB/T 475 Арилжааны нүүрсний дээжийг гараар цуглуулах арга
- GB/T 4000 коксын урвал ба урвалын дараах бат бэхийн туршилтын арга
- GB/T 8170 тоон бөөрөнхийлөх дүрэм ба хязгаарын утгыг илэрхийлэх ба шүүлт
- MT/T 1181 Коксжих нүүрсний коксжих туршилтын арга

### 3. Чанарын шаардлага

#### 3.1 Стандарт бүтээгдэхүүний чанарын шаардлага

Индекс	Чанарын стандарт	
Үнс (Ad)	10.5%	
Хүхэр (St,d)	1.30%	
Дэгдэмхий бодис (Vdaf)	[16.0%, 26.0%]	
Нэгдлийн индекс (GR.I)	Хадгалах хэмжээ $\geq 75\%$	Хүргэлт $>65\%$
Гель давхаргын хамгийн их зузаан (Y)	$\geq 10.0\text{мм}$	
Урвалын дараа коксын зууханд үүссэн коксын бат бөх чанарыг турших (CSR)	[60%, 65%]	

#### 3.2 Бүтээгдэхүүний чанар, ялгаа ба хөнгөлөлт

Стандарт	Зөвшөөрөгдөх хэмжээ	Шимтгэл, хөнгөлөлт (юань/тонн)	
Үнс (Ad)	$\leq 11.0\%$	(10.5%, 11.0%)	хямдрал 30
		(10.0%, 10.5%)	Үнийн өсөлт 0
		$\leq 10.0\%$	Үнийн өсөлт 30
Хүхэр (St,d)	$\leq 1.60\%$	(1.30%, 1.60%)	0.01%–ийн өсөлт бүрд 5 хөнгөлөлт үзүүлнэ.
		[0.70%, 1.30%)	0.01%–ийн бууралт тутамд үнэ 2.5–аар нэмэгдэнэ.
		$< 0.70\%$	0.70% үнэтэй
Дэгдэмхий бодис (Vdaf)	[16.0%, 28.0%]	(26.0%, 28.0%)	хямдрал 50
Урвалын дараа коксын зууханд үүссэн коксын бат бөх чанарыг турших (CSR)	$\geq 60\%$	$\geq 65\%$	Үнийн өсөлт 80

#### 4.3 Витринит санамсаргүй тусгалын стандарт хазайлт (S) $\leq 0.13$ .



4.4 Витринитийн хамгийн их тусгал нь 1.0%–1.7%,  $\geq 70\%$ –ийг эзэлдэг.

4.5 Чийг ( $Mt$ )  $\leq 8.0\%$ , чийг ( $Mt$ )  $> 8.0\%$ , 100 багцад хөрвүүлсэн жин =  $6000$  (тн)  $\cdot (1 - 8.0\%) / [1 - \text{чийг хэмжилтийн үр дүн} (\%)]$ .

5. Туршилтын арга, хяналтын дүрэм

5.1 Дээж цуглуулах, бэлтгэх ажлыг GB/T 475–ын заалтын дагуу гүйцэтгэнэ;

5.2 Чийг, үнс, дэгдэмхий бодисыг тодорхойлохдоо GB/T 212–ын заалтын дагуу гүйцэтгэнэ;

5.3 Хүхрийн агууламжийг тодорхойлохдоо GB/T 214–ийн заалтын дагуу гүйцэтгэнэ;

5.4 Нэгдлийн индексийг тодорхойлохдоо GB/T 5447 заалтын дагуу гүйцэтгэнэ;

5.5 Коллоид давхаргын хамгийн их зузааныг тодорхойлохдоо GB/T 479–ийн заалтын дагуу гүйцэтгэнэ;

5.6 Санамсаргүй тусгал ба витринитийн хамгийн их тусгалыг тодорхойлох нь GB/T 6948 заалтын дагуу хийгдэнэ;

5.7 Витринитийн санамсаргүй тусгалын стандарт хазайлтыг GB/T 15591–ийн заалтын дагуу шүүнэ;

5.8 Урвалын дараа туршилтын коксын зуухнаас гаргаж авсан коксын бат бөх чанарыг тодорхойлохдоо MT/T 1181 ба GB/T 4000–ын заалтын дагуу гүйцэтгэнэ.

5.9 Тоон утгыг дугуйлах, хязгаарын утгыг илэрхийлэх, тодорхойлох дүрмийг GB/T 8170–ын заалтын дагуу хэрэгжүүлнэ.

6. Тээвэрлэлтийн шаардлага

Коксжих нүүрсийг төмөр зам, вагон, хөлөг онгоцны бүхээг болон бусад тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Cunha, Rita. "The IOSCO Multilateral Memorandum of Understanding (MMoU): An International Benchmark for Securities Enforcement." Unif. L. Rev. 15 (2010): 677. Retrieved from: <https://www.iosco.org/library/pubdocs/pdf/IOSCOPD381.pdf>
2. [Financial Stability Board](#). The Financial Stability Aspects of Commodities Markets. 20 February 2023. Retrieved from: <https://www.fsb.org/wp-content/uploads/P200223-2.pdf>
3. ICICI Securities Ltd. Legal and Regulatory Environment of Commodity Derivatives, Retrieved from: <https://www.icicidirect.com/ilearn/currency-commodity/courses/chapter-16-legal-and-regulatory-environment-of-commodity-derivatives>
4. IOSCO. Principles for the Regulation and Supervision of Commodity Derivatives Markets. January, 2023. Retrieved from: <https://www.iosco.org/library/pubdocs/pdf/IOSCOPD726.pdf>
5. ISDA Associate Membership Brochure 2018 Retrieved from: <https://www.isda.org/>
6. БНХАУ-ын Далианы түүхий эдийн бирж Retrieved from: <https://www.dce.com.cn/>
7. Этиопын таваарын бирж Retrieved from: <https://www.ecx.com.et/>

2

# ББСБ-ЫН ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГА

Гүйцэтгэсэн: П.Байгалмаа<sup>4</sup>

<sup>4</sup> СЗХ, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт email: baigalmaa@frc.mn

## ХУРААНГУЙ

Өнөөдөр Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн байгууллагын салбарын үйл ажиллагаанд эрх зүйн тааламжтай орчныг бүрдүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх замаар санхүүгийн зуучлалыг хөгжүүлэх, салбарын хөгжлийг олон улсын жишигт нийцүүлэх, хяналтын оновчтой тогтолцоог бий болгох, салбарыг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна.

Мөнгөн гуйвуулга банкаар дамжиж хийгддэг гүйлгээ байсан. Банк бус санхүүгийн байгууллага банканд дахь өөрийн харилцах дансаар дамжуулан эсхүл интернэт, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж бусдын мөнгөн хөрөнгийг гуйвуулах үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлээд даруй 10 гаран жилийн нүүр үзжээ. Энэхүү цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний харилцааны зохицуулалтын талаар тусгайлан гүйцэтгэсэн судалгаа хараахан байхгүй байна.

2023 оны 01 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр 514 Банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 40 ББСБ нь цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Мөнгөн гуйвуулга нь санхүүгийн хүртээмжийг хөнгөвчлөх, ингэснээр хуримтлал, хөрөнгө оруулалт, бизнес эрхлэх, ажлын байр бий болгоход эергээр нөлөөлж байна. Тийм ч учраас улс орнууд мөнгөн гуйвуулгын үйлчилгээг дэмжихийн сацуу үүсэж болзошгүй эрсдэлээс хамгаалах үр дүнтэй зохицуулалтыг бий болгоход анхаардаг.

Иймээс өөрийн болон бусад орны цахим мөнгөн гуйвуулгын чиг хандлага, зохицуулалтын арга хэрэгсэл, туршлага зэргийг судлах нь зүйтэй гэж үзлээ.

Энэхүү судалгааны ажил нь дараах бүтэцтэй. Нэгдүгээрт цахим мөнгөн гуйвуулгын чиг хандлага, Хоёрдугаар бүлэгт олон улсын байгууллагаас боловсруулсан цахим мөнгөн гуйвуулгатай холбоотой зохицуулалт, болзошгүй эрсдэлийн талаар товч толилуулна. Гуравдугаар бүлэгт бусад орны цахим мөнгөн гуйвуулгын зохицуулалт, туршлага, Дөрөвдүгээр бүлэгт зохицуулагч байгууллагын хяналт, зохицуулалт, Тавдугаар бүлэгт Монгол Улсын цахим мөнгөн гуйвуулгын чиг хандлага, зохицуулалтын хүрээг танилцуулах ба сүүлийн бүлэгт судалгааны ажлыг нэгтгэн дүгнэж, санал зөвлөмж дэвшүүлнэ.

### **JEL ангилал:**

*Хураангуй:*

*Энэхүү судалгаанд цахим мөнгөн гуйвуулгын чиг хандлага, өөрийн болон бусад оронд зохицуулалт, туршлага зэргийг хамруулсан.*

### **Түлхүүр үг:**

*Цахим мөнгөн гуйвуулга, зардал, өглөг*

I.	<b>ЦАХИМ МӨНГӨ ГУЙВУУЛГЫН ЧИГ ХАНДЛАГА</b>	44
	1.1. Мөнгө гуйвуулгын урсгал нь хөгжиж буй орнуудын гадаад санхүүжилтийн гол эх үүсвэр хэвээр байна	44
	1.2. Дэлхийн цахим мөнгөн гуйвуулга	47
	1.3. Мөнгөн гуйвуулгын зардал	48
II.	<b>ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ, ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ</b>	49
	2.1. Олон улсын эрх зүйн нийтлэг зохицуулалт	49
	2.2. Цахим мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэл	51
III.	<b>БУСАД ОРНЫ ЦАХИМ МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА</b>	52
	3.1. Улс орнуудад мөрдөж буй эрх зүйн зохицуулалт	52
	3.2. Сонгон судалсан улс оронд үйлдэгдсэн мөнгөн гуйвуулгатай холбоотой сорил, шийдвэрлэлт	54
	3.3. Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний эрх зүйн нийтлэг зохицуулалт	57
IV.	<b>МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭ</b>	60
	4.1. Мөнгөн гуйвуулгын урсгалын чиг хандлага	60
	4.2. Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч ББСБ-ын өнөөгийн байдал	63
	4.3. Монгол Улсын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний зохицуулалтад мөрдөж буй хууль тогтоомж	68
	<b>ДҮГНЭЛТ</b>	70
	<b>САНАЛ ЗӨВЛӨМЖ</b>	71
	<b>ЗУРАГ ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ</b>	
	Зураг 1. Телеграф	44
	Зураг 2. Бага, дунд орлоготой орнуудад чиглэсэн мөнгөн гуйвуулга, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламжийн урсгал, 2000–2024f	45 46
	Зураг 3. Хятадыг эс тооцвол бага, дунд орлоготой орнууд руу шилжүүлсэн мөнгө, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламжийн урсгал, 2000–2024f	46
	Зураг 4. Хүлээн авагч бага, дунд орлоготой орнуудын мөнгөн гуйвуулга, 2022 он	46
	Зураг 5. Дэлхийн цахим мөнгөн гуйвуулгын зах зээлийн хэмжээ	47

---


Зураг 6. 200 ам.доллар илгээхэд мөнгөн гуйвуулгын зардал, 2021–2022	48
Зураг 7. Гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэд	60
Зураг 8. Гадаадад оршин суугаа иргэдийн эх орон руугаа явуулсан мөнгөн шилжүүлэг (ам. доллароор)	61
Зураг 9. Мөнгөн гуйвуулга 2000–2022 он /ДНБ–д эзлэх хувиар/	61
Зураг 10. Мөнгөн гуйвуулгын орлого 2020.I–2023.I	64
Зураг 11. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг /сая төгрөгөөр/	65
Зураг 12. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг ба Нийт өр төлбөр ба эздийн өмчийн хамаарал	66
Зураг 13. МУТС эрсдэлийн үнэлгээний түвшин	67
Хүснэгт 1. Бага, дунд орлоготой бүс нутгуудад мөнгөн гуйвуулгын урсгалын тооцоо, төсөөлөл (тэрбум ам.доллар)	45
Хүснэгт 2. Хувийн гуйвуулга 2023.I /мян ам.доллар/	
Хүснэгт 3. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ	62 64
Хүснэгт 4. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа төрлөөр	
Хүснэгт 5. Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/	64
Хүснэгт 6. Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	64
Хүснэгт 7. Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/	65
Хүснэгт 8. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 2019.I–2023.I /мянган төгрөгөөр/	65 65
Хүснэгт 9. Корреляцийн шинжилгээ	
ХАВСРАЛТ 1.	66 73

---



## I. ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ЧИГ ХАНДЛАГА

ЗУРАГ 1. ТЕЛЕГРАФ



Хамгийн анх мөнгөн гуйвуулгыг Western Union компани 1872 онд Самуэль Морзе бусад зохион бүтээгчдийн хамт бүтээсэн харилцаа холбооны хэрэгсэл болох морзыг ашиглаж үйлдсэн байна.

МЕТАЛЛ МӨНГӨ



1914 онд Western Union компани нь анхны цэнэглэгч зээлийн картыг "Metal Money" нэрээр харилцагчдадаа хүргэсэн.

БОГИНО ДОЛГИОНЫ СҮЛЖЭЭ



1943 онд хот хооронд богино долгионы радио станцууд бий болж улмаар мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч олон тооны байгууллагууд бий болсон гэж үздэг.

### 1.1. МӨНГӨ ГҮЙВУУЛГЫН УРСГАЛ НЬ ХӨГЖИЖ БҮЙ ОРНУУДЫН ГАДААД САНХҮҮЖИЛТИЙН ГОЛ ЭХ ҮҮСВЭР ХЭВЭЭР БАЙНА

Гадаадад ажиллаж, амьдарч буй иргэдийн мөнгөн гуйвуулга нь улс орнуудын хувьд хөгжлийн амин сүнс болдог.

Мөнгөн гуйвуулгын ихэнх нь албан бус сувгуудаар явагддаг тул мөнгөн гуйвуулгын урсгалын хэмжээг нарийн тооцоолох боломжгүй.

Илгээсэн мөнгөн гуйвуулгын урсгал 2021 онд дэлхийн хэмжээнд бага зэрэг буурч 2022 оны эхнээс удаашрах төлөвтэй болов. Энэ нь улс орнуудад инфляцын түвшин өндөрсөх, валютын ханш буурах, цар тахлын сөрөг нөлөөлөл илрэх, Украины дайн зэргээс эдийн засгийн орчин хүндэрч дэлхийн эдийн засаг удааширч цагаачдын бодит орлого бууруулсантай холбоотой гэж үзсэн.

2022 оны дундуур улс орон цар тахлын үед авч байсан хориг арга хэмжээнүүдээ суллах, чөлөөлөх дэс дараатай арга хэмжээ авснаар бага, дунд орлоготой орнууд руу илгээсэн мөнгөн гуйвуулгын урсгал өмнөх оноос 8 хувиар нэмэгдэж, 647 тэрбум ам.долларт<sup>1</sup> хүрсэн гэж Цагаачлал ба хөгжлийн товч 37-д нийтлэгдсэн. Тухайлбал: Европ болон Төв Ази руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулгын хэмжээ 2022 онд 79 тэрбум ам.долларт хүрч, өмнөх жилийнхээс 19 хувиар өссөн. Үүнд шилжүүлсэн мөнгөн гуйвуулгын дийлэнх нь ОХУ-аас ирсэн

<sup>1</sup> Joint statement by the UN Network on Migration on the occasion of the International Day of Family Remittances

байна. Энэ нь Орос хөрш зэргэлдээ орнууд руу мөнгөн гуйвуулга их хэмжээгээр хийгдсэнтэй холбоотой.

Латин Америк болон Карибын тэнгисийн орнууд руу мөнгөн гуйвуулгын урсгал 11.3 хувиар нэмэгдэж, 2022 онд 145 тэрбум ам.долларт хүрсэн. Үүнд АНУ–д хөдөлмөрийн зах зээл хүчтэй байсан нь 2022 онд мөнгөн гуйвуулгын урсгалд эергээр нөлөөлсөн. Мексик улс руу гэхэд шилжүүлсэн мөнгө 2022 онд 61.1 тэрбум ам.долларт хүрч, 12.9 хувиар өссөн байна.

Дэлхийн банкны хамгийн сүүлийн үеийн

шилжилт хөдөлгөөн ба хөгжлийн товч танилцуулгад мөнгө шилжүүлдэг улс орнуудын цагаачдын ажил эрхлэлт, цалингийн өсөлтийн хязгаарлалт зөөлөрч, эдийн засгийн идэвхжиж эхэлсэн тул 2023 онд бага, дунд орлоготой орнууд руу чиглэсэн мөнгөн гуйвуулгын урсгал 1.4 хувиар өсөж, 656 тэрбум ам.долларт хүрэх ба Дэлхийн хувьд 2023 онд мөнгөн гуйвуулгын урсгал 840 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй бөгөөд 2024 онд мөнгөн гуйвуулгын өсөлт 2.0 хувь болж, орох урсгалыг 18 тэрбум ам.доллороор нэмэгдэнэ (хүснэгт 1) гэж таамагласан.

**Хүснэгт 1.** Бага, дунд орлоготой бүс нутгуудад мөнгөн гуйвуулгын урсгалын тооцоо, төсөөлөл (тэрбум ам.доллар)


	2016	2017	2018	2019	2020	2021	2022e	2023f
<b>Бага, дунд орлоготой орнууд</b>	435	475	522	548	542	599	647	656
Дэлхий	590	640	695	727	717	791	831	840
Өсөлтийн хувь (хувь)								
Бага, дунд орлоготой орнууд	-1.5	9.3	9.8	5.0	-1.1	10.6	8.0	1.4
Дэлхий	-1.0	8.4	8.6	4.5	-1.4	10.4	5.1	1.1

Эх сурвалж: Дэлхийн банк – KNOMAD-2020.

Тайлбар: e = тооцоо; f = урьдчилсан мэдээ  
Мөнгөн гуйвуулга нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламж, багцын

хөрөнгө оруулалтын урсгалтай харьцуулахад гадаад санхүүгийн том эх үүсвэр хэвээр байсаар байна (зураг 1).


**Зураг 2.** Бага, дунд орлоготой орнуудад чиглэсэн мөнгөн гуйвуулга, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламжийн урсгал, 2000–2024f



Эх сурвалж: Дэлхийн банк–KNOMAD, ОУВС–гийн төлбөрийн тэнцлийн статистик.



**Зураг 3.** Хятадыг эс тооцвол бага, дунд орлоготой орнууд руу шилжүүлсэн мөнгө, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламжийн урсгал, 2000–2024f



Эх сурвалж: Дэлхийн банк–KNOMAD, ОУВС–гийн төлбөрийн тэнцлийн статистик.

**Тэмдэглэл:** Remittances–мөнгөн гуйвуулга, FDI = гадаадын шууд хөрөнгө оруулалт; ODA = хөгжлийн албан ёсны тусламж

Энэ зургаас Хятад улсыг түүврээс хасаж харуулсан ч гадаад санхүүжилтийн гол эхүүсвэрт мөнгөн гуйвуулга ихээхэн ач холбогдолтой болох нь тод харагдаж байна (Зураг 2).


Мөнгө гуйвуулга нь эдийн засгийн хувьд урсгал данс болон төсвийн хомсдолыг санхүүжүүлэхэд ач холбогдолтой тул дотоодын нийт бүтээгдэхүүн

(ДНБ)–д ихээхэн хувь эзэлдэг.


168 орны тоон мэдээллээс авч үзвэл ДНБ–д эзлэх 2022 оны дундаж 5.4 хувь байна. Тухайлбал: Тажикстан (ДНБ–ий 51 хувь), Тонга (44 хувь), Ливан (35 хувь), Самоа (34 хувь), Киргизстан (31 хувь) эхний аравт багтжээ (зураг 3).

**Зураг 4.** Хүлээн авагч бага, дунд орлоготой орнуудын мөнгөн гуйвуулга, 2022 он

а. тэрбум ам.доллар, 2022 он



б. ДНБ–д эзлэх хувь, 2022 он



Эх сурвалж: Дэлхийн банк–KNOMAD; ОУВС–гийн төлбөрийн тэнцлийн статистик.

Товчлол: ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн.

## 1.2. ДЭЛХИЙН ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГА

Уламжлалт мөнгөн гуйвуулга нь мөнгөө гуйвуулахын тулд заавал биечлэн очих ба холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх, хураамж төлөх гэх мэт цаг болон зардал шаарддаг.

Санхүүгийн байгууллагууд мөнгө гуйвуулгын үйлчилгээндээ цахим шийдлүүдийг эрчимтэй нэвтрүүлж ашигласнаар энэ салбарт өрсөлдөөн нэмэгдэж, шилжүүлгийн зардал буурах боломжууд бүрдэж үйлчлүүлэгчдийг ихээхэн татаж байна.


Сүүлийн жилүүдэд гар утсаар дамжуулан хил дамнасан төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгыг түргэн шуурхай үйлдэх нь улам түгээмэл болж байна. Хөдөлгөөнт холбооны глобал систем

(GSM) холбооны мэдээлснээр гар утасны аппликейшн ашиглаж 2020 онд 12.7 тэрбум ам.долларыг хил дамнасан гуйвуулсан гэжээ.

Түүнчлэн судалгаагаар гар утасны мөнгөн гуйвуулга 2027 он гэхэд дэлхийн цахим мөнгөн гуйвуулгын зах зээлийн 73 гаруй хувийг эзэлнэ гэж таамаглаж байна.

Дэлхийн цахим мөнгөн гуйвуулгын зах зээлийн хэмжээ 2021 онд 17 тэрбум ам.доллараар үнэлэгдсэн бол 2022 онд 19.65 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд 2030 он гэхэд 60.05 тэрбум ам.доллар болж жилийн нийлмэл өсөлтийн хурд (CAGR) 12.29 хувиар өсөх төлөвтэй гэж таамаглажээ.

**Зураг 5.** Дэлхийн цахим мөнгөн гуйвуулгын зах зээлийн хэмжээ



Урьдчилан тооцооллоор хил дамнасан цахим гүйлгээний хэмжээ, гар утасны төлбөрийн сувгийн хэрэглээ хоёулаа нэмэгдэх төлөвтэй байна.



### 1.3. МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ЗАРДАЛ


Олон улсын валютын сангаас санхүүгийн цахим шийдлүүдийг нэвтрүүлэх, оролцоог дэмжих замаар мөнгөн гуйвуулгын зардлыг бууруулах арга хэмжээ авахаа амласан. Түүнчлэн мөнгөн гуйвуулгын дэлхийн дундаж өртгийг Их 20-ийн 5 хувь хүртэл, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтод 2030 он гэхэд 3 хувь хүртэл тус тус бууруулна гэжээ.

Дэлхийн банкны мөнгөн гуйвуулгын үнийн мэдээллээр 2022 оны дөрөвдүгээр улиралд бага, дунд орлоготой орнуудад 200 ам.доллар гуйвуулахад дунджаар мөнгөн дүнгийн 6.2 хувьтай тэнцүү зардал гаргадаг гэсэн нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтоос 2 дахин их байгаа юм.

Хөгжиж буй орнуудын бүс нутгуудын дунд дундаж зардал Өмнөд Азид хамгийн бага буюу 4.9 хувь бол Африкийн Саб–Сахарын орнууд хамгийн өндөр буюу 8 хувь байна (Зураг 5).

Банкнүүдын хувьд 2022 оны дөрөвдүгээр улирлын байдлаар мөнгөн гуйвуулахад хамгийн өндөр өртөгтэй суваг хэвээр байгаа ба түүний дундаж зардал 11.7 хувьтай байна<sup>2</sup>. Шуудангийн үйлчилгээний дундаж зардал 6.3 хувь, мөнгөн гуйвуулгын операторынх 5.4 хувь, үүрэн холбооны операторынх 4.5 хувь байна. Мобайл үйл ажиллагаа нь хамгийн хямд үйлчилгээ үзүүлэгч ч нийт гүйлгээний багахан хэсэг буюу 1–ээс бага хувь эзэлдэг.

**Зураг 6.** 200 ам.доллар илгээхэд мөнгөн гуйвуулгын зардал, 2021–2022



Эх сурвалж: Дэлхийн банкны мөнгөн гуйвуулгын үнийн мэдээллийн сан.

Тайлбар: Улаан тасархай шугам = Тогтвортой хөгжлийн зорилт 3 хувь, EAP = Зүүн Ази, Номхон далай; ECA = Европ ба Төв Ази; LAC= Латин Америк ба Карибын тэнгис; MENA = Ойрх

Дорнод ба Хойд Африк; SAR = Өмнөд Ази; SDG = Тогтвортой хөгжлийн зорилго; SSA = Африкийн Саб–Сахарын орнууд.

<sup>2</sup> <https://unread.today/c/spotlight-sendmn>

## II. ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ, ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

### 2.1. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ

ББСБ–ын цахим мөнгөн гуйвуулгын эрх зүйн зохицуулалт нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлага, хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг хамгаалах, цахим аюулгүй байдал, гэрээний нөхцөл, хил дамнасан зохицуулалт зэрэг хууль эрх зүйн олон шинж чанарыг агуулсан байдаг. Эдгээр хууль эрх зүйн шаардлагыг дагаж мөрдсөнөөр ББСБ–ууд санхүүгийн системийн аюулгүй байдлаа хангаж, харилцагчдадаа хариуцлагатай, найдвартай үйлчилгээ үзүүлэх, тэднийг болон үйл ажиллагаагаа санхүүгийн болон залилан мэхлэгдэх гэмт хэргээс хамгаалж чадах учир олон улсын байгууллагууд нэгдсэн эрх зүйн зохицуулалт боловсруулан хамтран хэрэгжүүлж байна.



Мөнгө угаах (anti–money laundering (AML)) болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (counter–terrorist financing (CTF)) арга хэмжээний дэлхийн стандартыг тогтоодог Засгийн газар хоорондын байгууллага болох Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (The Financial Action Task Force (FATF) (ФАТФ)) юм.

ФАТФ–аас гаргасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зөвлөмж боловсруулсан. Уг зөвлөмж нь ББСБ санхүүгийн системийг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, мөнгө угаах болон терроризмыг

санхүүжүүлэхтэй тэмцэхэд зориулагдсан бөгөөд тэр дундаа харилцагчаа сайтар нягтлан шалгах, таньж мэдэх, бүртгэл хөтлөх, тайлагнах шаардлагын талаар зааварчилгаа өгснөөр ББСБ–дыг залилан мэхлэгдэх үйлдлээс болон мөнгө угаахаас урьдчилан сэргийлж хамгаалахад тусалдаг.



Цахим мөнгөн гуйвуулгын стандартыг тогтоодог өөр нэг байгууллага бол Олон улсын стандартчиллын байгууллага (the International Organization for Standardization (ISO)) юм. Тус байгууллагаас ISO 20022 стандартуудыг боловсруулсан. Энэ стандарт нь санхүүгийн байгууллагуудын хооронд цахим мессеж солилцох нийтлэг тогтолцоог бүрдүүлдэг бөгөөд мөнгөн гуйвуулга, цахим төлбөрийг найдвартай гүйцэтгэхэд тусалдаг.



Олон улс орон, бүс нутаг хэрэгжиж байгаа Европын холбооны төлбөрийн үйлчилгээний 2 (Payment Services Directive (PSD2)) стандарт юм. PSD2–ын гол зорилго нь:

- (i) Нэгдсэн хяналт, үр ашгийг нэмэр оруулах;
- (ii) шинэ тоглогчдыг оролцуулах замаар төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн өрсөлдөөний талбарыг тогтвортой байдлыг хангах;
- (iii) төлбөр тооцоог илүү найдвартай хийх;



(iv) Европын хэрэглэгчид болон бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах.

Энэ нь ББСБ-аас харилцагчийг таньж мэдэх баталгаажуулах арга хэмжээг дагаж мөрдөх, гүйлгээний мэдээллийг эрх бүхий гуравдагч этгээдтэй хуваалцахыг шаарддаг.



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон Улсын Худалдааны Хуулийн Комисс (United Nations Commission on International Trade Law (UNCITRAL)) 2005 онд ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгатай холбоотой заалтуудыг багтаасан Цахим шилжүүлгийн бүртгэлийн тухай загвар хуулийг<sup>3</sup> боловсруулжээ.

Загвар хууль ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг цогцоор нь бүрдүүлсэн. Тус хууль эрх зүйн тодорхой байдлыг хангах, хил дамнансан худалдааг хөнгөвчлөх, цахим шилжүүлэг, тэр дундаа тоон гарын үсгийг мөнгөн гуйвуулгад ашиглах тогтолцоог бүрдүүлэх, хэрэглэгчдийг хамгаалах зорилготой юм.

Тус загвар хуульд тусгасан үндсэн ойлголтуудаас дурдвал:

» **Цахим шилжүүлгийн бүртгэл** – Энэ нь санхүүгийн хөрөнгийг өмчлөх, шилжүүлэхтэй холбоотой мэдээллийг агуулсан цахим бүртгэл юм. Хуулиар цахим бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хамгаалж, шүүх хуралдаанд нотлох баримт болгон ашиглах боломж олгосон.

» **Дамжуулж болох бүртгэлийн системүүд** Цахим мөнгөн гуйвуулах эрх үүсгэх, хадгалах, дамжуулах боломжийг олгодог системүүд юм. Загвар хуулиар дамжуулж болох бүртгэлийн системүүдийг бий болгох, ажиллуулах талаар зааварчилгаа өгч, тэдгээрийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдалд тавигдах шаардлагыг тодорхойлсон.

» **Зуучлагч** – Энэ нь илгээгч болон хүлээн авагчийн хооронд цахимаар мөнгөн шилжүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэгч нь ББСБ юм. Загвар хуульд зуучлагчдыг хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрч, зохицуулах асуудлыг тусгасан бөгөөд тэдний үйл ажиллагаанд тавигдах шаардлага, харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг тодорхойлсон.

» **Зөвшөөрөл ба хэрэгжилт** – Загвар хуульд тоон гарын үсгийг мөнгө гуйвуулах болон холбогдох цахим бүртгэл хийх, түүний дотор цахим шилжүүлгийн бүртгэл, дамжуулж болох мэдээллийг хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрч, мөрдүүлэх талаар тусгасан.

» **Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай**–төлбөр, хураамжийг ил болгох шаардлага, маргаан шийдвэрлэх механизм зэрэг хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой заалтууд тусгажээ.

<sup>3</sup> [https://uncitral.un.org/en/texts/ecommerce/conventions/electronic\\_communications](https://uncitral.un.org/en/texts/ecommerce/conventions/electronic_communications)  
[https://unctad.org/system/files/official-document/a68d17\\_en.pdf](https://unctad.org/system/files/official-document/a68d17_en.pdf)

## 2.2. ЦАХИМ МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ

ББСБ нь цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлснээр дараах болзошгүй эрсдэлтэй тулгарч болох тул сэргийлэх нь зүйтэй. Үүнд:

- » **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх:** Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэх мэт хууль бус үйл ажиллагаанд ашиглаж болзошгүй юм. Энэ тохиолдолд ББСБ–нд өндөр торгууль оногдох бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээдэг тул болгоомжлох ёстой.
- » **Хэрэглэгчийн эрх ашгийг хохироох:** ББСБ–ууд цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ авагч хэрэглэгчдийн эрх ашгийг хохироохгүйн тулд үйлчилгээний мэдээллийг ил тод, шударга байлгахын зэрэгцээ шимтгэл, валютын ханшийг тодорхой зааж өгөх ёстой. Энэ нь хэрэглэгчдээс ирэх аливаа гомдол, асуудлыг шийдвэрлэхэд дөхөм болно.
- » **Кибер аюулгүй байдал:** Мөнгө гуйвуулгын үйлчилгээнд цахим технологийг ашиглах нь хакердуулах, мэдээлэл алдагдах боломжтой. Иймд ББСБ нь өөрийн ашиглаж буй систем, өгөгдөл, мөн харилцагчдынхаа хувийн болон санхүүгийн мэдээллийг хамгаалахад зохих арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх хэрэгтэй.
- » **Эрх зүйн асуудал:** Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд хил дамнасан гүйлгээ хамардаг тул тухайн улс орны зохицуулагч байгууллагуудын харьяаллын асуудал үүсгэх боломжтой. Энэ байдлаас болж ББСБ нь илгээгч болон хүлээн авагч орны аль алиных нь хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой.
- » **Зөвшөөрөл ба зохицуулалт:** ББСБ–аас үзүүлж буй цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээндээ тусгай зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг мөрдөх нь ББСБ–уудад нэмэлт зардал, захиргааны дарамт үүсгэж болох ч үйл ажиллагааны тогтвортой байдлаа хангахад тустай.
- » **Уламжлалт мөнгөн гуйвуулгын сувгийг тасалдуулах:** Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өсөлт нь уламжлалт мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Учир нь уламжлалт бол бэлэн мөнгөнд суурилсан шилжүүлгийг оператор үйлддэг тул салбарын зохицуулалтаас гадна санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнд нөлөөлж болно гэж үзэж байна.



### III. БУСАД ОРНЫ ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА

#### 3.1. УЛС ОРНУУДАД МӨРДӨЖ БҮЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Сонгон судалсан улс орнууд дахь ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээг зохицуулдаг эрх бүхий байгууллага болон эрх зүйн актуудтай танилцъя.

**Америкийн Нэгдсэн Улс /АНУ/** – АНУ-д мөнгө шилжүүлэх, төлбөр төлөх болон мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх нь холбооны болон муж улсын хууль тогтоомжийг мөрдөнө.

Холбооны түвшинд гол зохицуулагч байгууллага бол АНУ-ын Сангийн яамны нэг хэсэг болох Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (Financial Crimes Enforcement Network (FinCEN)) юм.

FinCEN нь Банкны нууцын тухай хууль болон холбогдох мөнгө угаахтай тэмцэх зохицуулалтыг мөрдөхийг шаарддаг. Тухайлбал ББСБ-аас сэжигтэй үйл ажиллагааны тайлан тайлагнах, мөнгө угаах хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцагчийг таньж мэдэх гэх мэт болно.

FinCEN-ээс гадна мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ-уудыг хянадаг холбооны бусад зохицуулагч байгууллагууд нь Хэрэглэгчийн санхүүг хамгаалах товчоо (Consumer financial protection bureau (CFPB)), Валютын хяналтын алба, Холбооны хадгаламжийн даатгалын корпорац (FDIC) байна.

Мужийн түвшинд мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ-ууд нь мужийн санхүүгийн зохицуулах агентлагаас тусгай зөвшөөрөл авч, зохицуулалтад хамрагддаг.

ББСБ нь дээр дурдсан хууль тогтоомжоос

гадна Мэдээллийн нууцлалын тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэрээний тухай хууль зэрэг анхаарах ёстой хууль эрх зүйн актууд бий.

**Энэтхэг улс** – Энэтхэг улсад цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ-уудын зохицуулалтын тогтолцоо бүрдсэн. ББСБ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг дүрэм, хэрэглэгчийн эрхийг хамгаалах журам, мэдээлэл хамгаалах дүрмийг дагаж мөрдөнө.

Харин хил дамнасан мөнгөн гуйвуулга эрхэлдэг ББСБ нь Гадаад валютын удирдлагын тухай хууль болон Энэтхэгийн үнэт цаас, биржийн зөвлөлөөс гаргасан дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллана.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ-ууд зөвшөөрөл авна.

Энэтхэгт мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ-уудыг 2007 онд баталсан Төлбөр тооцооны системийн тухай хуулийн дагуу мөнгөн гуйвуулгын системийн аюулгүй байдал, найдвартай байдал, тогтвортой байдлыг хангуулах чиг үүрэг нь Энэтхэгийн нөөцийн банк (Reserve Bank of India (RBI)) юм. ББСБ-д дараах арга хэмжээ, шаардлагыг хэрэгжүүлж ажиллана:

**Үйлчлүүлэгчээ таньж мэдэх хэм хэмжээ:**

Үйлчлүүлэгчээ таньж мэдэх удирдамжийн дагуу үйлчлүүлэгчдийнхээ хувийн мэдээлэл, хаягийг баталгаажуулах;

**Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй**

**тэмцэх арга хэмжээ:** МУТСТ хууль тогтоомжийг дагаж мөрдөх, хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтныг томилох, сэжигтэй гүйлгээний талаар Санхүүгийн тагнуулын байгууллагад мэдээлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх;

**Өөрийн хөрөнгийн хүрэлцээнд тавигдах шаардлага:**

Санхүүгийн тогтвортой байдлаа хангахын тулд өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хэмжээг хангаж ажиллах; Технологи, аюулгүй байдлын стандартууд; Харилцагчдынхаа гүйлгээний болон мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд зохих технологи, хамгаалалтын арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

**Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх механизм:**

Үйлчлүүлэгчдийн гомдлыг шийдвэрлэх, шуурхай шийдвэрлэхийн тулд гомдол барагдуулах механизмтай байх.

**Филиппин улс** – Филиппин улсад цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ–ууд тусгай зөвшөөрөл авах ба тэдгээрийн харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулдаг.

- 1993 онд батлагдсан Төв банкны тухай хууль (Бүгд найрамдах улсын хууль №7653) – Энэ хуулиар Филиппиний мөнгөний төв байгууллага болох Филиппиний Төв банк (Bangko Sentral ng Pilipinas (BSP)) нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–уудыг зохицуулах үүрэгтэй.
- 2000 онд батлагдсан Банкны ерөнхий хууль (Бүгд найрамдах улсын №8791 дүгээр хууль) Энэ хууль нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх ББСБ–д тавигдах шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг

зохицуулна. Энэ хуулийн дагуу ББСБ мөнгө гуйвуулгын үйлчилгээ эрхлэхийн тулд тусгай зөвшөөрөл авах ёстой.

- 2001 онд батлагдсан Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль (Бүгд найрамдах улсын хууль №9160)–аар Филиппиний санхүүгийн системийг мөнгө угаах үйл ажиллагаанд ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм. Энэ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–ыг харилцагчийг таних, баталгаажуулах журмыг дагаж мөрдөх, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэх, гүйлгээний бүртгэл хөтлөхийг шаардсан.
- Валютын журам (BSP Circular №1041) – Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ–уудын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмыг тусгасан. Үүнд лиценз, капиталжуулалт, тайлагналын шаардлага, эрсдэлийн удирдлага зэргийг хамруулсан.

Мөн ББСБ нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах журам, мэдээлэл хамгаалах дүрмийг тус тус дагаж мөрдөнө.

**Мексик улс** – Мексик улс цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч ББСБ–ын үйл ажиллагааг 2018 оны 09 дүгээр сарын 10–ны өдөр хүчин төгөлдөр болсон Мексикийн Санхүүгийн технологийн байгууллагын тухай хууль (Ley de Instituciones de Tecnologia Financiera буюу Финтекийн тухай хууль)–аар зохицуулдаг.

Уг хуулийн дагуу ББСБ нь санхүүгийн үйл ажиллагаа явуулахын тулд Үндэсний банк, Үнэт цаасны хороо (Comisión Nacional Bancaria y de Valores буюу “CNBV”)–ноос зөвшөөрөл авах ёстой. Мөн капиталжуулалт, засаглал, эрсдэлийн удирдлага, хэрэглэгчийн эрхийг



хамгаалахтай холбоотой зохицуулалтын тусгай зөвшөөрлийн шаардлагыг дагаж мөрдөнө.

Мексик улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ нь дээр дурдсан хуулиас гадна дараах эрх зүйн актыг дагаж мөрдөх ёстой.

- Гадаад валютын гүйлгээ, гадаад валют худалдах, худалдан авах үйл ажиллагааг зохицуулдаг Валютын тухай хууль (Ley del Mercado de Valores).
- Мөнгө угаахын эсрэг хууль (Ley Anti-Lavado de Dinero). Энэ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг тогтоодог.
- Төлбөрийн системийн тухай хууль (Ley de Sistemas de Pagos). Уг хуулиар ББСБ-уудыг төлбөрийн системийн операторын гишүүн байхыг шаарддаг.
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (Ley Federal de Protección al

Consumidor). Энэ нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах зохицуулалтыг бий болгож, ББСБ-аас харилцагчаа үйлчилгээ, төлбөрийн талаар тодорхой, ил тод мэдээллээр хангахыг шаарддаг.

Мексик дэх ББСБ-ууд мөн эдгээр зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөхийн тулд CNBV-ийн байнгын хяналт дор үйл ажиллагаагаа эрхэлнэ.

Дээр дурдсан улс орнуудад цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ-уудын харилцааг зохицуулах тогтолцоо нь өөр өөр байдаг ч нийтлэг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг зохицуулалт, хэрэглэгчийн эрхийг болон мэдээлэл хамгаалах зэрэг зохицуулалтууд нь ижил төстэй байна. ББСБ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүүгийн зах зээл, өөрийн байгууллагын болон харилцагчийн нэр хүндэд хохирол учруулахгүйн тулд үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэр бүртээ зохицуулалтын шаардлагыг бүрэн дагаж мөрдөнө.

## 3.2. СОНГОН СУДАЛСАН УЛС ОРОНД ҮЙЛДЭГДСЭН МӨНГӨН ГҮЙВУУЛГАТАЙ ХОЛБООТОЙ СОРИЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Сонгон судалсан улс орнуудад мөнгө гуйвуулгын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг авч үзвэл:

### Америкийн Нэгдсэн Улс:

**Western Union:** 2017 онд Western Union нь залилан мэхлэх, мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадаагүйн улмаас АНУ-ын Хууль зүйн яам (DOJ) болон Холбооны Худалдааны Комисс (FTC)-ын тооцоогоор 586

сая ам.долларын торгууль төлөх болсон. Тус компани нь хүн хууль бусаар хил давуулсан, гэмт хэрэгтнүүдийг хууль бусаар мөнгө шилжүүлсэн, залилан мэхлэгчид мөнгө гуйвуулгын үйлчилгээг ашиглан хэрэглэгчдийг залилан мэхлэх боломж олгосон гэдгээ хүлээн зөвшөөрсөн<sup>4</sup>.

**MoneyGram:** АНУ-ын Хууль зүйн яам, 2012 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр мөнгө угаахтай тэмцэх үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлээгүй,

<sup>4</sup> "Western Union to Pay \$586 Million Over Fraudulent Money Transfers," The New York Times, January 19, 2017

утсаар маркетингийн схемд мөнгө шилжүүлэх үйлчилгээгээ ашиглан хэрэглэгчдийг залилан мэхлэх боломж олгосон гэх гэм буруугаа хүлээсэн тул 100 сая ам.доллар төлүүлэх арга хэмжээ авсан<sup>5</sup>.

**Liberty Reserve:** Артур Будовский дэлхийн өнцөг булан бүрд гэмт хэрэгтнүүдийн хууль бус орлого /тухайлбал хөрөнгө оруулалтын луйвар, зээлийн картын луйвар, хувийн мэдээллийг хулгайлах, компьютерыг хакердсанаас олсон орлогыг цуглуулах, түгээх, хадгалах, угаах зорилгоор ашигладаг мөнгө дамжуулах гол үйлчилгээг/оос олон зуун сая ам.доллар угаасан далд ертөнцийн онлайн төлбөрийн кибер банкны систем болох Liberty Reserve-г 2006 онд үүсгэн байгуулж, ажиллуулж байсан. 2013 онд үүсгэн байгуулагч 42 настай Будовскийг Испанид баривчилж, АНУ-д шилжүүлэн өгчээ. 2013 оны тавдугаар сард АНУ-ын засгийн газар Liberty Reserve-ийг хаахаас өмнө дэлхий даяар 5 сая гаруй хэрэглэгчийн бүртгэлтэй үүний дотор АНУ дахь хэрэглэгчидтэй холбоотой 600,000 гаруй данс байсан бөгөөд сая сая гүйлгээг хийгдэж байжээ. Артур Будовский дижитал валютын бизнесээрээ дамжуулан 250 сая ам.долларыг гэмт хэргийн шинжтэй угаасан гэм буруугаа хүлээв. Иймд түүнд 2016 оны тавдугаар сарын 06-ны өдөр ял оноосон. Тус компанийг мөнгө угаах, хувийн мэдээлэл хулгайлах, хар тамхины наймаа зэрэг хууль бус гүйлгээнд 6 тэрбум гаруй ам.долларын гүйлгээ хийсэн гэж буруутгасан<sup>6</sup>.

#### Энэтхэг улс:

**Payworld:** 2019 онд дижитал төлбөрийн платформ Payworld нь Энэтхэгийн гадаад валютын зохицуулалтыг зөрчин Энэтхэгээс Дубай руу зөвшөөрөлгүй хууль бус мөнгөн гуйвуулга үйлдэхэд тусалсан гэж буруутгагдсан. Тус компани буруутай үйлдлээ үгүйсгэж байгаа<sup>7</sup>.

**Vodafone M-Pesa:** 2019 онд гар утасны мөнгө шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгч Vodafone M-Pesa-г Энэтхэгийн Нөөцийн банк (RBI) хэрэглэгчээ таних болон мөнгө угаахтай тэмцэх журам зөрчсөн гэж торгууль ногдуулсан. RBI нь Vodafone M-Pesa-г үйлчлүүлэгчийг зохих ёсоор шалгаж, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлээгүй болохыг тогтоож 3.05 сая рупи (ойролцоогоор 410,000 ам.доллар)-р торгожээ<sup>8</sup>.

**Weizmann Forex:** RBI -аас 2019 онд валютын болон мөнгө гуйвуулгын Weizmann Forex компанийг мөнгө угаахтай тэмцэх журмын зохих хяналтыг хэрэгжүүлж, үйлчлүүлэгчдэд зохих шалгалт хийж чадаагүй болохыг нь тогтоож 3 сая рупи (ойролцоогоор 400,000 ам.доллар)-ийн торгууль ногдуулсан<sup>9</sup>.

#### Филиппин улс:

**Филрем:** 2016 онд мөнгө гуйвуулгын үйлчилгээ эрхлэгч Philrem компанийг Бангладешийн банкнаас хулгайлагдсан 81 сая ам.долларыг угаасан хэрэгт холбогдуулсан. Уг хөрөнгийг Philrem болон хэд хэдэн банк, мөнгөн

<sup>5</sup> "MoneyGram to Pay \$100 Million for Fraudulent Money Transfers," The New York Times, November 9, 2012

<sup>6</sup> "Liberty Reserve Digital Currency Founder Pleads Guilty to Laundering \$250 Million," U.S. Department of Justice, October 31, 2014

<sup>7</sup> "ED arrests Payworld director in money laundering case," The Economic Times, October 16, 2019

<sup>8</sup> "Vodafone M-Pesa fined ₹3 crore by RBI for AML non-compliance," Livemint, October 10, 2019

<sup>9</sup> "RBI imposes Rs 3 crore penalty on Weizmann Forex for AML violations," The Economic Times, December 20, 2019



гуйвуулгын компаниудаар дамжуулан Филиппин рүү шилжүүлж, дараа нь казиногоор дамжуулан угаасан байна. Филиппиний засгийн газар Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулийг зөрчсөн Philrem компанийн эзэд болон удирдах ажилтнуудын эсрэг эрүүгийн хэрэг үүсгэсэн<sup>10</sup>.

**RCBC:** Мөнгө угаах гэмт хэрэгт Филиппиний Ризал Арилжааны Банкны Корпорац (RCBC) мөн холбоотой байсан. Иймд RCBC-г Филиппиний төв банкнаас хулгайлсан мөнгийг хууль бусаар шилжүүлэхээс сэргийлээгүй гэсэн үндэслэлээр торгууль ногдуулжээ. Мөн RCBC-ийн хэд хэдэн удирдлагуудыг мөнгө угаасан, банкны хууль зөрчсөн хэргээр буруутгасан<sup>11</sup>.

I-Remit: 2018 онд мөнгө гуйвуулгын I-Remit компанийг мөнгө угаахтай тэмцэх журмыг дагаж мөрдөөгүйн гэж Филиппиний төв банк торгууль ногдуулсан. Төв банк I-Remit нь мөнгө угаахын эсрэг хяналт хангалтгүй, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлээгүй болохыг тогтоожээ. Тус компанид 5 сая Филиппиний песо (олон улсын код PHP) (ойролцоогоор 100,000 ам.доллар)-ын торгууль ногдуулав<sup>12</sup>.

### Мексик улс:

Мексикт гарсан ББСБ-ын мөнгө гуйвуулгатай холбоотой гэмт хэргийн үйлдэл бол Вестерн Юнион /Western Union/ компани юм.

2018 онд Мексикийн засгийн газраас Вестерн Юнион компанийн мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэхэд шалгалт гүйцэтгэсэн.

Мөрдөн байцаалтын явцад Вестерн Юнион компани нь компани нь мөнгө угаахын эсрэг зохих хяналт, бодлого хэрэгжүүлээгүйн улмаас хууль бус үйл ажиллагаа, тухайлбал утсаар залилан мэхлэх, мөнгө угаах зэрэг хууль бус үйлдлүүдэд тус дөхөм үзүүлж, агентууддаа зохих шалгалт хийлгүйгээр, сэжигтэй үйлдлүүдийг мэдээлэхгүйгээр гүйлгээ хийх боломж олгосон болохыг тогтоосон. Вестерн Юнион компанийг мөнгө угаах, утасны залилангаас урьдчилан сэргийлж чадаагүй гэж 60 сая ам.долларын торгууль ногдуулсан.

Дээр дурдсан хэргүүд нь мөнгөн гуйвуулгын салбарт хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэхийн тулд хэрэглэгчээ таньж мэдэх болон мөнгө угаахын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэхийн чухлыг онцолж, холбогдох хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд өндөр торгууль, хуулийн хариуцлага хүлээлгэдэг болохыг илтгэж байна.

<sup>10</sup> "Philippines Charges Four Over Bangladesh Bank Heist," Reuters, March 15, 2016

<sup>11</sup> "Ex-RCBC manager convicted of money laundering," ABS-CBN News, January 10, 2020

<sup>12</sup> "I-Remit pays P5-M fine for AMLC violations," Manila Bulletin, May 7, 2018

### 3.3. ЦАХИМ МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ

Судалгаанд хамрагдсан улсуудын хувьд цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа бөгөөд харилцагчдадаа санал болгодог санхүүгийн бүтээгдэхүүн юм.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ–дын үйл ажиллагаанд байнгын хяналт нь аливаа асуудлыг томоохон асуудал болохоос өмнө илрүүлж, шийдвэрлэхэд туслах бөгөөд хяналт, зохицуулалт нь ББСБ–ын үйл ажиллагааг аюулгүй, ил тод байлгах, санхүүгийн системийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хангах, хэрэглэгчдийг хамгаалахад чухал ач холбогдолтой.

Хяналтад ихэвчлэн ББСБ–ын мөнгөн гуйвуулгын харилцааг зохицуулах холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэх, эрсдэл тодорхойлох, удирдах, үүссэн аливаа маргаан, гомдлыг шийдвэрлэх зэрэг асуудлууд багтана.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ–дад тавих хяналтыг тухайн ББСБ–ын үйл ажиллагаа явуулж буй тухайн улсын холбогдох төрийн зохицуулагч байгууллага гүйцэтгэдэг.

Зохицуулагч байгууллага нь ББСБ–ын үйл ажиллагаанд газар дээр нь хэсэгчлэн болон бүрэн хэмжээний хяналт шалгалт хийх, зайнаас ирүүлсэн санхүүгийн тайлан, баримт бичигтэй танилцаж байнгын хяналт тавьж ажилладаг.

Зохицуулагч байгууллага нь ББСБ–ын хэрэглэгчийн эрхийг хамгаалах, мэдээллийн хамгаалалт, эрсдэлийг удирдах хяналт, мөнгө угаах болон терроризмтой тэмцэх арга хэмжээ, харилцагчийн таньж мэдэх, гүйлгээний

хяналтын систем зэргийг үнэлж болно.

Нийтлэг ажиглагдсан зохицуулалтын хувьд мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор харилцагчийг таньж мэдэх, мөнгөн хөрөнгийн гарал үүслийг тодорхойлохтой холбоотой шаардлагуудыг нэлээд тавьдаг байна.

Мөн зохицуулагч байгууллага ББСБ–ын хууль бус үйл ажиллагааг илрүүлж, шийдвэрлэхийн тулд холбогдох хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллаж болно.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ–ын үзүүлж буй мөнгөн гуйвуулгын үйлчилгээг улс орон, харьяаллаас хамаарч зохицуулалт нь өөр өөр байж болох ч ерөнхийдөө дараах нийтлэг шинжийг агуулсан. Үүнд:

- » **Зохицуулалтын нийцэл** – ББСБ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон санхүүгийн үйлчилгээ, мөнгөн гуйвуулгатай холбоотой бүхий л холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой. Эдгээр журамд үйлчлүүлэгчийг таних, баталгаажуулах, гүйлгээг хянах, сэжигтэй үйл ажиллагааг мэдээлэх зэрэг багтана.
- » **Лиценз ба бүртгэл** – Олон оронд цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ нь тусгай зөвшөөрөл авах эсвэл холбогдох зохицуулах байгууллагад бүртгүүлэх шаардлагатай. Уг эрх мэдэлд төв банк, санхүүгийн зохицуулах байгууллага эсвэл бусад төрийн байгууллагууд багтаж болно.
- » **Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж



буй ББСБ нь үйлчилгээнийхээ хураамж, валютын ханш болон бусад нөхцөл, болзлыг ил тод болгох, хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийг дагаж мөрдөнө. ББСБ-аас гүйлгээтэй холбоотой асуудалтай тулгарсан харилцагчдад буцаан олголт эсвэл нөхөн төлбөр олгох ёстой.

- » **Мэдээллийн нууцлал** – ББСБ нь хэрэглэгчийн мэдээллийг найдвартай, нууцлалтай байлгах үүднээс мэдээллийн хамгаалалт, нууцлалын хуулийг чанд дагаж мөрдөнө.
- » **Гэрээний үүрэг** – ББСБ-ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь ББСБ болон мөнгө илгээгч, хүлээн авагчийн хооронд байгуулсан гэрээ байж болно. Эдгээр гэрээний нөхцөл, болзол нь хууль ёсны дагуу хүчин төгөлдөр байх ёстой. Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүсэх маргаан шийдвэрлэх үйл явц нь тухайн ББСБ-ын үйл ажиллагаа явуулж буй харьяалал, тухайн гүйлгээний тодорхой нөхцөл, ББСБ болон түүний харилцагчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөлөөс хамаарна. ББСБ-ууд маргаанаас зайлсхийх болон шийдвэрлэхэд чухал алхам бол холбогдох зохицуулалтын шаардлагуудыг дагаж мөрдөж, гэрээний нөхцөлүүд нь тодорхой, биелэгдэхээр байх явдал юм. ББСБ-ын маргааны шийдвэрлэлтийн нийтлэг байдлыг авч үзвэл:
  - **Холбогдох хууль** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээг зохицуулах холбогдох хууль тогтоомж нь ББСБ болон түүний харилцагчдын харьяаллаас хамаарч өөр өөр байж болно. Ихэнх тохиолдолд ББСБ-ын бүртгэлтэй эсвэл үндсэн үйл ажиллагаа

явуулдаг харьяаллын хууль үйлчилнэ. Мөн ББСБ болон харилцагчийн хооронд байгуулсан гэрээнд холбогдох хуулийг зааж өгч болно.

- **Маргаан шийдвэрлэх харьяалал** – ББСБ болон түүний харилцагчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөлөөс хамааран маргаан хянан шийдвэрлэнэ. Ихэнх тохиолдолд гэрээнд тодорхой шүүх, арбитр гэх мэт маргааныг шийдвэрлэх харьяаллыг зааж өгч болно. Эсвэл ББСБ-ын бүртгэлтэй буюу үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг харьяаллынх нь дагуу маргаан хянан шийдвэрлэх харьяаллыг тогтоож болно.
- **Арбитр** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний олон гэрээнд арбитрын заалтууд багтдаг бөгөөд маргааныг шүүхээр бус арбитрын шүүхээр шийдвэрлэхийг шаарддаг. Энэ нь маргааныг шийдвэрлэх илүү үр ашигтай, зардал багатай арга замыг бий болгож болно.
- **Зуучлах** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээний гэрээнд маргааныг зуучлагчаар дамжуулан шийдвэрлэх шаардлагатай зуучлалын заалтууд багтаж болно. Эвлэрүүлэн зуучлах нь маргааныг шийдвэрлэхэд бага зэрэг зөрчилдөөнтэй, илүү хамтран ажиллах боломжийг олгодог.
- **Зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх** – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ нь маргаан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөнө. Үүнд гомдлыг шийдвэрлэх үйл явц, тухайлбал, томилсон гомдол

хариуцсан ажилтантай байх ба тэрбээр үйлчлүүлэгчийн гаргасан гомдлыг хянах, гомдол шийдвэрлэх үйл явцад хамаарах алхмуудыг зааж, мэдээлэл өгөх зэрэг шаардлагууд багтаж болно.

» **Хил дамнансан зохицуулалт** – Хил дамнансан гүйлгээг хамарсан цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь гадаад валют болон татварын зохицуулалт, орон нутгийн хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

» **Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тавих** – Зохицуулагч байгууллага цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ–д зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоож болно. Энэхүү зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нь ББСБ–ын санхүүгийн тогтвортой байдал, тогтвортой байдлыг үнэлэх, үйл ажиллагаагаа аюулгүй, найдвартай эрхлэхэд ашигладаг санхүүгийн хэмжүүр болно.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хэмжээ нь харьяалал болон зохицуулах байгууллагаас хамаарч өөр өөр байж болно. Гэсэн хэдий ч хэрэглэж болох нийтлэг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг дурдъя. Үүнд:

» **Хөрөнгийн хүрэлцээний харьцаа (Capital Adequacy Ratio (CAR))** – Энэ нь ББСБ–ын алдагдлыг шингээх чадварыг илэрхийлдэг үзүүлэлт юм. ББСБ–ын дүрмийн санг эрсдэлд тооцсон хөрөнгөнд нь хувааж тооцдог. CAR өндөр байх тусам ББСБ нь санхүүгийн хувьд илүү найдвартай гэж үзэж болно.

– **Хөрвөх чадварын харьцаа (Liquidity Ratio)** – Энэ нь ББСБ–ын богино хугацаанд үүргээ биелүүлэх чадварыг хэмждэг. ББСБ–ын хөрвөх чадвартай

хөрөнгийг богино хугацаат өр төлбөрт нь хувааж тооцдог. Хөрвөх чадварын харьцаа өндөр байх нь ББСБ үүргээ биелүүлэх чадвартайг харуулна.

– **Хөшүүргийн харьцаа (Leverage Ratio)**

– Энэ нь ББСБ–ын өөрийн хөрөнгөтэй харьцуулахад эрсдэлд өртөх нийт хэмжээг хэмждэг. ББСБ–ын нийт хөрөнгийг өөрийн хөрөнгөд хуваах замаар тооцно. Хөшүүргийн харьцаа бага байх тусам ББСБ–ыг санхүүгийн хувьд илүү найдвартай гэж үзнэ.

– **Хөрөнгийн чанарын харьцаа (Asset Quality Ratio)** – Энэ нь ББСБ–ын хөрөнгөтэй холбоотой эрсдэлийг удирдах, хянах чадварыг хэмждэг.

ББСБ–ын чанаргүй зээлийг нийт зээлд нь хувааж тооцдог. Энэ харьцаа бага байх тусам ББСБ–ын хөрөнгийн чанар сайжирна.

– **Зохицуулалтын тайлан, хяналт** – ББСБ–ууд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтээ ханган ажиллаж байгаа эсэхэд зохицуулагч байгууллагууд байнгын хяналт тавьж, шалгалт хийх бөгөөд ББСБ нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээгээ зохицуулагч байгууллагад тогтмол хүргүүлж, аудит хийлгэх ёстой.

Ерөнхийдөө цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ нь хэрэглэгчдийг хамгаалах, санхүүгийн системийн нэгдмэл байдлыг хангахад чиглэсэн хууль эрх зүйн хүрээнд ажиллана.




## IV. МОНГОЛ УЛСЫН МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН УРСГАЛЫН ЧИГ ХАНДЛАГА, ББСБ-ЫН МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭ

### 4.1. МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН УРСГАЛЫН ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улсын Гадаад харилцааны яамны албан арьдарч байгаагаас 158 мянган иргэд буюу 80.1 бус мэдээллээр 2019 оны байдлаар нийт 197 хувь нь АНУ, Европын холбооны улсууд, БНСУ, мянган иргэн гадаад улс орнуудад ажиллаж, Япон, Австрали улсад байна<sup>13</sup>.

**Зураг 7.** Гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэд



Эх сурвалж: <http://hmc.mn/medee/v/32>

2020 оны байдлаар гадаадад Монгол Улсын 130 мянга орчим иргэн ажиллаж амьдарч, 25 мянга гаруй монгол оюутан суралцаж байна.


Тэдний эх орон руугаа шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 2017 оноос өмнө харьцангуй тогтвортой байв. Монгол Улс 2017 онд 269 сая ам.доллартой тэнцэх хэмжээний мөнгөн гуйвуулга хүлээн авсан.

Харин энэ тоо 2018, 2019 онд тус тус 440 сая, 561 сая ам.долларт хүрч огцом өссөн ч цар тахалтай холбоотой дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлын улмаас 2020 онд 549 сая ам.доллар болж буурсан<sup>14</sup>.

<sup>13</sup> <http://hmc.mn/medee/v/32>

<sup>14</sup> Дэлхийн банк, 2020. <https://data.worldbank.org/indicator/BX.TRF.PWKR.CD.DT?locations=MN>

**Зураг 8.** Гадаадад оршин суугаа иргэдийн эх орон руугаа явуулсан мөнгөн шилжүүлэг (ам.доллаароор)




Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/BX.TRF.PWKR.CD.DT?locations=MN>

Гадаадад оршин суугаа иргэдийн эх орныхоо эдийн засагт оруулах хувь нэмрийг илэрхийлдэг мөнгөн урсгал сүүлийн арав гаран жилд ДНБ-ний 2–4 орчим хувийн хооронд хэлбэлзэж байна.

Монгол Улсын эдийн засаг өсөлттэй байсан 2011 онд гадаадад ажиллаж амьдарч байсан монголчуудын мөнгөн гуйвуулгын урсгал ДНБ-ий 2.8 хувьд байсан. Харин 2012–2016 онд мөнгөн гуйвуулга харьцангуй тогтвортой болсон<sup>15</sup>.

**Зураг 9.** Мөнгөн гуйвуулга 2000–2022 он /ДНБ–д эзлэх хувиар/



Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/BX.TRF.PWKR.DT.GD.ZS?locations=MN>

<sup>15</sup> Монгол Улсын хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ 2018



Дэлхийн Банкны хөгжлийн шалгуур үзүүлэлтэд Монгол Улс 2020 онд ДНБ-ий 4.1 хувьтай тэнцэх хэмжээний гуйвуулгыг гадаадад амьдарч буй ажиллагсадаас хүлээж авсан<sup>16</sup>. Энэ үзүүлэлтээр хамгийн их валют хүлээн авдаг улс орны жагсаалтын 50 дугаар байрт бичигджээ<sup>17</sup>.

Харин 2022 онд ДНБ-ий 2.4 хувьтай тэнцэх хэмжээний гуйвуулгыг хүлээн авсан байна.

Монголбанкнаас эрхлэн гаргасан Гадаад секторын статистик 2023 оны I дүгээр улирлын тоймд Монгол Улс 154 сая ам.долларыг хувийн гуйвуулга, хандив тусламж болон бусад

хоёрдогч орлого хэлбэрээр хүлээн авч, 19 сая ам.долларын зардлыг гадагш шилжүүлсэн. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал орлого 3 хувиар, зардал 12 хувиар тус тус буурсан гэжээ.

Гадаадад ажиллаж, амьдарч буй монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулга өмнөх оноос 21 хувиар, гадаад руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 7 хувиар тус тус буурсан, цэвэр дүнгээр 12 сая ам.долларын орлого хүлээн авсан байна.

## Хүснэгт 2. Хувийн гуйвуулга 2023.I /мян ам.доллар/

Үзүүлэлт	Хүлээн авсан		Шилжүүлсэн	
	Дүн	Хувь	Дүн	Хувь
Солонгос	10,418	35%	3,624	21%
АНУ	8,581	29%	4,432	26%
БНХАУ	49	0%	446	3%
Хонконг	197	1%	256	1%
Их Британи	598	2%	670	4%
ОХУ	28	0%	-	0%
Сингапур	2,522	9%	437	3%
Швейцар	560	2%	199	1%
Герман	2,609	9%	916	5%
Япон	175	1%	634	4%
Бусад	3,865	13%	5,739	33%
НИЙТ	29,603	100%	17,354	100%

Эх үүсвэр: Гадаад секторын статистик /2023 оны I дүгээр улирал/

Монгол Улсаас мөнгө гуйвуулга илгээх, хүлээн авах зардлын талаарх нэгдсэн мэдээллийн сан одоогоор байхгүй байна. Ихэнх банкууд өөрийн цахим хуудсанд Монголоос мөнгө шилжүүлэхтэй холбоотой шимтгэл хураамжийн мэдээллийг байршуулсан байдаг. Жишээлбэл 200 ам.доллартой тэнцэх хэмжээний гүйлгээ

хийхэд корреспондент банкны үйлчилгээтэй холбоотойгоор үнийн дүнгийн 18–28 хувийг шимтгэлд авдаг.

Олон улсын мөнгөн гуйвуулгын операторуудын сүлжээгээр дамжуулж хийх тохиолдолд гүйлгээний хураамж 6–8 хувийн хооронд хэлбэлзэж байна.

Харин ББСБ мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд нийт дүнгийн 1.0–2.5 хувьтай тэнцэх хэмжээний шимтгэл авч байна.

<sup>16</sup> <https://tradingeconomics.com/mongolia/remittance-in-flows-to-gdp-percent-wb-data.html>

<sup>17</sup> <https://unread.today/c/insight-international-transfer-1>;  
<https://ikon.mn/n/1xtm>

## 4.2. ЦАХИМ МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ББСБ–ЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2023 оны I дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй 514 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 40 ББСБ нь цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Ийнхүү мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ББСБ–ууд эрхэлснээр харилцагчдадаа Арилжааны банкны SWIFT–ээр дамжуулан шилжүүлэг хийхэд 100 ам.доллар эсхүл 1000 ам.доллар ч байсан 35–60 ам.долларын шимтгэл авдаг, цаг хугацааны хувьд 2–7 хоног зарцуулах ба өөрийн биеэр баримт бичиг авч очих, анкет бөглөх, хүлээн авагч нь мөн өөрийн биеэр банкин дээр очиж хүлээн авах, бэлнээр авахад шимтгэл төлөх зэрэг асуудлыг хөнгөвчилж, үйлчилгээг хүртээмжтэй болгосон.

Өнөөдөр жишээлбэл: SendMN–ийг санхүүгийн апп ашиглаж, дэлхийн 170 гаруй улсын 435 мянга гаруй цэгээс мөнгө шилжүүлж, хүлээн авч байна. Мөн Өмнөд Солонгос, Япон, Орос, Хятад, Зүүн өмнөд Азийн нийт арван улс руу харилцагчид өөрийн гар утасны аппликейшн ашиглан “шууд” мөнгөн гуйвуулга хийх боломжтой болсон.

Төв Шууданд байрлах “Ард кредит” ББСБ–ын салбараас “Монгол шуудан” ХК–ийн салбаруудаар дамжуулан дэлхийн 160 гаруй орны шуудангийн 400 мянган гаруй салбараар дамжуулан мөнгө хүлээн авах, гуйвуулга хийж байна.

“Сайн финанс” ББСБ гэхэд олон улсын мөнгөн гуйвуулгыг гар утасны апп болон цахим хуудас ашиглан хийж байна.

ББСБ–уудын олон улсад хийгдэх мөнгөн гуйвуулгын шимтгэлийн хэмжээ тухайлбал 300 ам.долларт 4 ам.доллар, 500.0 ам.долларт 5.0 ам.доллар ба ерөнхийдөө шилжүүлэх мөнгөн дүнгийн 1.0–2.5 хувь хооронд байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос олон нийтэд мэдээлдэг ББСБ–уудын 2023 оны I улирлын санхүүгийн тайлан нэгтгэл<sup>18</sup>–ийн танилцуулгад санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй ББСБ өмнөх оны мөн үеэс 2 ББСБ–аар нэмэгджээ.

<sup>18</sup> ББСБ–уудын 2022 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

**Хүснэгт 3.** Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ<sup>19</sup>

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2022-	2023-	тоо	хувь
	Нийт ББСБ-ын тоо	529	514	(15)	-2.8%
1	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	38	40	2	5.3%

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй 40 ББСБ нь газар зүйн байршлын хувьд Улаанбаатар хотод оршиж байна.

**Хүснэгт 4.** Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа төрлөөр<sup>20</sup>


№	ТЗ-тэй ББСБ-ын тоо	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
		513	64	476	37	36	420	93	5	508	26
1	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	40	21	27	13	-	39	1	3	37	1

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх ББСБ-уудын мөнгөн гуйвуулгын орлого өмнөх оны мөн үеэс 95.4 хувиар өсөж 1,037,080.4 сая төгрөгт хүрчээ.

**Хүснэгт 5.** Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/

ОРЛОГО	2021	2022	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Мөнгөн гуйвуулга	530.6	1,037.1	0.4%	506,441.1	95.4%

Мөнгөн гуйвуулгын орлогыг сүүлийн 4 жилийн | улирлаар харуулбал дараах байдалтай байна.

**Зураг 10.** Мөнгөн гуйвуулгын орлого 2020.I-2023.I

<sup>19</sup> ББСБ-уудын 2022 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

<sup>20</sup> ББСБ-уудын 2022 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

Мөнгөн гуйвуулгын орлогыг задалж харуулбал:

**Хүснэгт 6.** Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Мөнгөн гуйвуулга	1,037.1	919.4	816.7	220.4	-	1,037.1	-	220.4	-

2023 оны I улирлын байдлаар нэр бүхий 18 ББСБ 48.8 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс нэр бүхий 7 ББСБ 4.8 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй байна.

**Хүснэгт 7.** Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	Дүн	Эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХК
Нийт	48,812.7	100.0	36,620.9	32,853.8	15,958.9	48,812.7	690.7
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	4,832.0	9.9	4,708.8	2,930.2	1,901.8	4,832.0	690.7


Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс 70.5 хувиар буурсан.

**Хүснэгт 8.** Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 2019.I–2023.I /мянган төгрөгөөр/

Өглөг	2019-I	2020-I	2021-I	2022-I	2023-I
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	2,545,088.9	6,178,955.0	3,753,541.3	16,370,513.9	4,832,041.5

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийг сүүлийн 5 жилийн I улирлуудын байдлаар зургаар харуулбал:

**Зураг 11.** Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг /сая төгрөгөөр/



Нийт өр төлбөр ба эздийн өмч болон Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн хооронд ач холбогдол бүхий шугаман хамаарал бий эсэх шугаман хамаарлыг шинжлэв.



Үүний тулд сүүлийн 3 жилийн I улирал бүрд мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй байсан 4 ББСБ-ын тоон үзүүлэлтэд тооцоолол хийсэн.



Ингэхдээ тэгш өнцөгт координатын хавтгайн хэвтээ тэнхлэгт нийт өр ба эздийн өмч, босоо тэнхлэгт мөнгөн гуйвуулгын үйлчилгээний

өглөг тоог авав. Нэг цэг бүр нь нэг оны I улирлыг илэрхийлнэ. Үр дүнг тархалтын диаграммаар дор харуулав.

**Зураг 12. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг ба Нийт өр төлбөр ба эздийн өмчийн хамаарал**



Нэг хувьсагчийн утга өөрчлөгдөхөд нөгөө хувьсагчийн утга дагаад өөрчлөгдөж байгаа эсэх өөрөөр хэлбэл хувьсагчууд хоорондоо тодорхой харьцаатайгаар харилцан бие биедээ нөлөөлж байгаа эсэхийг тайлант жилийн I улирлын

Нийт өр төлбөр ба эздийн өмч болон Мөнгөн гуйвуулга үйлчилгээний өглөг хоорондын хамаарлыг тооцож зураглаж үзвэл сөрөг буюу бага хамааралтай нь харагдаж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 9. Корреляцийн шинжилгээ**

	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	Нийт өр төлбөр ба эздийн өмч
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	1	
Нийт өр төлбөр ба эздийн өмч	0.313707462	1

Санхүүгийн зохицуулах хороо нь улирал бүр ББСБ-уудаас ирүүлсэн зохистой харьцааны тайлан мэдээнд зайны хяналт тавьж шаардлагатай бол тайлангийн хариу, Улсын байцаагчийн албан шаардлагаар илэрсэн зөрчил дутагдалд хугацаатай үүрэг даалгавар өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй бол үйл ажиллагааг түдгэлзүүлэх хүчингүй болгох, торгуулийн арга хэмжээ авах ба гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл харьяаллын дагуу харьяа байгууллагаар шалгуулахаар шилжүүлдэг байна.


Санхүүгийн зохицуулах хороо 2021 онд 36 ББСБ-аас 2-т, 2022 онд 37 ББСБ-аас 14-т итгэлцлийн үйлчилгээ, төслийн зээлийн санхүүжилт, өрийн бичиг, эх үүсвэр болон валют арилжаа, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн хэрэгжилтэд хэсэгчилсэн газар дээрх хяналт шалгалтыг гүйцэтгэсэн. Харин ББСБ-дын мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд тусгайлсан хяналт шалгалт хийгдээгүй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны Мөнгө угаахтай тэмцэх албанаас хагас жил тутам

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ыг ББСБ-аар өөрсдөөр нь бөглүүлж түүнд нь эрсдэлийн үнэлгээ хийдэг. Тус эрсдэлийн үнэлгээгээр 2022 оны жилийн эцсийн байдлаар цахим төлбөр тооцоо, мөнгөн

гуйвуулгын үйлчилгээ эрхлэх 40 ББСБ-ын 32 буюу 82.5 хувь нь бага эрсдэлтэй, 4 буюу 10 хувь нь маш бага эрсдэлтэй гэж үнэлүүлснээс харвал Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт амжилттай мөрдөгдөж байна гэж үзэхээр байна.

**Зураг 13. МУТС эрсдэлийн үнэлгээний түвшин**



2022 онд Санхүүгийн зохицуулах хороонд ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой иргэд, аж ахуйн нэгжээс нийт 99 өргөдөл гомдол ирснээс мөнгөн гуйвуулгатай холбоотой 1 өргөдөл байгаа нь гадаадаас шилжүүлсэн мөнгийг еврогоор авах хүсэлт байв.

Мөн Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) сайтад анхан шатны шүүхийн хүчинтэй шийтгэх тогтоолуудыг шүүж үзэхэд Эрүүгийн хуулийн

хуулийн 26.1 “Кибер орчинд хууль бусаар халдах”, 26.2 “Кибер орчинд хууль бусаар халдах, программ хангамж, техник хэрэгсэл бүтээх, бэлтгэх, борлуулах, ашиглах, тараах” зүйлээр зүйлчилж шийдвэрлэсэн нийт 20 шүүхийн шийдвэрийг нээлттэй байршуулснаас 18 нь Эрүүгийн хуулийн 26.1-д заасан гэмт хэргийг хулгайлах, цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэрэгтэй давхар зүйлчилж шийтгэсэн байна.

Харин цахим мөнгөн гуйвуулгатай холбоотой гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.



#### 4.3. МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТАД МӨРДӨЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

Санхүүгийн зохицуулах хороо 2002 онд батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу ББСБ болон санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй бусад банк бус хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, цуцлах бүрэн эрхтэй.

Хуулийн дагуу төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй ББСБ-ууд хоёр тусгай зөвшөөрлийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос давхардуулж авах шаардлагатай болсон тул 2021 онд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа, холбооны зохицуулах хороо (ХХЗХ) банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид тусгай зөвшөөрөл олгох чиг үүргийг хэрхэн хуваарилахыг тодорхой тусгасан хамтран санамж бичиг байгуулсан.

Монгол Улсын хууль тогтоомжид цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн тогтолцоо бүрдсэн гэж үзэж болно. Үүнд:

**Үндэсний төлбөрийн системийн тухай хууль<sup>21</sup>** – 2017 онд батлагдсан Үндэсний төлбөрийн системийн тухай хууль нь Монгол Улсын төлбөр тооцооны тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Энэхүү хууль нь цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ-дад хамаарах бөгөөд Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авсан байх ёстой.

**Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль<sup>22</sup>** – 2002 онд батлагдсан. Тус хуулиар Банк бус санхүүгийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон

тусгай зөвшөөрлийн дагуу Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд эрхлэх бөгөөд мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6–д “цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ...”–г банк бус санхүүгийн үйл ажиллагаанд хамааруулахаар хуульчлагдсан.

Хуулийн 4–р зүйлийн 4.1.5 “цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ” гэж бусдын мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернэт, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог нь гүйцэтгэх ажиллагааг; гэж зааснаар цахим төлбөр тооцооны үйлчилгээ болж байдаг бөгөөд энэхүү заалтаар “банк бус санхүүгийн байгууллага нь төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа” зэрэг үйл ажиллагааг эрхэлж болох ба энэ үйл ажиллагаатай холбогдсон төлбөр тооцоог банкаар зуучлуулж банк хоорондын төлбөр тооцоонд шууд бус оролцогчийн үүрэг гүйцэтгэхээр тусгагдсан.

Энэ хууль нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулсан. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар Санхүүгийн зохицуулах хороо нь банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага байхаар тодорхойлсон.

<sup>21</sup> <https://legalinfo.mn/mn/detail/12668>

<sup>22</sup> <https://legalinfo.mn/mn/detail/103>

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль<sup>23</sup> – мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эрх зүйн үндсийг тогтоож өгсөн.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль<sup>24</sup> – эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдэд үзүүлэх мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан.

Кибер аюулгүй байдлын тухай хууль<sup>25</sup> – кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Цахим гарын үсгийн тухай хууль<sup>26</sup> – цахим орчинд хүн, хуулийн этгээд цахим гарын үсэг хэрэглэхийг зохицуулна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль<sup>27</sup> – Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ нь хэрэглэгчийн мэдээллийг зөвшөөрөлгүй нэвтрэх, ашиглах, задруулахаас хамгаалах, мэдээл цуглуулах, ашиглах, хадгалах нөхцөл шаардлагыг мөрдөнө.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль<sup>28</sup> – Хэрэглэгчдийг хууран мэхлэх арилжаатай холбоотой үйлдлээс хамгаалах, хохирлыг нөхөн төлж барагдуулах зохицуулал тусгасан.

Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй

этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам<sup>29</sup> – Энэ журамд цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ–дад тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг тусгасан. Уг журмын дагуу Банкнаас бусад цахим мөнгө гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөгөөс доошгүй байх ёстой бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг зохицуулалтыг дагаж мөрдөх ёстой.

Цахим мөнгөний журам<sup>30</sup> – Монголбанкнаас гаргасан уг журамд цахим мөнгөний үйлчилгээ, үйлчилгээ эрхлэгчдэд тавих шаардлагыг тусгасан. Уг журамд ББСБ–аас хураамж, хураамж, валютын ханшийн талаар тодорхой, ил тод мэдээлэл өгөх, харилцагчийн маргааныг шийдвэрлэхэд чиглэсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журамтай байхыг шаарддаг.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам<sup>31</sup> – Монголбанк төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж буй ББСБ–дад мөрдөх мөнгөн гуйвуулгад тавигдах шаардлагуудыг тодорхойлсон. ББСБ–аас харилцагчийн нягтлан шалгах, сэжигтэй гүйлгээнд хяналт тавих, сэжигтэй гүйлгээг холбогдох байгууллагад мэдээлэхийг шаарддаг.

Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам – энэ журам нь үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, хөрөнгө хуримтлуулах,

<sup>23</sup> <https://legalinfo.mn/mn/detail/9242>

<sup>24</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230554816671>

<sup>25</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390365491061>

<sup>26</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390355252531>

<sup>27</sup> <http://www.frc.mn/resource/frc/Document/2023/02/01/y079>

<sup>28</sup> <https://legalinfo.mn/mn/detail/551>

<sup>29</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231238887911>

<sup>30</sup> <https://old.legalinfo.mn/annex/details/8386?lawId=13302>

<sup>31</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14078>



гэмт хэргийг санхүүжүүлэх зэрэг хууль бус үйлдэлд ашиглахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн.

Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги<sup>32</sup> нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Уг стратеги нь үндэсний төлбөрийн системийн оролцогч талуудын хамтын ажиллагаа, эрсдэлийг удирдах, ил тод байдлыг хангах, зохистой засаглалыг хэрэгжүүл, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам болон холбогдох яам, төлбөрийн системийн үйлчилгээ үзүүлэгчид болон системийн операторууд хоорондын өмчлөл, хариуцлагыг бий болгох зэргийг онцгойлсон.

## ДҮГНЭЛТ

Дүгнэж хэлэхэд, ББСБ-аас үзүүлж буй хувь хүн, аж ахуйн нэгжээс нөгөөд мөнгө шилжүүлэх цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ дэлхий даяар улам бүр түгээмэл болж, мөнгө шилжүүлэх ажлыг хялбар, зардал бага, хурдан гүйцэтгэх боломжтой болж байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.22-т “мөнгөн гуйвуулга” гэж төлбөр шилжүүлэгч, төлбөр хүлээн авагчийн нэр дээр данс үүсгэлгүйгээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх Монголбанкны зөвшөөрөлтэй эрхлэх үйлчилгээг;<sup>33</sup> гэж тодорхойлсноор төлбөр шилжүүлэгч, төлбөр хүлээн авагчийн нэр дээр данс үүсгэлгүйгээр төлбөрийн үйлчилгээ хийгддэг тул бусад санхүүгийн үйл ажиллагаанаас ялгаатай.

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ нь улс орон бүрд харилцан адилгүй эрх зүйн зохицуулалттай ч нийтлэг цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан, харилцагчаа таньж мэдэх, мөнгө угаахтай тэмцэх журам, хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, мэдээлэл хамгаалах хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

Эдгээр хууль тогтоомжийг дагаж мөрдөх нь хүндрэлтэй байж болох ч ББСБ-ууд харилцагчидтайгаа итгэлцлийг бий болгох, хурдацтай хөгжиж буй цахим мөнгөн гуйвуулгын салбарт өрсөлдөх давуу талыг хадгалах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, эрсдэлээс урьдчилсан сэргийлэх зэрэг нэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

Харин зохицуулагч байгууллагуудын хувьд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажуулснаар цахим мөнгөн гуйвуулгын салбарын тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааг аюулгүй, ил тод болгох, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зэрэгт чухал үүрэг гүйцэтгэдэг.

<sup>32</sup> <https://legalinfo.mn/mn/detail/12668>

<sup>33</sup> <https://legalinfo.mn/mn/detail/12668>

Энэхүү судалгаанд ББСБ–ын хувьд цахим мөнгөн гуйвуулгын эрх зүйн зохицуулалт, зохицуулагч байгууллага, үүссэн асуудал түүний шийдвэрлэлт зэрэг хөндсөн болно.

Судалгаа маань ББСБ–ын цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж түүхийн товч, мөнгөн гуйвуулгын урсгал, зардал эхэлсэн. Дараа нь Дэлхийн банк, ОУВС, ФАТФ зэрэг олон улсын байгууллагуудаас мөнгөн гуйвуулгын эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж буй эрх зүйн акт, түүний онцлог, хяналт зохицуулалтыг судлав. Мөн ББСБ–ын хэвийн үйл ажиллагааг хангах зохистой харьцааны үзүүлэлтийг дурдлаа.

Үүний дараа АНУ, Энэтхэг, Филиппин, Их Британи, Мексик, Монгол зэрэг улс орнуудын цахим мөнгөн гуйвуулгын эрх зүйн зохицуулалт, зөрчил шийдвэрлэлтийн талаар тусгасан.

Дээр сонгон судалсан улс орнуудад цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг ББСБ–уудын харилцааг зохицуулах тогтолцоо нь өөр өөр байдаг ч нийтлэг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг зохицуулалт, хэрэглэгчийн эрхийг болон мэдээлэл хамгаалах зэрэг зохицуулалтууд нь ижил төстэй байна.

Цахим мөнгөн гуйвуулгатай хууль тогтоомж зөрчсөн нийтлэг асуудалд залилан, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх орно. ББСБ–ууд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөж, хууль эрх зүйн орчинд гарсан өөрчлөлтийг цаг тухайд нь хэрэгжүүлэх нь цаг үетэйгээ зэрэгцэн амжилттай үйл ажиллагаа явуулж, харилцагчдынхаа мөнгөн хөрөнгийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой хэрэв хууль тогтоомж зөрчих юм бол өндөр торгууль, хариуцлагын шийтгэл хатуу байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ улам бүр дэлгэрэх өнөө үед зохицуулагч байгууллагын зүгээс тус үйлчилгээ үзүүлэгч ББСБ–д хийх хяналт, зохицуулалтыг эрчимжүүлэх, ББСБ–уудыг эрхлэх үйл ажиллагаанаас нь хамааруулж үйл ажиллагаанд тавих зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ялгаатай тооцох, бодит цагийн горимын хяналтыг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Мөн мөнгөн гуйвуулгын шимтгэл хураамжийн талаарх мэдээллийг тогтмол цуглуулж мэдээллийн сан үүсгэх, олон нийтэд ил тод мэдээлэх мөн Санхүүгийн зохицуулах хороо сар бүр зохицуулалттай этгээдээс хүлээн авдаг цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тайлан<sup>34</sup>–д тусгасан мэдээллийн цар хүрээг өргөтгөх саналтай байна.

Түүнчлэн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг өндөр болон жил дараалан өглөгтэй тайлагнасан ББСБ–уудад төлөвлөгөөт хэсэгчилсэн газар дээрх шалгалтад хамруулж шалтгааныг тодруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байгаа эсэх болон зайнаас гүйцэтгэсэн эрсдэлийн үнэлгээг баталгаажуулж болно.

<sup>34</sup> <http://www.frc.mn/p/469>



## ЭХ ҮҮСВЭР

- Банкны тухай хууль; Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль; Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль; Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль; Үндэсний төлбөрийн системийн тухай хууль; Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, холбоос: <https://legalinfo.mn>
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам; Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам; Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам; Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам; Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам, холбоос: <https://legalinfo.mn/>
- Цахим мөнгөний журам , холбоос: <https://old.legalinfo.mn/annex/details/8386?lawid=13302>
- Монгол Улсын хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ тайлан, 2018 он
- Монгол Улсын гадаад секторын тойм 2023 он 1 дүгээр улирал
- Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг 2022–2026 онд хөгжүүлэх стратеги
- <https://www.mglbar.mn/a/4597>
- <https://www.skyquestt.com/report/digital-remittance-market>
- Deloitte, “Digital Remittances: A New Era of Growth for Non-Bank Financial Institutions,” 2019
- Asian Development Bank, “Digital Financial Services for Remittances: The Role of Non-Bank Financial Institutions,” 2020
- World Bank Group, “Digital Financial Services for Remittances: Opportunities and Challenges for Non-Bank Financial Institutions,” 2019,
- International Finance Corporation, “Digital Financial Services for Remittances: A Guide for Non-Bank Financial Institutions,” 2019,
- Financial Action Task Force (FATF). (2019). Guidance for a risk-based approach to virtual assets and virtual asset service providers.
- International Organization for Migration (IOM). (2019). Regulatory challenges facing the remittance industry: A global perspective. Retrieved from
- World Bank. (2019). Remittance prices worldwide
- <https://www.worldbank.org/en/news/press-release/2023/06/13/remittances-remain-resilient-likely-to-slow>
- [https://www.1212.mn/mn/statistic/statcate/573087/table-view/DT\\_NS0\\_0100\\_001V10](https://www.1212.mn/mn/statistic/statcate/573087/table-view/DT_NS0_0100_001V10)
- <http://hmc.mn/medee/v/6>

**ХАВСРАЛТ 1.**

**ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО, МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН<sup>35</sup>**

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

Д/д	Валютын төрөл	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ /тайлант үеэр/						Хувь
		Шилжүүлсэн			Хүлээн авч олгосон			
		Валютын дүн	Гүйлгээний тоо	Төгрөгт хөрвүүлсэн дүн	Валютын дүн	Гүйлгээний тоо	Төгрөгт хөрвүүлсэн дүн	
1	USD						#DIV/0!	
2	EUR						#DIV/0!	
3	JPY						#DIV/0!	
4	CHF						#DIV/0!	
5	GBP						#DIV/0!	
6	CNY						#DIV/0!	
7	RUB						#DIV/0!	
8	KRW						#DIV/0!	
9	Бусад валют						#DIV/0!	
<b>НИЙТ</b>		-	0	-	-	0	-	
							Хамгийн их	#DIV/0!

**ТАМГА**

**ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/

ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

<sup>35</sup> <http://www.frc.mn/p/469>

# 3

## ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СИСТЕМИЙН ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Гүйцэтгэсэн: С.Будбаяр<sup>5</sup>



<sup>5</sup> СЗХ–ны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн

## ХУРААНГУЙ

Санхүүгийн хямрал нь хяналтын тогтолцооны алдааг ил болгож, цаашид санхүүгийн салбарыг зохицуулах шаардлагатайг харуулсан. Системийн хувьд ач холбогдол бүхий байгууллагуудын хяналт, зохицуулалтын аргачлалыг өөрчлөх шаардлага үүсээд байна.

Энэхүү судалгаагаар Монгол Улсын даатгалын зах зээлийн системийн хэмжээнд үзүүлэх эрсдэлийн нөлөөг эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалаар тооцон үнэлэхийг зорьсон.

Судалгаанд 2017 оны 4 дүгээр улирлаас 2022 оны 4 дүгээр улирал хүртэлх 21 улирлын хугацаанд цуваа тоон мэдээллийг 7 бүлгийн 41 үзүүлэлтээр тооцооллоо. Үүний тулд үзүүлэлт тус бүрийн дундаж болон стандарт хазайлтыг тооцож, түүнээс давсан нөхцөлд системийн эрсдэл, хямрал тохиолдоно гэсэн таамаглал дэвшүүлсэн.

Системийн эрсдэл тохиолдох эсэх магадлалыг 2017 онд тохиолдсон санхүүгийн мөчлөгийн ёроол цэгийг жишиг болгосон ба хямрал тохиолдсон үеийн дараагийн улиралд буюу 2018 оны 1 дүгээр улиралд ихэнх үзүүлэлт нь шар, улаан болсон нь хямралын нөлөөлөл бий болсныг илтгэж байна. Мөн дэлхий нийтээр эдийн засаг тогтворгүй болсон Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үе /2020 оны 1 дүгээр улирал/ болон дараагийн улирлуудад ихэнх үзүүлэлтэд хямралын нөлөөлөл ажиглагдсан болно.

*Түлхүүр үг: даатгалын зах зээл, системийн эрсдэл, эрт илрүүлэх дохиоллын систем*

*JEL ангилал: G18, G22, D81*

## АГУУЛГА

I.	УДИРТГАЛ	78
II.	ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СИСТЕМИЙН ЭРСДЭЛ	79
III.	СУДЛАГДСАН БАЙДАЛ	85
IV.	СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	86
V.	ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	89
VI.	ЭМПИРИК СУДАЛГАА	91
	ДҮГНЭЛТ	95
	ЭХ СУРВАЛЖ	96
	ХАВСРАЛТ	97
	ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	
	Хүснэгт 1. Системийн эрсдэл үүсэх шалтгаан	80
	Хүснэгт 2. Системийн эрсдэлийн хэмжигдэхүүн	83
	Хүснэгт 3. Даатгалын зах зээлийн системийн эрсдэлийг үнэлэх үзүүлэлтүүд	87
	ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
	Зураг 1. Системийн нөлөө бүхий даатгалын компаниуд /2015 оны байдлаар/	79
	Зураг 2. Системийн эрсдэлийг арилгах алхам	80

---

Зураг 3.	Дэлхийн банкны салбар болон даатгалын зах зээлийн системийн эрсдэлийн оноожуулалт	81
Зураг 4.	Системийн эрсдэлийн 4 шалгуур	82
Зураг 5.	Даатгалын эдийн засгийн судалгааны олон улсын холбооноос гаргасан 5 зөвлөмж	82
Зураг 6.	Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн тодорхойлсон хоёрдогч шалгуур	84
Зураг 7.	Даатгалын зах зээлийн системийн эрсдэлийн судлагдсан байдал	86
Зураг 8.	Системийн эрсдэлийн зураглалын хэмжигдэхүүн	88
Зураг 9.	Жишээ: нийт орлогод эзлэх цэвэр орлогын хэмжээ	89
Зураг 10.	Даатгалын зах зээлийн нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	89
Зураг 11.	Даатгалын зах зээлийн хураамжийн орлого /тэрбум төгрөг/	90
Зураг 12.	Даатгалын зах зээлийн нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	90
Зураг 13.	Даатгалын зах зээлийн нөөц сангийн хэмжээ /тэрбум төгрөг/	90
Зураг 14.	Хямралтай болон хямралын дараах улирлын үзүүлэлтийн төлөв байдал	91 92
Зураг 15.	Монгол Улсын даатгалын зах зээлийн системийн эрсдэлийн оноолт /улирлаар/	93 94
Зураг 16.	Даатгалын зах зээлийн системийн эрсдэлийн зураглал	

---



## I. УДИРТГАЛ

Даатгалын компаниуд нь санхүүгийн болон эдийн засгийн эрсдэлээс хамгаалах үйлчилгээ үзүүлэгчийн хувьд эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг. Сүүлийн жилүүдэд даатгалын компаниудын системийн эрсдэлд үзүүлэх нөлөө нэмэгдсэн.

Олон улсын валютын сангийн тайланд дурдсанаар энэхүү өсөлт нь үндсэн 2 шалтгаанаас үүдэлтэй байна. Нэгдүгээрт, даатгагчдын зээлийн хүүгийн мэдрэмж нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл, нийт эрсдэлд өртөх магадлал нэмэгдсэн. Хоёрдугаарт, цахим даатгалын эрсдэл нэмэгдсэн. Дэлхийн санхүүгийн системийн холбоо хамааралтай уялдуулан дэвшилтэт технологид илүү их найдах, кибер аюул заналхийлэл нь системийн шинж чанартай болж байна гэсэн үг юм.

Санхүүгийн байгууллагууд хоорондын холбоо хамаарал, шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг зохицуулагүйн улмаас үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөсрөлт хагарснаас үүдэн дэлхий нийтийг хамарсан 2008–2009 оны санхүүгийн хямралын дараа системийн эрсдэлийг хязгаарлах зорилгоор зарим зохицуулагч байгууллагууд макро зохистой бодлого хэрэгжүүлэхийг дэмжсэн.

Ялангуяа даатгалын зах зээлд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /FSB/ нь дэлхийн системийн нөлөө бүхий даатгагчдын жагсаалтыг гаргасан бөгөөд эдгээр байгууллагуудад зориулсан тусгай бодлогын арга хэмжээг 2019 оноос хэрэгжүүлж байна. Макро–зохистой бодлогыг эхлүүлэх оролдлогыг үл харгалзан ихэнх даатгалын зохицуулалт нь микро–зохистой шинж чанартай хэвээр байна.

Энэхүү судалгааны ажлын нэгдүгээр бүлэгт даатгалын зах зээлийн системийн эрсдэлийн талаар болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан системийн эрсдэлийг үнэлэх хэмжигдэхүүнийг, хоёрдугаар бүлэгт эрт илрүүлэх дохиоллын системийн арга зүй болон даатгалын зах зээлийн системийн эрсдэлийг тодорхойлох үзүүлэлтүүдийг тодорхойлсон бол гуравдугаар бүлэгт даатгалын зах зээлийн 2022 оны нөхцөл байдлыг тодорхойлсон. Дөрөвдүгээр бүлэгт дээрх аргачлалыг ашиглан даатгалын зах зээлийн 2017 оны 4 дүгээр улирлаас 2022 оны 4 дүгээр улирал хүртэлх 21 улирлын хугацаан цуваа тоон мэдээллийг 7 бүлгийн 40 үзүүлэлтээр тооцоолол хийж, санал дүгнэлт хэсгээр судалгаагаа дүгнэсэн болно.

## II. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СИСТЕМИЙН ЭРСДЭЛ

Санхүүгийн хямралын үед банк болон даатгагчид өөр өөр үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд хямралын эх үүсвэр болсон банкнуудад илүү хүндээр нөлөөлсөн.

Санхүүгийн хямралаас хойш олон улсын бодлого боловсруулагчид системийн эрсдэлтэй тэмцэх зохицуулалтын тогтолцоог бий болгохоор ажиллаж байна. Тэд хамгийн анх банкны салбарыг судалж байсан бол дараагаар нь даатгалын зах зээлийг судалж эхэлсэн. Дэлхийн системийн ач холбогдол

бүхий даатгагчдыг тодорхойлох аргачлалыг боловсруулах, тэдгээрийн нөлөөг бууруулах бодлогын арга хэмжээ боловсруулахыг Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбооноос үүрэг болгосон байна.

Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо /IAIS/ нь 2015 оны байдлаарх системийн нөлөө бүхий даатгагчдыг зарласан ба 2018 оноос эхлэн тус холбоо болон үндэсний эрх баригчид зөвшилцөн энэхүү жагсаалтыг цаашид нийтлэхгүй байхаар шийдвэрлэсэн.

Зураг 1. Системийн нөлөө бүхий даатгалын компаниуд /2015 оны байдлаар/





Хямралын үед даатгагчид үйл ажиллагаа, бизнесийн хэмжээ, үнийг харьцангуй тогтвортой барьсан ч Америкийн олон улсын групп /AIG/ болон хэд хэдэн даатгагчдад ихээхэн хүндрэл бэрхшээл тулгарч, үйл ажиллагаа нь унасан.

Даатгуулагчид эрсдэлээ даатгуулж, хураамж төлдөг учраас даатгалын компаниудаас их санхүүжилт шаардагдахгүйгээр үйл ажиллагаа явагддаг. Даатгагч болон давхар даатгагч нь санхүүгийн системийн тогтвортой байдлын

эх үүсвэр болдог онцлог шинж чанартай. Даатгалын бодлого нь ерөнхийдөө урт хугацаатай бөгөөд даатгуулагчдад санхүүгийн системийн тогтворжуулагч болж ажиллах боломжийг олгодог.

Европын Даатгал, Мэргэжлийн Тэтгэврийн газар /EIOPA/-ын тодорхойлсон системийн эрсдэлийг арилгах алхам болон даатгалын зах зээлийн системийн эрсдэл үүсэх шалтгаан нь дараах байдалтай байна.

**Зураг 2. Системийн эрсдэлийг арилгах алхам**



1. Хөрвөх чадварын эрсдэл, макро эдийн засгийн эрсдэл гэсэн 2 чиглэлд илүүтэй анхаардаг.
2. Шинэ бодлогын арга хэмжээ авах хэрэгцээ/шаардлагыг тодорхойлох
3. Системийн эрсдэлд шинжилгээ хийх – Бодлогын аль нэг арга хэмжээгээр хангалттай бууруулж чадаагүй эрсдэлийг тодорхойлох
4. Системийн бүх үлдэгдлийг арилгах


**Хүснэгт 1. Системийн эрсдэл үүсэх шалтгаан**

Системийн эрсдэл үүсэх шалтгаан	Зөвлөмж
Байгууллагад суурилсан – шууд үйл ажиллагаанд суурилсан	<ul style="list-style-type: none"> <li>• Алдагдлыг нөхөх нөөц бололцоог хангалттай байлгах</li> <li>• Тодорхой үйл ажиллагаа эсвэл бүтээгдэхүүнд хэт их анхаарал хандуулахгүй байх / тэнцвэртэй байдлыг хадгалах/</li> </ul>
Төлбөрийн чадвар муудаж, даатгалын эрсдэл тохиолдох	
Үйл ажиллагаанд суурилсан – шууд бус үйл ажиллагаанд суурилсан	
Тодорхой үйл ажиллагаа эсвэл бүтээгдэхүүнээс болж системийн эрсдэл үүсэх	
Зан төлөвт суурилсан – шууд бус үйл ажиллагаанд суурилсан	<ul style="list-style-type: none"> <li>• Мөчлөгийн эрсдэлээс болгоомжлох</li> <li>• Эрсдэлтэй үйл ажиллагаа хийхээс өмнө судлах</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>• Даатгалын компани хэт их эрсдэл хүлээх</li> <li>• Өр төлбөрийн эрсдэл үүсэх</li> </ul>	

IAIS–н Дэлхийн хяналтын газар нь /GME/ нь дэлхийн даатгалын зах зээл дэх эрсдэл, чиг хандлагыг тодорхойлох, системийн эрсдэл үүсэх нөхцөл байдлыг үнэлдэг. Хяналт, зохицуулалтын байгууллагууд дэлхийн хэмжээнд өнөөгийн

даатгалын зах зээлийн эрсдэлд хяналт тавих, тандалт судалгааг төрөлжүүлэх, тус зах зээлийн системийн эрсдэлийг тодорхойлох мониторинг, шинжилгээг нэмэгдүүлэхийн тулд цаашид интервенц хийхээр төлөвлөж байна.

**Зураг 3.** Дэлхийн банкны салбар болон даатгалын зах зээлийн системийн эрсдэлийн оноожуулалт



Даатгагчдын системийн эрсдэлийн нийт оноолт нь банкны салбараас хамаагүй бага хэвээр байна. Системийн эрсдэлийн үзүүлэлтүүдийн хамгийн их эрсдэлтэй нь хөрвөх чадваргүй активууд, санхүүгийн дотоод хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, дериватив болон санхүүгийн дотоод өр төлбөрийн үзүүлэлтүүд байна.


Ерөнхийдөө даатгалын зах зээлийн системийн эрсдэл дунд түвшинд хэвээр байгаа боловч хөрвөх чадваргүй, үнэлэгдэхэд хэцүү хөрөнгө, биржээс гадуурх дериватив, богино хугацаат эх үүсвэр, санхүүгийн дотоод хөрөнгийн эрсдэл зэрэг нь нэмэгдэж байгаагаас хамааран цаашид тус зах зээлийн системийн эрсдэл өсөх хандлагатай байна.

2021 онд дэлхийн даатгагчдын төлбөрийн чадвар болон ашигт ажиллагааны үзүүлэлт сайжирч, санхүүгийн зах зээлд эзлэх байр суурь нэмэгдсэн. Харин 2022 онд геополитикийн зөрчилдөөн, инфляц, мөнгөний хатуу бодлого, эдийн засгийн тогтворгүй байдал зэрэг хүчин зүйлсээс хамааран хөрвөх чадварын эрсдэл нэмэгдсэн.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /FSB/ нь хэмжээ, холбоо хамаарал, хөрвөх чадвар гэсэн 3 шалгуураар системийн эрсдэлийг үнэлдэг байсан бол Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо /IAIS/ нь цаг хугацаа буюу алдагдлыг гуравдагч этгээдэд дамжуулах хурдыг дөрөв дэх шалгуур болгон нэмсэн.



Зураг 4. Системийн эрсдэлийн 4 шалгуур



Даатгагч, давхар даатгалын үндсэн үйл ажиллагаанд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гурван шалгуурыг ашигласнаар системчилсэн эрсдэлд орох магадлал бага гэж дүгнэдэг. Эдгээр үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтын менежмент (хөрөнгө оруулалтын бодлого, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө), хариуцлагын эх үүсвэр (хамгаалалт, баталгаа өгөх), эрсдэл шилжүүлэх (давхар даатгал, үнэт цаасжуулах гэх мэт), хөрөнгийн менежмент орно. Европын Холбооны Solvency II даатгалын зохицуулалт нь даатгалын үйл ажиллагааг зохих ёсоор хангаж өгдөг. Харин эдгээр зохицуулалт

нь үндсэн бус үйл ажиллагаанаас үүдэлтэй системийн болзошгүй эрсдэлийг зохих ёсоор бууруулж чадаж байна уу, эсхүл шинэ арга хэмжээ авах, солих шаардлагатай байна уу гэдгийг анхаарах шаардлагатай.

Даатгалын эдийн засгийн судалгааны олон улсын холбоо /IARIE/ дараах 5 арга хэмжээг авахыг зөвлөдөг. Эхний хоёр арга хэмжээ нь даатгалын салбарын зохицуулалт, бодит байдалд тулгардаг эрсдэлийг бууруулах, сүүлийн гурван арга хэмжээ нь санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн.

Зураг 5. Даатгалын эдийн засгийн судалгааны олон улсын холбооноос гаргасан 5 зөвлөмж



Даатгагчийн үндсэн үүрэг болох даатгалын чиг үүрэг нь даатгуулагчдын эрсдэлийг хүлээн авах, эдгээр эрсдэлийг нэгтгэх, идэвхтэй удирдах, давхар даатгагчид хэсэгчлэн шилжүүлэх замаар хамгаалах үйлчилгээ юм.

Даатгал нь эрсдэлийн санхүүгийн үр дагаврыг нэгтгэх, шилжүүлэх механизмыг бий болгодог. Даатгуулагч шимтгэлийн хариуд гэрээ, үйл ажиллагааны зардал, хөрөнгийн зардлаас үүдэлтэй хүлээгдэж буй алдагдлыг даатгуулагчид санхүүгийн хувьд нөхөн төлөх үүрэг хүлээдэг.

Даатгагчид эрсдэл хүлээж байгаа тул эдгээр эрсдэлийг удирдах, ялангуяа даатгагчид шилжүүлэх зэрэгт онцгой анхаарал хандуулдаг. Даатгагчид даатгуулагчдад эрсдэлээ өөрсдөө удирдах, бууруулахад нь ихээхэн хөрөнгө оруулалт хийдэг. Даатгагчдын хүлээх эрсдэл нь олон янз байдаг бөгөөд даатгагчид эдийн засгийн бусад оролцогчдод учирч болзошгүй

зарим эрсдэлийг даатгуулах боломжтой гэж үзэж болох шинэ чиглэлүүдийг байнга хайж байдаг.

Банкны үйл ажиллагааны системийн эрсдэл, хөрөнгийн зах зээлийн системийн эрсдэл болон даатгалын зах зээлийн эрсдэл зэрэг нь харилцан адилгүй байдаг бөгөөд нөлөөлж буй хүчин зүйлс, үр дүн нь өөр өөр байдаг. Даатгалын эрсдэл нь өвөрмөц шинж чанартай бөгөөд ихэнх тохиолдолд эдийн засгийн мөчлөгөөс хамаардаггүй. Богино хугацаат, хөрвөх чадвартай хугацаат хадгаламжийг хүлээн авч, урт хугацаат зээл олгосноор банкнууд зээлийн үйл ажиллагаатай холбоотой зээлийн эрсдэл, богино хугацаат зээлээс үүссэн үл нийцэх байдлаас үүдэн хөрвөх чадварын эрсдэлийг хариуцдаг.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Олон улсын валютын сангаас системийг дараах байдлаар тодорхойлсон байна:

## Хүснэгт 2. Системийн эрсдэлийн хэмжигдэхүүн

Системийн эрсдэл	Системийн хамааралтай байгууллагуудыг тодорхойлох шалгуур
<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн системийн бүх хэсэг эсвэл хэсэгчилсэн үйл ажиллагааны алдагдлаас үүдэлтэй санхүүгийн үйлчилгээний урсгал тасалдах эрсдэл – бодит эдийн засагт ноцтой сөрөг үр дагавар авчрах боломжтой.</li> <li>Энэхүү тодорхойлолтын үндэс: системийн эрсдэл нь гаднын сөрөг хүчин зүйлүүд эсхүл зах зээлийн алдагдалтай холбоотой бөгөөд санхүүгийн байгууллагын алдаа, доголдол нь санхүүгийн систем эсхүл бодит эдийн засгийг алдагдуулж болзошгүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li><b>Хэмжээ</b> – Санхүүгийн системийн бие даасан бүрэлдэхүүн хэсгээс үзүүлж буй санхүүгийн үйлчилгээний эзлэхүүний хэмжээ</li> <li><b>Холбоо хамаарал</b> – Системийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй холбоо тогтоох харилцаа</li> <li><b>Хөрвөх чадвар</b> – Алдаа гарсан тохиолдолд системийн бусад бүрэлдэхүүн хэсгүүд ижил үйлчилгээ үзүүлж чадах хэмжээ</li> <li><b>Хугацаа</b> – Даатгалын системийн эрсдэл нь ихэвчлэн гэнэтийн цочролын үр дагавар авчирдаггүй, гэхдээ илүү урт хугацаанд хэрэгжих хандлагатай байдаг.</li> </ul>

Эх сурвалж: Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь зарим байгууллагын эмзэг байдлыг нэмэгдүүлж

болзошгүй хоёрдогч шалгуурыг тодорхойлсон. Үүнд:



**Зураг 6.** Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн тодорхойлсон хоёрдогч шалгуур



**Хэмжээ**

Системийн эрсдэлийн хувьд тухайн байгууллагын хэмжээ, үйл ажиллагааны бүтэц, харилцан хамаарал гэх мэт хүчин зүйлс нь чухал нөлөөтэй байдаг.

**Холбоо хамаарал**

Холбоо хамаарал нь системийн эрсдэлийн чухал хэмжигдэхүүн юм. Санхүүгийн байгууллагуудын хоорондын харилцан үйлчлэл нь өмчлөлийн хэлбэр, төлбөрийн систем, эрсдэлийн үйл ажиллагаа, давхар даатгал зэргээс хамааран харилцан адилгүй хэлбэртэй байдаг.

**Хөрвөх чадвар**

Байгууллагын санхүүгийн үйлчилгээний хөрвөх чадварыг тодорхойлоход дараах 2 хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай.

- Тухайн байгууллагын зах зээлд эзлэх байр суурь, байгууллага дампуурахад түүнийг орлох байгууллага богино хугацаанд бий болох боломжтой эсэх;
- Тухайн байгууллагын зах зээлд нэвтрүүлж буй үйлчилгээ нөлөө бүхий эсэх.

**Хугацаа**

Даатгалын нөхөн төлбөр нь банкны нэхэмжлэлтэй харьцуулахад харьцангуй хурдан хугацаанд шийдвэрлэгддэг. Тухайлбал, Дэлхийн худалдааны төвтэй холбоотой нэхэмжлэлийн 50 гаруй хувь нь 2 жил орчмын дараа шийдвэрлэгдсэн байдалтай байна.

Ихэвчлэн нэхэмжлэлийн агуулга, шүүхийн шийдвэр, нэхэмжлэгч зэргээс хамааран өөр өөр хугацаатай шийдвэрлэгддэг.

### III. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Системийн эрсдэлийг тодорхойлох, хэмжихэд чиглэсэн олон арга зүй, эмпирик судалгаа байдаг ч даатгалын зах зээлд 100 хувь тохирсон аргачлал одоогоор байхгүй. Судлаачид даатгалын зах зээлийн системийн эрсдэлийг дараах байдлаар тодорхойлсон:

Камминс ба Вайсс, Харрингтон, Тайлер, Хорниг, Грейс: Уламжлалт даатгалын үйл ажиллагаа нь системийн эрсдэл үүсгэдэггүй.

Ричардсон, Бобчеф: Уламжлалт даатгалын үйл ажиллагаа нь эрсдэлийг төрөлжүүлэх замаар хийгддэг тул системийн эрсдэл үүсгэдэггүй. Гэвч энэ нь уламжлалт бус үйл ажиллагаанд хамаардаггүй.

Ачария: Статистик мэдээлэл, системийн эрсдэлийн хэмжүүр дээр үндэслэн уламжлалт бизнесийн загвартай даатгагчид уламжлалт бус даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудаас ялгаатай нь системийн эрсдэл бага.

Бах ба Нгуен: Бусад үйл ажиллагаа тухайлбал, кибер даатгалын андеррайтеринг хийх зэрэг эсхүл уламжлалт даатгалд гэрээний нэмэлт заалтуудыг хавсаргасан тохиолдолд системийн эрсдэл үүсэх хандлагатай байдаг. Хэдийгээр уламжлалт даатгалын үйл ажиллагаа нь системийн хувьд эрсдэлтэй биш ч гэсэн даатгалын зах зээлийн эдийн засгийн зардлаас

шалтгаалан макро зохистой зохицуулалт хийх шаардлагатай.

Берри, Столзл: 2007–2009 оны хямралын үед даатгагчид мөнгө босгоход ямар ч бэрхшээлгүй байсан. Тиймээс даатгалын зах зээлд нэмэлт зохицуулалт шаардлагагүй.

Иймд энэхүү судалгааны ажлаар эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалыг ашиглан Монгол Улсын даатгалын зах зээлийн системийн хэмжээнд үзүүлэх эрсдэлийн нөлөөг тооцон үнэлэхийг зорилоо.

Эрт илрүүлэх дохиоллын систем нь хугацааны цуваан үзүүлэлтийн дундаж болон стандарт хазайлтыг тооцоолон уг стандарт хазайлтын тодорхой түвшнээс тухайн улиралд давсан нөхцөлд системийн эрсдэл үүссэнийг таамагладаг аргачлал юм.

Одоогийн байдлаар даатгагчдын хяналтшалгалт, зохицуулалтын үйл явцыг хялбаршуулах системийн эрсдэлийн талаар судалгааны ажил ховор байна. Хөрөнгийн зах зээл, банкны салбарт эрт илрүүлэх дохиоллын системийн талаар нарийвчилсан ойлголт, эрсдэлийг үнэлэх, нийт эдийн засгийн тогтолцооны үйл явдлыг урьдчилан таамаглах талаар өргөн хүрээнд судалсан байдаг ч даатгалын зах зээлд чиглэсэн судалгаа төдийлөн хийгдээгүй байна.



### Зураг 7. Даатгалын зах зээлийн системийн эрсдэлийн судлагдсан байдал

Дэвис, Карим  
(2008)

Банкны хямралыг урьдчилан тооцоолоход эрт илрүүлэх дохиоллын системийг практикт ашиглах шаардлагатай талаар онцолсон. Логит загвар ба банкны хямралын эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалыг харьцуулан 105 орны 1979–2003 оны нэгдсэн мэдээллийн санг ашиглан үнэлгээ өгсөн. Эрт илрүүлэх дохиоллын систем нь улс орны онцлог шинж чанартай уялдсан хямралыг урьдчилан таамаглахад илүү давуу талтай гэж дүгнэсэн.

Алесси, Деткен  
(2011)

Бодит болон санхүүгийн хувьсагчдын гүйцэтгэлийг үнэлэхэд хувь нийлүүлсэн хөрөнгийн үнийн өсөлт/уналтын мөчлөгийг эрт үед нь тодорхойлсон байдаг. Хөрөнгийн үнийн өсөлтийг тодорхойлохын тулд үл хөдлөх хөрөнгө, арилжааны болон хувьцааны үнийн индексийг хослуулан ашигладаг. Санхүүгийн хувьсагчдыг үнийн өсөлт, дэлхийн хувийн зээлийн зөрүүг хамгийн сайн таамаглагч гэж үзсэн.

Ло Дука,  
Пельтонен  
(2013)

Системийн эрсдэлийг үнэлэх, үйл явдлыг урьдчилан таамаглах аргачлалыг боловсруулсан. Тэдний судалгааны шинэлэг зүйл нь аргачлалаас илүү системийн үйл явдлын тодорхойлолт байв. Системийн үйл явдлыг тухайн улсын санхүүгийн систем дэх үйл явдлын түвшинг хэмжих нийлмэл индекс ашиглан “Эдийн засгийн бодит үр дагаварт хүргэсэн санхүүгийн хямралын үе” гэж тодорхойлдог.

## IV. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Системийн эрсдэлийг үнэлэх, хямралыг урьдчилан мэдэхийн тулд тоон үзүүлэлтүүдийг тодорхойлон, хэлбэлзлийн нөлөөллөөс дүгнэх боломжтой. Системийн эрсдэлийг илрүүлэх боломжит тоон үзүүлэлтүүдийг олон улсын болон санхүүгийн зохицуулагч байгууллагууд судалсан байдаг.

Даатгалын зах зээлийн болзошгүй эрсдэлийг урьдчилан таамаглах зорилгоор эрт илрүүлэх дохиоллын системийн загварыг ашиглах

боломжтой. Иймд даатгалын зах зээлийн хямралын эрсдэлийн дохиоллыг судлахаар 2017 оны 4 дүгээр улирлаас 2022 оны 4 дүгээр улирал хүртэлх 21 улирлын хугацааны цуваан тоон мэдээллийг ашиглан 7 бүлгийн 40 үзүүлэлт үзүүлэлтэд тулгуурлан тооцоолол, шинжилгээ хийлээ.

Даатгалын зах зээлийн системийн эрсдэлийг үнэлэх 7 бүлгийн 40 үзүүлэлт нь дараах байдалтай байна.

### Хүснэгт 3. Даатгалын зах зээлийн системийн эрсдэлийг үнэлэх үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	
<b>1. ХӨРӨНГИЙН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ</b>	
1	Үндсэн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь
2	Хөрөнгийн элэгдэл
3	Нийт хөрөнгийн өсөлт
<b>2. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ</b>	
4	Өөрийн хөрөнгийн хувийн жин
5	Эргэлтийн харьцаа
6	Урт хугацаат өр төлбөрийн нийт эх үүсвэр эзлэх хувийн жин
7	Нөөц сангийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин
<b>3. АШИГТ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ</b>	
8	Цэвэр ашгийн өөрчлөлт
9	Нийт ашгийн түвшин
10	Үйл ажиллагааны ашгийн түвшин
11	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа
12	Даатгагчид үлдэх хураамжийн хувь
13	Даатгалын цэвэр ашгийн хувь
14	Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа
<b>4. ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЖИЛГЭЭ</b>	
15	Хохирлын харьцаа
16	Зардлын харьцаа
17	Хосолсон харьцаа
18	Үйл ажиллагааны харьцаа
19	Дүрмийн сан/хураамжийн нийт орлого
20	Дүрмийн сан/нөөц сан
21	Дүрмийн сан/нөхөн төлбөр
<b>5. ӨСӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ</b>	
22	Эргэлтийн хөрөнгийн эргэц
23	Авлагын эргэц
24	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа
<b>6. ЭРСДЭЛИЙН ХАРЬЦАА</b>	
25	Нийт эрсдэлийн харьцаа
26	Цэвэр эрсдэлийн харьцаа
<b>7. БУСАД</b>	
27	Нэхэмжлэлийн харьцаа
28	Зардлын харьцаа
29	Хосолсон харьцаа
30	Өөрт үлдээх эрсдэлийн харьцаа
31	Авлагын харьцаа
32	Өр төлбөрт эзлэх эздийн өмчийн эзлэх хувь



33	Хөрвөх харьцаа
34	Аюулгүй байдлын харьцаа
35	Эзэмшигчийн өмчийн өгөөж
36	Эзэмшигчийн өмчийн нийт хөрөнгөд эзлэх хувь
37	Даатгалын нягтрал
38	Даатгалын гүнзгийрэлт
39	Нөөц сангийн хураамжийн орлогод эзлэх хувь
40	Нөөц сангийн нөхөн төлбөрт эзлэх хувь

Хугацааны цуваагаар илэрхийлсэн үзүүлэлтийг нэгдүгээрт оноолтоор, хоёрдугаарт эрсдэлт хүчин зүйлсийн зураглалаар харууллаа. Үүний тулд 21 улирлын үзүүлэлт тус бүрийн арифметик дунжийг олж, үүний дараагаар дунджаас хазайх хазайлт буюу стандарт хазайлт ( $\sigma$ )–ын утгыг тодорхойлсон. Хасах нэг стандарт хазайлтаас нэмэх нэг стандарт хазайлт буюу

$-\sigma < x < \sigma$  хооронд байгаа үзүүлэлтийг аюулгүй буюу ногоон өнгөөр,  $-1.5\sigma \leq x \leq -\sigma$  болон  $\sigma \leq x \leq 1.5\sigma$  завсар байгаа утгыг анхаарах шаардлагатай буюу шар өнгөөр тэмдэглэсэн. Харин  $1.5\sigma < x$  болон  $-1.5\sigma > x$  тохиолдолд хямрал үүсэх өндөр магадлалтай гэж үзэн улаан өнгөөр тус тус тэмдэглэсэн.

### Зураг 8. Системийн эрсдэлийн зураглалын хэмжигдэхүүн



$-\sigma < x < \sigma$

$-1.5\sigma \leq x \leq -\sigma$

$1.5\sigma < x$

$\sigma \leq x \leq 1.5\sigma$

$-1.5\sigma > x$

### Жишээ нь: Үндсэн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь

2017 оны 4 дүгээр улирлаас 2022 оны 4 дүгээр улирал хүртэл нийт хөрөнгөд эзлэх үндсэн хөрөнгийн эзлэх хувиудыг олж арифметик дундаж болон стандарт хазайлтыг тооцоолсон бөгөөд харгалзан 10.3 хувь, 1.0 хувь байсан.

Нийт хөрөнгөд эзлэх үндсэн хөрөнгийн эзлэх хувь нь  $10.3 \pm 1.0$  хувь (1 стандарт хазайлт) дотор буюу 9.3%–11.3% хооронд бол ногоон буюу эрсдэлгүй гэж, 11.3%–11.8% эсвэл 8.8%–9.3% хооронд бол шар өнгөөр буюу эрсдэл тохиолдох магадлалтай гэж тэмдэглэсэн. Харин 8.8 хувиас эрс бага ба 11.8 хувиас эрс их байгаа тохиолдолд хямрал үүсэх өндөр эрсдэлтэй байгааг илтгэж улаан өнгөөр тэмдэглэсэн.

**Зураг 9.** Жишээ: Нийт орлогод эзлэх цэвэр орлогын хэмжээ



Системийн эрсдэлийн оноолтыг ногоон бол 0, шар бол 1, улаан бол 1.5 оноогоор үнэлж нийт 40 үзүүлэлтийн онооны нийлбэрийг зурагласан.


Харин эрсдэлт хүчин зүйлийн самбараар хугацааны цуваан дахь эрсдэлийн түвшнийг ногоон, шар, улаан өнгөөр илэрхийлсэн болно.

## V. ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нийт хөрөнгө: 2022 онд даатгалын зах зээлийн нийт хөрөнгийн дүн 2022 оны 3 дугаар улирлаас 5.6 хувиар, 2021 оноос 11.6 хувиар өсөж 474.9 тэрбум төгрөгт хүрлээ. Урт хугацааны даатгалын компаниудын нийт хөрөнгө 75.3 хувиар өсөж 16.3 тэрбум төгрөг болж, нийт хөрөнгийн 3.4 хувийг эзлэв. Ердийн даатгалын компаниудын

нийт хөрөнгө өмнөх онтой харьцуулахад 11.1 хувиар өсөж 398.2 тэрбум төгрөг болсон нь салбарын нийт хөрөнгийн 83.9 хувийг, давхар даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 4.3 хувиар өсөж 60.3 тэрбум төгрөгт хүрч, нийт хөрөнгийн 12.7 хувийг тус тус эзэллээ.

**Зураг 10.** Даатгалын зах зээлийн нийт хөрөнгө /тэрбум төгрөг/






Хураамжийн орлого: Даатгалын компаниуд 2022 оны байдлаар нийт 304.8 тэрбум төгрөгийн даатгалын болон давхар даатгалын хураамжийн орлоготой ажиллав. Үүнээс ердийн даатгалын компаниуд 298.0 тэрбум төгрөг, урт хугацааны

даатгалын компаниуд 2.7 тэрбум төгрөг, давхар даатгалын компаниуд 4.1 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн. 2022 оны хураамжийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 23.2 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.


**Зураг 11.** Даатгалын зах зээлийн хураамжийн орлого /тэрбум төгрөг/



Нөхөн төлбөр: Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2022 онд 72.9 тэрбум төгрөгт хүрсэн. Үүний 98.4 хувийг ердийн даатгал, 1.4 хувийг урт хугацааны даатгал, 0.2 хувийг давхар

даатгалын компанийн нөхөн төлбөр тус тус эзэлж байна. Нөхөн төлбөрийн зардлыг өмнөх онтой харьцуулахад 34.9 хувиар өссөн үзүүлэлттэй.

**Зураг 12.** Даатгалын зах зээлийн нөхөн төлбөр /тэрбум төгрөг/




Нөөц сан: Даатгалын зах зээлийн нийт нөөц сангийн хэмжээ 2022 онд 216.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 12.0 хувиар өссөн үзүүлэлт юм.

Тайлант онд ердийн даатгалын компаниудын нийт нөөц сан (орлогод тооцоогүй хураамжийн

нөөц болон нөөц сангийн нийлбэр дүн)-ийн хэмжээ 11.2 хувиар өсөж 182.2 тэрбум төгрөгт, урт хугацааны даатгалын компаниудын нөөц сан 20.8 хувиар өсөж 2.9 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 15.6 хувиар өсөж 31.8 тэрбум төгрөг болжээ.

**Зураг 13.** Даатгалын зах зээлийн нөөц сангийн хэмжээ /тэрбум төгрөг/



## VI. ЭМПИРИК СУДАЛГАА

Даатгалын зах зээлд үүсэх системийн эрсдэлийг эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалыг ашиглан 2017 оны 4 дүгээр улирлаас 2022 оны 4 дүгээр улирал хүртэлх 21 улирлын хугацаанууа тоон мэдээллийг 7 бүлгийн 40 үзүүлэлтэд шинжилгээ хийлээ. Үүний тулд үзүүлэлт тус бүрийн дундаж болон стандарт хазайлтыг тооцож, түүнээс давсан нөхцөлд системийн


эрсдэл, хямрал тохиолдоно гэсэн таамаглал дэвшүүлсэн.

### Монгол Улсын санхүүгийн мөчлөг

Санхүүгийн зах зээл дэх хямрал тохиолдох магадлалыг Монгол Улсад өмнө нь тохиолдож байсан 2017 оны мөчлөгийн уналт болон 2020–2021 оны Ковид–19 цар тахлыг жишиг болгон харлаа.



**Зураг 14.** Хямралтай болон хямралын дараах улирлын үзүүлэлтийн төлөв байдал



Дээрх 2 зурагт буюу 2018 оны 1 дүгээр улирал болон 2020 оны 1 дүгээр улирлын системийн эрсдэлийн зураглалыг харахад харгалзан улаан тэмдэглэгээтэй 7, 9 үзүүлэлт байсан ба энэ нь хямралын дохио илэрсэн болохыг илтгэнэ.

Хямралын өмнөх 1 улиралд улаан болон шар тэмдэглэгээ огцом нэмэгдсэн байгаа нь эрт илрүүлэх дохиоллын системийн аргыг ашигласнаар хямралыг 1 улирлын өмнө урьдчилан таамаглах боломжтойг харуулж байна.

2017 онд үүссэн хямралаас үүдэн 2018 оны 1 дүгээр улирлын санхүүгийн байдлын үнэлгээ, ашигт ажиллагааны үнэлгээ болон үйл ажиллагааны шинжилгээний бүлгийн үзүүлэлтүүд огцом өссөн үзүүлэлттэй гарсан. Энэ нь үзүүлэлтийг улаанаар тэмдэглэх хүчин зүйл болж, хямралын дохиог өгсөн байна.


Дээрх зургаас харахад, хямралын үеэр үзүүлэлтүүд далайцтай өөрчлөлтүүдийг үзүүлдэг бол 1-2 улирлын дараагаас хэвийн байдалдаа шилжиж байгааг харж байна.

Хугацааны цуваагаар тооцсон эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлал

Системийн эрсдэлийн зураглалаас 2019 оны 4 дүгээр улирал болон 2020 оны 1, 2 дугаар улирлын үзүүлэлтийг харахад санхүүгийн байдлын үнэлгээний бүлгийн үзүүлэлтээс бусад бүх бүлгийн үзүүлэлтэд огцом өөрчлөлт гарсан байна. 2020 оны эхний хагас жилийн байдал нь Ковид-19-ийн цар тахлаас шууд хамааралтай байсан нь 2020 оны 1 дүгээр улирлын олон улаан, шар тэмдэглэгээтэй байна.

Хугацааны цуваагаар тооцсон эрт илрүүлэх дохиологч системийн арга нь системийн эрсдэлийг тооцоход Монгол Улсад санхүүгийн хямрал тохиолдсон 2016, 2020 онд сонгосон 40 үзүүлэлт хамгийн ихээр хямрал тохиосон гэж харуулсан. Учир нь 2017.IV-2018.II болон 2019.IV-2020.II улиралд 1. 5стандарт хазайлтаас /стандарт хазайлт\*1.5/ их хэлбэлзэж хямрал тохиолдох өндөр магадлалтайг илэрхийлсэн нь дээрх хугацаанд тохиосон санхүүгийн хямралуудтай цаг хугацааны хувьд яг таарч байна.

**Зураг 15.** Монгол Улсын даатгалын зах зээлийн системийн эрсдэлийн оноолт /улирлаар/



Дээрх зурагт даатгалын зах зээлийг эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалаар үнэлэн, үнэлгээг оноожуулан харууллаа. Бүх үзүүлэлт эрсдэлтэй эсвэл эрсдэлгүй байх хамгийн их болон бага утга харгалзан 25.5 болон 0 байсан ба тус зах зээлийн тухайд санхүүгийн мөчлөгийн ёроол цэгт хамгийн ихдээ 25.5 оноотой байжээ. Үүнээс санхүүгийн хямрал тохиолдсон 2017.IV–2018.II болон 2019.IV–2020.II улиралд тус тус 24.5 ба 25.5 оноотой байна. Хямрал тохиолдсоны

дараагийн 1–2 улиралд Даатгалын зах зээл нь эргэн хэвийн байдалдаа орж буй зураглал ажиглагдсан. Харин хямрал тохиолдохын өмнөх улиралд тооцоолсон 40 үзүүлэлтийн 4–8 үзүүлэлт улаан тэмдэглэгээтэй гарч, хямралын дохиоллыг үзүүлсэн гэж харж байна.

Системийн эрсдэлийн оноолтыг үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй тооцоолж, эрсдэлтэй, анхаарах шаардлагатай болон эрсдэлгүй бүсчлэлээр харууллаа.



Зураг 16. Даатгалын зах зээлийн системийн эрсдэлийн зураглал

№	Үзүүлэлт	2017				2018				2019				2020				2021				2022			
		4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4			
<b>1. ХӨРӨНГИЙН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ</b>																									
1	Үндсэн хөрөнгийн нийт хөрөнгө эзлэх хувь	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
2	Хөрөнгийн эзтгэл	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
3	Нийт хөрөнгийн өсөлт	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
<b>2. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ</b>																									
4	Өөрийн хөрөнгийн хувийн жин	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
5	Эргэлтийн харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
6	УХӨТ-ийн нийт эх үүсвэр эзлэх хувийн жин	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
7	Нөөц сангийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
<b>3. АШИГТ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ</b>																									
8	Цэвэр ашгийн өөрчлөлт /сал төгрөгөөр/	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
9	Нийт ашгийн түвшин	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
10	Үйл ажиллагааны ашгийн түвшин	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
11	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
12	Даатгагчид үлдэх хураалжийн хувь	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
13	Даатгалын цэвэр ашгийн хувь	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
14	Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
<b>4. ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЖИЛГЭЭ</b>																									
15	Хохирлын харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
16	Зарлагын харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
17	Хосолсон харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
18	Үйл ажиллагааны харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
19	Дурийн сан хураалжийн нийт орлого	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
20	Дурийн сан нөөц сан	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
21	Дурийн сан нөхөн төлбөр	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
<b>5. ӨСӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ</b>																									
22	Эргэлтийн хөрөнгийн эргэлт	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
23	Аллагын эргэлт	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
24	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
<b>6. ЭРСДЭЛИЙН ХАРЬЦАА</b>																									
25	Нийт эрсдэлийн харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
26	Цэвэр эрсдэлийн харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
<b>7. БУСАД</b>																									
27	Нэхэмжлэлийн харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
28	Зарлагын харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
29	Хосолсон харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
30	Өөрт үлдэх эрсдэлийн харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
31	Аллагын харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
32	Өр төлбөрт эзлэх эзний өмчийн эзлэх хувь	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
33	Хөрвөх харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
34	Аюулгүй байлалын харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
35	Эзэмшигчийн өмчийн өгөөж	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
36	Эзэмшигчийн өмч нийт хөрөнгийн харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
37	Даатгалын нөхрөл	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
38	Даатгалын гуагийррагт	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
39	Нөөц сан хураалжийн орлогын харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		
40	Нөөц сан нөхөн төлбөрийн харьцаа	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green	Green		

## ХӨЛГӨН ДАТАГААР ТООЦСОН ЭРТ ИЛРҮҮЛЭХ ДОХИОЛЛЫН СИСТЕМИЙН АРГАЧЛАЛ

Даатгалын компаниудаас үүсэж байгаа системийн эрсдэлийг тэдгээрийн хугацааны цуваан үзүүлэлтээр үнэлсэн бол нэг даатгалын компани системийн эрсдэлд ямар хэмжээтэйгээр нөлөө үзүүлж болохыг 7 бүлгийн 40 үзүүлэлтээр эрт илрүүлэх дохиоллын

системийг ашиглан тооцлоо.

Ийнхүү тооцоход нэг даатгалын компани системийн хэмжээнд бага нөлөөтэй ба салбарын бүх компаниудын эрсдэл нийлж системийн эрсдэлд нөлөөлж буйг харууллаа.

## ДҮГНЭЛТ

Эрт илрүүлэх дохиологч системийн Даатгалын компаниудын системийн эрсдэлийг таамаглах байдал нь Монгол Улсад санхүүгийн мөчлөгийн ёроол цэг тохиолдож байсан үетэй давхацсан тул уг аргачлалаар системийн эрсдэлийг үнэлэхэд тохиромжтой гэж үзлээ.

Даатгалын зах зээлийн болзошгүй эрсдэлийг урьдчилан таамаглах зорилгоор эрт илрүүлэх дохиоллын системийн аргачлалыг ашиглан 2017 оны 4 дүгээр улирлаас 2022 оны 4 дүгээр улирал хүртэлх 21 улирлын хугацааны цуваан тоон мэдээллийг ашиглан 7 бүлгийн 40 үзүүлэлт үзүүлэлтэд тулгуурлан тооцоолол, шинжилгээ хийлээ.

Санхүүгийн хямрал тохиолдсон 2017.IV–2018.II болон 2019.IV–2020.II улиралд тус тус 24.5 ба 25.5 оноотой гарсан ба хямрал тохиолдсоны дараагийн 1–2 улиралд зах зээл нь эргэн хэвийн байдалдаа орж буй

зураглал ажиглагдсан. Харин хямрал тохиолдохын өмнөх улиралд тооцоолсон 40 үзүүлэлтийн 4–8 үзүүлэлт улаан тэмдэглэгээтэй гарч, хямралын дохиоллыг анхааруулсан байв.

Даатгалын зах зээлийн системийн эрсдэлийг улирал бүр эрт илрүүлэх дохиоллын аргачлалаар тооцоолох саналтай байгаа ба эрсдэлийн оноолтыг тухай бүр тодорхойлсноор хямрал тохиолдохоос 1 улирлын өмнө таамаглах боломжтой гэж харж байна. Зах зээлд тохиолдох эрсдэл/хямралыг 1 улирлын өмнө тодорхойлж чадсанаар бодлогын хэмжээнд арга хэмжээ авч, системийн хэмжээнд хямрал тохиолдохоос сэргийлэх боломжтой.

Цаашид даатгалын зах зээлийн эрсдэлийг тогтмол, нарийвчлал өндөртэйгөөр тооцох, мөн стресс тестийн аргачлалыг дэлгэрүүлэн судлах, тооцоололдоо ашиглах нь илүү үр дүнтэй гэж харж байна.



## ЭХ СУРВАЛЖ

1. Ernst N.Csiszar. “Systemic risks and the Insurance industry”
2. European Central Bank. “Financial Stability Review”. 2009
3. European Commission “Lessons learned from the crisis /Solvency II and beyond/”. 2020
4. European Commission. “Systemic Risk in Insurance”. 2021
5. European Insurance and Occupational Pensions Authority. “Systemic risk and macroprudential policy in insurance”. 2017
6. Financial Stability Board. “Guidance to Assess the Systemic Importance of Financial Institutions, Markets and Instrument: Initial Considerations”. 2019
7. International Association of Insurance Supervisors. “Global Insurance Market Report”. 2022
8. International Association of Insurance Supervisors. “IAIS Global Insurance Market Report 2022 highlights key risks and trends facing the global insurance sector”. 2022
9. Lloyd’s. “Systemic Risk: Insurance Market”
10. Pan European Insurance Forum. “Insurance Risk Management Response to the Financial Crisis”. 2020
11. Санхүүгийн зохицуулах хороо. “Даатгалын зах зээлийн тоон мэдээлэл”. 2017–2022





**Хавсралт 2. Даатгалын зах зээлийн хугацааны цуваан статистикийн эрсдэлд тооцох тоон утга**

ҮЗҮҮЛЭЛТ	Арифметик дундаж	Эрсдэлгүй / Ногоон			Анхаарах шаардлагатай / Шар			
		Стандарт хазайлт	Дээд хязгаар	Доод хязгаар	Стандарт хазайлт*1.5	Дээд хязгаар	Доод хязгаар	
<b>1. ХӨРӨНГИЙН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ</b>								
1	Үндсэн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь	10.3%	1.0%	11.3%	9.4%	1.4%	11.8%	8.9%
2	Хөрөнгийн элэгдэл	32.5%	5.1%	37.6%	27.4%	7.6%	40.1%	24.9%
3	Нийт хөрөнгийн өсөлт	10.2%	7.6%	17.8%	2.7%	11.3%	21.6%	-1.1%
<b>2. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ</b>								
4	Өөрийн хөрөнгийн хувийн жин	52.3%	2.2%	54.6%	50.1%	3.3%	55.7%	49.0%
5	Эргэлтийн харьцаа	72.55	41.70	114.25	30.85	62.55	135.10	10.00
6	УХӨТ-ийн нийт эх үүсвэр эзлэх хувийн жин	91.2%	13.0%	104.2%	78.2%	19.5%	110.7%	71.7%
7	Нөөц сангийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин	15.9%	3.1%	19.0%	12.8%	4.6%	20.5%	11.3%
<b>3. АШИГТ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ</b>								
8	Цэвэр ашгийн өөрчлөлт	(187.91)	441.97	254.06	(629.88)	662.95	475.05	(850.86)
9	Нийт ашгийн түвшин	38.4%	36.5%	74.9%	2.0%	54.7%	93.1%	-16.3%
10	Үйл ажиллагааны ашгийн түвшин	84.2%	64.3%	148.6%	19.9%	96.5%	180.7%	-12.2%
11	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	6.9%	3.0%	9.9%	3.8%	4.6%	11.4%	2.3%
12	Даатгагчид үлдэх хураамжийн хувь	76.7%	2.3%	79.0%	74.3%	3.5%	80.2%	73.2%
13	Даатгалын цэвэр ашгийн хувь	33.5%	30.8%	64.3%	2.7%	46.2%	79.7%	-12.7%
14	Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа	3.8%	1.7%	5.6%	2.1%	2.6%	6.5%	1.2%
<b>4. ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЖИЛГЭЭ</b>								
15	Хохирлын харьцаа	45.0%	7.1%	52.2%	37.9%	10.7%	55.7%	34.4%
16	Зардлын харьцаа	71.7%	26.5%	98.3%	45.2%	39.8%	111.5%	32.0%
17	Хосолсон харьцаа	117.9%	32.0%	149.9%	85.9%	48.0%	165.9%	69.9%
18	Үйл ажиллагааны харьцаа	91.5%	8.2%	99.6%	83.3%	12.2%	103.7%	79.3%
19	Дүрмийн сан/хураамжийн нийт орлого	13.24	37.03	50.27	(23.79)	55.55	68.79	(42.31)
20	Дүрмийн сан/ нөөц сан	5.00	3.65	8.66	1.35	5.48	10.48	(0.48)
21	Дүрмийн сан/нөхөн төлбөр	19.67	15.34	35.00	4.33	23.01	42.67	(3.34)

**5. ӨСӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

22	Эргэлтийн хөрөнгийн эргэц	0.34	0.25	0.59	0.09	0.37	0.72	(0.03)
23	Авлагын эргэц	4.47	2.71	7.18	1.76	4.06	8.53	0.41
24	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	0.07	0.03	0.10	0.04	0.05	0.12	0.02

**6. ЭРСДЭЛИЙН ХАРЬЦАА**

25	Нийт эрсдэлийн харьцаа	0.89	0.44	1.33	0.45	0.66	1.55	0.23
26	Цэвэр эрсдэлийн харьцаа	0.60	0.29	0.89	0.31	0.44	1.04	0.17

**7. БУСАД**

27	Нэхэмжлэлийн харьцаа	44.9%	8.1%	53.1%	36.8%	12.2%	57.2%	32.7%
28	Зардлын харьцаа	64.6%	3.3%	68.0%	61.3%	5.0%	69.6%	59.6%
29	Хосолсон харьцаа	109.6%	9.2%	118.8%	100.3%	13.9%	123.4%	95.7%
30	Өөрт үлдээх эрсдэлийн харьцаа	76.5%	2.5%	78.9%	74.0%	3.7%	80.2%	72.7%
31	Авлагын харьцаа	14.6%	3.6%	18.2%	10.9%	5.5%	20.0%	9.1%
32	Өр төлбөрт эзлэх эздийн өмчийн эзлэх хувь	176.0%	30.8%	206.8%	145.2%	46.2%	222.2%	129.7%
33	Хөрвөх харьцаа	176.9%	22.3%	199.2%	154.6%	33.4%	210.3%	143.4%
34	Аюулгүй байдлын харьцаа	33.8%	9.3%	43.1%	24.5%	13.9%	47.7%	19.9%
35	Эзэмшигчийн өмчийн өгөөж	15.9%	7.9%	23.8%	8.0%	11.8%	27.7%	4.1%
36	Эзэмшигчийн өмч, нийт хөрөнгийн харьцаа	37.7%	8.9%	46.6%	28.8%	13.3%	51.1%	24.4%
37	Даатгалын нягтрал	63,937.71	14,914.45	78,852.16	49,023.26	22,371.67	86,309.38	41,566.03
38	Даатгалын гүнзгийрэлт	0.6%	0.1%	0.6%	0.5%	0.1%	0.6%	0.5%
39	Нөөц сан, хураамжийн орлогын харьцаа	176.1%	120.4%	296.5%	55.6%	180.7%	356.7%	-4.6%
40	Нөөц сан, нөхөн төлбөрийн харьцаа	546.5%	337.1%	883.6%	209.4%	505.7%	1052.1%	40.8%

# 4

## ФИНТЕК ЗОХИЦУУЛАЛТЫН ИННОВАЦ ХАБ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА

Гүйцэтгэсэн: Б.Батчимэг<sup>6</sup>  
Б.Тэргэл<sup>7</sup>  
Б.Даваамаа<sup>8</sup>

<sup>6</sup> СЗХ, Сэндбоксын албаны дарга email: batchimeg\_b@frc.mn

<sup>7</sup> СЗХ, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт email: fergel@frc.mn

<sup>8</sup> СЗХ, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн email: davaamaa@frc.mn

## ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд технологид суурилсан санхүүгийн үйлчилгээний зах зээл хурдтай хөгжин банк, санхүүгийн системд зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ шинээр нэвтэрч байна. Технологийн энэхүү үр ашгийг ашиглахын сацуу санхүүгийн тогтвортой байдлаа хадгалах чиглэлд улс орнуудын зохицуулагч байгууллага, бодлого гаргагчид сэндрбоксын зохицуулалт, инновацын хаб зэрэг төрөл бүрийн инновацын хурдасгуур хэрэгслийг ашиглаж байна. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар дэлхийн 90 орчим улс сэндрбокс зохицуулалтыг нэвтрүүлээд байгаа бол 60 гаруй улс инновац хабыг санхүүгийн зохицуулагч байгууллагынхаа дэргэд байгуулсан статистик мэдээлэл байна. Манай улсын хувьд сэндрбокс зохицуулалтын орчин 2021 онд нэвтрэн шинэ төрлийн технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг туршин амжилттай хэрэгжиж байна. Гэсэн хэдий ч дан ганц зохицуулалтын сэндрбоксоос гадна санхүү, технологийн компаниудад бодлого, зохицуулалтын зөвлөгөө өгөх, тус салбарын мэргэжилтэн, боловсон хүчнийг чадавхжуулах, шинэ тутам хөгжиж буй финтек зах зээлийн талаарх судалгаа, шинжилгээг тогтмол гүйцэтгэх, санхүүгийн зохицуулагч байгууллагын хяналт, шалгалтын үйл ажиллагаанд технологийг нэвтрүүлэх зэрэг олон тооны ажлуудыг хийх хэрэгцээ, шаардлага үүсэж байна. Финтек зохицуулалтын инновац хаб нь эдгээр асуудлуудыг шийдэх, бүс нутагтаа тэргүүлэх, инновацад суурилсан ухаалаг санхүүгийн системийг хөгжүүлэхэд туслах инновац хурдасгуур, бодлогын нэгэн хувилбар байх боломжтой юм.

**Түлхүүр үгс:** технологи, ухаалаг санхүүгийн систем, инновац хурдасгуур

**JEL ангилал:** E44, G28, O31, O38

I.	УДИРТГАЛ	104
II.	ФИНТЕКИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	105
	2.1. Финтекийн зах зээл	105
	2.2. Бодлого, зохицуулалтын орчин	107
III.	ФИНТЕКИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ ОЛОН УЛСАД	113
	3.1. Финтек салбарын зах зээл, хүлээгдэж буй ирээдүй	113
	3.2. Финтек салбарын зохицуулалт	115
	3.3. Инновацын хабын хөгжил олон улсад	117
IV.	ИННОВАЦЫН ХАБ БАЙГУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА	122
	4.1. Хэрэгцээ, шаардлага	122
	4.2. Давуу болон сул тал	125
	4.3. Эрсдэлийн менежмент	126
V.	ИННОВАЦЫН ХАБ	128
	5.1. Үндсэн зорилго, зорилт	128
	5.2. Үндсэн бүрэлдэхүүн	128
	5.3. Үйл ажиллагааны схем, зураглал	129
	5.4. Оролцогч талуудын шинжилгээ	130
	5.5. Засаглал, ажиллах зарчим	131
VI.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	132
	ЭХ СУРВАЛЖ	135
	ХАВСРАЛТ I. ИННОВАЦЫН ХАБ БАЙГУУЛАХ БОДЛОГЫН САНАЛ /АНГЛИ ХЭЛ ДЭЭР/	136
	ХАВСРАЛТ II. ИННОВАЦЫН ХАБ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН САНАЛ /АНГЛИ ХЭЛ ДЭЭР/	141

---

## ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол Улсын финтек зах зээлийн экосистем	105
Зураг 2. Банк бус санхүүгийн байгууллагын финтек зээлийн статистик	106
Зураг 3. Виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ	107
Зураг 4. Сэндбоксын орчинд орохоор ирүүлсэн хүсэлт, үйлчилгээний төрлөөр	110
Зураг 5. Финтекийн салбарын жилийн орлого, өсөлтийн таамаглал	113
Зураг 6. Санхүүгийн салбарт тэргүүлэх бизнес салбаруудын орлого, өсөлтийн таамаглал	114
Зураг 7. Инновацын хаб болон сэндбоксын тархалт	118
Зураг 8. Англи Улсын инновацын хабын хөгжил	119
Зураг 9. Инновацын хабын бүрэлдэхүүн /санал/	128
Зураг 10. Инновацын хаб байгуулахад оролцогч талуудын шинжилгээ	130
Зураг 11. Инновацын хабын бүтэц /санал/	132
Хүснэгт 1. Санхүүгийн салбарын голлох хуулиуд, цахим үйлчилгээтэй холбоотой харилцааг тусгасан байдал	110
Хүснэгт 2. Цахим хөгжлийг дэмжих хуулиуд	111
Хүснэгт 3. Финтекийн зах зээлийн боломж ба сорилт	116
Хүснэгт 4. Үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө	133
Хүснэгт 5. Инновацын хаб үүсгэн байгуулах төсвийн санал	134

---



## I. УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд санхүүгийн технологи буюу финтекийн хөгжил хурдсан уламжлалт банк, санхүүгийн салбарт урьд өмнө нь хүлээгдэж байгаагүй амар хялбар байдал, үр ашиг, хүртээмжийг авчирч байна. Гэсэн хэдий ч санхүүгийн салбарт өрнөж буй энэхүү хурдтай өөрчлөлтийг даган санхүүгийн зах зээлд шинэ төрлийн эрсдэлүүд үүсэх, санхүүгийн салбарын интеграцчлалыг хурдасган санхүүгийн систем, тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх зэрэг эрсдэлүүд ажиглагдаж байна. Иймд санхүүгийн зах зээлд шинээр үүсэж буй эрсдэлээс системийн тогтвортой байдал, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахын сацуу технологийн дэвшлийн зах зээлд авчирч буй үр шим, өгөөжийг боломжит түвшинд нь ашиглах чиглэлд улс орнуудын засгийн газар, бодлого гаргагчид, олон улсын байгууллагууд эрчимтэй ажиллаж байна.

Финтекийн энэхүү хөгжил Монгол Улсын зах зээлд ч мөн эрчимтэй нэвтэрч буй бөгөөд төрийн бодлого гаргагчид болон санхүүгийн зохицуулагч байгууллагууд технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн зах зээл, эдийн засгийн өсөлтийг дэмжин, тогтвортой хөгжилд хүрэх боломжийг эрэлхийлэн ажиллаж байна.

Санхүүгийн салбар дахь инновацыг нэмэгдүүлэх, түүний үр шимийг хүртэх олон боломж, хурдасгуур хэрэгслүүдийн нэг

нь Финтекийн инновацын хаб юм. Финтекийн инновацын хаб нь санхүүгийн салбарын оролцогчид, гарааны бизнесүүд, технологийн компаниудын хөгжлийг дэмжих, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн санхүүгийн салбарын экосистемийг хамарсан төв бөгөөд санхүүгийн байгууллагууд, технологийн компаниуд, хөрөнгө оруулагчид, академик салбарынхан, болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны цэг болон финтек салбарын хөгжил, инновацыг дэмжих чиглэлд ажилладаг.

Энэхүү судалгаа нь Монгол Улсад финтекийн салбарыг дэмжсэн инновацын хаб байгуулахын ач холбогдлыг судлах, олон улсын сайн туршлагаас судлан өөрийн орны нөхцөл байдалд нийцсэн инновацын хабын үйл ажиллагааны гол зураглал, холбогдох тооцооллыг гаргах мөн цаашид уг төлөвлөгөөг ажил хэрэг болгоход шаардлагатай ерөнхий төлөвлөгөөг гаргахад чиглэсэн. Судалгааны дараах бүлгүүдэд Монгол Улсын финтек салбарын өнөөгийн нөхцөл байдал, олон улсын чиг хандлага, инновацын хабын олон улсын туршлага, Монгол Улсын санхүүгийн зах зээлд инновацын хаб байгуулах хэрэгцээ, шаардлагыг судлан, инновацын хабын үндсэн бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зураглалыг эхний байдлаар боловсруулан, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг гарган тусгасан болно.






Технологийн дэвшлийн нөлөө хамгийн өндөр санхүүгийн үйлчилгээ нь төлбөр, тооцооны үйлчилгээ бөгөөд дэлхий даяар зах зээл дэх бэлэн мөнгөний хэрэглээ жил ирэх тусам хурдацтайгаар буурах хандлагатай байна. Монгол Улсын тухайд ч мөн адил иргэдийн бэлэн мөнгөний хэрэглээ жил ирэх тутам буурч буй бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар гэхэд нийт гүйлгээн дэх бэлэн мөнгөний гүйлгээний тоо 16 хувьтай байна. Энэхүү үзүүлэлт нь 2016 онд 45 хувьтай байсан бөгөөд сүүлийн жилүүдэд эрчимтэй буурч буй юм (Монголбанк, 2022). Цахимаар хийгдэж буй гүйлгээний дийлэнх хувийг интернэт банк болон мобайл банкаар хийгдэж буй гүйлгээ бүрдүүлж буй хэдий ч сүүлийн жилүүдэд иргэд хувийн хэвшлээс зах зээлд нийлүүлж буй цахим мөнгө, мөн банкнаас бусад санхүүгийн салбарын оролцогчид, технологийн компаниудын хөгжүүлж буй цахим хэтэвч, төлбөр тооцооны хэрэгслийг ашиглах хандлага нэмэгдэж байна. Өнөөгийн байдлаар Монголбанкнаас цахим мөнгө, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах тусгай зөвшөөрөлтэй нийт 7 компани зах зээлд цахим хэтэвч, төлбөрийн хэрэгслийн үйлчилгээг эрхэлж байна.

Түүнчлэн финтекийн хөгжил хамгийн амжилттай нэвтэрч буй салбар нь банк бус санхүүгийн байгууллагын салбар тэр дундаа зээлийн үйлчилгээ бөгөөд нийт 42 банк бус санхүүгийн байгууллага гар утасны аппликейшнд суурилсан финтек зээлийн үйлчилгээг эрхэлж байна. Финтек зээлийн давуу тал нь бүрэн цахимаас гадна хэрэглэгчдийн богино хугацаат, бага дүнтэй санхүүжилтийн эрэлт, хэрэгцээг ямар нэгэн барьцаа хөрөнгө шаардахгүйгээр хурдан шуурхай шийдэж буй явдал юм.

**Зураг 2.** Банк бус санхүүгийн байгууллагын финтек зээлийн статистик



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2023 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын салбарын зээлдэгчдийн тоо 1.3 саяд хүрсэн бөгөөд үүний 93 хувийг финтек зээлдэгчид бүрдүүлж байна. Мөн салбарын нийт зээлийн үлдэгдэл 3.1 их наяд төгрөг хүрснээс 4.2 хувийг финтек зээлийн үлдэгдэл эзэлж байна. Салбарын хэмжээнд нийт олгосон зээлийн 19.2 хувийг, төлөгдсөн зээлийн 20.5 хувийг мөн тус тус финтек зээлийн үйлчилгээ бүрдүүлж буй юм.

Зээлийн салбарт технологийн дэвшлийг ашиглан P2P, хамтын санхүүжилт болон худалдан аваад дараа нь төл (buy now pay later) үйлчилгээнүүд шинээр нэвтэрч байна. P2P зээл болон хамтын санхүүжилтийн үйлчилгээнүүдийн хувьд сэндрокс зохицуулалтын орчинд хамрагдан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршиж байгаа бол худалдан аваад дараа нь төлөх нөхцөл бүхий үйлчилгээний хувьд санхүүгийн зохицуулалтад хамаарахгүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөрөнгийн зах зээл, болон даатгалын зах зээлийн оролцогчид мөн өөрсдийн үйлчилгээг хэрэглэгчдэд цахимаар хүргэж эхэлсэн бөгөөд

2023 оны 2 дугаар улирлын байдлаар хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг нийт 52 үнэт цаасны компаниас 18 нь цахим үйлчилгээг нэвтрүүлэн хөрөнгө оруулагчдад үнэт цаасны дансаа цахимаар нээх, мөн хөрөнгийн зах зээлийн арилжаанд гар утасны аппликейшн болон цахим хуудсаа ашиглан шууд оролцох боломжийг бүрдүүлсэн байна. Даатгалын салбарын хувьд ердийн даатгалын нийт 16 компани байгаагаас 8 нь цахим үйлчилгээг нэвтрүүлэн иргэдэд даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимаар борлуулж байна.

**Зураг 3. Виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ**



*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлд тохиосон хамгийн том өөрчлөлтүүдийн нэг нь

виртуал хөрөнгө, болон криптовалютын зах зээл бөгөөд уг зах зээл Монгол Улсын санхүүгийн салбарт ч мөн хурдтайгаар нэвтрэн хөгжиж байна. Монгол Улсын хувьд виртуал хөрөнгийн үйлчилгээ эрхлэгчид буюу биржүүдийг хянаж зохицуулдаг бөгөөд өнөөгийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй нийт 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ эрхлэгч байгаа бөгөөд дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 263.9 тэрбум төгрөг байна.

Дотоодын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдээр дамжин 211 нэр төрлийн виртуал хөрөнгө арилжаалагдаж буй бөгөөд эдгээрийн 19 хувь нь буюу 41 нь дотоодын виртуал хөрөнгө байна.

Технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн системд шинээр нэвтэрч буй нэг үйлчилгээ нь цахим платформд суурилсан мөнгөний захын бирж юм. Тус биржээр банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн багцаар баталгаажсан репо хэлцэл, итгэлцэл болон хадгаламжийн сертификатад суурилсан мөнгөний захын хэрэгсэл арилжаалагдан сэндбоксын орчинд туршигдаж байна. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар уг платформоор дамжин нийт 705 удаагийн хэлцлээр 118.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

**2.2. БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН**

Монгол Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа– 2050”

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод ухаалаг санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогын зорилт тусгагдсан байдаг бөгөөд цахим технологид суурилсан, ухаалаг


санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын нэгэн чухал хэсэг нь юм.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2022 онд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 469 дүгээр тушаалаар “Санхүүгийн зохицуулах




хорооны стратеги төлөвлөгөө (2022–2025)–г батлан хэрэгжүүлж буй бөгөөд тус стратеги төлөвлөгөөнд Санхүүгийн зохицуулах хорооны эрхэм зорилго нь “олон тулгуурт, хүртээмжтэй, цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ” гэж тодорхойлсон. Түүнчлэн уг стратеги төлөвлөгөөнд “уян хатан зохицуулалт, цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг дэмжих” гэж тусгасан

байдаг. Энэхүү эрхэм зорилго болон стратегийн зорилтынхоо хүрээнд технологид суурилсан санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжсэн хууль, эрх зүй, бодлого зохицуулалтын орчныг бүрдүүлэх, санхүүгийн хяналт, шалгалт, зохицуулалтын үйл ажиллагаанд мөн цахим технологийг нэвтрүүлэх зэргийг төлөвлөн ажиллаж байна.



Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлийн бодлого, зохицуулалтын орчинд нэлээд түгж буй бодлогын хэрэгсэл нь технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, инновацыг хязгаарлагдмал хүрээнд бодит орчинд турших боломжийг олгодог сэндбоксын зохицуулалт бөгөөд Монгол Улсын санхүүгийн

зах зээлийн хувьд 2021 оны 3 дугаар сард Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллагуудын хамтарсан тушаалаар “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг баталж, уг зохицуулалтын арга хэрэгслийг нэвтрүүлсэн.



2021 оны 12 дугаар сарын 17–ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд “технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хязгаарлагдмал хүрээнд бодитоор турших, нэвтрүүлэх сэндбокс зохицуулалтын орчныг бий болгох, холбогдох зохион байгуулалтын нэгж, зөвлөл байгуулах зэрэг харилцааг зохицуулсан сэндбокс зохицуулалтын журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгчтэй хамтран батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих” заалтыг тусгасан. Санхүүгийн зохицуулах хороо нь сэндбоксоод

бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших хүсэлтийг хүлээн авах, сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршиж буй компаниудтай хамтран ажиллах, холбогдох зөвлөгөө, мэдээллээр хангах чиг үүрэг бүхий “Сэндбоксын алба”–ыг 2022 оны 4 дүгээр сард байгуулан сэндбоксоод орох хүсэлтийг хүлээн авч эхэлсэн.

2023 оны 2 дугаар улирлын байдлаар сэндбокс зохицуулалтад өөрсдийн хөгжүүлж буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг турших нийт 15 хүсэлт ирсэн бөгөөд эдгээрээс 5 нь сэндбоксын орчинд орон 1 үйлчилгээ нь нэг жилийн хугацаагаар туршигдан сэндбоксын орчноос гарч, 4 үйлчилгээ нь туршигдаж байна.



**Зураг 4. Сэндбоксын орчинд орохоор ирүүлсэн хүсэлт, үйлчилгээний төрлөөр**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Эдгээр 4 үйлчилгээ нь санхүүгийн зах зээл дээрх богино хугацаат эх үүсвэрийн хэрэгцээг хангах онцлог бүхий банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн багцаар баталгаажсан репо хэлцэл, банкны хадгаламжийн сертификат болон банк бус санхүүгийн байгууллагын итгэлцлийн үйлчилгээнд суурилсан мөнгөний захын хэрэгслийг арилжаалдаг мөнгөний захын бирж, мөн хиймэл оюун ухаанд суурилсан зээлийн үнэлгээ бүхий P2P зээлийн платформ, төслийн санхүүжилтийг дэмжих хамтын

санхүүжилтийн үйлчилгээ, болон эрсдэлийн газрын зураглалд суурилсан инсуртекийн үйлчилгээ зэрэг болно.

Монгол Улсын санхүүгийн салбарт дараах голлох хуулиуд болон бусад холбогдох хууль, дагалдан батлагдсан журам, заавар, аргачлалууд мөрдөгддөг бөгөөд цахим технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн болон цахимаар хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцаанууд салбарын хууль, дүрэм, журмуудад тусгагдаж байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн салбарын голлох хуулиуд, цахим үйлчилгээтэй холбоотой харилцааг тусгасан байдал**

№	Хуулиудын нэр	Цахим санхүүгийн үйлчилгээтэй холбоотой заалт туссан эсэх
1	Төв банк /Монголбанк/-ны тухай хууль	-
2	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль	Сэндбокс зохицуулалттай холбоотой харилцаа туссан.
3	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль	Цахим мөнгө, шилжүүлэг, виртуал хөрөнгө болон технологид суурилсан санхүүгийн харилцаатай холбоотой харилцаа туссан.
4	Үндэсний төлбөрийн системийн тухай хууль	Цахим мөнгө гаргах, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэгтэй холбоотой харилцаа туссан.
5	Банкны тухай хууль	Банкны мэдээллийн технологийн шалгуур үзүүлэлтийн журам болон холбогдох журмаар цахим банкны харилцааг зохицуулдаг.

6	Даатгалын тухай хууль	Даатгалын багц дүрэмд цахим даатгалын үйлчилгээтэй холбогдох харилцааг тусгасан.
7	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль	Даатгалын зуучлалыг цахимаар үзүүлэхтэй холбоотой харилцаа даатгалын багц дүрэмд туссан.
8	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	Үнэт цаасны багц дүрэмд үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд нь цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх программ хангамжтай байх шаардлагыг тусгасан.
9	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль	Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журамд финтек зээлийн үйлчилгээтэй холбогдох харилцаа туссан.
10	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль	Цахимаар данс нээх, хаах, гэрээ байгуулах, үйлчилгээ авахтай холбоотой харилцаа туссан.
11	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль	-
12	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль	Виртуал хөрөнгийн үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой харилцаа туссан.

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Технологод суурилсан санхүүгийн үйл ажиллагаануудын хувьд санхүүгийн системд мөрдөгдөж буй хууль, дүрэм журмуудаас гадна цахим хөгжил, харилцаа холбооны салбарт мөрдөгдөж буй хууль, дүрэм,

журмууд стандартууд мөн мөрдөгдөх шаардлагатай бөгөөд дараах хуулиуд холбогдох зохицуулалтын хүрээнд санхүүгийн системд ашиглагдаж байна.

## Хүснэгт 2. Цахим хөгжлийг дэмжих хуулиуд

№	Хуулиудын нэр	Санхүүгийн үйлчилгээтэй холбоотой зохицуулалт бий эсэх
1	Инновацын тухай хууль	Гарааны компани үнэт цаас гаргахтай холбоотой харилцаа туссан.
2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Төрийн байгууллагуудын мэдээлэл мэдээллийн ил тод байдал, цахим үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулдаг.
3	Цахим гарын үсгийн тухай хууль	Цахим гарын үсэг, тоон гарын үсэг, цахим тамгатай холбоотой харилцааг зохицуулдаг.
4	Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль	Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.
5	Кибер аюулгүй байдлын тухай хууль	Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцоо, зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

*Эх сурвалж: Цахим хөгжил, харилцаа холбооны яам*



Санхүүгийн системийн хяналт, зохицуулалтыг ерөнхийд нь институционал суурьтай болон үйл ажиллагаанд суурилсан гэж хоёр ангилдаг. Институционал суурьтай зохицуулалтын хувьд санхүүгийн системд оролцогч байгууллагуудыг тус бүрд нь ялгаатай, хууль, эрх зүйн хүрээнд хянаж зохицуулдаг бөгөөд санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалах талаасаа уг аргачлал нь илүү давуу талтай байдаг. Харин үйл ажиллагаанд суурилсан зохицуулалтын хувьд санхүүгийн байгууллагуудад бус санхүүгийн үйл ажиллагаанд нь суурилсан хууль, эрх зүйн зохицуулалттай байдаг бөгөөд илүү уян хатан, инновац, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд амар хялбар байдлыг бий болгодог. Хэдийгээр зохицуулалтын уг хоёр хандлага нь өөрсдийн давуу болон сул талуудтай хэдий ч сүүлийн жилүүдэд улс орнууд аль, алиныг нь тодорхой түвшинд хослуулан хэрэгжүүлж байна. Тухайлбал АНУ, Англи, Европын холбоо, болон Австрали зэрэг улсууд хосолмол зохицуулалтыг хэрэгжүүлж байна.

Харин Монгол Улсын хувьд манай улс санхүүгийн үйл ажиллагааг биш санхүүгийн байгууллагуудад нь суурилан ялгаж зохицуулдаг бөгөөд энэ нь санхүүгийн хяналтыг нарийн тодорхой хэрэгжүүлэх, нийт системийн эрсдэлийг хянахад давуу талыг бий болгодог хэдий ч шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд хүндрэл

Австрали, Хонконг, Энэтхэг, Малайз, Мексик	– Итгэлцлийн бүтэцтэй

Эх сурвалж: <https://www.cclcx.com/publications/a-comparison-of-the-legal-structures-of-reits>



## IV. ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭ

Хөрвөх чадвар: Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын итгэмжлэлийн хувьд хөрөнгө оруулалт хийхэд хөрвөх чадварыг хангахын тулд хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулах хувийг тогтоодог.

Хонконгийн REIT –ийн кодексоор үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулах итгэмжлэл нь орлого олохуйц үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулах зохицуулалт тусгасан. REIT нь баригдаж байгаа үл хөдлөх хөрөнгө худалдан авах эрхтэй байдаг

ба сангийн цэвэр хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байх зохицуулалттай. Харин газарт хөрөнгө оруулалт хийх, үл хөдлөх хөрөнгийг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцохыг хориглодог.

Франц улс REIT–ийн нийт хөрөнгийн 60 хувийг үл хөдлөх хөрөнгөд, 10 хувийг хөрвөх чадвартай хөрөнгөд оруулах зохицуулалттай.


Харин Герман улсад уг харьцаа 51:49 хувь байдаг.

### Хүснэгт 2. Багц бүрдүүлэх шалгуур үзүүлэлт

Ирланд	Итали	Португал
<ul style="list-style-type: none"> <li>– Нэг үл хөдлөх хөрөнгөд сангийн цэвэр хөрөнгийн <b>20–оос илүүгүй хувийг</b> оруулах (Люксембург, Онтарио хот, Кэбэк хот)</li> <li>– Цэвэр хөрөнгийн 25–аас илүүгүй хувийг баригдаж байгаа, засвар хийх шаардлагатай үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулж болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Сангийн нийт хөрөнгийн гуравны нэгээс илүүгүй хувийг нэг үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулахгүй байх.</li> <li>– Үл хөдлөх хөрөнгийн сан нь шууд болон толгой компаниараа дамжуулан барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг компанийн эзэмшлийн 10–аас илүүгүй хувийг эзэмшихгүй байх.</li> </ul>	<p>Нээлттэй үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын санд багц бүрдүүлэх шалгуур тогтоодог:</p> <ul style="list-style-type: none"> <li>– Хөрөнгийн үнэ цэн сангийн нийт хөрөнгийн 75 хувиас илүүгүй байх.</li> <li>– Барилгын төслийн хөгжил сангийн нийт хөрөнгийн 25 хувиас илүүгүй байх.</li> <li>– Нэг үл хөдлөх хөрөнгөд сангийн нийт хөрөнгийн 20–оос илүүгүй хувийг оруулах.</li> <li>– Үл хөдлөх хөрөнгийн холдинг компанид сангийн нийт хөрөнгийн 25–аас илүүгүй хувиар түрээслүүлэх.</li> <li>– Нээлттэй буюу хаалттай үл хөдлөх хөрөнгийн тусгай сангууд нь нийтийн өмч бол захиалгын санал болгож буй болон хөдөө орон нутгийн барилга байгууламжид хөрөнгө оруулахыг зөвшөөрөхгүй: а) тухайн хотын захиргаа, түүнтэй адилтгах нутаг дэвсгэрийн дүүрэг дэх сангийн нийт хөрөнгийн 20 хувиас дээш; б) Зэргэлдээх хотын захиргаа эсвэл түүнтэй адилтгах сангийн нийт хөрөнгийн 30 гаруй хувь. нутаг дэвсгэрийн дүүргүүд дэх эд хөрөнгийг даатгуулсан бол а) ба б)–д заасан хязгаарыг 50 хувиар тогтооно.</li> </ul>

Испани	Их Британи	Швейцар
<ul style="list-style-type: none"> <li>– Нэг групп дор харьяалагдах компаниудад үл хөдлөх хөрөнгийг түрээслэхдээ нийт цэвэр хөрөнгийн 35 хувиас илүүгүй байхаар түрээслүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Арилжааны болон оршин суух зориулалттай хамгийн багадаа 3 түрээсийн үл хөдлөх хөрөнгөтэй байх.</li> <li>– Нэг үл хөдлөх хөрөнгө нь үл хөдлөх хөрөнгийн түрээсийн бизнесийн нийт үнэ цэний 40–өөс илүүгүй хувь байх.</li> <li>– Хөрөнгө оруулалтын эрсдэлийг зохистой тараах.</li> </ul>	<p>Хөрөнгө оруулалтаа үл хөдлөх хөрөнгийн төрөл, хэрэглээний зорилго, барилгын нас, байршил зэргээр нь ялгаатай багц үүсгэх шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> <li>– Үл хөдлөх хөрөнгийн сан нь хамгийн багадаа 10 үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалтаа байршуулсан байх.</li> <li>– Нэг үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ нь сангийн хөрөнгийн 25 хувиас илүүгүй байх.</li> <li>– Сангийн хөрөнгийн 30 хүртэлх хувийг баригдаж буй барилгад хөрөнгө оруулах.</li> <li>– Сангийн хөрөнгийн 20 хүртэлх хувийг түрээсийн газарт хөрөнгө оруулах.</li> <li>– Сангийн хөрөнгийн 30 хүртэлх хувийг баригдаж буй барилга болон түрээсийн газарт хоёуланд нь хөрөнгө оруулах.</li> <li>– Сангийн хөрөнгийн 10 хүртэлх хувийг ипотекийн зээл болон үл хөдлөх хөрөнгийн барьцааны бусад эрхэд хөрөнгө оруулалт хийж болно.</li> </ul>

Зураг 1. Зөвшөөрөгдсөн зээлийн дээд хэмжээ /хувиар/



Энэхүү зурагт зээлээр санхүүжиж болох зохицуулалттай орнуудын нийт авах зээл, өрийн санхүүжилтийн хэмжээ нь сангийн цэвэр хөрөнгийн үнийн дүнгийн хэдэн хувиас хэтрэхгүй байхыг орон тус бүрээр харууллаа.

Харин дараах улс орнуудад зээл авах, өрөөр санхүүжих нөхцөлд тодорхой хязгаарлалт байхгүй бөгөөд улс орон тус бүр өөр өөрийн хууль, журмаар зохицуулдаг байна.



- Австрали, Мексик, Нидерланд зэрэг улсуудад тусгайлсан журам зохицуулалт байхгүй.
- АНУ /SEC/ нээлттэй сан нь сангийн танилцуулагд зээлээр санхүүжих талаар тодорхой тусгасан байх, хөрөнгө оруулагчийн саналыг үндэслэн зээл авах нөхцөлтэй.
- Япон улсад тусгай зориулалтын компаниудад зөвхөн банкнаас зээл авахыг зөвшөөрдөг.
- Бразил улсад хуулиараа үл хөдлөх хөрөнгийн сан зээл авахыг хориглодог.

#### Ил тод байдлын шаардлага:

- **Герман:** ТЗК нь өөрийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод тайлагнадаг.
- **Хонконг:** REIT-тай холбоотой мэдээлэл, гүйлгээний талаар хувьцаа эзэмшигчдэд хагас жилээр, бүтэн жилээр мэдээлэх үүрэгтэй.
- **Итали:** Бүх хөрөнгө оруулалтын сангууд ил тод байдлын ижил журмыг мөрддөг. Ил тод тайлагнах мэдээлэлд аудитын тайлан, хөрөнгө оруулагчдын талаарх мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр, санхүүгийн тайлан хамаарна.
- **Япон:** ТЗК нь өөрийн хөрөнгийн удирдлагын тайлан, хаяг байршлын талаарх мэдээлэл, үл хөдлөх тус бүрийн зохих үнэ, хөрөнгийн үнэлгээний аргын талаарх мэдээллийг тухай бүр олон нийтэд ил тод мэдээлэлдэг.
- **Люксембург:** Хөрөнгө оруулалтын сангийн танилцуулгад UCI-ийн хөрөнгө оруулалтын бодлогод хамаарах хөрөнгө

орүүлалтын эрсдэлийн мэдээллийг ил тод мэдээлэх, шимтгэлийн төрөл, зардлын бүтэц, хураамж хэрхэн тооцоолж байгаагаар дэлгэрэнгүй тусгасан байх шаардлагатай.

- **Нидерланд:** Жилийн тайланд эрсдэлийн удирдлага, санхүүгийн тайлан, зээлийн мэдээлэл, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний арга, өгөөжийн хувь хэмжээ, хөрөнгөө эргүүлэн татах тухай тусгадаг.

#### Үл хөдлөх хөрөнгийн сангийн удирдлагад тавигдах шаардлага:

- Бразилын үнэт цаасны хорооноос гаргасан хуульд зааснаар үл хөдлөх хөрөнгийн санг зөвшөөрөл авсан дараах байгууллагууд удирдах эрхтэй.
  1. Хөрөнгө оруулалтын банк
  2. Моргейжийн банк
  3. Брокерын компани
  4. Үнэт цаасны компани
- **Герман:** Үл хөдлөх хөрөнгийн нээлттэй сан нь ТЗК-аар дамжуулан сангаа удирддаг бөгөөд сангийн удирдлага нь мэргэжлийн чадварлаг мэргэжилтэн байх ёстой.
- **Хонконг:** Сангийн удирдлагад REIT зохицуулалтын дагуу Үнэт цаас ба фьючерсийн тусгай зөвшөөрөлтэй, туршлагатай менежерийг томилох ёстой.
- **Испани:** Сангийн удирдах зөвлөлийн гишүүд үл хөдлөх хөрөнгийн зах зээлд багадаа 2 жил ажилласан байх шаардлага тавьдаг.
- **Швейцар:** Сангийн удирдлага нь боловсрол, туршлага, карьерын шаардлагыг хангасан байх ёстой.

- Их Британийн NURS болон PAIFs: Эрх бүхий сангийн удирдлага нь хөрөнгө оруулагчийн зөвшөөрлийн дагуу томилогдож сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.
- АНУ-ын SEC-ээс сангийн удирдлагыг хангалттай туршлагатай байх шаардлага тавьдаг.

**Үл хөдлөх хөрөнгийн сангийн ногдол ашгийн хэмжээний талаарх зохицуулалт:**

- **Бразил:** Хамгийн багадаа 180 хүртэлх хоногийн хугацаатай хөрөнгө оруулалт хийдэг. Энэ хугацаанд хөрөнгө оруулалтын сан хангалттай өгөөжтэй ажиллаагүй бол хөрөнгө оруулагчдад хөрөнгийг эргүүлэн хуваарилдаг.
- **Герман:** Хуримтлагдсан ашиг нь сангийн цэвэр хөрөнгийн дүнгийн 15 хувиас хэтрэхгүй тохиолдолд хуульд заасны дагуу хөрөнгийг хуваарилна.
- **Франц:** Сангийн цэвэр ашгийн 85-аас доошгүй хувийг хуваарилах зохицуулалттай.
- **Хонконг:** Татварын дараах аудитаар баталгаажсан тайланд жилийн цэвэр орлогын 90 хувиас доошгүй хувийг нэгж хувьцаа эзэмшигчдэд жил бүр ногдол ашиг болгон хуваарилах үүрэгтэй.
- **Япон:** ТЗК-ийн ногдол ашгийн 90 гаруй хувийг хөрөнгө оруулагчдад хуваарилах ёстой.
- **Португал:** Ноогдол ашиг хуваарилах хамгийн бага хөрөнгийн хэмжээг сангийн дүрмээр тогтоож болно.
- **Их Британи:** Татварын дараах ашгийн 90 хувийг ноогдол ашиг хэлбэрээр

санхүүгийн тайлан гарснаас 4 сарын дотор шилжүүлэх үүрэгтэй.

- АНУ-ын SEC-ээс татварын орлогын 90-ээс доош хувийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах үүрэгтэй. Тусгай зориулалтын компани ААНОАТ төлдөггүй.

**Хаалттай хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалт:**

- **Герман:** Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу үл хөдлөх хөрөнгийн хаалттай санг хуулиар хориглодог. REIT-ийн дагуу хөрөнгө оруулалтын сан байгуулах зөвшөөрөлтэй компани нь тусгай зохицуулалттай байдаг.
- **Хонконг:** REIT кодекс нь хаалттай сан байгуулахад уян хатан нөхцөлөөр хангадаг, уян хатан зарчимд суурилдаг.
- **Ирланд:** Хаалттай үл хөдлөх хөрөнгийн сан нь Ирландын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. Бусад арилжааны компаниудаас ялгаатай нь хөрөнгийн биржид бүртгэлтэй хаалттай үл хөдлөх хөрөнгийн сангууд нь Санхүүгийн Зохицуулагчийн зохицуулалтад байдаг.
- **Люксембург:** Хөрөнгийн биржид бүртгэлтэй хаалттай үл хөдлөх хөрөнгийн сангууд нь бусад хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудтай адил зохицуулалттай байдаг.
- **Онтарио:** Хаалттай үл хөдлөх хөрөнгийн сан нь бусад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сангуудтай ижил зарчмаар зохицуулагдана.
- **Швейцар:** Одоогоор Швейцарын хөрөнгийн бирж дээр зөвхөн нээлттэй CIS гэрээт хөрөнгө оруулалтын 14 сан



бүртгэлтэй байна. ХХК-ийн хэлбэрээр хаалттай үл хөдлөх хөрөнгийн сангийн

ерөнхий зохицуулалтын талаар тусгай зохицуулалттай.

### Үнэлгээ

#### Хүснэгт 3. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний шаардлага

Герман	Бразил	Франц
<ul style="list-style-type: none"> <li>Нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн үнэлгээг хараат бус үнэлгээний компаниар хийлгэхийг хуульд заасан байдаг.</li> <li>Жилд нэгээс доошгүй удаа сангийн бүх үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг гаргадаг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Улирал бүрийн тайланд сангийн хөрөнгө, зах зээлийн үнэлгээ, үнийн дундаж өсөлт, бууралтыг тусгадаг. Мөн ямар шалгуураар тайлагнаснаа тусгана.</li> <li>Хөрөнгийн үнэлгээг гурваас дээш мэргэжилтэн эсвэл бие даасан мэргэшсэн компани хийх ёстой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Улирал бүр тусгайлсан хөрөнгийн үнэлгээний компаниар үнэлгээ хийлгэнэ. Жил бүр үл хөдлөх тус бүрээр мэргэшсэн үнэлгээний шалгалт хийдэг.</li> <li>Үнэлгээний тайланг ил тод мэдээлж хөрөнгө оруулагчдад тухай бүр тогтмол илгээдэг.</li> </ul>
Хонконг	Ирланд	Австрали
<ul style="list-style-type: none"> <li>REIT-ийн шаардлагын дагуу хөрөнгийн үнэлгээг жилд нэг удаа заавал хийх шаардлагатай.</li> <li>Үнэлгээг олон улсын үнэлгээний стандартын дагуу үнэлгээний бие даасан хараат бус компани хийдэг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үл хөдлөх хөрөнгийн сан нь жилд хоёроос доошгүй удаа хараат бус үнэлгээний компаниар сангийн хөрөнгийг зах зээлийн үнээр үнэлүүлэх ёстой.</li> <li>Үнэлгээ хийсний дараа цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлдог.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бие даасан тусгай шаардлага байхгүй, Австралийн санхүүгийн үйлчилгээний байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгохдоо ашиг сонирхлын зөрчлийг зохицуулдаг хуультай.</li> <li>Хамгийн багадаа 3 жил тутамд хөрөнгийн бие даасан үнэлгээг хийх шаардлагатай.</li> </ul>
Люксембург	АНУ /SEC/	Португал
<ul style="list-style-type: none"> <li>ТУЗ-аас үнэлгээ хийх компанийг баталдаг. Санхүүгийн жилийн эцэст үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хийдэг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нээлттэй хөрөнгө оруулалтын сан нь жил бүр аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг улирал бүр гаргах шаардлагатай.</li> <li>Үнэлгээ хийхдээ GAAP дагуу цэвэр хөрөнгийг хуримтлагдсан элэгдлийг хассан дүнгээр тооцно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн үнэлгээг жил бүр хийх, хараат бус үнэлгээний компаниар хийлгэх, үнэлгээний дараах аргуудаас 2-оос доошгүйг ашиглах ёстой. /харьцуулах арга, өгөөжийн арга, зардлын арга/</li> </ul>

#### Хүснэгт 4. Үнэлгээний үнээр худалдах, худалдан авахад гүйлгээ хийх хэмжээ

Франц	Хонконг	Герман
<ul style="list-style-type: none"> <li>– Үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах арилжааны хувьд хөрөнгийн үнэлгээний үнэ хамаарахгүй. Ямар ч тохиолдолд үл хөдлөх хөрөнгийг зах зээлийн үнээр үнэлнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Хонконгийн REIT-ийн кодексоор худалдах, худалдан авах үнийг хэрхэн тогтоохыг заадаггүй. Талууд арилжааны журмаар тогтоосон үнээс хямд буюу түүнээс дээш үнээр тооцож болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Хөрөнгийн үнэлгээ нь нэг жилийн хугацаанд хүчинтэй байна.</li> <li>– Арилжаа хийхээс өмнө зах зээлийн үнэ нь үнэлгээний үнээс хэтрээгүй буюу бага зэрэг давсан тохиолдолд үл хөдлөх хөрөнгийг худалдан авч болно. Харин худалдах үнэ нь зах зээлийн бага тохиолдолд үл хөдлөх хөрөнгө зарахыг зөвшөөрдөг.</li> </ul>
Испани	Португал	Ирланд
<ul style="list-style-type: none"> <li>– Үнэлгээний компанийн зөвшөөрлөөр үнэлгээнд 3% хүртэл хэлбэлзэл хэрэглэж болно. Энэ үнэ нь тухайн тайланд тусгагдсан зах зээлийн үнээс хэтэрч болохгүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн худалдан авах үнэ болон шинжээчийн үнэлгээний арифметик дунджаар тогтоодог.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Хөрөнгийн үнэлгээний тайлан гаргаснаас хойш зургаан сарын дотор үнэлгээний үнийн дүнгийн 5%-иас доогуур үнээр авах ёстой. Мэргэжлийн хөрөнгө оруулагч болон шаардлага хангасан хөрөнгө оруулагчдад үнэлгээний үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй хэмжээний үл хөдлөх хөрөнгө худалдаж авах боломжтой бол хөнгөлөлт үзүүлж болно.</li> </ul>
АНУ /SEC/	Их Британи	Люксембург
<ul style="list-style-type: none"> <li>– Үл хөдлөх хөрөнгийн сангаас үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, худалдах үнэд нөлөөлж болох боловч үүнийг зохицуулсан зохицуулалт байхгүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хуульд зааснаар жилд нэгээс дээш удаа нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу үнэлэх ёстой.</li> <li>– Үнэлгээний үнийн дүнгийн 105 хувиас дээш үнээр үл хөдлөх хөрөнгө худалдаж авч болохгүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Хөрөнгийн үнэлгээ хийснээс хойш зургаан сарын дотор үл хөдлөх хөрөнгийг худалдсан тохиолдолд шинээр үнэлгээ хийх шаардлагагүй. Харин үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ огт хийгдээгүй тохиолдолд үл хөдлөх хөрөнгийг худалдах боломжгүй. Зөвшөөрөгдсөн онцгой нөхцөлөөс бусад үед худалдан авалтын үнэ нь холбогдох үнэлгээнээс мэдэгдэхүйц өндөр, борлуулалтын үнэ мэдэгдэхүйц бага байж болохгүй.</li> </ul>

#### Үнэлгээ хийхэд нийтлэг тулгардаг асуудлууд:

- Хангалттай олон давтамжтай үнэлгээ хийхгүй байх
- Хараат бус байдал алдагдах
- Үнэлгээний чанар
- Ашиг сонирхлын зөрчил
- Үнэлгээний зардал өндөр байх
- Үнэлгээний арга
- Үнэлгээ нь зах зээлийн төлбөрийн чадварын баталгааг хангаж чаддаггүй.
- Үл хөдлөх хөрөнгө нь хөрвөх чадвар багатай тул үнэлгээ нь субъектив шинж чанартай байдаг.
- Худалдан авалтын үнэ, үнэлгээний үнийн хооронд хэт их зөрүү үүсэж болзошгүй.
- Хөрөнгө оруулалтын багцын хөрөнгийн үнэ буурах магадлалтай.
- Үл хөдлөх хөрөнгийг үнэлэхэд хэцүү байдаг.



**Үл хөдлөх хөрөнгийн сангийн хувьцааны хөрвөх чадвар, нэгж эрх**

Үл хөдлөх хөрөнгийн нээлттэй сан

- Үл хөдлөх хөрөнгийн нээлттэй сан байгуулахыг зөвшөөрсөн улс орнууд: Австрали, Франц, Герман, Япон, Жерси, Люксембург, Португал, Испани, Швейцар,

Их Британи,

- Зөвшөөрөөгүй улс орнууд: Бразил, Хонконг, Итали, Мексик, Онтарио, Кебек
- Үл хөдлөх хөрөнгийн сан нь нээлттэй эсвэл хаалттай байж болдог улсууд: Нидерланд

**Хүснэгт 5. Үл хөдлөх хөрөнгийн итгэмжлэлийн хөрвөх чадвар**

Герман	Япон	Австрали
– Германы хөрөнгө оруулалтын тухай хуульд зөвхөн үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын сангууд нээлттэй байхаар заасан байдаг. Хаалттай үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын санг зөвшөөрдөггүй.	– Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын компаниудыг нээлттэй хэлбэрээр байгуулахад хөрөнгө оруулагчийн эргүүлэн авах хүсэлтийг хангахын тулд үл хөдлөх хөрөнгийн багцаа зарах эсвэл хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээг хэт өндөр байлгах шаардлагатай болдог.	– Нээлттэй сан нь: үүсгэн байгуулсан баримт бичигт хөрөнгө оруулагчдын тоо, хөрөнгө оруулах боломжтой үл хөдлөх хөрөнгийн тоо, хөрөнгө оруулалтын хугацаа зэргийн тусгасан, хөрөнгө оруулалтын өгөөжийг нийт хөрөнгийг хүүгийн тоонд хуваах замаар тодорхойлсон тохиолдолд хөрөнгө оруулагч хүүгээ хэдийд ч эргүүлэн авах боломжтой болдог. – “Нээлттэй” эсвэл өөр төрлийн санг үүсгэн байгуулахад үнэ төлбөргүй байдаг.
Хонконг	Ирланд	Итали
– Хаалттай сан хэлбэрээр зохион байгуулагдаж, SENK дээр бүртгэлтэй, арилжаалагдах ёстой.	– Нээлттэй үл хөдлөх хөрөнгийн сангууд хангалттай хөрвөх чадварыг хангаж чадсан тохиолдолд санг эрхэлж болно, гэхдээ энэ нь тийм ч түгээмэл биш юм.	– Италид байрладаг үл хөдлөх хөрөнгийн сангууд нь зөвхөн хаалттай сан байж болно.

**Хүснэгт 6. Хөрвөх чадварын доод хэмжээг тогтоох тусгай зохицуулалт**

Франц	Герман	Ирланд
– 6 сар тутамд 1 удаа буюу жилийн бүрийн 6 сарын 30, 12 сарын 31–ний дотор цэвэр хөрөнгийн үнийг тооцож нийтлэх ёстой.	– Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн 5–аас доошгүй хувь нь тус сангийн нэрийн өмнөөс төлбөр хийх боломжтой өдөр бүр бэлэн байгаа хөрөнгөд хадгалагдаж байгаа эсэхийг баталгаажуулах ёстой.	– Хөрөнгө оруулалтын сангууд нь хувьцаа эзэмшигчид жижиг хөрөнгө оруулагчдын сангаас доод тал нь сар бүр, мэргэжлийн болон шаардлага хангасан хөрөнгө оруулагчдын сангаас доод тал нь улирал тутам өөрийн нэгжийг эргүүлэн авах хүсэлт гаргахыг зөвшөөрсөн тохиолдолд нээлттэй хөрөнгө оруулалтын сан гэж үзэж болно.

Нидерланд	Португал	Испани
– Нээлттэй сан нь хөрөнгө оруулагчдын хүсэлтээр хувьцаагаа эргүүлэн худалдаж авах боломжтой байх ёстой.	– Хөрвөх чадварын тодорхой доод хэмжээг тогтоох тусгай зохицуулалт байхгүй ч хөрвөх чадварын байнгын доод түвшнийг зөвшөөрөхийн тулд дэлхий даяар боловсруулсан түвшнийг авч үзнэ.	– Хөрөнгө оруулагч жилд 1–ээс доошгүй удаа нэгж хувьцаагаа захиалах эсвэл зарах үед сан хөрвөх чадварыг хангасан байх ёстой. – Үл хөдлөх хөрөнгө нь нийт хөрөнгийнхөө 10–аас доошгүй хувийг бэлэн мөнгө, банкны хадгаламж эсвэл төрийн сангийн богино хугацааны тогтмол орлоготой бүтээгдэхүүнд оруулсан байх ёстой, зөвхөн эргүүлэн авах боломжтой, хөрвөх чадвар сайтай байдаг.
Швейцар	Их Британи	АНУ /SEC/
– Хөрөнгө оруулагчид санхүүгийн жилийн эцэст хөрөнгөө эргүүлэн авах хүсэлт гаргаж болно. Энэ байдлыг тэгшитгэхийн тулд үл хөдлөх хөрөнгийн сангийн нэгжийг банк эсвэл үнэт цаасны дилерээр дамжуулан хөрөнгийн бирж эсвэл биржийн бус зах дээр тогтмол арилжаалж байдаг.	– Нээлттэй сангийн хөрөнгө оруулагчид хөрөнгөө эргүүлэн татах тодорхой тусгай заалт агуулаагүй бол хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хөрвөх чадвар сайтай хөрөнгөөр хадгалдаг. Үүнд хамгийн бага тооны хувьцаа олон нийтийн гарт (25%) байх ёстой бөгөөд тэдгээр нь хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн биржид бүртгэлтэй байх ёстой.	– Үнэт цаасны бирж дээр арилжаалагддаг үл хөдлөх хөрөнгийн сангууд нь тухайн биржийн арилжааны хамгийн бага шаардлагыг дагаж мөрддөг. Жишээлбэл, Нью-Йоркийн хөрөнгийн биржид бүртгэлээ хадгалахын тулд үл хөдлөх хөрөнгийн сан ерөнхийдөө сард дунджаар 100,000 ширхэг хувьцаа арилжаалах ёстой. Үл хөдлөх хөрөнгийн бусад сангуудын хувьд холбооны хуулиар тогтоосон хувьцааны хөрвөх чадварыг тодорхой хэмжээгээр баталгаажуулах тусгай журам байдаггүй. Харин үл хөдлөх хөрөнгийн сангууд нь өөрийн хөрвөх чадварыг бий болгож болно.

### Ашиг сонирхлын зөрчил

#### Ёс зүйн дүрэм, компанийн засаглалын кодексын зохицуулалт:

Компанийн засаглалтай холбоотой кодексын тусгай зохицуулалт байхгүй улс орнууд:

- Австрали
- Ирланд
- Люксембург
- АНУ /SEC/

Компанийн засаглалтай холбоотой кодексын тусгай зохицуулалтын журамтай улс орнууд:

- Их Британи
- Япон

Бразил: SVM Харилцагчийн үнэ цэнийн менежментийн дагуу сангийн удирдлагад

хамаарах үүрэг, хариуцлага, хориглох дүрмүүдийг тусгасан байдаг.

Франц: Хамтын хөрөнгө оруулалтын санд хамаарах ашиг сонирхлын зөрчлийн тухай тусгай хуультай, хуульд тухайн байгууллага ашиг сонирхлын зөрчлийг эсрэг хэрэгжүүлэх бодлогыг боловсруулах тухай тусгасан байдаг.

Герман: Германы хөрөнгө оруулалтын менежментийн салбарын төлөөллийн холбооноос гаргасан (BVI Bundesverband Deutscher Investment-Gesellschaften e.V.) нарийвчилсан компанийн засаглалын кодексыг гишүүн байгууллагууд дагаж мөрддөг.

Хонконг: REIT-ийн боловсруулсан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрсдэлийг удирдах тусгай кодексыг дагаж мөрддөг.



**Нидерланд:** Голландын сан ба хөрөнгийн менежментийн холбооноос (DUFAS) засаглалын багц зарчмуудыг хэрэгжүүлдэг бөгөөд хөрөнгө оруулалтын сангуудад нэмэлт зөвлөмж хүргүүлдэг.

**Португал:** Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд засаглалын дүрэмтэй байдаг. Ашиг сонирхлын зөрчлийг хуулийн дагуу зохицуулдаг. Удирдлагын компани нь нэг ба түүнээс дээш хөрөнгө оруулалтын сан эзэмшсэн тохиолдолд ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэн Португалийн үнэт цаасны зах зээлийн хорооноос тусгайлан зохицуулалт хийдэг.

**Кебект:** Бие даасан хяналтын хорооноос гаргасан (IRC) ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой тусгай журам үйлчилдэг. Хөрөнгө оруулалтын сангуудад зөвлөмж өгч бүрэн хяналт тавьдаг. Үнэт цаасны тухай хуулийн 109 дүгээр зүйлд: Хөрөнгө оруулалтын сангийн менежер нь сангийн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд өөрийн ажлаа хянамгай, хичээнгүй хийж, мэргэжлийн чиг үүргээ үнэнчээр гүйцэтгэнэ гэж заасан байдаг.

**Испани:** Хөрөнгийн менежментийн компаниуд INVERCO-оос боловсруулсан загварын хүрээнд өөрийн загварыг боловсруулж түүнийгээ дагаж мөрддөг. ТУЗ-ийн гишүүд эсвэл хөрөнгийн удирдлагын компанийн дотоод хэлтсээс бүрдсэн бие даасан хороо байх ёстой. Энэхүү хороо нь компанийн үйл ажиллагаа ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн дүрэмд тусгагдсан дотоод журамд нийцэж байгаа эсэхийг шалгадаг. Үйл ажиллагааны жилийн тайланд компанийн засаглал, ашиг сонирхлын зөрчлийн талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг хөрөнгө оруулагчдад тайлагнадаг.

## Бие даасан хяналтын байгууллага

Сангийн удирдлага, хөрөнгө оруулагчийн дунд үүсэж болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах бие даасан хяналтын байгууллагын зохицуулалт:

- **Австрали:** Ашиг сонирхлыг зохицуулах тусгай бие даасан нэгж байхгүй, Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн хуулийн дагуу аливаа гомдлыг шийдвэрлэх дотоод тогтолцоотой байхыг шаарддаг.
- **Бразил:** Үнэт цаас, биржийн хорооноос ашиг сонирхлын зөрчлийг арилгах, түүнд хяналт тавих захиргааны эрхтэй байдаг.
- **Герман:** Хөрөнгө оруулалтын сангийн үнэт цаас, харилцах дансны гүйлгээг кастодиан банк хийдэг. Германы Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу кастодиан банк нь хөрөнгө оруулалтын сантай холбоотой хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Мөн кастодиан банк нь хөрөнгө оруулагчдын нэрийн өмнөөс учирч болзошгүй хохирлыг нөхөн төлүүлэх, хөрөнгө оруулалтын сангийн эд хөрөнгөтэй холбоотой нэхэмжлэлийн талаар гуравдагч этгээдэд холбогдох шүүх ажиллагаа явуулах эрхтэй. Кастодиан банканд Холбооны санхүүгийн хяналтын газар / BaFin/ хяналт тавьдаг.
- **Итали:** Компанийн ТУЗ-д гишүүд салбарын холбооноос гаргасан зөвлөмжийн дагуу хяналт хийдэг. Сангийн дүрэмд ихэвчлэн ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөлд менежментийн компани гүйлгээ хийхээс өмнө сангийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас тодорхой зөвшөөрлийг авах зохицуулалттай заалтуудыг байдаг.

**Үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн нэр / хууль ёсны өмчийн бүтэц**

**Хүснэгт 7. Үл хөдлөх хөрөнгийн сангуудын хөрөнгө эзэмшигчийн бүртгэлийн зохицуулалт**

Бразил	Франц	Хонконг
– Үл хөдлөх хөрөнгийн сангийн хөрөнгө нь тусгай зориулалтын компанийн өмчлөлд байна.	– OEREF-ийн дагуу хөрөнгийг ХОМК нэр дээр бүртгэдэг. Мөн хөрөнгийн бүртгэлд ХОМК-ийн эзэмшигчдийг тодорхой зааж өгөх ёстой.	– REIT-ийн хөрөнгийг итгэмжлэгдсэн төлөөлөгч нь сангийн хөрөнгийг эзэмшдэг. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр сонгодог. REIT-ийн хөрөнгийг итгэлцлээр хадгалах үүрэгтэй.
Герман	Япон	Ирланд
– Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын сангийн үл хөдлөх хөрөнгө нь ХОМК-ийн хууль ёсны өмч байдаг.	– Бодит хөрөнгийг сангийн нэр дээр бүртгэдэг. Харин итгэлцэл болон үнэт цаасыг итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр дээр бүртгэдэг.	– Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг кастодиан банкны нэр дээр бүртгэдэг. Мөн сангийн өөрийн нэр дээр болон сангийн охин компанийн нэр дээр бүртгэх тохиолдол ч бий. – Өмчийг зарах болон бусдад шилжүүлэхийг хязгаарласан зохицуулалттай.
Итали	Их Британи	Люксембург
– Италийн хууль тогтоомж дагуу сангийн хөрөнгө нь үргэлж сангийн нэр дээр хадгалж, бүртгэдэг.	– Үл хөдлөх хөрөнгийн сангийн хөрөнгийг сангийн нэр дээр эзэмшиж, бүртгэдэг.	– Үл хөдлөх хөрөнгийн сангийн хөрөнгийг хамтын хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн нэр дээр бүртгэдэг. Хамтын хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт хийж буй үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалахыг кастодиан банк хариуцдаг.
Испани	Швейцар	АНУ-ын SEC
– Үл хөдлөх хөрөнгийн сангийн санхүүгийн хөрөнгийг Хадгаламжийн байгууллагад, санхүүгийн бус хөрөнгийг үл хөдлөх хөрөнгийн сангийн нэрээр хөрөнгийн бүртгэлд бүртгэнэ.	– Хөрөнгө оруулалтын сангийн хувьд үл хөдлөх хөрөнгийн сангийн хөрөнгийг ихэвчлэн ХОМК-ийн нэр дээр бүртгэдэг. SICAV хэлбэрийн үл хөдлөх хөрөнгийн сангийн хөрөнгийг SICAV-ийн нэр дээр бүртгэнэ.	– Үл хөдлөх хөрөнгийн сан нь хөрөнгөө шууд эзэмшдэг. Зарим үл хөдлөх хөрөнгийн сангууд хөрөнгөө шууд бусаар эзэмшихийн тулд түншлэлийг ашигладаг. Түншлэлийн хүрээнд сан нийт хөрөнгийг дийлэнх хувийг эзэмших үүрэгтэй.



## V. ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ӨНӨӨГИЙН ОРЧИН

Монгол Улсад үл хөдлөх хөрөнгийн хувьд барилгын компаниудын тусгай зөвшөөрөл, барилгын чанарыг Барилга, хот байгуулалтын яам хариуцаж, Барилгын тухай хуулиар зохицуулагддаг. Харин барилга баригдах хугацааны хувьд зохицуулалтгүй. Түүнчлэн Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбар нь 2020 оноос тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхлэх боловч салбарын хуульгүй тул нарийвчилсан эрхзүйн орчин шаардлагатай. Нэг үгээр хэлбэл үл хөдлөх хөрөнгийн салбар нь үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт сул тул үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын сангийн эрхзүйн орчныг бүрдүүлэхдээ дээрх хүчин зүйлсийг харгалзах шаардлагатай. Үүнд:

- Дуусаагүй барилгад хөрөнгө оруулалт хийх нөхцөл, шалгуурыг тогтоох
- Ашиг сонирхлын зөрчлийг удирдах
- Хөрвөх чадварын харьцааг зохистой тогтоох

### REIT-ийн өмчлөлийн бүтэц:

1. Хувьцаа эзэмшигчид/хөрөнгө оруулагчид: Хувь хүн, байгууллагын хөрөнгө оруулагчид болон бусад аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээл дээр REIT-ийн хувьцааг худалдан авах боломжтой. Хувьцаа бүр нь REIT-ийн хувь эзэмшлийн хувийг илэрхийлдэг.
2. Нийтэд арилжаалагддаг REITs: Олон REIT-ийг хөрөнгийн бирж дээр олон нийтэд арилжаалдаг тул хөрөнгө оруулагчдад хувьцаагаа хялбархан худалдаж авах, худалдах боломжийг олгодог. Олон нийтэд арилжаалагддаг REIT-үүд нь АНУ-ын Үнэт цаас, биржийн хороонд (SEC)

тогтмол санхүүгийн тайлан гаргах зэрэг зохицуулалтын шаардлагуудыг дагаж мөрддөг.

3. Хувийн REITs: Зарим REIT нь олон нийтэд арилжаалагддаггүй бөгөөд хувийн эзэмшилд байж болно. Ийм тохиолдолд өмчлөх эрх нь ихэвчлэн итгэмжлэгдсэн хөрөнгө оруулагчид эсвэл байгууллагуудын жижиг бүлэгт хязгаарлагддаг.
4. Менежмент: REIT-ийн өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ болон гүйцэтгэх захирлууд удирддаг. Удирдах зөвлөл нь REIT-ийн зорилгод нийцсэн шийдвэр гаргах, зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.
5. Орлогын хуваарилалт: REIT-ийн нэг гол онцлог нь орлогынхоо нэлээд хэсгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр хуваарилах үүрэгтэй. Орлогын энэхүү хуваарилалт нь хөрөнгө оруулагчдад томоохон хөшүүрэг бөгөөд татварын зохицуулалтын дагуу REIT статусыг хадгалахад тавигдах шаардлага юм.
6. Татварын бүтэц: REIT-үүд нь татварын зорилгоор дамждаг аж ахуйн нэгжийн бүтэцтэй. Энэ нь итгэлцэл өөрөө холбооны орлогын албан татвар ногдуулдаггүй гэсэн үг юм. Харин орлогыг хувьцаа эзэмшигчдэд шилжүүлж, хуваарилсан орлогынхоо татварыг төлөх үүрэгтэй.

Хувьцаа эзэмшигчид REIT-ийг хамтад нь эзэмшдэг ч тэд итгэлцлийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн тодорхой хөрөнгөд шууд хяналт тавьдаггүй гэдгийг анхаарах

нь чухал юм. Удирдлагын баг болон ТУЗ нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, үл хөдлөх хөрөнгийн менежмент болон бусад үйл ажиллагааны асуудлыг хариуцдаг.

REIT-д хөрөнгө оруулагчид ногдол ашиг хүртэх боломж, үл хөдлөх хөрөнгийн төрөлжүүлсэн багцад хөрөнгө оруулах чадвараас ашиг тус хүртэж, үл хөдлөх хөрөнгийг шууд эзэмших, удирдахгүйгээр үл хөдлөх хөрөнгийн хөрөнгийн төрөлжсөн багцад хөрөнгө оруулах боломжтой. Хувь хүмүүс REIT-д хөрөнгө оруулахаасаа өмнө түүний хөрөнгө оруулалтын стратеги, эрсдэлийн хүчин зүйлс, гүйцэтгэлийг ойлгохын тулд итгэлцлийн танилцуулга, санхүүгийн тайлан болон бусад холбогдох мэдээллийг сайтар судалж үзэх хэрэгтэй.

### **Дагаж гарч байгаа үйлчилгээ зохицуулалт-Менежментийн үйлчилгээ**

Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын итгэмжлэл (REIT) болон түүний зохицуулалтын хүрээнд цэвэрлэгээний үйлчилгээний талаарх тусгай зохицуулалтыг тодорхой заагаагүй боловч холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, бизнесийн ухаалаг үйл ажиллагааг бүхэлд нь дагаж мөрдөх нь чухал юм.

#### **1. Үйл ажиллагааны нийцэл:**

- Цэвэрлэгээний үйлчилгээний зохицуулалт нь эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны стандарттай холбоотой орон нутгийн, муж улсын болон холбооны холбогдох дүрэм журамд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах. Үүнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын (OSHA) удирдамж болон бусад холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөх зэрэг багтаж болно.

#### **2. Түрээслэгчийн гэрээ:**

- Түрээслэгчийн гэрээг хянан үзэж, үл хөдлөх хөрөнгийн засвар үйлчилгээ, цэвэр байдал, дундын талбайтай холбоотой аливаа заалттай холбоотой хариуцлага, үүргийг тодорхойлох. Цэвэрлэгээний үйлчилгээний зохицуулалт нь эдгээр гэрээний үүрэгт нийцсэн байх ёстой.

#### **3. Төсөв болон санхүүгийн нийцэл:**

- Цэвэрлэгээний үйлчилгээтэй холбоотой зардлыг REIT-ын санхүүгийн ерөнхий бүтцэд зохих ёсоор төсөвлөж, хуваарилах. Санхүүгийн тайлангийн ил тод байдал нь хууль тогтоомжийг дагаж мөрдөх, хөрөнгө оруулагчдын харилцаанд чухал ач холбогдолтой.

#### **4. Байгаль орчны тогтвортой байдал:**

- Цэвэрлэгээний үйлчилгээний зохион байгуулалтад байгаль орчинд ээлтэй практикийг тусгах талаар авч үзэх хэрэгтэй. Зохицуулалтын шаардлага байх албагүй ч байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа нь тогтвортой байдлын өргөн хүрээний зорилтуудтай нийцэж, REIT-ийн нэр хүндийг өсгөж чадна.

#### **5. Даатгал ба хариуцлага:**

- Цэвэрлэгээний үйлчилгээ үзүүлэгч нь зохих даатгалд хамрагдаж, хариуцлагын асуудлыг гэрээний зохицуулалтад тусгасан эсэхийг шалгах. Энэ нь REIT-ийг цэвэрлэх үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйн асуудлаас хамгаалахад тусалдаг.

#### **6. Чанарын баталгаа ба баримт бичиг:**

- Цэвэрлэгээний үйлчилгээний чанарыг баталгаажуулах, үе үе хяналт шалгалт



хийх, баримтжуулах тогтолцоог бүрдүүлнэ. Шууд зохицуулалтын шаардлага биш ч гэсэн нарийн баримтжуулалт нь аудит хийх, эд хөрөнгийн засвар үйлчилгээний өндөр стандартыг хангах гэх мэт.

#### 7. Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөлт:

- Асгарсан, осол аваар, яаралтай анхаарал хандуулах шаардлагатай бусад тохиолдлууд гэх мэт яаралтай цэвэрлэгээ хийх төлөвлөгөөг боловсруулах. Энэхүү идэвхтэй арга нь аюулгүй байдал, зохицуулалтыг дагаж мөрдөхөд хувь нэмэр оруулдаг.

#### 8. Гэрээнд нийцсэн байдал:

- Цэвэрлэгээний үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээ нь хууль тогтоомж, зохицуулалтын стандартад нийцэж байгаа

эсэхийг шалгах. Гэрээ нь ойлгомжтой, цогц, хуулийн дагуу хэрэгжих боломжтой байх ёстой.

#### 9. Түрээслэгчийн харилцаа холбоо:

- Цэвэрлэгээний хуваарь, аливаа тасалдал, тэдний үүрэг хариуцлагын талаар түрээслэгчидтэй нээлттэй харилцах шугамыг хадгалах. Тодорхой харилцаа холбоо нь үл ойлголцол үүсэхээс сэргийлж, түрээслэгчийн эерэг туршлагыг баталгаажуулдаг.

#### 10. Тогтмол аудит, шалгалт:

- Цэвэрлэгээний үйлчилгээний зохицуулалтын үр нөлөө, дүрэм журамд нийцэж байгаа эсэх, REIT-ийн зорилгод нийцэж байгаа эсэхийг үе үе хянаж, аудит хийнэ. Энэхүү байнгын үнэлгээ нь тасралтгүй сайжруулахад хувь нэмэр оруулдаг.

## САНАЛ, ДҮГНЭЛТ

1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд REIT-ийн эрхзүйн зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй.
2. Хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын санг үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулахыг хориглох. Үл хөдлөх хөрөнгийн эрхзүйн орчин нарийн бүрдээгүй, мөн Ром–Германы хуулийн системтэй.
3. REIT хөрвөх чадварыг хангахын тулд хамгийн багадаа хэдэн үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулах, нэг үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулах хэмжээ сангийн хөрөнгийн хэдэн хувиас хэтрэхгүй байх, баригдаж байгаа барилга, ипотекийн зээлийн болон барьцаанд байгаа хөрөнгөд хэдэн хувийг оруулах зэргийг журамд нарийн зааж оруулах.
4. Хөрөнгийн багц бүрдүүлэхэд сангийн хөрөнгийн хэдэн хувийг үл хөдлөх хөрөнгөд, хэдэн хувийг хөрвөх чадвартай хөрөнгөд хөрөнгө оруулахыг зааж өгөх.
5. Хөрөнгийг зах зээлийн үнээр үнэлэх, тусгай мэргэжлийн хөрөнгийн үнэлгээний компаниар хийлгэх. Хөрөнгийг үнэлгээг улирал тутам хийх.
6. Зээлээр санхүүжих зохицуулалт оруулбал зөвшөөрөгдөх хувь хэмжээг тусгах.
7. Сангийн удирдлагад мэргэшсэн албан хаагчийг томилох.
8. Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын сангийн мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, эрсдэлийг удирдах зорилгоор сангийн танилцуулгад мэдээллийн ил тод байдлын журмын дагуу мэдээллээ улирал бүр ирүүлэхээр зохицуулах.
9. СЗХ–ноос баталсан Компанийн засаглалын кодексийг тусгай зориулалтын компаниуд дагаж мөрдөх, кодексийн хэрэгжилттэй холбоотой тайланг жилийн үйл ажиллагааны тайландаа тусган хөрөнгө оруулагчдад мэдээлэх
10. Үл хөдлөх хөрөнгийн сангийн хөрөнгийг тухайн сангийн нэр дээр бүртгэж, эзэмших. Хэрвээ сангийн нэр дээр тухайн сангийн хөрөнгийг бүртгээгүй бол хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалж холбогдох газарт бүртгүүлэхийг шаардах,
11. ХОМК сангийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хязгаарлах, хэрвээ зарцуулах тохиолдолд хөрөнгө оруулагчдын саналыг авах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.
12. Ноогдол ашиг хуваарилах хамгийн бага хөрөнгийн хэмжээг сангийн дүрмээр тогтоох.
13. Компанийн ТУЗ–аас тусгай зөвлөмжийн дагуу бие даасан хяналтын байгууллагаар дамжуулан ашиг сонирхлын зөрчлийг удирдах, хянах.
14. Үл хөдлөх хөрөнгийн сангийн хууль ёсны өмчлөгч нь тусгай зориулалтын компани байна.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. REVIEW of the REGULATORY ISSUES RELATING to REAL ESTATE FUNDS REPORT of the TECHNICAL COMMITTEE of the INTERNATIONAL ORGANIZATION of SECURITIES COMMISSIONS. 2008, <https://www.iosco.org/library/pubdocs/pdf/IOSCOPD275.pdf>
2. Martin, William L. "Federal Regulation of Real Estate Investment Trusts: A Legislative Proposal." University of Pennsylvania Law Review, vol. 127, no. 2, Dec. 1978, p. 316, scholarship. law.upenn.edu/cgi/viewcontent.cgi?article=4837&context=penn\_law\_review, <https://doi.org/10.2307/3311701>.
3. Ng'ati, Martin, and Machira. UNIVERSITY of NAIROBI SCHOOL of LAW MASTER of LAWS COLLEGE of HUMANITIES and SOCIAL SCIENCES ASSESSING KENYA'S LEGAL FRAMEWORK on REAL ESTATE INVESTMENT TRUSTS (REITS): MAKING a CASE for MORTGAGE REITS, [http://erepository.uonbi.ac.ke/bitstream/handle/11295/104576/Ng%E2%80%99ati\\_Assessing%20Kenya%E2%80%99S%20Legal%20Framework%20On%20Real%20Estate%20Investment%20Trusts%20%28Reits%29.pdf?sequence=1&isAllowed=y](http://erepository.uonbi.ac.ke/bitstream/handle/11295/104576/Ng%E2%80%99ati_Assessing%20Kenya%E2%80%99S%20Legal%20Framework%20On%20Real%20Estate%20Investment%20Trusts%20%28Reits%29.pdf?sequence=1&isAllowed=y)
4. Nareit. "REITs by the Numbers." Nareit, 2019, [www.reit.com/data-research/data/reits-numbers](http://www.reit.com/data-research/data/reits-numbers). <https://www.reit.com/data-research/data/reits-numbers>
5. <https://rak.co.ke/legal-framework-governing-real-estate-investment-trusts-reits-in-kenya>



# 8

## ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ, ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ЭРХЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Гүйцэтгэсэн: Б.Тэмүүжин<sup>14</sup>

<sup>14</sup> СЗХ, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт email: [temuujin@frc.mn](mailto:temuujin@frc.mn)



## УДИРТГАЛ

Тус судалгаагаар үнэт металл, үнэт чулуу болон үнэт эдлэлийн урлал, үйлдвэрлэл, худалдаа адилхан жигд хөгжсөн бөгөөд зах зээл нь өндөр түвшинд хүрсэн улс орнуудын сонгон авч, тэдгээр улс орнуудын эрх зүйн орчны зохицуулалт хэрхэн хийгдэж, ямар байдлаар зохион байгуулдаг талаар судлахыг зорьсон.

Тухайлбал, 1–р бүлэгт Япон улсыг, 2–р бүлэгт АНЭУ–ыг, 3–р бүлэгт Багамын хамтын нөхөрлөл, 4–р бүлэгт АНУ, 5–р бүлэгт ӨАБНУ–ыг, 6–р бүлэгт Хонконг улсыг, 7–р бүлэгт Сингапур гэсэн улс орнуудын туршлагыг жишээгээр баяжуулан, харьцуулалт хийж, санал, дүгнэлт гаргалаа.

Судалгаандаа үнэт эдлэл, өнгөт чулуу, дагалдах хэрэгсэл гэж юу болох талаар, тэдгээрийн хоорондын ялгаатай байдлаас эхлүүлээд, тэдгээрийн худалдаа борлуулалт экспорт импортод анхаарах зүйлс, хаяг шошгожилт, бүтээгдэхүүнд тавигдах стандарт, шаардлага татварын систем, тус зах зээл дээр хэн ямар журмаар тусгай зөвшөөрлийг ямар процедурын дагуу, ямар материал бүрдүүлж, ямар шаардлагыг хангаж байж авдаг болох, тавигдсан шаардлага стандарт цензурийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, шийтгэлийн асуудал зэрэг сэдэв, цар хүрээг хамруулсан болно.

## АГУУЛГА

I.	ЯПОН УЛС	282
II.	АРАБЫН НЭГДСЭН ЭМИРАТ УЛС	290
III.	БАГАМЫН ХАМТЫН НӨХӨРЛӨЛ / THE COMMONWEALTH OF THE BAHAMAS/	294
IV.	АНУ	296
V.	ӨМНӨД АФРИКИЙН БҮГД НАЙРАМДАХ УЛС	300
VI.	ХОНКОНГ	301
VII.	СИНГАПУР УЛС	302
VIII.	МОНГОЛ УЛС	305
	САНАЛ, ДҮГНЭЛТ	311
	ЭХ СУРВАЛЖ	312

---

## ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Үнэт чулууны ангилал /Японд/	282
Хүснэгт 2: Япон улсын үнэт чулуу, үнэт металлын зохицуулалтын байгууллагууд	286
Хүснэгт 3: Японы үнэт эдлэлийн бүтээгдэхүүний тариф	289
Хүснэгт 4: 2018 оны байдлаар санхүүгийн гүйлгээний тайлагналтай холбоотойгоор захиргааны мөнгөн торгууль ноогдуулах зөрчлүүд	294
Хүснэгт 5: Сингапурын үнэт эдлэлийн арилжаа эрхлэгчийн ангилал	302
Хүснэгт 6: Жишээ /Сингапурт/	303
Хүснэгт 7: Сингапурт үнэт эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалууд	304
Зураг 1. Японы шошгожуулалтын жишээ зураг	286
Зураг 2. Японы үнэт эдлэлийн гарал үүслийн тэмдгийн жишээ	287
Зураг 3. Японы үнэт эдлэлийн чанарын тэмдгийн жишээ	287
Зураг 4. Японы үнэт эдлэлийн гарал бүтээгдэхүүний анхааруулах карт, жишээ	288
Зураг 5. Сингапурт үнэт эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах процесс	303

---



## I. ЯПОН УЛС

Япон улсад үнэт металл, үнэт эдлэлийг "үнэт эдлэл", "өнгөт чулуу", "дагалдах хэрэгсэл" гэсэн гурван ангилалд хуваадаг. "Үнэт эдлэл" гэдэг нь үнэт металлаар (алт, мөнгө, цагаан алт) хийсэн хувийн гоёл чимэглэлийг хэлдэг. Хувийн гоёл чимэглэл нь бөгж, бугуйвч, хүзүүний зүүлт, ээмэг, хавчаар, зангиа, ханцуйвч зэрэг биед зүүдэг жижиг эд зүйлсийг хэлдэг.

"Өнгөт чулуу" –г "үнэт чулуу", "хагас үнэт чулуу" гэж ангилдаг. Энэ хоёр ангилалд тодорхой тодорхойлолт байхгүй ч бадмаараг, индранил, маргад эрдэнийн гурван гол үнэт чулууг ерөнхийд нь үнэт чулуу гэж ангилдаг.

Бусад өнгөт чулууг хагас үнэт чулуу гэж нэрлэдэг. Эдгээр чулуунуудын хатуулаг, бат бөх байдлын зэрэг нь ихэвчлэн 7 ба түүнээс доош байдаг. Хагас үнэт чулууны жишээнд анар, аметист, оюу гэх мэт орно.

"Дагалдах хэрэгсэл" гэдэг нь үнэт металл, өнгөт чулууг ашигладаггүй хувийн гоёл чимэглэлийн зүйлсийг хэлнэ. Тэдгээрийг титан эсвэл зэвэрдэггүй гангаар хийсэн "үндсэн металлын дагалдах хэрэгсэл" болон хуванцар гэх мэт металлаас бусад материалаар хийсэн "бусад хэрэгслүүд" гэж тус тус ангилдаг.

### Хүснэгт 1. Үнэт чулууны ангилал /Японд/

Хамрах хүрээ		
Зүйл	Тодорхойлолт	HS код
Үнэт эдлэл	Алтан үнэт эдлэл	7113.11.021.029
	Мөнгөн үнэт эдлэл	7113.11.000
	Платинум үнэт эдлэл	7113.19.010
Өнгөт чулуу	Үнэт чулуу (бадмаараг, индранил, маргад)	7103.91.000
	Хагас үнэт чулуу	7103.99.000
Дагалдах хэрэгсэл	Үндсэн металл	7117.11, 19
	Бусад (металлаас бусад материал)	7117.90.

**Тайлбар 1:** Үнэт эдлэл гэдэг нь үнэт металлаар хийсэн цэвэр үнэт эдлэл болон үнэт чулуун оруулгатай үнэт металл, үнэт эдлэлийг хоёуланг нь багтаасан "үнэт металлаар (алт, мөнгө, цагаан алт) хийсэн хувийн хэрэгслүүд" гэсэн үг юм.

**Тайлбар 2:** Өнгөт чулуу нь зөвхөн өнгөлсөн өнгөт эрдэнийн чулууг агуулдаг. Үүнд огтлоогүй өнгөт

чулуу эсвэл синтетик эрдэнийн чулуу багтдаг.

**Тайлбар 3:** Дагалдах хэрэгсэл гэдэг нь үнэт металл болон өнгөт чулууг ашигладаггүй хувийн гоёл чимэглэлийн зүйлсийг хэлдэг. Үнэт металлаар бүрсэн, эсвэл үнэт металлаар чимэглэсэн жижиг гоёл чимэглэлийн зүйлс багтдаг.

## А. Япон руу экспортлох, борлуулахдаа анхаарах зүйлс

### (1) Импортын зохицуулалт ба журам

Үнэт эдлэл, дагалдах хэрэгслийг импортлоход зарчмын хувьд хууль эрх зүйн тусгай хязгаарлалт байхгүй. Гэсэн хэдий ч зарим төрлийн зэрлэг амьтан, ургамал (зааны ясан, шүр гэх мэт) ашигладаг бүтээгдэхүүнийг Вашингтоны конвенцын (*Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийн олон улсын худалдааны тухай конвенц, CITES*) нөхцөлийн дагуу хязгаарлаж эсвэл хориглож болно.

Засаагүй очир алмазыг импортлох нь олон улсын Kimberley Process Certificate program-ийн хүрээнд Гадаад валютын болон гадаад худалдааны тухай хуулийн заалтуудыг дагаж мөрддөг. Түүнчлэн Гаалийн тарифын тухай хуульд хуурамч брэндийн бүтээгдэхүүн, knockoff copies хуулбарыг хилээр нэвтрүүлэхийг хориглодог бөгөөд эдгээр зүйлийг Гаалийн тухай хуульд заасан журмын дагуу гааль дээр хурааж, устгадаг. Холбогдсон импортлогч этгээдүүдэд торгууль, хорих зэрэг эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой.

- Гадаад валют ба гадаад худалдааны тухай хуулийн дагуу Импортын худалдаанд тавих хяналт (CITES дагуу)

Вашингтоны конвенцын дагуу Гадаад валютын болон гадаад худалдааны тухай хууль нь тус конвенцын хавсралтад орсон зэрлэг амьтан, ховор ургамлын төрлийн импортлохыг зохицуулдаг. Энэ нь зэрлэг амьтан, ургамлын худалдааг дангаар нь төдийгүй тэдгээрээр бүрэн буюу хэсэгчлэн хийсэн, орц найрлагатай бүтээгдэхүүнийг хамардаг.

Вашингтоны конвенц нь дор дурдсан гурван төрлийн ангиллыг хамаардаг. Эдгээр ангиллын

тодорхой агуулга, хэрэглэх заалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Япон улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны товчоо, Худалдаа, хяналтын хэлтэс, Худалдааны тусгай зөвшөөрлийн хэлтэст тус тус хандаж болдог байна.

#### Ангилал I: (Устах аюулд орсон бүх төрөл зүйл)

Эдгээр зүйл эсвэл эдгээр зүйлээр хийсэн бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор тээвэрлэхийг хориглодог байна. Эрдэм шинжилгээний зорилгоор гэх мэт онцгой тохиолдолд худалдаа хийхийг зөвшөөрдөг. Гэхдээ экспортлогч улсын засгийн газраас олгосон экспортын зөвшөөрөл, Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн сайдын импортын зөвшөөрөл шаардлагатай болдог.

\*Жишээ нь: Азийн заан (Энэтхэгийн заан), Африкийн заан (Ботсвана, Намиби, Өмнөд Африк, Зимбабвегийн заануудаас бусад)

#### Ангилал II: (Мөхөх аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд олон улсын хатуу зохицуулалт шаарддаг бүх төрөл зүйл)

Ийм зүйлээр хийсэн аливаа зүйл, бүтээгдэхүүнийг импортлогч нь Японы гаалийн байгууллагад экспортлогч улсын удирдлагын холбогдох байгууллагаас гаргасан экспортын гэрчилгээ эсвэл дахин экспортын гэрчилгээг гаргаж өгөх ёстой болдог. Зарим төрөл зүйл нь Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн сайдаар урьдчилан баталгаажуулах шаардлагатай ч хүртэл болдог.

\*Жишээ нь: Африкийн заанууд (Ботсвана, Намиби, Өмнөд Африк, Зимбабвегийн заануудаар хязгаарлагддаг)

Бүх төрлийн Антипатари (хар шүр), гелиопорида (цэнхэр шүр), склерактиниа (чулуун шүр),



tubiporidae (эрхтэн хоолойт шүр), milleporidae (галын шүр), stylasteridae (нэхсэн шүр) г.м орно.

**Ангилал III: (Худалдааг хянахад бусад талуудын хамтын ажиллагаа, зохицуулалт шаардлагатай гэж тодорхойлсон бүх зүйл)**

Арилжааны зорилгоор ийм зүйлээр хийсэн аливаа зүйл, бүтээгдэхүүнийг импортлогч нь экспортлогч улсын захиргааны холбогдох байгууллагаас олгосон экспортын гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээ, эсвэл эсхүл уг сорьцыг тухайн улсад боловсруулсан тухай реэкспортын улсын захиргааны эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээг Япон улсын гаалийн байгууллагад танилцуулах ёстой. Зарим төрөл зүйл нь Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн сайдаар урьдчилан баталгаажуулахыг хүртэл шаарддаг.

\*Жишээ нь: Хятадаас ирдэг *Corallium elatius* (ягаан шүр), *corallium japonicum* (улаан шүр), шүрэн коножой (цагаан шүр), шүрэн секундм (түүхий шүр) зэрэг багтдаг.

Ховор материалыг арилжааны зорилгоор зориудаар өсгөж болно, эсхүл конвенцод нэгдэхээс өмнө олж авсан материалыг экспортлогч улсын захиргааны эрх бүхий байгууллагаас энэ тухай гэрчилгээ олгосон тохиолдолд зөвшөөрнө. Үнэт металл, зааны яс, шүрэн болон бусад тодорхой төрлийн үнэт эдлэл агуулсан үнэт эдлэл импортлохдоо мэдүүлэг дээр шинжлэх ухааны нэршлийг бичсэн байх нь хамгийн зохимжтой байдаг.

■ **Гадаад валют ба гадаад худалдааны хуулийн дагуу Импортын худалдааны хийгдэх хяналт (Kimberley Process Certificate System дагуу)**

2003 оны 1–р сарын байдлаар Японы зүсээгүй очир алмаз импортлогчид Африк дахь

мөргөлдөөнийг санхүүжүүлэхэд зарцуулсан алмазын зохисгүй худалдааг зогсоох зорилгоор олон улсын Кимберли процессын хөтөлбөрийн хүрээнд зохицуулсан экспортлогчоос гаргасан KPCS–ийг танилцуулж зөвшөөрөл авах ёстой. Одоогоор KPCS–д 70 гаруй гишүүн улс орон байна. НҮБ–ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолын дагуу KPCS–д гишүүнчлэлгүй улс орнуудын импортыг хориглосон байдаг. Түүнчлэн, сайн дурын салбарын стандартад зүсээгүй очир алмаз болон алмаазан үнэт эдлэлийн мэдүүлэгт гарал үүслийн бичгийг заавал хавсаргасан байх ёстой гэж заасан байдаг.

## **(2) Борлуулалтын үеийн дүрэм журам ба процедурын шаардлага**

Үнэт металл, үнэт эдлэл худалдан борлуулахад "Үндэслэлгүй хөрөнгөжих болон төөрөгдүүлсэн мэдээллийн эсрэг" хуулийг дагаж мөрддөг. Төрөл бүрийн оюуны өмчийн тухай хууль (*Барааны тэмдгийн тухай хууль, Загварын тухай хууль, Шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гэх мэт*) нь барааны тэмдэг, дизайны эрх болон бусад оюуны өмчийн эрхийг зөрчсөн бүтээгдэхүүнийг зохицуулдаг. Үүнд: knockoff хуулбар, төөрөгдүүлсэн худалдааны нэр томьёо, зар сурталчилгааны дүрүүдийг зөвшөөрөлгүй ашиглах зэрэг болно.

Үйл ажиллагаа эрхлэгчид хуулийн дагуу арга хэмжээнд өртөж болзошгүй тул ирээдүйн импортлогчид эдгээр асуудлыг мэдэж байх ёстой. Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг хамгаалах тухай хуулийн дагуу тодорхой зүйлээр (*зааны ясан, шүр гэх мэт*) хийсэн бүтээгдэхүүнийг хязгаарлаж эсвэл хориглож болно. Үүнээс гадна door-to-door худалдаа хийх, шуудангийн захиалгын худалдаа, chain худалдаа болон бусад тодорхой

арилжааны гүйлгээ нь "Арилжааны гүйлгээний тухай" хуулийн заалтад хамаарна.

Мөн сав, сав баглаа боодол нь Нөөцийн үр ашигтай ашиглалтыг дэмжих тухай хууль, Хог хаягдлыг ангилан цуглуулах, сав, сав баглаа боодлыг дахин боловсруулахыг дэмжих тухай хуулийн дахин боловсруулалтын заалтуудад (зарим жижиг үйлдвэрлэгчид зохицуулалтаас чөлөөлөгдөнө) хамрагддаг.

■ **Үндэслэлгүй хөрөнгөжилт, төөрөгдүүлсэн мэдээллийн эсрэг үйл ажиллагаа явуулах**

Энэ хууль нь бүтээгдэхүүний шинж чанар, чанарын талаар хэрэглэгчдийг төөрөгдүүлсэн зохисгүй, хэтрүүлсэн, хуурамч шошго хэрэглэхийг хориглодог. Хэрэглэгчийн асуудал эрхэлсэн газар нь дээд зэргийн чанартай гэх мэт тодотгол бүхий барааны нэр, шошгын үндэслэлийг нотлох зорилгоор түүний баримт бичгийг шаардаж болно. Хэрэв импортлогч эсвэл борлуулагч үүнийг хийх боломжгүй бол эдгээр хаягжилтыг буруу шошгын нэг хэлбэр гэж үзнэ. Бодит гарал үүслийг тогтооход үйлдвэрлэсэн улсыг ялгахад хүндрэл учруулдаг, тодорхой бус эсвэл будилаантай шошгоолтыг буруу шошгын нэг хэлбэр гэж үзнэ.

■ **Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг хамгаалах тухай акт**

Энэхүү хууль нь устах аюулд орсон зүйлүүдийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилготой. Хамгаалах зорилгоор тусгайлан тодорхойлсон төрөл зүйлээр хийсэн бүтээгдэхүүнийг Япон улсад зарах, шилжүүлэхийг хориглоно. Гэхдээ байгаль орчны яаманд бүртгүүлсэн, зохих журмын дагуу арилжааны зорилгоор өсгөж буй төрөл зүйлийг Япон улсад худалдаалж болно.

Бүртгэлийн үйл ажиллагаа нь Байгаль орчны яамнаас албан ёсоор томилогдсон бүртгэлийн байгууллага болох Японы Зэрлэг амьтан судлалын төвд явагддаг.

■ **Тодорхой арилжааны гүйлгээг хийх тухай акт**

Шуудангийн захиалгын худалдаа, door-to-door худалдаа хийх гэх мэт тодорхой арилжааны гүйлгээгээр дамжуулан ердийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, эрх, үйлчилгээг борлуулах нь тодорхой арилжааны гүйлгээний тухай хуулийн заалтад хамаарна. Хуулийн дагуу тодорхойлогдсон арилжааны гүйлгээнд: (1) door-to-door худалдаа хийх, (2) шуудангаар худалдаа хийх, (3) утсаар худалдаа хийх, (4) сүлжээний борлуулалт (олон түвшний маркетинг), (5) тасралтгүй үйлчилгээ үзүүлэх тусгай гүйлгээ, (6) бизнесийн боломжуудыг санал болгодог борлуулалтын гүйлгээ зэрэг багтдаг.

Шуудангийн захиалгын борлуулалтад интернэт худалдаа, цахим шуудангаар арилжааны сурталчилгаа (URL-тай холбогдсон мэдээлэл) орно. Хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахын тулд шуудангаар худалдаа хийхдээ операторууд зар сурталчилгаандаа (1) борлуулалтын үнэ, (2) төлбөрийн хугацаа, арга, (3) хүргэлтийн хугацаа, (4) буцаах системтэй холбоотой заалтууд, (5) болон операторын нэр, хаяг, утасны дугаар зэргийг оруулж, мэдээлэх шаардлагатай байдаг. Хуулийн дагуу худал, хэтрүүлсэн мэдээлэл агуулсан сурталчилгааг хориглодог.



### (3) Холбогдох эрх бүхий байгууллагууд

#### Хүснэгт 2. Япон улсын үнэт чулуу, үнэт металлын зохицуулалтын байгууллагууд

Эрх бүхий байгууллагуудтай харилцах		
Холбогдох зохицуулалт, хяналт	Эрх бүхий байгууллагууд	Холбоо барих / Вэбсайт
Гадаад валютын болон гадаад худалдааны тухай хууль	Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны товчоо, Худалдааны тусгай зөвшөөрлийн хэлтэс, Худалдааны хяналтын газар	УТАС: +81-3-3501-1511, <a href="http://www.meti.go.jp">http://www.meti.go.jp</a>
Гаалийн тарифын тухай хууль/ Гаалийн тухай хууль	Сангийн яамны Гааль, тарифын товчооны Нөхөн олговор, ашиглалтын хэлтэс	УТАС: +81-3-3581-4111, <a href="http://www.mof.co.jp">http://www.mof.co.jp</a>
Үндэслэлгүй урамшуулал, төөрөгдүүлсэн мэдээллийн эсрэг үйл ажиллагаа явуулах тухай	Японы Шударга Худалдааны Хорооны Худалдааны практикийн газрын Хэрэглэгчтэй холбоотой худалдааны хэлтэс	УТАС: +81-3-3507-8800, <a href="http://www.caa.go.jp">http://www.caa.go.jp</a>
Байгаль хамгаалах товчоо, Зэрлэг ан амьтдын ховордсон хамгаалах тухай хууль	Байгаль орчны яамны Байгаль хамгаалах товчоо, Ан амьтдын хэлтэс	УТАС: +81-3-3581-3351, <a href="http://www.env.go.jp">http://www.env.go.jp</a>
Зөвшөөрөгдсөн арилжааны гүйлгээний тухай хууль	Японы Шударга Худалдааны Хорооны Худалдааны практикийн газрын Хэрэглэгчтэй холбоотой худалдааны хэлтэс	УТАС: +81-3-3501-1511, <a href="http://www.meti.go.jp">http://www.meti.go.jp</a>
Нөөцийн үр ашигтай ашиглалтыг дэмжих тухай хууль/Хог хаягдлыг ангилан цуглуулах, сав, сав баглаа боодлыг дахин боловсруулахыг дэмжих тухай хууль	Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамны Аж үйлдвэрийн шинжлэх ухаан, технологийн бодлого, байгаль орчны товчоо, Дахин боловсруулалтыг дэмжих газар,  Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хог хаягдлын менежмент, дахин боловсруулах газар	УТАС: +81-3-3501-1511, <a href="http://www.meti.go.jp">http://www.meti.go.jp</a>  УТАС: +81-3-3581-3351, <a href="http://www.env.go.jp">http://www.env.go.jp</a>

### Б. Бүтээгдэхүүний шошгожилт / Labeling/

#### 1/ Хуулийн зохицуулалтын дагуу шошголох

#### Зураг 1. Японы шошгожуулалтын жишээ зураг

[Representation example]



Нөөцийн үр ашигтай ашиглалтыг дэмжих тухай хуулийн дагуу ангилсан цуглуулгыг дэмжих зорилгоор тусгай сав, баглаа боодол нь таних тэмдэгтийн заалттай байдаг. Цаас эсвэл хуванцрыг бие даасан бүтээгдэхүүний сав баглаа боодол, шошго, гадаад сав баглаа боодол болон бусад зүйлд ашиглах тохиолдолд материалын таних тэмдгийг савны хажуу талд дор хаяж нэг цэг дээр байрлуулсан байх ёстой.

## 2/ Японы гарал үүслийн тэмдэг /Hallmark by Japan Mint/

Зураг 2. Японы үнэт эдлэлийн гарал үүслийн тэмдгийн жишээ

[Representation example]




Японы mint нь металл бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагчдаас хүсэлт гаргасны дагуу үнэт металлын бүтээгдэхүүний зэрэглэлийг баталгаажуулах системийн дагуу чанарын туршилт хийдэг. Ашигласан металлын цэвэр байдлын түвшинг харуулахын тулд туршилтад тэнцсэн бүтээгдэхүүн дээр "Hallmark" гэж нэрлэгддэг баталгаажуулалтын тэмдгийг дардаг.

Энэ систем нь сайн дурынх боловч Японд үнэт эдлэлийн тэмдэглэгээг ийм байдлаар хийх нь нийтлэг болж, бараг стандарт болсон. Бусад өндөр хөгжилтэй орнуудад үйлдвэрлэсэн үнэт эдлэл нь ямар нэгэн төрлийн металлын агууламжийн тэмдэгтэй байдаг ч үнэт металл, чанарын шошготой холбоотой олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой стандарт байдаггүй.

### Японы үнэт эдлэлийн холбооны чанарын тэмдэглэгээ

Зураг 3. Японы үнэт эдлэлийн чанарын тэмдгийн жишээ

[Representation example]



Японы үнэт эдлэлийн холбоо нь чанарын тэмдэглэгээний системийг бий болгосон. Энэ нь үнэт металлын чанарыг (үнэт металлын агууламжийг) баталгаажуулдаг гэсэн үг. Энэхүү системийн дагуу шошгологчийн (Холбооны гишүүн) хариуцлагыг бүртгэгдсэн барааны тэмдэг, шошгологчийн таних тэмдэгт тамга дарснаар бий болохыг тодорхой заасан байдаг. Чанарын тэмдгийг Японы үнэт эдлэлийн холбооны чанарын тэмдэглэгээний хороонд бүртгэлтэй шошгочид сайн дурын үндсэн дээр үзүүлдэг.

### Үнэлгээний сайн дурын стандартууд

Японы үнэт эрдэнийн лабораториудын холбоо (AGL) болон Японы үнэт эдлэлийн холбоо (JJA) хамтран “*Үнэт чулуу, үнэт металлаар хийсэн гоёл чимэглэлд ашиглагдах эрдэнийн чулуу, материалыг тодорхойлох, нэрлэх аргачлал*”-ыг тогтоож, тэдгээрийн үнэлгээнд тусгах ашигт малтмалын нэр, материалын нэр, эрдэнийн чулууны нэрийг тусгаж өгсөн (эрдэнийн чулуу судлаачдын дүгнэлтийн бичгээр гаргасан тунхаглалаар). Ингэхдээ зүсэх, өнгөлөхөөс өөр өнгө үзэмжийн өөрчлөлт, сайжруулалт, өөрчлөлтийг хэрэглэгчдэд мэдээлэх зорилгоор “Тодруулга тайлбар<sup>1</sup>” мэдээлэл гаргасан байна. Японы үнэт эдлэлийн холбооны гишүүд баталгааны захидалдаа энэ мэдээллийг тайлбарлах шаардлагатай. Борлуулалтын ажилтан мөн борлуулалтын зорилгоор бүтээгдэхүүнийг тайлбарлахдаа эдгээр баримтуудыг хэрэглэгчдэд мэдэгдэх үүрэгтэй. Нэмж дурдахад Японы үнэт эдлэлийн холбоо энэ салбарт гүйлгээ хийх ёс зүйн удирдамжийг бий болгосон байдаг.

<sup>1</sup> Disclosure comments



### Японы үнэт эдлэлийн нийгэмлэгийн анхааруулга

Японд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний гэмтэл, алдааны улмаас хүний амь нас, бие махбод, эд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд үйлдвэрлэгчдэд нөхөн төлбөр олгох гэх мэт хариуцлагыг тогтоох зорилгоор “Бүтээгдэхүүний хариуцлагын тухай” хуулийг баталсан байдаг. Импортлогчид нь импортолсон бүтээгдэхүүнээс учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй. Үнэт эдлэлийн салбарт металл болон дагалдах хэрэгслээс үүдэлтэй арьсны харшил үүсэж болзошгүй эрсдэл байдаг. Импортлогчид зааварчилгааны гарын авлага, сэрэмжлүүлгийн заалт бэлтгэхдээ болгоомжтой хандах хэрэгтэй болдог. Японы үнэт эдлэлийн холбоо нь Бүтээгдэхүүний хариуцлагын тухай хуулийн хариу арга хэмжээ болгон харшилд анхаарлаа хандуулахын тулд “анхааруулах карт” бэлтгэдэг байна.

#### Зураг 4. Японы үнэт эдлэлийн гарал бүтээгдэхүүний анхааруулах карт, жишээ



Жишээ нь:

Таны эрүүл мэндийн байдлаас шалтгаалан та загатнах, тууралт гарч болзошгүй. Хэрэв таны арьсанд ямар нэгэн эмгэг илэрвэл бүтээгдэхүүнийг хэрэглэхээ зогсоож, мэргэжилтэнтэй холбоо барина уу.

- Хүний биед хор хөнөөл учруулж болзошгүй тул биеийн тамирын дасгал хийх, идэвхтэй спортоор хичээллэх, унтах, нярай хүүхэд асрах үед гоёл чимэглэлээ тайлна уу.
- Түлэнхийн гэмтэл, хөлдөлт үүсгэж болзошгүй тул ээмэг гэх мэт үнэт эдлэлийг саун зэрэг өндөр хэмтэй газар, цанын бааз гэх мэт хэт бага температурт зүүж болохгүйг анхаарна уу гэх мэтчилэн анхааруулдаг байна.

## V. Татварын систем

### 1/ Тарифын татвар

Зураг 2–т үнэт эдлэл, дагалдах хэрэгслийн тарифын татварыг үзүүлэв. Импортлогч нь хөнгөлөлттэй нөхцөлтэй улсаас импортолсон бараа бүтээгдэхүүнд хөнгөлөлттэй тариф ногдуулах хүсэлт гаргахын тулд тухайн экспортлогч улсын гаалийн болон бусад эрх бүхий байгууллагаас олгосон хөнгөлөлтөд хамрагдах гарал үүслийн улсын гэрчилгээг (татвар ногдуулах нийт үнэ нь 200,000₯–аас ихгүй бол шаардлагагүй) ирүүлэх шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээллийг Японы Сангийн яамны Гааль, тарифын товчооноос авах боломжтой. Тарифын ангилал эсвэл холбогдох тарифыг урьдчилан баталгаажуулсан тохиолдолд "урьдчилсан зөвлөгөө өгөх program"–ийг ашиглах нь тохиромжтой байдаг.

Хүснэгт 3. Японы үнэт эдлэлийн бүтээгдэхүүний тариф

**Fig2. Tariff duties on precious metal and Jewelry**

HS Code.	Description	Rate of duty				
		General	Temporary	WTO	Preferential	Special preferential
7101.22	Cultured pearls worked	Free		(Free)		
210	Akoya pearls					
220	Silver lipped pearls and Black lipped pearls					
290	Other					
7102.39	Diamonds, non-industrial	Free		(Free)		
7103	Precious stones and semi-precious stones					
7103.91	Rubies, sapphires and emeralds (precious stone)	Free		(Free)		
7103.99	Other (semi-precious stones)	Free		(Free)		
7113	Articles of jewellery and parts thereof, of precious metal or of metal clad with precious metal					
7113.11	1. Of Silver (Silver jewelry)	6.2%		5.2%	2.08%	Free
7113.19	2. Other					
010	Of Platinum (Platinum jewelry)	6.2%		5.2%	2.08%	Free
	Other (Gold jewelry)	6.6%		5.4%	2.16%	Free
021	—Chains for watches, spectacles or pince-nez and other ornamental chains worn on person					
029	—Other					
7117	Imitation jewellery					
	Of base metal (metallic imitation jewellery)					
7117.11	Cuff-links and studs					
010	1.Made of, or combined with metal plated with precious metal, coral, elephants' tusk or Bekko (cuff-links plated with precious metal)	6.6%		5.4%	Free	
020	2.Other (cuff-links plated with base metal )	6.4%		5.3%	Free	
7117.19	Other	5.6%		3.7%	0.74%	Free
010	1.Plated with precious metal (Other plated with precious metal)					
	2.Other (Other plated with base metal)					
7117.90	Other (other imitation jewellery)					
010	Of at least two materials (for example, wood and glass, bone and amber, mother-of-pearl and plastics), no account being taken of materials (for example, necklace strings) used only for assembly, not plated with precious metal (combined imitation jewellery)	12.5%		10%	2%	Free
	Other					
021	1.Of wood (wooden imitation jewellery)	3.2%		2.7%	Free	
022	2.Of ivory, of bone, of tortoise-shell, of antlers, of coral, of mother-of –pearl or of other animal carving material (Ivory)	4.1%		3.4%	Free	
	3.Other	5.5%		5%	Free	
023	Of plastics (plastic imitation jewellery)					
024	Plated with precious metal (imitation jewellery plated with precious metal)					
029	Other					

Note 1: Special preferential rate is applicable only for the Least Developed Countries.

Note 2: Normally the order of precedence for application of tariff rates is Preferential, WTO, Temporary, and General, in that order. However, Preferential rates are only eligible when conditions stipulated by law or regulations are met. WTO rates apply when those rates are lower than Temporary or General rates. Refer to "Customs Tariff Schedules of Japan" (by Customs and Tariff Bureau, Ministry of Finance) for a more complete interpretation of the tariff table and for more details on economic partnership agreements (EPAs) with each country.

2/ Хэрэглээний татвар / Consumption Tax /

(CIF + тарифын татвар) \* 5%



## II. АРАБЫН НЭГДСЭН ЭМИРАТ УЛС

Арабын нэгдсэн Эмират улсын эдийн засагт үнэт металл, үнэт чулуу (DPMS) борлуулагчид чухал үүрэг гүйцэтгэдэг. DPMS нь үнэт металл, чулуутай холбоотой үйлдвэрлэлээс эхлээд худалдаа хүртэл өргөн хүрээний үйл ажиллагааг хамруулдаг бөгөөд АНЭУ–ыг энэ салбарын бүс нутгийн чухал төв болгодог.

Дубайн Multi Commodities Centre нь үнэт металлын дилер, биржүүдэд үйлчилгээ үзүүлэх чиглэлээр мэргэшсэн бөгөөд ихээхэн хэмжээний гүйлгээ нь Жебел Али чөлөөт бүсээр дамждаг. Мөн Дубайн алтны захад ихээхэн хэмжээний үйл ажиллагаа явагдаж байна.

Гэсэн хэдий ч үнэт металл, үнэт чулууны салбар нь хууль бус орлогоо нуун дарагдуулах, шилжүүлэх, хөрөнгө оруулахыг эрэлхийлж буй гэмт хэрэгтнүүдэд боломж олгодог сул талтай. Бэлэн мөнгөний нэгэн адил үнэт металл, үнэт чулуу нь үнэ цэнээ хэзээ ч алдахгүй, мөрдөн мөшгөх, тодорхойлоход хэцүү бөгөөд цаг хугацааны явцад үнэ цэнээ сайн хадгалдаг. DPMS–ыг /Dealers in precious metals and stones (DPMS)/ урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авахгүй бол гэмт хэргийн орлогыг угаах, терроризмыг санхүүжүүлэх, зэвсгийн наймаа, хориг арга хэмжээ авахаас зайлсхийх болон бусад хууль бус үйл ажиллагаа эрхэлдэг хууль бус этгээдүүдийн хүчирхийлэлд өртөхөд хүргэж болзошгүй байдаг.

Үнэт металл, үнэт чулуунуудын шинж чанар нь тэдгээрийг хадгалах, шилжүүлэх, солилцох хэрэгсэл болгоход онцгой тохиромжтой болгодог.

- I. Үнэт металл, чулуу нь ерөнхийдөө авсаархан, удаан эдэлгээтэй, үнэргүй, өндөр үнэ цэнтэй байдаг.
- II. Зарим металл, үнэт чулууг (жишээ нь, алт эсвэл алмаз) солилцох эсвэл мөнгөн тэмдэгтээр солилцох арга хэрэгсэл болгон өргөнөөр хүлээн зөвшөөрдөг.
- III. Үнэт металл, чулуу нь цаг хугацааны явцад үнэ цэнээ хадгалж, дэлхий дахинд ойролцоо, ижил үнэ цэнтэй байдаг.

АНЭУ–ын ФАТФ–ын 2020 оны 4–р сард гаргасан харилцан үнэлгээний тайланд үл хөдлөх хөрөнгө болон үнэт металл, үнэт чулууны салбар хоёр нь АНЭУ–д эрсдэл, материаллаг байдлын хувьд маш чухал ач холбогдолтой гэж тодорхойлсон. Эдгээр хоёр салбарыг данс болон бусад санхүүгийн үйлчилгээгээр хангадаг тусгай зөвшөөрөл бүхий санхүүгийн байгууллагад / licensed financial institutions – LFI/ учирч буй эрсдэлийн шинж чанар, цар хүрээ нь өөр боловч тэдгээрийг LFI–үүд хүлээн зөвшөөрч, анхаарах ёстойг сануулсан байна. Үүнд:

- Хууль бус санхүүжилтийг татах сонирхлыг нэмэгдүүлдэг. Үл хөдлөх хөрөнгө болон үнэт металл, үнэт чулууны салбар нь АНЭУ–ын эдийн засгийн чухал хэсэг бөгөөд тус бүр нь АНЭУ–ын хүн ам болон дэлхийн худалдааны түншүүдэд чухал хууль ёсны бараа, үйлчилгээгээр хангадаг. Гэсэн хэдий ч эдгээр салбарууд хууль бус оролцогчдын сонирхлыг маш их хүчтэй татаж байна.
- Олон улсын хөрөнгийн урсгал, хөдөлгөөнийг дэмжих. Өөр өөр шинж чанартай хэдий ч тус хоёр салбар нь хувь хүмүүст томоохон үнэт

зүйлсийг олон улсын хилээр нэвтрүүлэх боломжийг олгодог бөгөөд заримдаа албан ёсны санхүүгийн системийн оролцоо бага шаардаж байдаг. Жишээлбэл, маш үнэ цэнтэй алмаз ачсан шуудан зөөгч олон улсын богино нислэгээр л сая сая AED-ийг зөөж чадна. Нэмж дурдахад үл хөдлөх хөрөнгө болон үнэт металл, үнэт чулууны салбар нь хувь хүмүүст албан ёсны санхүүгийн системд данс хөтлөх шаардлагагүйгээр үнэ цэнийг нь цаг хугацааны явцад (алт, үл хөдлөх хөрөнгө гэх мэт) хадгалж үлдэх боломжийг олгодог. Эдгээр нь олон хууль ёсны бизнесүүдэд ч ашигтай, хууль бус этгээдүүдэд ч эрэлт ихтэй байдаг.

- Төрөл бүрийн зохицуулалтын горимууд.

Эдгээр салбарын зохицуулалтын цар хүрээ, мөн чанар нь харилцан адилгүй байдаг. Зарим улс орнуудад үнэт металл, чулууны дилерүүд (DPMS) болон үл хөдлөх хөрөнгийн агент, брокер зэрэг оролцогчид тусгай зөвшөөрөлтэй эсвэл бүртгэлтэй байх ёстой бөгөөд LFI-дэд ноогдуулдагтай ижил төстэй AML/CFT шаардлагыг дагаж мөрдөх шаардлага тавьдаг. Үүнд хамгийн багадаа үйлчлүүлэгчдийг танин мэдэх, CDD /Customer Due Diligence/ хийх, сэжигтэй гүйлгээг мэдээлэх шаардлага багтана.

Сонирхуулахад, АНЭУ нь хуулиараа гадаадын хөрөнгө оруулагч нарт ҮХХ худалдан авахад хөрөнгө оруулагчийн виз олгож зах зээлээ дэмжих бодлого баримталдаг байна. Гаднын хөрөнгө оруулагч АНЭУ-д үл хөдлөх хөрөнгө худалдан авч, өмчлөгч болбол АНЭУ-д хязгаарлагдмал оршин суух эрх бүхий виз олгох бөгөөд ҮХХ-ийн үнэ цэн их байх тусам визний хугацаа урт байх зохицуулалтыг Засгийн газрын 2018 оны 56 дугаар тогтоолоор Арабын нэгдсэн Эмират

улсын холбооны засгийн газраас тогтоож, бүх Эмират улсад хүчин төгөлдөр үйлчилж байна.

Үүнд:

- 1/ Доод тал нь 1 сая AED-ийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгө эзэмших нь зургаан сарын олон удаагийн визтэй болох эрх дагалддаг. Тогтвортой оршин суувал, гурван жилийн хугацаатай оршин суух виз олгоно.
- 2/ Доод тал нь 5 сая AED-ийн үнэтэй үл хөдлөх хөрөнгө худалдаж авбал гурван жилийн эрхтэй визтэй болох бөгөөд энэ хугацаандаа тогтвортой оршин суувал таван жилийн оршин суух виз болгож сунгадаг.
- 3/ Ипотекийн болон бусад зээлийн санхүүжилтгүйгээр дор хаяж 10 сая еврогийн үнэтэй үл хөдлөх хөрөнгө худалдаж аваад гурван жилийн турш амьдарвал, тухайн иргэн арван жил оршин суух виз авах эрхтэй болдог байна.

АНЭУ-ын үнэт чулуу, үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлийн худалдаанд хяналт тавих хуульд дараах сонирхолтой зохицуулалтуудыг оруулсан байдаг. Үүнд:

1/ Бүрмэл эдлэл нь өөрөө хийсэн эдлэлийн шинж тэмдгийг агуулсан байх ёстой. Хэрэв боловсруулсан эдлэлийн жингийн талаас илүү хувийг үнэт металлаар, үлдсэн хэсэг нь нэг буюу түүнээс дээш үнэт металлаар хийгдсэн бол боловсруулагдсан эдлэл нь илүү хүнд буюу илүү орц найрлагад орсон үнэт металлын тэмдэглэлтэй байх ёстой.

2/ Үнэт чулууг дангаар нь худалдах, худалдахаар санал болгох, зарах зорилгоор олж авахыг хориглодог.



3/ Ажилласан бүтээгдэхүүний жинг нэмэгдүүлэхийн тулд гагнуурын материалыг ашиглаж болохгүй. The Emirates Standardisation and Metrology Authority буюу АНЭУ–ын Стандартчилал хэмжил зүйн газрын дарга боловсруулсан эдлэлд ашиглагдаж байгаа гагнуурын материалын хууль ёсны нарийн ширхэгтэй байдал, тэдгээрийн нийт масстай харьцуулсан харьцааг тогтоох шийдвэрийг эрх бүхий байгууллагатай тохиролцон гаргана.

4/ Холбогдох байгууллагад бүртгэлжүүлээгүй, итгэмжлэлгүй үнэт металл, үнэт чулууг ялган таних, гэрчилгээ олгох үйл ажиллагаа явуулж болохгүй. Тус улсын үнэт металл, үнэт чулууг таних тэмдэг, баталгаажуулагч байгууллагаас магадлан итгэмжлэх, бүртгүүлэхэд шаардагдах нөхцөлийг хэрэгжүүлэх тухайлсан журмыг тусад нь баталж мөрдүүлдэг.

5/ Тус хуулийг хэрэгжүүлэх журамд заасан нөхцөл, журмын дагуу эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авалгүйгээр боловсруулсан эдлэл, үнэт чулууны үзэсгэлэн гаргахыг хориглодог.

6/ Мэргэжилтэн, шинжээчдийн хороог АНЭУ–ын Стандартчилал хэмжил зүйн газрын даргын саналыг үндэслэн эрх бүхий байгууллагатай зөвшилцөн Засгийн газрын шийдвэрээр байгуулж, “Үнэт чулуу, үнэт металл, тэдгээрийн тэмдэгтийн худалдааг зохицуулах хороо”–г бүрдүүлнэ. Хороо нь өөрийн өмнө тавьсан асуудлаар санал өгөх эрх олгохгүйгээр зөвшилцөх шаардлагатай гэж үзсэн аливаа мэргэжилтэн, мэргэжилтэнд хандаж болно.

7/ Хороо нь дараах бүрэн эрхийг хангана.

Энэ хуулийн болон түүнийг хэрэгжүүлэх журам, шийдвэрийн заалтыг зөрчсөн тухай эрх бүхий байгууллага, эсхүл эрх бүхий байгууллагаас ирүүлсэн тайланг хянан шалгах.

Энэ хуульд заасан бусад шийтгэлийг харгалзахгүйгээр дор дурдсан шийтгэлийн аль нэгийг оногдуулах эрхтэй байдаг.

Зөрчил гаргасан этгээдэд анхааруулга илгээх; AED (50000) тавин мянгаас хэтрэхгүй торгууль.

Энэ хуулийн заалт, түүнийг хэрэгжүүлэх журмын хэрэгжилтийг хангахтай холбогдсон техникийн асуудлаар санал, дүгнэлт гаргах, АНЭУ–ын Стандартчилал хэмжил зүйн газрын дарга, эсхүл эрх бүхий байгууллагад санал бодлоо илэрхийлэх.

Өөрт нь шилжүүлсэн асуудлаар зөвлөмж, санал гаргаж, үе үеийн тайлангаа АНЭУ–ын Стандартчилал хэмжил зүйн газрын дарга хүргүүлж, зохих шийдвэр гаргах.

8/ Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан аливаа шийтгэл хүлээсэн этгээд шийтгэл оногдуулах тухай мэдэгдсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий шүүхэд гомдол гаргаж болно.

9/ Дараах тохиолдолд хоёр жилээс доошгүй хугацаагаар хорих эсвэл таван зуун мянган дирхам (500,000) таван зуун мянгаас доошгүй, нэг сая (1,000,000)–аас ихгүй дирхамаар торгох ял шийтгэнэ.

Боловсруулалт хийсэн эдлэл дээр хуурамч тэмдэг наах;

Хуурамч тэмдэгтэй гэдгийг мэдсээр байж үйлдвэрлэсэн эдлэлийг худалдах, худалдахаар санал болгох, худалдах зорилгоор олж авах, эсхүл худалдаа хийх;

Үнэт металл эсвэл үнэт чулууны гэрчилгээг хуурамчаар үйлдэх;

Тус байгууллагад бүртгүүлээгүй, магадлан итгэмжлэлгүйгээр үнэт металлын тэмдэглэгээ хийх, үнэт металл, үнэт чулууг баталгаажуулах;

Боловсруулалт хийсэн эдлэлд тэмдэглэгээ хийсний дараагаар тухайн зүйлийг тэмдэглэгээнд заасан нарийн чанарт үл нийцүүлэх аливаа өөрчлөлт, өөрчлөлт оруулах;

**10/** Дараах тохиолдолд нэг жилээс доошгүй, хоёр жилээс дээшгүй хугацаагаар хорих, эсвэл хоёр зуун тавин мянган (250,000)–аас доошгүй дирхамаар, таван зуун мянган (500,000)–аас дээшгүй дирхамаар торгох ял шийтгэнэ.

энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6–д заасны дагуу үнэт металлаар хийсэн эдлэлийг ялгах тэмдэггүй худалдаалах;

Баталгаажуулагчийн шошго, гэрчилгээгүй үнэт металл, үнэт чулууны худалдаа;

Баталгаажуулагч байгууллагаас бусад байгууллагаас олгосон гэрчилгээг ашиглан үнэт металл, үнэт чулууны худалдаа эрхлэх;

Албан ёсны болон гадаад тэмдэгтээс өөр тэмдэглэгдсэн бүтээлийн худалдаа эрхлэх.

**11/** Дараах зөрчлийн аль нэгийг үйлдсэн магадлан итгэмжлэгдсэн байгууллагыг нэг зуун мянган AED (100,000)–аас доошгүй, таван зуун мянган AED (500,000)–аас ихгүй дирхамаар торгох шийтгэл оногдуулна.

Худал мэдээлэл агуулсан үнэт чулуу, үнэт металлын гэрчилгээ олгох;

Бодит чулуу, металлтай тохирохгүй үнэт чулуу, үнэт металлын гэрчилгээ олгох;

Онцлох тэмдэг нь бодит ажилласан зүйлтэй тохирохгүй тэмдэгтэй ажилласан;

Дахин гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд торгуулийг хоёр дахин нэмэгдүүлж, магадлан итгэмжлэлийг хүчингүй болгоно.

**12/** Хууль зүйн сайдын шийдвэрээр АНЭУ–ын Стандартчилал хэмжил зүйн газрын даргатай зөвшилцөн, эрх бүхий байгууллагатай зөвшилцөн сонгогдсон албан хаагчид тус бүр өөрийн бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн заалтад заасан зөрчлийг тогтоох, түүнийг дүрэм, журмыг хэрэгжүүлэх эрхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтанд олгоно. Эдгээр ажилтнууд нь үнэт чулуу, үнэт металлын салбарт шаардагдах туршлага, ур чадвартай байна.

АНЭУ–д хууль тогтоомжийг дагаж мөрдөхгүй байх нь дараах үр дагаварт хүргэнэ.

Үнэт металлын сорьц, тэмдэг эсвэл үнэт чулуу, үнэт эдлэлийн гэрчилгээг хуурамчаар үйлдсэн, эсхүл хуурамч тэмдэг, гэрчилгээ бүхий үнэт эдлэл худалдсан, санал болгосон, эзэмшиж, худалдаалсан бол хоёр жилээс доошгүй хугацаагаар хорих эсвэл 500,000–1000,000 дирхамын торгуул оногдуулна.

Үнэт металл эсвэл үнэт чулуу, үнэт эдлэлийн зохицуулалтын эрх бүхий байгууллагаас зохих бус тэмдэглэгээ, гэрчилгээ авсан бол нэг жил хорих эсвэл 250,000–500,000 дирхамын торгуул төлнө.

Үнэт чулуу, металлын гэрчилгээг буруу мэдээлэлтэй олгосон эрх бүхий байгууллагад 100,000–500,000 дирхамын торгууль ногдуулна.

Үнэт металл, үнэт чулуу, алт, мөнгө, цагаан алтны үнэт эдлэлийн худалдаа, тэмдэглэгээ, баталгаажуулалтад хамаарах Холбооны №11 хуулийн аль нэг заалтыг зөрчсөн тохиолдолд 50,000–100,000 торгууль төлөхөөр тус тус зохицуулсан байна.



### III. БАГАМЫН ХАМТЫН НӨХӨРЛӨЛ / THE COMMONWEALTH OF THE BAHAMAS/

Санхүүгийн гүйлгээний тайлагналын тухай хууль болох FTRA–ийн /Financial Transactions Reporting Act, 2018/ 33(2) хэсгийн заалтыг дагаж мөрдөөгүй үнэт металл, үнэт чулууны дилерүүд гэмт хэрэг үйлдэж, FIR / Financial

Intelligence (Transactions Reporting) Regulations/ тайлагнаж, мэдээлэл хүргүүлээгүй өдөр тутамд таван мянган долларын (5,000 доллар) торгууль ногдуулдаг байна.

#### Хүснэгт 4.2018 оны байдлаар санхүүгийн гүйлгээний тайлагналтай холбоотойгоор захиргааны мөнгөн торгууль ноогдуулах зөрчлүүд

№	Зөрчлийн төрөл	Section	Зөрчлийн түвшин	Санхүүгийн байгууллагад ногдуулах торгуулийн хэмжээ	Хувь хүний торгуулийн хэмжээ
1	Хяналтын эрх бүхий этгээдийн хүсэлт дагуу эрсдэлийн үнэлгээ хийж, баримтжуулж, шинэчилж өгөхгүй байх.	5	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
2	Үйлчлүүлэгч/client–ийг олж тогтоогоогүй эсвэл үйлчлүүлэгч/client болон эцсийн өмчлөгчөөс үйлчлүүлэгчид зохих шалгалт явуулахад тавигдах бусад шаардлагыг хангуулж, шаардлагатай мэдээллийг аваагүй байх.	6—10	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
3	Нэргүй данс эсвэл зохиомол нэрээр данс үүсгэх, хөтлөх.	6 /4/	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
4	Доорх 5–9, 14–р хэсгийн шаардлагыг биелүүлээгүй, данс нээлгэсэн эсвэл бизнесийн харилцаа үүсгэсэн; гүйлгээ хийдэг харилцагчийг бүртгээгүй эсвэл харилцааг албан ёсоор дуусгасан байж бизнесийн бүртгэлийн харилцааг дуусгавар болгож чадаагүй.	11	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
5	Үйлчлүүлэгч/client, ашиг хүртэгч өмчлөгчтэй холбоотой хэрэглэгчийн зохих шалгалтын сайжруулсан үүргийг хэрэгжүүлээгүй.	13	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
6	Үйлчлүүлэгч/client эсвэл эцсийн эзэмшигч нь улс төрийн нөлөөнд автсан хүн мөн эсэхийг тодорхойлох эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлээгүй.	14	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл

7	Үйлчлүүлэгч/client-тэй холбоотой бүртгэл хөтлөөгүй эсвэл хуульд заасан хугацаанд ийм бүртгэлийг гаргаж өгөхгүй байх.	15	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
8	Бүртгэлийг шаардлагатай хэлбэрээр хөтлөөгүй.	16	Бага	\$50,000 хүртэл	\$20,000 хүртэл
9	Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сүүлийн гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш 5 жилийн хугацаа өнгөрсний дараа бүртгэлийг устгаагүй.	17	Ноцтой	\$125,000 хүртэл	\$35,000 хүртэл
10	Тодорхойлсон эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх журмыг боловсруулж хэрэгжүүлээгүй.	19	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
11	Дагаж мөрдүүлэх албан тушаалтныг томилоогүй /compliance officer/.	20	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
12	Дотоод алба нэгжүүдийн дотоод хяналтыг хэрэгжүүлэхгүй байх.	21	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
13	Гадаадын охин компани, салбар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх эсвэл зохих нэмэлт арга хэмжээ авахгүй байх.	23	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
14	Дотоод болон олон улсын хэмжээнд shell банк байгуулах, ажиллуулах, харилцахтай холбоотой хоригийг дагаж мөрдөхгүй байх.	24	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
15	Сэжигтэй гүйлгээг мэдээлэхгүй байх.	25—26	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
16	Нийцлийн комисст /Compliance commission/ бүртгүүлээгүй.	33 /1/	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
17	Оффист эсвэл бизнесийн үндсэн чиг үүргийн газарт өөрчлөлт орсон тухай Нийцлийн комисст мэдэгдээгүй.	33/3/a/	Ноцтой	\$125,000 хүртэл	\$35,000 хүртэл
18	Эцсийн өмчлөгч, захирал, түнш, нийцлийн ажилтан эсвэл мөнгө угаах гэмт хэргийн талаар мэдээлэгчийн өөрчлөлтийн талаар Нийцлийн комисст мэдэгдээгүй.	33/3/b/	Ноцтой	\$125,000 хүртэл	\$35,000 хүртэл
19	Нийцлийн комиссын шаардлагын дагуу ямар нэгэн бүртгэл, мэдээлэл, тайлбар өгөхгүй байх.	34	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл
20	Үйл ажиллагааны дүрмийг дагаж мөрдөхгүй байх.	37	Маш ноцтой	\$200,000 хүртэл	\$50,000 хүртэл

Дээрх шалгууруудын аль нэгийг хангаагүй тохиолдолд компанийг бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авч болно. Цаашилбал, мөнгө угаах гэмт хэрэг, эсхүл илэрсэн эрсдэлтэй аливаа

үйлдлийг санаатай болон мэдэлгүй үйлдсэн этгээд 2018 оны Гэмт хэргийн орлогын тухай хуулийн 15 дугаар зүйлийн дагуу хорих ялаар шийтгэгдэх ч хүртэл арга хэмжээ авдаг байна.



## IV. АНУ

Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ ("FinCEN") нь АНУ-ын USA PATRIOT ACT-ын 352-р хэсгийг хэрэгжүүлэх талаар болон үнэт металл, үнэт чулуу, үнэт эрдэнийн худалдаа эрхлэгчдийг гэмт хэргээс сэргийлэхтэй холбоотой мөнгө угаах хөтөлбөрүүдийн хүрээнд эдгээр зохицуулалтуудыг хэрэгжүүлж байна.

1/ Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөрийг бий болгохыг шаарддаг FinCEN-ийн бүх дүрэм журмын нэгэн адил үнэт эдлэл, үнэт металл, үнэт чулууны наймаа эрхэлдэг хүмүүсийг гэмт хэрэгтэн, террористуудын болзошгүй хүчирхийллээс хамгаалах, АНУ-ын санхүүгийн систем, ялангуяа үнэт металл, үнэт эдлэл, үнэт чулууны салбарын хамгаалалтыг нэмэгдүүлэх зорилгоор FinCEN энэхүү зохицуулалтыг гаргаж хэрэгжүүлж байна. Үнэт эдлэл, үнэт металл, үнэт чулууг үнэ цэнтэй болгодог шинж чанарууд нь мөнгө угаахыг эрэлхийлж буй хүмүүст өртөмтгий болгодог.

Энэхүү зохицуулалт нь эдгээр бизнест Банкны нууцын тухай хуулийг зохих ёсоор хэрэгжүүлэх үндсэн алхам юм.

АНУ-ын USA PATRIOT ACT-ийг Конгресс баталж, Ерөнхийлөгч гарын үсэг зурж, Банкны нууцын тухай хуулийн хүрээнд санхүүгийн байгууллага гэж тодорхойлсон бүх этгээдүүд AML/Мөнгө угаах хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг шаарддаг.

Үнэт эдлэл, үнэт металл, үнэт чулууны дилерийг Банкны нууцын тухай хуулийн дагуу "санхүүгийн байгууллага" гэж тодорхойлдог бөгөөд энэхүү зохицуулалт нь АНУ-ын USA PATRIOT ACT-д тусгагдсан тэрхүү үүргийг биелүүлэх шаардлагатай болдог.

2/ "Бүрмэл бараа-covered good" гэдэгт үнэт эдлэл, үнэт металл, үнэт чулуу бүхий бүтээгдэхүүний үнэ цэнийх нь 50 ба түүнээс дээш хувийг эдгээр материал бүрдүүлдэг бэлэн бүтээгдэхүүнийг (үнэт эдлэл, нумизматик, эртний эдлэл гэх мэт) хэлдэг.

FinCEN нь " худалдаачин"<sup>2</sup> гэсэн нэр томъёог covered good барааг худалдан авч, борлуулдаг хүн гэсэн нийтлэг ойлголтоор тодорхойлсон байдаг.

Нэмж дурдахад, FinCEN нь дилерийн тодорхойлолтод арилжааны босгыг оруулсан болно. Тухайн дилер гэх хүн жилийн хугацаанд дор хаяж 50,000 ам.долларын бүрмэл эдлэл худалдан авч, хамгийн багадаа 50,000 ам.долларын өртөгтэй бараа борлуулсан байх ёстойг шаарддаг. Доод босго тогтоосон нь жижиг бизнес эрхлэгчид, хааяа нэг "дилерүүд" болон хобби, хүсэл сонирхлын зорилгоороо ийм төрлийн бараа худалдаа эрхэлдэг "retailer" хүмүүсийг зөвхөн эдгээр барааг их хэмжээгээр худалдаж авах, худалдах бизнес эрхэлдэг хүмүүсээс ялгаж, зааглаж, энэ дүрэм үйлчлэхийг баталгаажуулах зорилготой юм.

Ач холбогдол нь, дүрмийн дагуу "барааны дилер" болон "жижиглэн худалдаачин retailer" хоёрыг ялгаж, салгадаг. FinCEN нь жижиглэн худалдаалагч "retailer" гэдэг нэр томъёогоор АНУ-д эзэмшилтэй бүрмэл эдлэлийг<sup>3</sup>, ялангуяа олон нийтэд борлуулдаг хүн гэж тодорхойлсон. FinCEN-ийн үзэж байгаагаар жижиглэнгийн худалдаачид дилерүүдтэй адил хэмжээний

<sup>2</sup> Dealers

<sup>3</sup> Covered good.

мөнгө угаах эрсдэл үүсгэдэггүй. Тиймээс ихэнх жижиглэнгийн худалдаачид мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагагүй болдог.

Жижиглэн худалдаачид ерөнхийдөө АНУ-ын дилерүүд болон бусад жижиглэн худалдаачдаас covered бараагаа худалдаж авдаг бол жижиглэнгийн худалдаачид мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагагүй болдог.

Түр зохицуулалтын дагуу АНУ-д байрладаг дилер эсвэл жижиглэнгийн худалдаачдаас бусад хүмүүсээс 50,000 ам.доллар хүртэлх covered бараа худалдаж авсан жижиглэн худалдаачдыг жижиглэнгийн худалдаачнаас чөлөөлнө. Гэсэн хэдий ч, өмнөх татвар эсвэл хуанлийн жилийн хугацаанд жижиглэн худалдаачин АНУ-ын дилер эсвэл жижиглэн худалдаачдаас бусад хүмүүсээс (АНУ-ын бус дилерүүд болон олон нийтийн гишүүд гэх мэт) 50,000 ам.доллараас дээш баталгаат барааг худалдан авч, 50,000 ам.доллараас дээш covered барааг худалдсан бол жижиглэн худалдаалагчийг "дилер" гэж үзэх үндэслэл болох бөгөөд мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх ёстой болдог.

Эцэст нь, муж улс бүрийн болон хотуудын хуулийн дагуу ломбардын үйл ажиллагааны лицензтэй буюу бүртгэлтэй бизнесүүд нь түр журмын дагуу "дилер" гэсэн тодорхойлолтоос тусгайлан чөлөөлөгддөг. Иймд ломбардууд зохих зөвшөөрөлтэй, эсвэл зохих улсын болон орон нутгийн засаг захиргаанд бүртгүүлж, ломбардын гүйлгээ хийж байгаа тохиолдолд энэ дүрмийн дагуу мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагагүй болдог байна. Түр журмын зохицуулалтад "бүрмэл эдлэл"-ийн "дилерүүдэд" л хамаарна

3/ AML/Мөнгө угаах хөтөлбөр хэрэгжүүлэх этгээд нь нийцлийн ажилтан /compliance officer/ заавал ажиллуулах бөгөөд дийлерийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцаж, мөнгө угаах хөтөлбөрийн хэрэгжилтийг өдөр тутам хариуцан ажиллах тул хангалттай эрх мэдэл өгөх ёстой.

Бүх тохиолдолд compliance officer нь бизнесийн үйл ажиллагаа болон мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөрийг бүх талаар, түүнчлэн Банкны нууцын тухай хууль болон холбогдох FinCEN журмын шаардлагуудыг сайтар мэддэг байх хэрэгтэй.

4/ АНУ-ын муж улс бүр тусдаа өөрийн гэсэн онцлог зохицуулалттай. Тухайлбал Minnesota мужид үнэт металлын дилерийн лиценз нь зөвхөн тусгай зөвшөөрөлд заасан байршилд л үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг. Дилерүүд нь ломбард, үнэт эдлэлийн дэлгүүр байж болдог. "Үнэт металл" гэдэгт алт, мөнгө, цагаан алтыг оролцуулан хэлэх бөгөөд үнэт эдлэл гэдэгт үнэт металл агуулсан эд зүйлсийг бүхэлд нь буюу цул байдлаар эсвэл хэсэгчлэн, хольцтой хийсэн байж болох бөгөөд нийт найрлагын нэгээс дээш хувьд агуулагдсан байхыг шаарддаг.

Лицензийн хүсэлтийг дараах материалуудтай хамт бөглөж нотариатаар баталгаажуулж, гарын үсэг зурж баталгаажуулан шуудангаар илгээж болно.

- *Үнэт металлын худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл*
- *Маягт SP: C1 – Тусгай зөвшөөрөл хүсэгчийн мэдээлэл*
- *Миннесотогийн ажилчдын Compensation хуульд нийцэж буйг баталгаажуулах*



Тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд хүчинтэй байна.

Хураамж шимтгэл:

Шинээр зөвшөөрөл авах болон лицензийн хугацаагаа сунгахад хураамж нь 200 ам.доллар.

Лицензийн сунгалтын хүсэлтийг хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө ирүүлэх ёстой.

Бусад шаардлага:

Үнэт металлын дилер бүр үнэт металл агуулсан хуучин эд өлгийн зүйл худалдан авах бүртээ анхны гүйлгээ хийсэн цагаас хойш 14-с доошгүй хоногийн дотор зөвшөөрөл олгосон дилерийн байршил, эсвэл лиценз олгосон муж дах бусад байршилд байлгах шаардлагатай байдаг.

Худалдах үед барааг өөрчлөх ёсгүй бөгөөд шаардлагатай 14 хоногийн хугацаанд өөрчлөхгүй байх ёстой.

Хадгалах газар нь лиценз олгосон мужаас гарахгүй байх ёстой.

Хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олон мужид лицензтэй бөгөөд нэгээс олон мужид хуучин үнэт металл худалдаж авдаг бол муж тус бүрд эд зүйлсийг хадгалах газар хэрэгтэй болно.

Харин Виржиниа мужид бол Fairfax County-ийн хуулийн 33-р бүлэгт олон нийтээс үнэт металл эсвэл эрдэнийн чулуу (Precious metal and gem – PMG) худалдаж авах дилерүүд зөвшөөрөл авахыг шаарддаг. PMG дилерийн зөвшөөрлийг Зохицуулалт, лицензийн хэлтсээс /branch/ олгодог байна.

PMG dealer нь бизнес эрхэлдэг аливаа хувь хүн, пүүс, нөхөрлөл, корпорац байж болдог. Үүнд: 1/ хуучин үнэт металл эсвэл эрдэнийн чулуу худалдах авах, 2/ тухайн хүн, пүүс, нөхөрлөл,

корпорацын эзэмшиж байгаагүй бөгөөд бусад этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс үнэт металл, эрдэнийн чулууг ямар нэгэн байдлаар ялгаж, салгаж авах, эсвэл 3/ үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үнэт эдлэлээс салгаж, гаргаж авсан үнэт металл, эсвэл чулууг худалдаж авах, олж авах худалдах үйл ажиллагаа багтдаг. Энэхүү үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүсийг хамруулдаггүй байна.

1/ Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн эзэмшиж буй хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс үнэт металл эсвэл эрдэнийн чулуу худалдаж авах үйл ажиллагаа,

2/ Жижиглэнгийн худалдаачны өмнө нь худалдсан барааг худалдаанд гаргаж байгаа этгээдэд хүлээн авах,

3/ Жижиглэн худалдаалагчийн үнэт эдлэлийг засварлах, сэргээх, загвар зохион бүтээх, хэрэв ийм үйл ажиллагаа нь түүний ердийн бизнесийн хүрээнд байвал,

4/ Жижиглэнгийн худалдаачид, бөөний худалдаачид, дилерүүдээс шууд худалдан авалт хийдэг аж үйлдвэрийн боловсруулагч, үйлдвэрлэгчид

5/ Дагалдах бүтээгдэхүүн буюу заримдаа үнэт металл агуулсан болзошгүй хаягдал металлыг худалдан авах, боловсруулах бизнесийг тогтмол эрхэлдэг хүмүүсийн үйл ажиллагаа,

6/ Жижиглэнгийн худалдаагаар бусад дилер, үйлдвэрлэгч эсвэл бөөний худалдаачдаас үнэт металл эсвэл эрдэнийн чулууг шууд худалдан авах, эсвэл журмын дагуу бөөний худалдаа эрхэлж буй борлуулагч нар багтана.

Үнэт металл, эрдэнийн чулуу борлуулагчийн зөвшөөрөл авахын тулд Зохицуулалт, лицензийн хэлтэст дараах материалыг бүрдүүлж өгнө.

1/ Хувийн мэдээллийн тухай өргөдөл, маягтад гарын үсэг зурж, нотариатаар баталгаажуулсан. Өргөдөл гаргах бол энэ төрлийн үйл ажиллагаанд нотариат үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг байна.

2/ Хүчинтэй, шаардлага хангасан зураг.

3/ Сүүлийн 12 сарын хугацаанд Виржиниа мужаас гадуур амьдарч байсан өргөдөл гаргагч бол оршин суугаа мужаасаа (Виржиниа мужаас бусад муж бол Виржиниа мужийн цагдаагаар дамжуулан авах боломжтой) оршин суусан тодорхойлолт авч хавсаргаж өгөх ёстой.

4/ Fairfax County-гийн Татварын албанаас авсан бизнес эрхлэх болон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх лицензийн хуулбарыг хавсаргах /Business, Professional and Occupational License (BPOL)/

5/ Фэйрфакс мужийн Төлөвлөлт, хөгжлийн хэлтсээс олгосон оршин суугч бусаар тусгай зөвшөөрөл ашиглах зөвшөөрлийн хуулбар /non-residential use permit (non-RUP)/

6/ Виржиниа муж улсын захиргаа Fairfax County-д төлөх дэнчингийн баталгааны /surety bond/ 10,000 доллар төлөх байршуулах ёстой.

7/ Виржиниа мужийн худалдааны үйлчилгээний тайланд туссан талаарх мэдээллийг хавсаргаж өгөх. Жич: Виржиниа мужийн Бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн стандартын газраас баталгаажуулсан томоохон компаниудын жагсаалтыг Зохицуулалт, лицензийн хэлтсээс авах боломжтой.

8/ Лицензийн хураамж 215.00 ам.долларын төлбөрийг Фэйрфакс мужид төлөх ёстой бөгөөд зээлийн картаар /Credit card/ төлсөн бол хүлээн авдаггүй байна.

Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хянан баталгаажуулахад 14–21 хоног зарцуулдаг байна.

Жич: Нэгэнт тусгай зөвшөөрлөө авсан бол дилерүүд Фэйрфакс мужийн хуулийн 33–р бүлэгт зохицуулж, тайлбарласны дагуу /Chapter 33 of the Fairfax County Code/ Цагдаагийн байгууллагын тодорхойлсон тайлагнах, хадгалах шаардлагыг хангасан байх ёстой болдог.

### **Түр зуурын / Transient PMG Dealer / PMG<sup>4</sup> дилерт тавигдах шаардлага**

Фэйрфакс мужийн захиргаан дор өдөр бүр бизнес эрхэлдэггүй түр оршин суугч үнэт металл, үнэт чулууны арилжааны лиценз эзэмшигчид, эсвэл байнгын үйл ажиллагаа явуулж буй газраасаа өөр газар тухайлсан худалдан авалт хийх сонирхолтой оршин суух зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд бизнесийн үйл ажиллагааны хувьд дараах мэдээллийг гаргаж өгөх ёстой.

Байнга оршин суудаггүй түр зуурын аль нэг байршилд худалдан авалт хийхээс ажлын 10 хоногийн өмнө тусгай зөвшөөрөл эзэмшигч нь худалдан авах арга хэмжээнийхээ өдөр, цаг, байршил хаягийн талаарх мэдээллийг Зохицуулалт, лицензийн хэлтэст болон Фэйрфакс мужийн Цагдаагийн газарт урьдчилан бичгээр мэдэгдэх ёстой. Фэйрфакс мужийн нутаг дэвсгэр, захиргаанд явагдсан худалдан авалтын арга хэмжээ бүрд мэдэгдэх ёстой гэсэн үг юм. Ийм мэдэгдлийг биечлэн эсвэл факс, цахим шуудан эсвэл АНУ–ын харьяаллын шуудангаар илгээх ёстой.

Худалдааны үйл ажиллагааг тогтсон байршилд зохион байгуулж, олон нийтэд нээлттэй байлгах ёстой.

<sup>4</sup> Precious metal and gemstone dealer



Фэйрфакс мужийн зүгээс PMG буюу Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн талаар худалдан авах үйл

ажиллагаа бүрд олон нийтэд дэлгэн харуулж байх үүрэгтэй.

## V. ӨМНӨД АФРИКИЙН БҮГД НАЙРАМДАХ УЛС

### –Үнэт металлын тусгай зөвшөөрөл:

Зохицуулагч нь үнэт металл баяжуулах тусгай зөвшөөрлийг аливаа этгээдэд тогтоосон доорх 3 хэлбэрээр, 10 жилээс илүүгүй хугацаагаар олгодог байна.

1. Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан үнэт металлыг худалдах, арилжаалах, захиран зарцуулах эрх бүхий этгээдээс аливаа хэлбэрээр боловсруулаагүй буюу хагас боловсруулсан үнэт металлыг худалдан авах, хүлээн авах;
2. Өөрийн хууль ёсны эзэмшилд байгаа аливаа боловсруулаагүй болон хагас боловсруулсан үнэт металлыг бүрдүүлэх, хэлбэрийг нь өөрчлөх, өөр хэлбэрээр үнэ цэнийг нь нэмэгдүүлэх;
3. Өөрийн хууль ёсны эзэмшилд байгаа аливаа боловсруулаагүй буюу хагас боловсруулсан үнэт металлыг захиран зарцуулах.

### –Үнэт эдлэлийн тусгай зөвшөөрөл:

Зохицуулагч нь аливаа этгээдэд доорх тогтоосон хэлбэрээр, таван жилээс илүүгүй хугацаагаар үнэт эдлэлийн зөвшөөрөл эзэмшигчид тусгай зөвшөөрөлд заасны дагуу дараах үйл ажиллагаа явуулах эрхийг олгож болно.

1. Хуулийн дагуу хагас боловсруулсан үнэт металл худалдах, худалдаалах, захиран зарцуулах эрх бүхий этгээдээс хагас боловсруулсан үнэт металлыг аливаа хэлбэрээр худалдан авах, хүлээн авах;
2. Өөрийн хууль ёсны эзэмшилд байгаа хагас боловсруулсан үнэт металлын хэлбэрийг өөрчлөх, эсхүл өөр хэлбэрээр нэмүү өртөг шингээх;
3. Өөрийн эзэмшилд байгаа аливаа хагас боловсруулсан үнэт металлыг захиран зарцуулах

## VI. ХОНКОНГ

Хонконгод үнэт металл, үнэт чулууны наймаа эрхэлж, 120,001 Хонконг доллар ба түүнээс дээш үнийн дүнтэй аливаа гүйлгээ хийх хүсэлтэй хүн Гаалийн татварын албанд бүртгүүлэх шаардлагатай.

Хонконгийн бус үнэт металл, чулууны дилер гэдэг нь Хонконгод үнэт металл, үнэт чулууны наймаа эрхэлдэг хүн юм. Энэ нь Хонконгод байнга оршин суудаггүй хувь хүн; эсвэл Хонконгоос гадуур бүртгэлтэй буюу үүсгэн байгуулагдсан хувь хүнээс бусад хуулийн этгээд бөгөөд Компанийн тухай хуульд заасны дагуу Хонконг улсад бүртгэлтэй бус компани; мөн Хонконгод бизнес эрхлэх газаргүй этгээд бөгөөд; Хонконгод тухайн хүний үнэт металл, үнэт чулууны бизнес эрхлэх нийт өдрийн тоо 1 жилд 60 хоногоос хэтрэхгүй байхаар зохицуулагдсан.

### Бүртгэлийн горимын дагуу дараах хоёр ангилалд хуваадаг:

1/ Бизнесийн явцад нийт үнэ нь 120,000 Хонконг доллар буюу түүнээс дээш бэлэн бус гүйлгээ хийхээр төлөвлөж буй аливаа дилер нь А ангиллын бүртгүүлэгчээр бүртгүүлэх шаардлагатай.

2/ Бизнесийн явцад нийт гүйлгээ нь 120,000 Хонконг доллар ба түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн ба бэлэн бус гүйлгээ хийх хүсэлтэй аливаа дилер В ангиллын бүртгүүлэгчээр бүртгүүлэх шаардлагатай болдог. Харин В ангилалд бүртгүүлэгч дилер нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтад хамрагдах зохицуулалттай.

### Тайлагнал:

Хонконгийн бус үнэт металл, үнэт чулууны дилер нь бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргах ёстой бөгөөд үүнд дилер ба/эсвэл дилерийн нэрийн өмнөөс ажиллаж буй этгээдийн үйл ажиллагааны мэдээлэл, дэлгэрэнгүй мэдээлэл, харилцагчийн мэдээлэл, гүйлгээний дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байх ёстой. Энэ нь гүйлгээ хийснээс хойш 1 хоногийн дотор багтаж хийгдсэн хийгдсэн бүх бэлэн мөнгөний гүйлгээний талаар, эсвэл дилер буюу дилерийн нэрийн өмнөөс ажиллаж буй этгээд Хонконгийн хилээс гарсан эсэхээс үл хамааран харилцагчийн мэдээлэл болон гүйлгээний дэлгэрэнгүй мэдээллийг Гаалийн татварын албанд өгсөн байх ёстой.



## VII. СИНГАПУР УЛС

Хэрэв бүртгэлгүй, тусгай зөвшөөрөлгүйгээр зохицуулалттай дилерийн үйл ажиллагаа эрхэлбэл энэ нь гэмт хэрэгт тооцогдоно. Аливаа зохицуулалттай хэлцлийг хийхийн өмнө заавал бүртгүүлсэн байх ёстой.

Бүртгэлгүй арилжаачин, дилерүүдийг илрүүлбэл албадлагын арга хэмжээ авдаг. Бүртгүүлээгүй эсвэл тусгай зөвшөөрөлгүйгээр зохицуулалттай дилерийн үүрэг гүйцэтгэсэн аливаа этгээдийг 75,000 Сингапур долларын торгууль болон/эсвэл 3 жил хүртэл хорих ялаар шийтгэгдэг.

### Хэн хэрхэн бүртгүлдэг вэ?

Хэрэв үнэт чулуу, үнэт металл болон/эсвэл үнэт эрдэнийн бүтээгдэхүүний зохицуулалттай этгээдийн бизнес, наймаа эрхлэхээр бол эсвэл PSPM<sup>5</sup>-ийн зохицуулалттай хэлцлийн зуучлагчийн хувьд Зохицуулалттай дилерүүдийн бүртгэлийн газарт бүртгүүлэх шаардлагатай болдог.

Бүртгүүлэх шаардлагатай зохицуулалттай дилерүүдийн жишээнд үнэт эдлэл, алт мөнгөн зоосны худалдаачид, үнэт эдлэлийн бөөний болон жижиглэн худалдаачид, хуучин барааны худалдаачид, дуудлага худалдааны төвүүд / auction house/, худалдааны платформууд орно.

### Бүртгэлийн хураамж, төлбөр ба бүртгэлжүүлэлт

Зохицуулалттай дилерүүд Бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийн тулд 120 Сингапур долларын өргөдлийн хураамж төлөх ёстой. Бүх төлбөр, тооцоог “GoBusiness Licensing Portal” сайтаар дамжуулан хийх ёстой.

Бүртгэлийг жил бүр хийлгэх ёстой. Бүртгэлийн ажилтан өргөдлийг журмын дагуу зөвшөөрсний дараа бүртгэлийн шатлал болон үйл ажиллагаа явуулах салбар, цэгүүдийн тоонд үндэслэн бүртгэлийн хураамжийг дараах байдлаар төлөх ёстой.

### Хүснэгт 5. Сингапурын үнэт эдлэлийн арилжаа эрхлэгчийн ангилал

Бүртгэлийн ангилал	Бүртгэлийн болзол	Хураамж	Үргэлжлэх хугацаа
<b>A ангилал</b>	Энэ ангиллын бүртгэлд бүртгүүлсэн дилерийн борлуулах гэж буй үнэт чулуу, үнэт металл, үнэт эдлэл, хөрөнгөөр баталгаажсан token бүрийн цэвэр үнэ нь 1 ширхэг нь 2000 с.доллараас бага байх ёстой.	Жилийн хураамж нь 1 салбар бүрт 250 с.доллар тушаах ёстой.	энэ хэмжээ жил бүр шинэчлэгддэг.
<b>B ангилал</b>	Энд бүртгэгдсэн дилер нь үнэт чулуу, үнэт металл, үнэт эдлэл, ямар ч үнэ цэнийн хөрөнгөөр баталгаажсан token-ийг худалдах эрхтэй.	Жилийн хураамж нь 1 салбар болгонд 350 с.доллар байдаг.	энэ хэмжээ жил бүр шинэчлэгддэг.

*Class A\** – Энэ ангиллын бүртгэлд бүртгүүлсэн дилерийн борлуулах гэж буй үнэт чулуу, үнэт металл, үнэт бүтээгдэхүүн/үнэт эдлэл/, хөрөнгөөр баталгаажсан token бүрийн цэвэр үнэ нь нэг ширхэг нь 2000 сингапур доллароос бага байх ёстой. Жилийн хураамж нь нэг салбар бүрд 250 сингапур доллар тушаах ёстой бөгөөд энэ хэмжээ жил бүр шинэчлэгддэг.

*Class B\*\** – Энд бүртгэгдсэн дилер нь үнэт чулуу, үнэт металл, үнэт бүтээгдэхүүн/үнэт эдлэл, ямар ч үнэ цэний хөрөнгөөр баталгаажсан token-ийг худалдах эрхтэй. Жилийн хураамж нь нэг салбар болгонд 350 Сингапур доллар байдаг.

<sup>5</sup> Precious stones, precious metals and/or precious products –PSPM

Жишээгээр тайлбарлая: Зохицуулалттай этгээд болох гэж байгаа "ABC Pte Ltd" нь хоёр салбартайгаар үйл ажиллагаа явуулна гэж үзье. Тэгвэл "ABC Pte Ltd" нь В ангиллын бүртгэлийн гэрчилгээ авах хүсэлт гаргавал нийт 820 Сингапур доллар төлөх ёстой гэсэн үг юм. Үүний 120 Сингапур доллар бол өргөдлийн хураамжийн төлбөр болно.

**Хүснэгт 6. Жишээ /Сингапурт/**

Хураамж шимтгэлийн төрөл	Хураамж
Өргөдлийн хураамж	120 S\$
Б ангилалд бүртгүүлэх бүртгэлийн хураамж	350 S\$
2 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулах	*2
	<b>700 S\$</b>
Нийт төлбөр хураамж	<b>820 S\$</b>

**Зураг 5. Сингапурт үнэт эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах процесс**



Тусгай зөвшөөрөл автал бүртгүүлж, хүсэлт гаргагч нь улсын бүртгэгчийн зохимжтой этгээд гэж үзэгдэх хүртэл улсын бүртгэгч өргөдлийг хүлээн авснаас хойш 4 долоо хоног хүртэл хугацаагаар судалж үздэг.

Анхаарах зүйлс:

- Бүртгэлийн гэрчилгээ олгох аж ахуйн нэгжийн Корппас болон UEN<sup>6</sup>-тэй эсэхээ шалгах.
- Өөрийн бизнесийн талаарх мэдээллийг Нягтлан бодох бүртгэл, аж ахуйн нэгжийн

зохицуулах газар ("ACRA")-д өргөдлийн маягтаар дамжуулан цахимаар хүргүүлэх.

- Нэг аж ахуйн нэгжид зөвхөн нэг ширхэг л өргөдөл уламжлах ёстой, тухайлбал UEN бүрд нэг өргөдөл хавсаргаж өгнө гэсэн үг юм. Харин өргөдөл бүрд хэдэн ч салбар байгуулах хүсэлтийг оруулах боломжтой.
- Бүртгэлийн ажилтан бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч шийдвэр гаргах хүртэл 4 долоо хоног орчим хугацаа шаардаг дана. Нэмэлт мэдээлэл шаардлагатай бол түүнээс ч илүү урт хугацаа шаардагдаж болдог.

<sup>6</sup> Unique Entity Number – Аж ахуйн нэгжийн дахин давтагдахгүй дугаар



## Хүснэгт 7. Сингапурт үнэт эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалууд

Аж ахуйн нэгж	Ирүүлэх шаардлагатай мэдээллүүд
Захирал Түнш Менежер Компанийн нарийн бичгийн дарга Их хэмжээний хувьцаа эзэмшигч (хэрэв компанийг төлөөлж байгаа бол)	<ol style="list-style-type: none"> <li>1. Нэр</li> <li>2. NRIC/ Паспорт/ FIN дугаар</li> <li>3. Иргэншил эсвэл үүсгэн байгуулагдсан улс</li> <li>4. Төрсөн он сар өдөр (Үүсгэн байгуулагдсан) <ul style="list-style-type: none"> <li>(а) Залилан, шударга бус үйлдэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэргийн лавлагаа;</li> <li>5. Тунхаглал /Declaration/ <ul style="list-style-type: none"> <li>(б) Аливаа дампуурал, төлбөрийн чадваргүй байдал, татан буугдахтай холбоотой;</li> <li>(в) Тухайн этгээдийн оролцогч болж байсан аливаа нэхэмжлэл; болон</li> <li>(г) ML/CFT шаардлагыг зөрчсөн аливаа зөрчлийн талаарх</li> </ul> </li> </ul> </li> </ol> <p>* Мэдээллийг ACRA-д бүртгэлтэй байгууллагуудад автоматаар оруулдаг</p>
Өргөдөл хүсэлт гаргагчийн удирдлагад ижил төстэй албан тушаал хашдаг этгээд	<ol style="list-style-type: none"> <li>1. Нэр</li> <li>2. NRIC/ Паспорт/ FIN дугаар.</li> <li>3. Иргэншил эсвэл үүсгэн байгуулагдсан улс</li> <li>4. Төрсөн он сар өдөр</li> <li>5. Тунхаглал /Declaration/</li> </ol>
Outlet менежер	<ul style="list-style-type: none"> <li>(а) Залилан, шударга бус үйлдэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэргийн лавлагаа;</li> <li>(б) Аливаа дампуурал, төлбөрийн чадваргүй байдал, татан буугдахтай холбоотой;</li> <li>(в) Тухайн этгээдийн оролцогч болж байсан аливаа нэхэмжлэл; болон</li> <li>(г) ML/CFT шаардлагыг зөрчсөн аливаа зөрчлийн талаарх</li> </ul>
Дагаж мөрдүүлэх / нийцлийн ажилтан	<ol style="list-style-type: none"> <li>1. Нэр</li> <li>2. NRIC/ Паспорт/ FIN дугаар.</li> <li>3. Иргэншил эсвэл үүсгэн байгуулагдсан улс</li> <li>4. Төрсөн он сар өдөр</li> <li>5. Имэйл хаяг</li> <li>6. Гар утасны дугаар</li> </ol>
Бизнесийн дэлгэрэнгүй мэдээлэл	Ирүүлэх шаардлагатай мэдээллүүд
Хаяг          Бүтээгдэхүүн Үйл ажиллагаа	<ol style="list-style-type: none"> <li>1. Бүртгэлтэй хаяг*</li> <li>2. Үйл ажиллагааны хаяг</li> <li>3. Шуудангийн хаяг</li> <li>4. Outlet хаяг</li> <li>5. Бизнесийн утасны дугаар</li> <li>6. Бизнесийн факсын дугаар</li> <li>7. Бизнесийн цахим шуудангийн хаяг</li> </ol> <p>* Мэдээллийг ACRA-д бүртгэлтэй байгууллагуудад автоматаар оруулдаг</p> <p>Үнэт чулуу, үнэт металл, үнэт эдлэлийн төрөл Бөөний худалдаа, үйлдвэрлэл, жижиглэн худалдаа гэх мэт.</p>

### Өргөдлийн маягтад хавсаргах дагалдах бичиг баримтууд:

- Захирал, partners, менежер, компанийн нарийн бичгийн дарга, борлуулалтын менежер, томоохон хувьцаа эзэмшигчид нь гадаадын иргэн бол гадаад паспорт гэх мэт гадаад иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргаж өгнө.
- Корпорац бол хувьцаа эзэмшигчдийнхээ бүртгэлийн мэдээллийн хуулбарыг хавсаргаж өгөх ёстой. (Жишээлбэл, захирал, partners, менежерүүд, компанийн нарийн бичгийн дарга, худалдааны менежерүүд, томоохон хувьцаа

эзэмшигчдийн талаарх мэдээллийг багтаасан байх).

- Нэгээс олон түвшний хувьцаа эзэмшигчидтэй өргөдөл гаргагчийн хувьд байгууллагынхаа бүтэц зохион байгуулалтын мэдээллийг хавсаргаж өгдөг.

Бүртгэлтэй компанийн хувьцаа эзэмшигчдийн хувьд бүх хувьцаа эзэмшигчдийнхээ нэрийг оруулах шаардлагагүй буюу хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн 5 хувиас дээш хувийг эзэмшдэг хүмүүсийн жагсаалтыг гаргаж өгөхөд болно.

## VIII. МОНГОЛ УЛС

Үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн харилцааг зохицуулахтай холбоотой дараах хууль, дүрмүүд хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

### 1/ Зөрчлийн тухай хууль

7.10 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хууль зөрчих

4. Газрын хэвлийг:

4.2. ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй;

4.3. ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй;

4.4. ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж

хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

### 7.11 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хууль зөрчих

3. Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоолгох, эсхүл бүртгүүлэх журам зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

### 2/ Эрүүгийн хууль

18.16 дугаар зүйл. Барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчих

1. Бусдын барааны тэмдэг, эсхүл газар зүйн заалтыг ашиглан хэрэглэгчийг төөрөгдөлд оруулан хуурамч бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, хадгалсан, тээвэрлэсэн,



худалдсан, улсын хилээр нэвтрүүлсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.байнга тогтвортой үйлдсэн;

2.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ зүйлийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн/

**23.2 дугаар зүйл.Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах**

1.Тусгай зөвшөөрөл, эрх олгосон, үүргээс чөлөөлсөн баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт, иргэний, албаны, жолоодох эрхийн үнэмлэх, боловсролын үнэмлэх, диплом, гадаад паспорт, төрийн шагнал, хүний хувийн байдлыг тодруулсан, гэрчилсэн, эдийн, эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг тодорхойлсон баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, хуурамч болохыг мэдсээр байж ашигласан, худалдсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй

тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2.Энэ гэмт хэргийг үйлдэж бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

**18.5 дугаар зүйл.Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх**

1.Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуухориглосон бараа, эрдэнэс, эрдсийг Монгол Улсын хилээр, гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

2.Энэ гэмт хэргийг:

2.1.албан тушаалынхаа байдлыг ашиглаж;

2.2.байлдааны галт зэвсэг, галт хэрэгсэл,

цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, тэсэрч дэлбэрэх бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

4. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хоёр зуун мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар: – Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн хүнийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлсэн хүнийг ялаас чөлөөлнө. Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн барааг хяналт шалгалтын

үеэр, эсхүл мөрдөн шалгах ажиллагааны үед гаргуулан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй.

## 18.6 дугаар зүйл. Мөнгө угаах

1. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Энэ гэмт хэргийг:

2.1. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж;

2.2. байнга тогтвортой үйлдэж;

2.3. албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

3. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн



өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

*25.6 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх*

1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2.Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй, эсхүл түүх, соёлын дурсгалт зүйлийг завшсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### *3/ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль*

*4 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээд*

4.1. Дараах этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаар энэ хуулийн 16.1-д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй:

4.1.8. энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээнд оролцсон бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;

5.1.2. дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээд тохиолдлын чанартайгаар 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;

*15 дугаар зүйл. Монгол Улсын хилээр бэлэн мөнгө оруулах, гаргах*

15.4. Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн 20 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй тэнцэх хэмжээний биет үнэт металл, бэлэн гадаад валютыг Монгол Улсын хилээр гаргахыг хориглоно.

/Энэ хэсгийг 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө./

15.5. Энэ хуулийн 15.4-т заасан үнийн дүн хүртэлх хэмжээний биет үнэт металл, бэлэн гадаад валютыг гаальд мэдүүлснээр Монгол Улсын хилээр гаргаж болно.

/Энэ хэсгийг 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө./

### *4/ Ашигт малтмалын тухай хууль*

*7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглахад тавигдах ерөнхий шаардлага*

7.3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай

зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. Байгалийн өнгөт болон үнэт чулууг түүх, олборлох үйл ажиллагааг ердийн ашигт малтмалын адил тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

#### 46 дугаар зүйл. Үнэт металл, эрдэнийн чулууг бүртгэх, худалдах

46.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон бүх төрлийн үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл эрх бүхий хуулийн этгээдээр тогтоолгож, тоо хэмжээг бүртгүүлнэ.

/Энэ хэсгийг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

/Энэ хэсэгт 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

46.2. Энэ хуулийн 46.1-д заасны дагуу бүртгүүлбэл зохих үнэт металл, эрдэнийн чулууны жагсаалт, тэдгээрийн сорьц, чанарыг тогтоох, бүртгэх журмыг Засгийн газар батална.

46.3. Үнэт металл, эрдэнийн чулууг Монголбанк худалдан авч төлбөр хийхдээ олон улсын зах зээлийн үнийг баримтална.

46.4. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон үнэт металл, эрдэнийн чулууг Монголбанкаар дамжуулан экспортод гаргаж болно.

46.5. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 400 граммаас дээш жинтэй, эсхүл түүнээс хөнгөн боловч онцгой чамин дүрс хэлбэртэй байгалийн төрц алт, түүнчлэн ховор өнгө, дүрстэй эрдэнийн чулуу олборлосон бол тэдгээрийг Монголбанкны төрийн эрдэнэсийн санд урамшуулалтай үнээр худалдах үүрэгтэй.

## 5/ Эрдэнэсийн сангийн тухай хууль

### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "эрдэнэс" гэж түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл, байгалийн төрцийг;

3.1.2. "үнэт металл" гэж алт, мөнгө, платина болон түүний бүлэгт багтдаг палладий, иридий, родий, рутений, осмийг;

3.1.3. "үнэт чулуу" гэж доржпалам, бадмаараг, маргад эрдэнэ, индранил, сувдыг;

3.1.4. "Эрдэнэсийн сан" гэж төрийн нэрийн өмнөөс Монголбанк эрхэлж, бүрдүүлж, хамгаалж, эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж байгаа эрдэнэс, түүний дагалдах зүйл, хөрөнгийн хуримтлалыг;

3.1.5. "байгалийн төрц" гэж онцгой чамин дүрс хэлбэртэй, ховор өнгөтэй, байгалийн тогтцоороо олдсон үнэт металл, эрдэнийн чулууг;

3.1.6. "эрдэнийн чулуу" гэж олон улсад хэвшсэн ангилалыг харгалзан эрх бүхий байгууллагаас тодорхойлсон ангилалд хамрагдах үнэт, хагас үнэт чулууг.

### 4 дүгээр зүйл. Эрдэнэсийн сан, түүний ангилал

4.1. Эрдэнэсийн сан төрийн өмчид байна.

4.2. Эрдэнэсийн санг үндсэн болон гүйлгээ санд хуваана.

4.3. Үндсэн сан байнгын болон байнгын бус хэсгээс бүрдэнэ.



4.4. Үндсэн сангийн байнгын хэсэгт Монгол Улсын хуваагдашгүй өмч болох эрдэнэс байх бөгөөд тэдгээрийг худалдах, шилжүүлэх, захиран зарцуулахыг хориглоно.

4.5. Үндсэн сангийн байнгын бус хэсэгт олон улсын жишгээр цэвэршүүлсэн үнэт металл, засаж өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх, соёлын үнэт дурсгалт зүйл, үнэт болон бусад металлаар хийж нөөцөд авсан зоос байна.

4.6. Үндсэн сангийн байнгын хэсэгт байх түүх, соёлын дурсгалт зүйл нь хосгүй үнэт зэрэглэлтэй байна.

4.7. Гүйлгээ санд энэ хуулийн 4.4, 4.5-д зааснаас бусад үйлдвэрлэл, судалгаа, дурсгалын зориулалтаар гүйлгээнд оруулах эрдэнэс хамаарна.

#### 4 дүгээр зүйл. Эрдэнэсийн сан, түүний ангилал

4.1. Эрдэнэсийн сан төрийн өмчид байна.

4.2. Эрдэнэсийн санг үндсэн болон гүйлгээ санд хуваана.

4.3. Үндсэн сан байнгын болон байнгын бус хэсгээс бүрдэнэ.

4.4. Үндсэн сангийн байнгын хэсэгт Монгол Улсын хуваагдашгүй өмч болох эрдэнэс байх бөгөөд тэдгээрийг худалдах, шилжүүлэх, захиран зарцуулахыг хориглоно.

4.5. Үндсэн сангийн байнгын бус хэсэгт олон улсын жишгээр цэвэршүүлсэн үнэт металл, засаж өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх, соёлын үнэт дурсгалт зүйл, үнэт болон бусад металлаар хийж нөөцөд авсан зоос байна.

4.6. Үндсэн сангийн байнгын хэсэгт байх түүх, соёлын дурсгалт зүйл нь хосгүй үнэт зэрэглэлтэй байна.

4.7. Гүйлгээ санд энэ хуулийн 4.4, 4.5-д зааснаас бусад үйлдвэрлэл, судалгаа, дурсгалын зориулалтаар гүйлгээнд оруулах эрдэнэс хамаарна.

#### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭД, БУСАД БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

#### 15 дугаар зүйл. Хүн, хуулийн этгээд, бусад байгууллагын эрх, үүрэг

15.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт эрдэнэс эзэмшигч хүн, хуулийн этгээд, бусад байгууллага нь эрдэнэсийн санд худалдах эрдэнэс, тэдгээрээр хийсэн эдлэлийг сорьц тогтоох эрх бүхий хуулийн этгээд, эсхүл сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар сорьц тогтоолгон баталгаажуулсан байх үүрэгтэй.

15.2. Хүн, хуулийн этгээд, бусад байгууллага нь эрдэнэсийн санд худалдах болон хадгалуулах эрдэнэсийн үнийг хэлэлцэн тохирох, нэхэмжлэн авах эрхтэй.

15.3. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монголбанкны хүсэлтийн дагуу түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийн бүртгэл, мэдээллийг гаргаж өгнө.

#### 6/ Монгол Улсын сорьцын хяналтын дүрэм

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 281 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

#### 7/ Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх журам

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 281 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

#### 8/ Хэмжил зүйн тухай хууль

## САНАЛ, ДҮГНЭЛТ

Үнэт металл, үнэт чулуу болон үнэт эдлэлийн урлал, үйлдвэрлэл, худалдаа өндөр түвшинд хүрсэн Япон, АНЭУ, Багамын хамтын нөхөрлөл, АНУ, ӨАБНУ, Хонконг, Сингапур зэрэг улс орнуудын тус зах зээлийн зохицуулалт, тусгай зөвшөөрөл олгох асуудлаарх эрх зүйн орчны зохицуулалт туршлагыг харьцуулан судаллаа.

Манай улсын хувьд энэ чиглэлээр тусдаа биеэ даасан хууль эрх зүйн орчныг хараахан хөгжүүлээгүй байгаа тул бусад улсын туршлагаас суралцаж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Дээрх улс, орнуудын туршлагаас харахад зохицуулалттай этгээдүүдийг үйл ажиллагаа явуулах цар хүрээ, төрлөөс нь хамааруулаад тусгай зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх материал, тавигдах шаардлага болон өргөдлийн хураамж шимтгэл нь хүртэл харилцан адилгүй, ялгаатай байна.

Мөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотойгоор тус зах зээл дээр явагдах үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох, мэдээлэл солилцох урсгалыг сайжруулах, тавигдах хяналтыг өндөр түвшинд, маш нарийвчилсан болгох чиглэлд илүү их хүчин чармайлт, зүтгэл гаргаж нэлээдгүй туршлага хуримтлуулжээ.

Тиймээс манай улсын нөхцөлд тус зах зээл дээрх үйл ажиллагаатай холбоотой мэргэжлийн нэр томъёог нэгдсэн ойлголтод оруулж хэрэглэхээс эхлээд, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, стандартын шаардлага, тохирлын гэрчилгээ, стандарт хэмжил зүй, гадаад худалдаанд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүний чанар, татвар, хаяг, шошгожилт зэрэг асуудлыг дотоод орчинтой уялдуулах, нийцүүлэх шаардлагатай болох бөгөөд мөн тус салбарын үйл ажиллагааг нээлттэй ил тод бөгөөд бүрэн хяналттай байлгахын тулд хариуцлагажуулах зохицуулалтыг мөнгө угаах, болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон зөрчил, эрүүгийн хуулиудад холбогдох зохицуулалтуудыг нэмж оруулах шаардлагатай байгааг тодорхой жишээгээр баримтжууллаа.



## ЭХ СУРВАЛЖ

1. <https://www.scribd.com/>
2. <https://lexmena.com/>
3. <https://www.bahamas.gov.bs/>
4. <https://www.fincen.gov/>
5. <https://www.dmr.gov.za/>
6. <https://www.customs.gov.hk/>
7. <https://www.centralbank.ae/>
8. <https://www.ramseycounty.us/>
9. <https://www.fairfaxcounty.gov/>
10. <https://www.gobusiness.gov.sg/>
11. <https://acd.mlaw.gov.sg/>
12. <https://www.loudoun.gov/>



# 9

## ИНСУРТЕКИЙН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Гүйцэтгэсэн: Б.Тэргэл<sup>15</sup>

<sup>15</sup> СЗХ, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт email: tergel@irc.mn

## ХУРААНГУЙ

Хурдтай өөрчлөгдөж буй орчинд даатгалын салбар нь эрчим хүчний шилжилт, эргэлтийн эдийн засаг, нэмэгдэж буй хотжилт, дижиталчлал зэрэг урьд өмнө байгаагүй өөрчлөлтүүдийг даван туулах үетэй нүүр тулсан. Маш удаан хугацаанд эдгээр хэв маяг нь бидний хэрхэн ажиллаж, амьдрахад нөлөөлөх билээ. Ковид-19 цар тахал, инфляц, дайн, улс төрийн орчин зэрэг гаднын хүчин зүйлс зах зээлд ихээхэн нөлөөлсөн. Сүүлийн жилүүдэд даатгалын салбар нь их төвөгтэй, олон янз болсон. Даатгалын технологи (инсуртек) олон жилийн өмнөөс бий болсон ч сүүлийн жилүүдэд хэрэгцээ нь огцом өссөн. Өнөөгийн эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлаас үл хамааран 2020 оноос хойш инсуртек нь зах зээлийг өөдрөг үзлээр хөдөлгөж, гэрээний тоо, санхүүжилтийн хэмжээ мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд уламжлалт даатгалын компаниуд дижитал бизнесийн загварт шилжихийн чухлыг ойлгож эхэлж байна. Энэхүү судалгааны ажлыг инсуртекийн бүтээгдэхүүнүүд болон олон улсын сайн туршлагауд болон Монгол Улсад нэвтрүүлэх боломжтой орчныг бүрдүүлэх зорилгоор хийж гүйцэтгэн холбогдох санал, дүгнэлтийг боловсрууллаа.

**Түлхүүр үгс:** Инсуртекийн бүтээгдэхүүнүүд, даатгалын цахим үйлчилгээ, зохицуулалт

**JEL ангилал:** O16, O36

I.	УДИРТГАЛ	317
II.	ИНСУРТЕК	318
III.	ИНСУРТЕК БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД	325
	Параметрик даатгал /Parametric insurance/	325
	Угсармал даатгал /embedded insurance/	328
	Телематик буюу хэрэглээнд суурилсан даатгал	331
	Open insurance буюу даатгалын хяналтын самбарын үйлчилгээ	335
IV.	МОНГОЛ УЛСЫН ДААТГАЛЫН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ	340
	ДҮГНЭЛТ, САНАЛ	341
	ЭХ СУРВАЛЖ	343
	ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
	Зураг 1. Инсуртекийн хөгжил	319
	Зураг 2 Даатгалын өртгийн сүлжээ	321
	Зураг 3 Телематик даатгал	331
	Зураг 4 Даатгалын хяналтын самбарын хэрэглэгчийн харагдах байдал	335
	Зураг 5 Даатгалын хяналтын самбарын үйлчилгээний зураг төсөл	336
	ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	
	Хүснэгт 1 Олон улсын инсуртекийн хөгжил	319
	Хүснэгт 2 Телематик даатгалын сайн болон сул талууд	333

## I. УДИРТГАЛ

Дэлхий даяар инсуртекийн байнга хувьсан өөрчлөгдөж буй орчинд Монгол Улс уламжлалт, технологийн шинэчлэлийн уулзвар дээр зогсож байна. Даатгалын уламжлалт үйл явцыг оновчтой болгох, сайжруулахад чиглэсэн технологийн дэвшлийн давлагааг Монгол Улсад инсуртек авчрах юм. Эдгээр шинэлэг зүйл нь Монголын хүн амын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээг хангахаас гадна даатгалын үйлчилгээний үр ашиг, хүртээмжийг хангахад хувь нэмэр оруулна.

Дижитал платформ, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжилгээний нэгдмэл байдал нь даатгалын бүтээгдэхүүнийг хэрхэн бүтээх, түгээх, удирдахад хувьсгал хийж байна. Хялбаршуулсан андеррайтерийн үйл явцаас эхлээд хувь хүнд тохирсон даатгалын гэрээг

санал болгох гэх мэт инсуртек нь илүү харилцагч төвтэй, мэдрэмжтэй даатгалын салбарыг бий болгох замыг нээж байна. Хиймэл оюун ухаан, блокчэйн, мэдээллийн аналитикийг нэгтгэснээр уламжлалт даатгалын тогтолцоог шинэчилж, илүү боловсронгуй болгож зах зээлд ажиглагдаж буй хувьслын тодорхой үе шатуудыг ахиулах юм.

Энэхүү судалгааны хүрээнд инсуртекийн ач холбогдлыг судлан сүүлийн үед ашиглаж байгаа инсуртекийн хамгийн эрэлттэй бүтээгдэхүүний талаар болон түүний төрөл, онцлог, зохицуулалт ба улс орнуудын сайн туршлагыг судлан манай улсын даатгалын салбар дахь инсуртекийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар саналаа оруулахад чиглэсэн.



## II. ИНСУРТЕК

Даатгалын компаниуд бизнесийн үйл явцыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хиймэл оюун ухаан (AI), зүйлсийн интернэт (IoT) болон блокчэйн зэрэг шинээр гарч ирж буй технологиудыг ашиглаж байгаа нь инсуртек юм. Инсуртек стартапууд эдгээр шинэ технологиудыг хамгийн түрүүнд хөшүүрэг болгож байсан бол

үндэсний томоохон даатгалын компаниуд өдгөө бизнесийнхээ олон салбарт инсуртекийг ашиглаж байна.

Инсуртек нь хэрэглэгчдийн хэрэгцээний өөрчлөлт, технологийн шинэ чадавхын өсөлт гэсэн хоёр хүчний огтлолцол дээр бий болсон.

### ХЭРЭГЛЭГЧИЙН ХЭРЭГЦЭЭ, ХҮЛЭЭЛТ



Үнийн эмзэг байдал



Түрээслэх, өмчлөх  
(ялангуяа залуу хэрэглэгчдийн дунд)



Хотод бага жолоодох  
(Уян хатан байдал)



Хэрэглэгч төвтэй туршлага  
(Тав тухтай байдал, ил тод байдал)



Илүү их технологийн мэдлэгтэй хэрэглэгчид  
(эрэлттэй эдийн засаг)

### ШИНЭ ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ЧАДАВХ



Платформд суурилсан аргууд  
(Дижитал)



тохиргоо болон захиалгат үйлчилгээ



Хүсэлтийн дагуу үйлчилгээ



Урьдчилан таамаглах аналитик  
(нөхөн төлбөрийн мэдүүлэг, ирээдүйн алдагдал, шимтгэл)



AI-д суурилсан хэрэгсэл ба автоматжуулалт  
(нөхөн төлбөрийн удирдлага)

**Инсуртекийн хувьсал:** 2010–аад оны дундуур санхүүгийн үйлчилгээний бусад салбараас ялгаатай нь даатгалын салбар нь шинэ технологи, бизнесийн загвараар үндсэндээ тасалдаагүй. Гэсэн хэдий ч олон их наяд долларын дэлхийн аж үйлдвэрийн бүхий л салбарт чиглэсэн инсуртек стартапууд олширч, энэ салбар маш чухал эргэлтийн цэгт тулгарсан. Уламжлалт ёсоор маш нарийн, өндөр зохицуулалтын үйл явцтай байсан салбар хурдацтай ганхав. Ковид–19 цар тахал 2019 оны сүүлээр дэгдсэний дараа томоохон гарааны өсөлт дээд цэгтээ хүрч, өсөлтийн хурд бага зэрэг буурсан. Үүнд 2020 оны эхээр дэлхийн хэмжээний томоохон

хорио/тусгаарлалтын үеэр хөрөнгийн зах зээл дэх тодорхой бус байдал, аж үйлдвэрийн эхлэлийн үе шатнаас хэтэрсэн төлөвшил голлон нөлөөлсөн. Өнөөгийн байдлаар Ковид–19–ийн урьд өмнө хэзээ ч байгаагүй нөлөөллөөс болж цочирдсон үйлчлүүлэгчид даатгалыг нэн тэргүүнд тавьж байгаа ч уламжлалт даатгалын компанид хандах хандлага өөрчлөгдсөн. Цар тахлын дараах даатгуулагчид ерөнхийдөө дижитал туршлагыг эрэлхийлж байгаа бөгөөд энэ нь инсуртек салбарт цөөн тооны тогтсон тоглогчдын өсөлтийг бий болгож 2020 онд олон нийтэд бүртгэлтэй инсуртекийн зах зээлийн үнэлгээ 22.0 тэрбум доллароос давж байна.

## ИНСУРТЕКИЙН ХӨГЖИЛ

Хэрэглэгчдийн үйлчлүүлэгчдэд саадгүй хаана ч, хэзээ ч үйлчлүүлэх боломжтой үйлчилгээний талаарх хүлээлт нь инсуртек салбарын хувьслыг голчлон удирддаг. Даатгагчид ашигт ажиллагааг нэмэгдүүлж, үйл ажиллагааны зардлыг бууруулахын зэрэгцээ үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл ханамжийг хангах шаардлагатай байдаг.

Эдгээр хүлээлт, хэрэгцээ нь их хэмжээний өгөгдлийн багц болон тэдгээрийг технологиор удирдах, ашиглах хэрэгслүүдийн хүртээмж нэмэгдэж байгаатай нийлж байна. Өөрсдийгөө инсуртек гэж нэрлэсэн компаниудын тоо үүнээс хойш өргөжин тэлж, харилцан уялдаатай үйлчилгээ, бүтээгдэхүүн санал болгох өргөн уудам, хөгжиж буй системийг багтаасан.

Зураг 1. Инсуртекийн хөгжил



Хүснэгт 1. Олон улсын инсуртекийн хөгжил

Үнийн харьцуулалт ба зуучлагчид	Удирдах ерөнхий агент, тодорхой салбарын сегментэд анхаарлаа төвлөрүүлдэг компаниуд болон процесс	Дэд бүтэц	Экосистем
2010–2012	2013–2016	2017–2018	2019–одоо
Цахим даатгалын хураамжийн тооцоо, цахимаар оруулсан мэдээлэл	Цахим түгээлт	IoT интеграцчилал	Даатгалд хамрагдах хэмжээг нэмэгдүүлэх
Хялбар нэвтрэлт	Олон төрлийн бүтээгдэхүүн	Технологийн багц	White labelling /нэг компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг өөр компаниар заруулах/
Сайн маркетинг	Автоматжуулсан процесс	Бодлогын нөхөн төлбөрийн удирдлага	IaaS / Үүлэн тооцооллын үйлчилгээний нэг төрөл / Угсармал даатгал

Эх сурвалж: drakestar.com



Инсуртек нь дижиталчлалаар дамжуулан илүү энгийн, илүү үр ашигтай бүтээгдэхүүн, үйлчилгээг шаарддаг үйлчлүүлэгчдээс бий болсон нь томоохон онлайн зуучлагчдыг бий болгоход хүргэсэн. Ковид-19 цар тахлын улмаас онлайн хэрэглээнд хурдацтай шилжсэн нь тус салбарын бас нэгэн чухал түлхэц болсон юм. Ил тод байдлыг сайжруулснаар инсуртек компаниуд бүтээгдэхүүнээ хөгжүүлж, дэд бүтцийг сайжруулахад анхаарч эхэлсэн. Хамгийн сүүлийн үеийн хөгжил нь салбарыг угсармал даатгал болон IaaS руу хөтөлсөн.

**Инсуртекийн төрлүүд:** Энэ салбар хөгжиж буй хоёр арга зам: шинэ дижитал загварууд нь одоо байгаа зах зээлийн тоглогчдыг тасалдуулахыг оролдож буй (өрсөлдөөнт хандлага), үр ашгийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд уламжлалт даатгалын өртгийн сүлжээг дижитал болгох зорилготой программ хангамжийн үйлчилгээ үзүүлэгчид (хамтын ажиллагааны арга).

Өрсөлдөөнт арга барилыг дагаж мөрддөг инсуртекийг даатгалын төрөл, бизнесийн загвар, үйлчлүүлэгчийн төрлөөр нь хувааж болно.

- Урт хугацааны даатгал:

Амьдралын даатгал нь ихэвчлэн даатгуулагчийн нас баралтыг хариуцдаг бөгөөд урт хугацааны гэрээний хугацаатай, хөрөнгө оруулалттай төстэй шинж чанартай байдаг.

- Эрүүл мэнд/Аяллын даатгал

Эрүүл мэндийн даатгал нь эмчилгээний зардлыг хариуцдаг. Аялал жуулчлалын даатгал нь гадаадад гарах эмчилгээний зардлыг мөн адил нөхдөг.

- Эд хөрөнгө ба хохирлын даатгал

Эд хөрөнгө ба хохирлын даатгал нь объектод учирсан хохирлыг хамардаг. Эд хөрөнгийн даатгалын хамгийн том дэд ангилал нь бүтээгдэхүүн, орон сууц, автомашины даатгал юм.

- Бизнесийн даатгал

Бизнесийн даатгал нь ажилчдын гэмтэл, цахим гэмт хэрэг зэрэг бизнесийн эрсдэлийг хамардаг.

### Бизнесийн модель

Инсуртек нь үйлчлүүлэгчдэдээ хэрхэн хүрэхийг тодорхойлдог өөр өөр бизнесийн загвартай байдаг. Тэдгээрийг ойролцоогоор дөрвөн хэсэгт хувааж болно:

B2C: Бизнесээс хэрэглэгчдэд: Үйлчилгээг шууд хэрэглэгчдэд хүргэдэг.

B2B: Бизнесээс бизнес рүү: Үйлчилгээг өөр компанид санал болгодог.

B2B2X: Бизнесийг бизнесээр дамжуулан аливаа этгээд рүү: Үйлчилгээг өөр бизнесээр дамжуулан сонирхсон аливаа этгээдэд үзүүлдэг.

P2P: Хэрэглэгчдийг хооронд нь холбож үйлчилгээ үзүүлэх.

### Хэрэглэгчдийн төрөл

Инсуртек компаниуд олон төрлийн үйлчлүүлэгчдэд үйлчилдэг. Эдгээрийг жижиглэнгийн худалдан авагчдаас эхлээд томоохон аж ахуйн нэгж хүртэл хэмжээгээр нь ангилж болно.

Жижиглэн худалдаа – Даатгалын үйл явцыг хялбаршуулсан нь жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад ашигтай болж байна. Нэмж дурдахад инсуртекийн үйлчлүүлэгчдийг

төвлөрүүлдэг шинж чанар нь хувь хүмүүст илүү олон сонголтыг өгч, амьдралынхаа олон талыг даатгах боломжийг олгодог.

ЖДҮ – Уламжлалт даатгалын компаниуд жижиг, дунд үйлдвэрүүдэд (ЖДҮ) хангалтгүй үйлчилгээ үзүүлдэг. Даатгалд илүү энгийн, илүү хялбар шийдэл бүхий инсуртек бий болсон нь санхүүгийн асар том боломжийг олгож байна.


Компани – Airbnb зэрэг компаниудын хувьд даатгалыг хөнгөвчлөх нь ирээдүйд хамгийн

чухал зүйл байх болно. Инсуртек нь технологид суурилсан угсармал даатгалд чухал үүрэг гүйцэтгэнэ.

**Инсуртекийн өртгийн сүлжээ**

Орчин үеийн даатгалын өртгийн сүлжээ нь үйлчлүүлэгчээс эхлээд долоон үе шатаас бүрддэг. Өгөгдөл болон дүн шинжилгээгээр бүх үе шатыг дэмждэг.

**Зураг 2. Даатгалын өртгийн сүлжээ**



Эх сурвалж: drakestar.com

- Маркетинг, борлуулалт болон түгээлт – инсуртек компаниуд зах зээлд гарах стратегидаа уламжлалт даатгалыг дэмждэг; одоо байгаа түгээлтийн сувгууд шинэчлэгдэж, шинэ сувгууд хөгжиж байна. Мобайл болон дижитал борлуулалтын сувгууд улам бүр нэмэгдэж байгаа нь даатгалд урьд өмнө хүрч байгаагүй газруудад үйлчлүүлэгчидтэй харилцах боломжийг олгож байна.
- Бүтээгдэхүүн, боловсруулалт, актуар – инсуртек нь зах зээлд шинэ санаа төдийгүй шинэ бүтээгдэхүүний төрлүүдийг авчирдаг. Захиалгад суурилсан, хувь хүний хэрэглээнд суурилсан бодлогод (P2P, Pay-as-you-go) ахиц дэвшил гарсан бүтээгдэхүүнүүд нь даатгалын компаниудад орлогын шинэ урсгалыг нээх боломжийг олгодог.
- Эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ, андеррайтинг – мэдээлэлд суурилсан ихэнх инсуртекууд компьютерын шинжлэх ухааны сүүлийн үеийн дэвшилтүүдийг, тухайлбал хиймэл оюун ухаан, машин сургалтыг ашиглан эрсдэлийг илүү сайн, хурдан, үр дүнтэйгээр үнэлж байна.
- Нэвтрүүлэлт, удирдлага, харилцагчийн оролцоо, урьдчилан сэргийлэлт – Зарим инсуртекүүд хуучин систем дэх алслагдсан өгөгдлийн асуудлыг олоход тусалдаг. Мэдээллийг бусад системд ашиглах боломжтой болгох нь үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж, өртгийн сүлжээнд дүн шинжилгээ хийх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлдэг.



- Нэмж дурдахад, үйлчлүүлэгчээ таних (KYC) үйл явцыг оновчтой болгож, хурдасгаж, үйлчлүүлэгчдэд илүү сайн туршлага өгөх боломжтой. Бусад инсуртекүүд нь тусламжийн хүсэлтийг автоматаар зохицуулах замаар харилцагчийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр ажилладаг. Өөр нэг чухал чиглэл бол алдагдлаас урьдчилан сэргийлэх;
- Нөхөн төлбөрийн удирдлага – Инсуртек нь нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах, үнэлэх, боловсруулах, шийдвэрлэх ажиллагааг автоматжуулж, үйл ажиллагааны нэмэлт зардлыг багасгаж, үйл явцын хурдыг нэмэгдүүлдэг. Анхаарах өөр нэг чиглэл бол залилангаас урьдчилан сэргийлэх; их өгөгдлийг ашигласнаар инсуртек нь залилангийн хэв маягийг илрүүлж чадна.
- Давхар даатгал – Энэ чиглэлээр инсуртек нь үндсэндээ давхар даатгагчтай холбоотой тоон хэсгүүдэд анхаарлаа төвлөрүүлж, дэвшилтэт шинжилгээ, бодит цагийн эрсдэлийн үнэлгээний тусламжтайгаар давхар даатгалд тохирсон бусад төрлийн программ хангамжаар хангадаг.
- Хөрөнгийн удирдлага – Үйлчилгээнүүд нь үйлчлүүлэгчээ танихаас эхлээд багцын удирдлага, тайлагнах зэрэг өргөн хүрээтэй.
- Өгөгдөл болон тоон шинжилгээ – Даатгалын компаниуд асар их хэмжээний өгөгдөл, мэдээлэл дээр суурилдаг боловч эдгээр хөрөнгийг олж авах, ашиглахад шинэлэг шийдэл хэрэгтэй. Өгөгдөл ба шинжилгээ нь өртгийн сүлжээг бүхэлд нь дэмждэг. Ихэнх инсуртекүүд тодорхой үе шатуудад өгөгдөл ашиглахад онцгой анхаарал хандуулдаг.

### Инсуртек Юникорны өсөлт

Даатгалын технологийн салбарын өсөлт, шинээр гарч ирж буй энэ салбарт томоохон хөрөнгө оруулалтууд нийлээд дэлхий даяар хэд хэдэн юникорнуудыг бий болгосон. Зарим юникорнууд аль хэдийн холимог зах зээлийн гүйцэтгэлээр олон нийтэд ил болсон. Эдгээр юникорнууд нь янз бүрийн бизнесийн загваруудыг төлөөлөн, өөр өөр даатгалын төрлүүдийг хамарч, төрөл бүрийн хэрэглэгчийн бүлгүүдэд ханддаг нь инсуртекийн хөгжил ямар чухал болсныг харуулж байна. Дэлхийн Финтекийн орон зайд юникорны статустай болсон компаниудын багагүй хувийг инсуртек стартапууд эзэлдэг нь даатгалын салбарын хамгийн хүчирхэг тоглогчдын тоонд оруулдаг. Эдгээр том өсөлт нь голчлон даатгалын салбар хангалттай хурдан цахимжаагүйтэй холбоотой юм. Инсуртек нь илүү хурдан шийдвэр гаргах, мэдээллийн гүн гүнзгий ойлголт, эрсдэлд дүн шинжилгээ хийх болон бусад олон боломжийг олгодог шинэ технологиор энэ цоорхойг нөхөж байна. Түүнчлэн гаднын үйл явдлуудаас (дайн, байгалийн гамшиг гэх мэт) шинэ эрсдэлүүд бий болж, инсуртекийн шийдлүүдээр эдгээр эрсдэлийг даатгах бүтээгдэхүүнийг санал болгож байна. Лондонд төвтэй боловсролын платформын Fintech Unicorns Hub-ийн мэдээлснээр өнөөг хүртэл 280 юникорн Финтек компаниудаас 40 нь инновацыг бий болгох эсвэл даатгалын салбарын загварыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Эдгээр компаниудын ихэнх нь АНУ, Их Британид байрладаг. АНУ дэлхийн юникорн инсуртекийн бараг тавны хоёрыг эзэлдэг; Их Британид тус салбарын найман тэрбум долларын стартапууд байрладаг.

Жишээ нь:

1. Coalition – 2017 онд байгуулагдсан 5 тэрбум ам.долларын үнэлгээтэй компани нь бүх төрлийн дижитал эрсдэлийг илрүүлэх, бууруулах, даатгахад байгууллагуудад туслахын тулд цахим аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл, дижитал шүүх шинжилгээнд хамрагдах, ослын хариу арга хэмжээ авах зэрэг цогц даатгалын үйлчилгээг хослуулсан. Инсуртек Юникорн нь 500 ажилтантай бөгөөд дэлхий даяар 160,000 гаруй үйлчлүүлэгчдэд үйлчилдэг. АНУ-ын бүх 50 мужид үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн лицензийн ачаар Сан Францискод төвтэй пүүс нь цахим эрсдэл, технологийн алдаа, орхигдол болон бусад гүйцэтгэх эрсдэлээс хамгаалж, өөрийн хүлээн зөвшөөрөгдсөн даатгалын компаниар дамжуулан даатгалын гэрээг санал болгодог.
2. Alan – Францын 2.69 тэрбум ам. долларын үнэлгээтэй эрүүл мэндийн даатгалын компани тус улсын эрүүл мэндийн тогтолцооны үр ашиггүй байдлыг арилгах зорилгоор 2016 онд эрүүл мэндийн дижитал даатгалын платформыг эхлүүлсэн. Франц улс Европын ихэнх орнуудаас илүү олон нийтийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд анхаарал хандуулж байгаа хэдий ч удаан хүлээх хугацаа, захиргааны нарийн төвөгтэй журам, тусламж үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдал байсаар байна гэж Алан компани үзсэн.

## Даатгалын зах зээлд тулгарч буй бэрхшээлүүд

### 1. Даатгалын онцлогоос хамаарч буй бэрхшээлүүд

Зохицуулалтын стандартыг эрчимжүүлэх – Даатгагчид зохицуулалтын нарийн, илүү өндөр стандартад бэлтгэх шаардлагатай; ОУСТС17, Мэдээлэл хамгаалах ерөнхий зохицуулалт зэрэг байдаг. Өсөлт багатай, хүү багатай орчинд дагаж мөрдөх өндөр комплайнсын зардлыг нөхөхөд хэцүү байдаг.

Чадварлаг ажилтнуудыг олох – Өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх, ялангуяа технологи, аналитикт шаардлагатай авьяас чадвартай хүмүүсийг татах, хадгалах нь ихэнх компаниудын хувьд байнгын сорилт юм.

Хуучирсан түгээлтийн сувгууд – Ихэнх даатгалын компаниуд цөөхөн хэрэглэгчид ашигладаг түгээлтийн сувгуудад найдсан хэвээр байна; олон хүмүүс дижитал сувгаар компаниудтай харилцах хүсэлтэй байгаа тул уламжлалт загвар аажмаар хуучирна.

Хуучин технологи – Хуучин системийн зардал, эрсдэл нэмэгдэж, кибер халдлагын хохирогч болох магадлал нэмэгдэж байна. Нэмж дурдахад, олон компаниудад бүх арын системийн өгөгдлийг нэгтгэх дунд давхарга байдаггүй.

Нийт зардлын дарамт – Компаниудад тулгарч буй олон сорилт нь томоохон хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шаарддаг тул үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай болдог.

Өндөр өрсөлдөөн – Дэлхий даяар бараг 7000 компани зах зээл дээр байгаа тул өрсөлдөөн ширүүн байна. Удаан хугацаанд үйл ажиллагаагаа явуулахын тулд чадвар шаардагдаж байна.



## 2. Эдийн засгийн онцлогоос хамаарч буй бэрхшээлүүд

Гадаад цочролын нөлөө – Ковид–19 цар тахлын үр дагавар даатгалын компаниудад тодорхойгүй хэвээр байна. Эрүүл мэндийн зардал ихээхэн нэмэгдэх магадлалтай. Нэмж дурдахад Украины дайн дэлхий дахинд болж буй үйл явдлуудыг урьдчилан тааварлах боломжгүйг харуулсан.

Эдийн засгийн өсөлт бага – Хөгжингүй эдийн засагтай орнууд, ялангуяа Европын орнуудын ДНБ–ий өсөлт бага байгаа нь даатгалын компаниудын өсөлтөд хүндрэл учруулж байна. Украины дайн, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний асуудал, инфляц энэ асуудлыг улам хурцатгаж байна.

Хүүгийн түвшин – 2008 оны санхүүгийн хямралын дараа бий болсон бага хүү нь урт хугацааны даатгагчдад онцгой сорилт болж, бүтээгдэхүүний шинэчлэлд анхаарлаа хандуулахыг шаарддаг. Инфляцтай тэмцэхийн тулд хүүгийн түвшин нэмэгдэж байгаа ч түүхэндээ бага хэвээр байна.

Уур амьсгалын өөрчлөлт – Байгалийн гамшигт үзэгдэл нэмэгдэж байгаа нь томоохон сорилт болж байна. Байгалийн гамшгаас үүдэлтэй

нөхөн төлбөр нь 2017/18 онд салбарын түүхэн дээд хэмжээний алдагдалд хүргэсэн. Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар нь ирээдүйд илүү их нөлөө үзүүлэх болно.

## 3. Хэрэглэгчийн онцлогоос хамаарч буй бэрхшээлүүд

Хүн ам зүйн өөрчлөлт – Хүн амын тоо багасаж, хөгширч байгаа нь эрүүл мэндийн үйлчилгээний зардал нэмэгдэхэд хүргэж байна. Залуу үеийнхэн эхлээд гэрлэж, хожим нь орон сууц худалдан авч байгаа нь даатгалын салбартай харилцах цаг хугацааг өөрчилдөг.

Хэрэглэгчийн холбоо барих цэг цөөн – Мэргэшсэн зуучлагчаар дамжуулан даатгалын бүтээгдэхүүнийг худалдан авах уламжлалт борлуулалтын загвар нь харьцуулалтын портал эсвэл дижитал шийдлээр дамжуулан илүү олон бүтээгдэхүүн зарагдаж, үйлчлүүлэгчдийг хадгалахад бэрхшээл учруулж байгаа тул буурах хандлагатай байна.

Хэрэглэгчийн хүлээлт ихсэх – Үйлчлүүлэгчдийн өдөр тутмын амьдралд дижиталчлал нэвтэрч байгаа нь даатгагчид болон тэдний бүтээгдэхүүнүүдтэй харилцах, ялангуяа илүү хувь хүний бодлого, илүү сайн үйлчилгээтэй харилцахдаа тэдний хүлээлтийг өөрчилсөн.

### III. ИНСУРТЕК БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Дижитал технологи нь хэрэглэгчдийн хүлээлтийг өөрчилж, салбарын хил хязгаарыг дахин тодорхойлсоор байна. Дэлхийн мегатренд "угсармал экосистем" –ийн зэрэгцээ инсуртекийн ирээдүйг тодорхойлох бусад томоохон чиг хандлага бий. Шинээр гарч ирж буй инсуртек бүтээгдэхүүнүүд болон тэдгээрийг хэрхэн зохицуулдаг тухай зарим жишээг дурдвал:

#### Параметрик даатгал /Parametric insurance/

Параметрик даатгал нь хувьсан өөрчлөгдөж буй индексэд суурилсан даатгалын бүтээгдэхүүний шинэ ангилал юм. Индекс дээр суурилсан даатгалын бодлого нь хур тунадасны түвшин эсвэл салхины хурд зэрэг урьдчилан тогтоосон индекс дээр үндэслэн нөхөн төлбөрийг төлдөг. Параметрик даатгал нь тодорхой хэмжүүрийн хүрээнд явагддаг. Уламжлалт даатгалаас ялгаатай нь параметрик даатгал нь даатгуулагчийн бодит хохирлыг нөхөн төлдөггүй. Бодит алдагдал нь параметрик даатгалд бараг хамааралгүй юм. Үүний оронд параметрик даатгал нь даатгуулагчийг урьдчилан тодорхойлсон үйл явдлын магадлалаас хамгаалдаг. Жишээлбэл, хар салхины үед уламжлалт даатгал нь даатгуулагчийн нөхөн төлбөр болон бодит хохирлын үнийг төлдөг бол параметрик даатгалын бодлого нь бодит хохирлоос үл хамааран салхи тодорхой хурдтай болсон эсэхээс хамаарч нөхөн төлбөрийг төлдөг. Параметрик даатгалын бүтээгдэхүүнүүд нь олон төрлийн эрсдэлд зориулагдсан байдаг бөгөөд даатгуулагчдын хэрэгцээг хангахын тулд шинэ бүтээгдэхүүнүүд байнга боловсруулагддаг боловч ихэвчлэн параметрик

даатгалд хамрагдах эрсдэлүүд нь түүхэндээ даатгахад хэцүү байсан эрсдэлүүд байдаг – маш их хохирол учруулдаг ховор тохиолдлууд. Параметрик даатгалын компаниуд одоогоор уламжлалт даатгалын компаниудтай ижил зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Уламжлалт даатгалын төлөвлөгөө нь ихэвчлэн жил бүр байдаг бол параметрик даатгалын бүтээгдэхүүн нь ихэвчлэн таван жил хүртэлх олон жилийн төлөвлөгөө байдаг. Өөрөөр хэлбэл, зарим параметрик төлөвлөгөө нь улирлын шинж чанартай бөгөөд жишээлбэл, хар салхины улирал эсвэл ган гачгийн үед л эрсдэлийг даатгах зорилгоор ажилладаг. Ихэнх параметрик даатгалын бүтээгдэхүүнийг бизнес эрхэлдэг үйлчлүүлэгчид эсвэл Засгийн газрын нэгжүүдэд зориулж бичсэн бөгөөд захиалгат гэрээтэй байдаг. Стандарт бодлогыг зарахаас илүүтэйгээр ихэнх даатгагчид даатгуулагчтай шууд хамтран ажиллаж, даатгуулагчийн эрсдэлд тохирсон параметрик даатгалын төлөвлөгөөг боловсруулдаг. Эдгээр нь ихэвчлэн олон сая доллар төлдөг өндөр үнэ цэнтэй, өндөр өртөгтэй төлөвлөгөө юм. Параметрик даатгал нь даатгуулагчийн цорын ганц даатгалын бодлого биш бөгөөд үүний оронд энэ нь урьдчилан таамаглаж болохуйц, боломжийн алдагдлын дараа хөрвөх чадварыг нэмэгдүүлэх уламжлалт даатгалын нэмэлт үүрэг гүйцэтгэдэг.

#### Параметрик даатгалын гарал үүсэл

Мексик улс нь параметрик хэрэглээний анхдагч орон юм. 1996 онд Мексикийн Засгийн газар байгалийн гамшгийн эсрэг үндэсний сан болох FONDEN-ийг байгуулж, гамшгаас аврах, сэргээн босгох ажилд зориулж төсвийн хөрөнгийг шилжүүлдэг. FONDEN нь байгалийн гамшгийн



эсрэг хариу арга хэмжээ авахад орон нутгийн муж, аж ахуйн нэгжүүдийг дэмжихийн тулд янз бүрийн санхүүгийн хэрэгслийг ашигладаг бөгөөд үүнд нөөц сан, эрсдэл шилжүүлэх шийдэл байдаг. 2006 онд FONDEN Мексикийн газар хөдлөлтийн эрсдэлийг олон улсын хөрөнгийн зах зээлд шилжүүлэх зорилгоор 160 сая ам.долларын гамшгийн бондыг ("Cat-Mex" гэж нэрлэдэг) гаргасан. Энэ нь тусгаар тогтносон улсын гаргасан анхны параметрт гамшгийн бонд байв. Олон талаараа, гамшгийн бонд нь даатгагчдад зориулсан параметрик даатгалтай адил юм, учир нь эдгээр нь өндөр хохиролтой байгалийн гамшгийн эрсдэлийг даатгагчаас хөрөнгө оруулагчдад шилжүүлж, уламжлалт давхар даатгалыг нөхөх зорилгоор олгодог. Гамшгийн бондын параметрик даатгалын хувьслыг сайн баримтжуулаагүй байгаа нь зарим талаараа параметрик бодлого нь ихэвчлэн хувь хүний арилжааны үйлчлүүлэгчдэд зориулсан захиалгат гэрээ байдагтай холбоотой байж болох юм.

Параметрик даатгалын хамгийн эртний баримтжуулсан тохиолдлуудын нэг нь үнэндээ даатгалын бодлого биш, харин бүрэн хэмжээний гамшгийн бонд байсан юм. Энэ нь 1999 оны 4 дүгээр сард Токиогийн Диснейлэндийг газар хөдлөлтөөс хамгаалах зорилгоор гаргасан бөгөөд хэрэв хөдөлсөн тохиолдолд 100 сая долларын нөхөн төлбөр олгоно гэж амласан. Энэхүү холбоо нь паркийг гурван төвлөрсөн тойргоор бүрхсэн параметрик ашигласан бөгөөд тус бүр нь магнитудын хэмжээ юм: дотоод тойрогт JMA масштабаар 6.5 ба түүнээс дээш, дунд тойрогт 7.1, гадна цагаригт 7.6 байвал нөхөн төлбөрөө шилжүүлэхээр тохиролцжээ.

Карибын тэнгисийн гамшгийн эрсдэлийн даатгалын сангаас тусгаарлагдсан багцын

компани (CCRIF) нь найман жилийн дараа уламжлалт болон хөрөнгийн зах зээл дээр тулгуурласан параметрик бодлогыг амжилттай ашигласан даатгалын анхны хэрэгсэл болгон хөгжүүлсэн. Түүнчлэн CCRIF нь параметрик даатгал гаргасан бүс нутгийн эрсдэлийг нэгтгэх анхны сан юм. CCRIF нь ашгийн бус даатгалын компани хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд анх Карибын тэнгисийн 16 мужийн Засгийн газарт үйлчилж байсан. Энэ нь 2004 онд тус бүс нутгийг сүйрүүлсэн Иван хар салхины улмаас учирсан хохирлын хариу арга хэмжээ болгон боловсруулсан бодлого юм. Эдгээр сүйрсэн орнуудын Засгийн газруудад тулгарч буй гол асуудал бол гамшгийн дараах хөрвөх чадвар байсан – яаралтай тусламжийн сангийн шавхагдах, буяны хандив хүлээн авах хооронд зөрүү хугацаа гарч, засгийн газрууд зайлшгүй шаардлагатай үйлчилгээг үзүүлэх эсвэл нөхөн сэргээх үйл явцыг эхлүүлэхэд бэрхшээлтэй байсан. Карибын тэнгисийн нийгэмлэг (CAR-ICOM) шийдлийг олохоор шийдсэн бөгөөд гамшгийн эрсдэлийг шилжүүлэх зардал багатай арга хэрэгслийг зохион бүтээх, хэрэгжүүлэхэд нь туслахыг Дэлхийн банкнаас хүсжээ. Хөтөлбөрийн гол зорилго нь байгалийн гамшгийн дараа эдгээр засгийн газруудын төлж чадах үнээр богино хугацаанд түргэн хөрвөх чадварыг тогтвортой хангах явдал байв. CCRIF нь хар салхины үндэсний төв болон АНУ-ын геологийн албанаас нийлүүлсэн параметрик тэгшитгэл, өгөгдлийг ашигладаг бөгөөд хамрах хүрээг тодорхойлж, төлбөрийг тооцдог. Улс орнуудыг бүс болгон хуваадаг бөгөөд бүс бүрд тухайн бүсийн хүн амын тоо, засгийн газрын дэд бүтцийн хэмжээг тодорхойлдог өөрийн гэсэн параметрик тэгшитгэлийг өгдөг. Засгийн газрын нийт алдагдлыг (мөн түүний төлбөрийг) бий болгох нь салхины хурд, газар

